

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА (ОУИТБС)

Монгол улсын баталгаажуулалт

ОУИТБС-ын Олон улсын Ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

2016 оны 9 дүгээр сарын 3

Товчилсон үгс

АХБ	Азийн хөгжлийн банк
БУ	Бичил уурхай
БЭ	Бенефициар эзэмшигч
МБ	МонголБанк
НТТХ	Нэгдсэн төсвийн тухай хууль
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ОУДДХД	Олборлох үйлдвэрлэлийн даян дэлхийн хөтөлбөрийн дэмжлэг
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
МОУИТБС	Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ЭТТ	Эрдэнэс Таван Толгой
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ТЕГ	Татварын ерөнхий газар
ЗГСС	Засгийн газрын санхүүгийн статистик
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ХБН-Х	Хараат бус нэгтгэгч-Хянагч
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУСТС	Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт
ОТДИС	Олон талт донорын итгэлцлийн сан
МБОИЗ	Монголын байгаль орчны иргэний зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУУҮА	Монголын Уул уурхайн үндэсний ассоциац
МНТ	Монгол төгрөг
СЯ	Сангийн яам
АМГ	Ашигт малтмалын газар
ОТОБ	Олон талын оролцоот бүлэг
ОТОАХ	Олон талын оролцоот ажлын хэсэг
ҮЗ	Үндэсний зөвлөл
ҮДТ	Үндэсний дата төв
ТББ	Төрийн бус байгууллага
БНЗХ	Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн
ҮСГ	Үндэсний статистикын хороо
ННФ	Нээлттэй нийгэм форум
ОТ	Оюу Толгой
ГТГ	Газрын тосны газар
УТХЭ	Улс төрд хамааралтай этгээд
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль
ТАН	Төлсөн, авсанаа нийтэл
ТӨК	Төрийн өмчит компани
ТӨХ	Төрийн өмчийн хороо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
АД	Ажлын даалгавар
УБТЗ	Улаанбаатар төмөр зам (Монгол-Оросын хамтарсан)
ам.д	Америк доллар
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар

Агуулга

Товчилсон үгс	2
Гүйцэтгэх хураангуй	5
Нийтлэг дүгнэлт	5
Зөвлөмжүүд	8
Танилцуулга	12
ОУИТБС-д нэгдэн орох шатны тухай товч танилцуулга	12
Хэрэгжилтийн зорилтууд болон ажлын төлөвлөгөөнд гарсан ахиц дэвшил	12
ОУИТБС-ын тайлагналын түүх	13
Төр, иргэний нийгэм болон компаниудын оролцооны тойм	14
Олборлох салбарын гол онцлогууд	14
Баталгаажуулалтын үйл явцын талаарх тайлбар	16
Хэсэг I – ОТОБ-ийн хяналт	20
1. ОТОБ-ийн хяналт	20
1.1 Тойм	20
1.2 Үнэлгээ	20
ОУИТБС-ын үйл явц дахь Засгийн газрын оролцоо (#1.1)	20
ОУИТБС-ын үйл явц дахь компаниудын оролцоо (#1.2)	25
ОУИТБС дахь иргэний нийгмийн оролцоо (#1.3)	28
ОТОБ-ийн засаглал болон үйл ажиллагаа (#1.4)	32
Ажлын төлөвлөгөө (#1.5)	43
Хэсэг II – ОУИТБС-ын ил тод байдал	50
2. Гэрээ хийх болон тусгай зөвшөөрөл олгох	50
2.1 Тойм	50
2.2 Үнэлгээ	50
Эрх зүйн орчин (#2.1)	50
Тусгай зөвшөөрөл хуваарилалт (#2.2)	51
Тусгай зөвшөөрлийн бүртгэл (#2.3)	54
Гэрээний ил тод байдал (#2.4)	56
Бенефициар өмчлөгчийг ил тод болгох (#2.5)	58
Төрийн оролцоо (#2.6)	60
3. Мониторинг болон үйлдвэрлэл	66
3.1 Тойм	66
3.2 Үнэлгээ	66
Олборлох салбар, үүнд хайгуулын үйл ажиллагааны талаарх тойм (#3.1)	66
Үйлдвэрлэлийн мэдээлэл (#3.2)	67
Экспортын мэдээлэл (#3.3)	68
4. Орлого төвлөрүүлэх	70
4.1 Тойм	70
4.2 Үнэлгээ	70
Иж бүрэн байдал (#4.1)	70
Мөнгөн бус орлого (#4.2)	75
Бартер болон дэд бүтцийн төлбөр шилжүүлэг (#4.3)	76
Тээврийн орлого (#4.4)	76
ТӨК болон Засгийн газар хоорондын шилжүүлэг (#4.5)	77
Орон нутгийн шууд төлбөр (#4.6)	79
Задаргааны түвшин (#4.7)	80
Мэдээллийн цаг хугацаа (#4.8)	81
Мэдээллийн чанар (#4.9)	82
5. Орлогын удирдлага болон хуваарилалт	93
5.1 Тойм	93
5.2 Үнэлгээ	93

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Орлого хуваарилалт (#5.1).....	93
Орон нутгийн шилжүүлэг (#5.2)	93
Орлогын удирдлага болон зарцуулалтын тухай нэмэлт мэдээлэл (#5.3)	96
6. Нийгэм, эдийн засгийн зарцуулалт	97
6.1 Тойм.....	97
6.2 Үнэлгээ.....	97
Нийгмийн зарцуулалт (#6.1).....	97
Төрийн өмчит компаниудын төсвийн шинжтэй зарцуулалтууд (#6.2).....	100
Олборлох салбараас орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр (#6.3).....	101
Хэсэг III – Үр дүн болон нөлөөлөл.....	105
7. Үр дүн болон нөлөөлөл.....	105
7.1 Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)	105
7.2 Мэдээллийн хүртээмж (#7.2).....	111
7.3 Сургамжууд, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь (#7.3)	114
7.4 Хэрэгжилтийн үр дүн болон нөлөөлөл (#7.4)	117
7.5 Нөлөөллийн дүн шинжилгээ (ОУИТБС-ын заалтуудын хэрэгжилтийг үнэлэхэд харгалзан үзэхгүй).....	120
Хавсралтууд.....	123
Хавсралт А – ОТОБ-ийн гишүүдийн жагсаалт, холбоо барих хаяг	123
Үндэсний зөвлөлийн гишүүдийн нэрс, холбоо барих хаяг (2016 оны 7 дугаар сарын байдлаар)	123
ОТОБ-ийн гишүүдийн нэрс, холбоо барих хаяг (2016 оны 7 дугаар сарын байдлаар)	125
Хавсралт Б – Уулзан ярилцсан талуудын нэрсийн жагсаалт (96).....	130
Хавсралт В – Лавлах баримт бичиг, ном зүйн жагсаалт	134
Хавсралт Г – Монгол улсын ОУИТБС-ын болон Баталгаажуулалтын тайлангийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл.....	139
Хавсралт Д – 2013- 2015 онуудад Хараат бус нэгтгэгчийг сонгон шалгаруулсан дүн.....	142
Хавсралт Е – Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлсэн шилжүүлэг, 2013 – 2016 оны 1 дүгээр хагас.....	143

Гүйцэтгэх хураангуй

Монгол улсын Засгийн газар 2006 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг (ОУИТБС) хэрэгжүүлж эхлэх тухай #1 тоот тогтоолыг гаргаснаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлж эхэлжээ. 2006 онд Олон талын оролцоот бүлэг (ОТОБ) буюу ОУИТБС-ын Ажлын хэсгийг байгуулж, улмаар Монгол улсыг ОУИТБС-ын нэр дэвшигчээр 2007 оны 9 дүгээр сард хүлээн зөвшөөрсөн байна. ОУИТБС-ын Удирдах хорооноос хийсэн баталгаажуулалтын дараагаар 2010 оны 10 дугаар сард Монгол улс нь “хэрэгжүүлэгч” орны статустай болсоноор ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 4 дэхь орноор тодорсон байна.

2016 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Олон улсын Удирдах хороо ОУИТБС-ын 2016 оны стандартын Монгол улсын баталгаажуулалтыг 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг өгсөн байна. Энэхүү тайлан нь ОУИТБС-ын Олон улсын Ажлын албаны зүгээс хийсэн мэдээлэл цуглуулах, оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны хүрээнд гарсан үр дүн, анхдагч үнэлгээг танилцуулж байна. Олон улсын Ажлын алба нь Монгол улсад ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэхэд гаргаж буй ахиц дэвшлийг үнэлэхдээ Үнэлгээний журмыг¹ даган мөрдөж, Үнэлгээний зааварчилгааг² ашиглан гүйцэтгэсэн. Энэхүү үнэлгээг ОТОБ хараахан судлан үзээгүй эсвэл чанарын баталгаажилт хийгдээгүй буй ч Олон улсын ажлын албаны зүгээс гаргаж буй анхдагч үнэлгээгээр 2.2, 2.3, 2.5, 2.6, 4.1, 4.5, 4.6, 4.9, 5.2, 6.1, 6.2 болон 7.4 дүгээр шаардлагуудыг Монгол улс хангаагүй хэмээн дүгнэж байна. Дээрх шаардлагуудын нэгийг (Шаардлага 6.2) “хязгаарлагдмал ахицтай, хангаагүй” хэмээн үнэлсэн болно.

Асуудалтай буюу санаа зовнихуйц томоохон хэсгүүдэд мэдээллийн чанарын баталгаажуулалт, Засгийн газар, олборлох салбар болон төрийн өмчит компаниуд, үүнд төсвийн шинжтэй зарцуулалт бүхий, төртэй санхүүгийн харилцаатай болон гуравдагч талын санхүүжилт бүхий компаниудын тайлагналтын иж бүрэн байдал зэрэгт хамаарч байна. Шаардлага нэг бүрээр авч хэрэгжүүлэх засан залруулах үйл ажиллагааг доор санал болгосон буй.

Нийтлэг дүгнэлт

Монгол улс нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч анхны улсуудын нэг, мөн тайлан гаргах үйл ажиллагааг өргөжүүлэн олон тооны компаниудыг хамруулсан зэрэг үзүүлэлтээр ОУИТБС-ын хэрэгжилтийг тэргүүлсэн, анхдагч улс билээ. Монгол улсын ОУИТБС-ын тайлан нь олборлох үйлдвэрлэлийн салбарын зүгээс байгаль орчинд зарцуулж буй хөрөнгө, хувь нэмэр болон орон нутгийн захиргаадын тайлан зэрэг өргөн салбарыг хамарч байна. Монгол улс нь өмнө Орон нутгийн дэд зөвлөлүүдийг байгуулж, ОУИТБС-ын мэдээллийг шинээр бий болгосон онлайн мэдээллийн порталаар дамжуулан хүртээмжтэй болгоход томоохон алхам хийсэн билээ.

Тус улс нь 2007 онд “нэр дэвшигч” улсын статустай болсон цаг мөчөөс хойш Засгийн газрын зүгээс олон нийтэд хандсан мэдэгдэл гаргах, хамаарах хууль тогтоомжуудыг батлан гаргах, 2010 оноос эхлэн ОУИТБС-ын үйл ажиллагааг санхүүжүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж ирсэн байна. Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөл нь ОУИТБС-ын ОТОБ-ийн (Ажлын хэсэг) үйл ажиллагааг эрхлэн явуулахад идэвхтэй оролцож, ОУИТБС-ын тайланд шаардлагатай мэдээллийг ханган өгч, тайлан гаргах үйл ажиллагааг төрийн тогтолцоонд уялдуулан

¹ <https://beta.eiti.org/document/validation-procedures>

² <https://beta.eiti.org/document/validation-guide>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

нэгтгэхийг дэмжин ажиллаж иржээ.

Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн өөр нэгэн давуу тал нь тайлан гаргах үйл явцыг ОУИТБС-стандартаар шаардаагүй асуудлуудад өргөтгөн хамруулж, үүнд орон нутгийн оролцогч талуудыг бодитоор харгалзан үйл ажиллагаа явуулсанд оршиж байна. 2013 оны ОУИТБС-ын стандарт хэрэгжиж эхлэхээс ч өмнө ОТОБ нь компаниудын нийгмийн чиглэлтэй зарцуулалт болон байгаль орчныг нөхөн сэргээх санд оруулсан хувь нэмэр зэргийг тайланд тусгах болжээ. Мөн ОТОБ нь бенефициар өмчлөл болон гэрээний ил тод байдлыг чиглэлээр тодорхой үйл ажиллагааг явуулж иржээ.

ОТОБ нь оролцогч талуудын бүлгүүдийн дунд харилцан илтгэлцлийг шат дараатай бий болгосон ч хэрэгжилтийн гол хөдөлгүүр бус харин хяналтын чиг үүргийг илүүтэй гүйцэтгэж байна. Харин хэрэгжилтийг хангах чиг үүргийг ОТОБ-ийн байгуулсан түр ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг ОУИТБС-ын Ажлын алба гүйцэтгэж байна. Эдгээр албан бус ажлын хэсгүүд нь ОУИТБС-ын тайлангаар гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, тайлангийн маягтуудыг шинэчлэх зэрэг гол үүрэг даалгаварыг гүйцэтгэж буй ч албан ёсны эрх хомс, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг³ саяхнаас хөтөлж эхлэх болсон зэрэг шалтгаанаас улбаалан ОУИТБС-ын Ажлын албанд ихээхэн хэмжээний үүрэг хариуцлагыг давхар ноогдуулан үлдээхэд хүргэж байна. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл нь санаачилгын үйл ажиллагааг дээд түвшинд хянах үүрэгтэй ч энэхүү чиг үүргээ гүйцэтгэхэд нь улс төрийн хүрээнд ойр давтамжтай гарч буй өөрчлөлтүүд болон сонгогдсон гишүүдийн оролцоо бага байх зэрэг асуудлаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл тулгарч байна. Тиймээс одоо Монгол улс дахь ОУИТБС-ын институцын бүтцийг эргэн харж, ОТОБ-ийн албан ёсны хяналтыг сайжруулах, Монголын ОУИТБС-ын Ажлын албанд ноогдож буй ачааллыг буруулах зохистой цаг ирээд байна.

Монгол улсын хувьд уул уурхайн салбарын татварын хувь хэмжээ байнга өөрчлөгдөж, 1500 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниас 400 гаруй нь олборлолт хийж, 2012 оны дунд үеэс эхэлсэн эдийн засгийн уналтын нөлөөлөл үргэлжилж буйн улмаас ОУИТБС-ын хувьд ихээхэн түвэгтэй нөхцөл байдлыг үүсгээд байна. Хараат бус нэгтгэгч (аудитор) нь нийт компаниудын тавны нэгийн гаргасан мэдээллийг Засгийн газрын мэдээлэлтэй нэгтгэн тулгалт хийж буй ч бүртгэл, тайлагналын асуудалд цуцалтгүй анхаарал хандуулсанаар ОТОБ нь тайлан гаргах үйл ажиллагаанд 100 гаруй компанийг сүүлийн жилүүдэд хамруулж, онлайн тайлангийн системийг (eReporting) эхлүүлжээ.

Нарийвчлан нэгтгэн тулгалт хийхэд хандсан энэхүү анхаарал нь ОУИТБС-ын Стандартын дагуу одоо шаардагдаж буй орлогын бус мэдээллийг судлан үзэж буй байдалтай нийцэхгүй буй юм. ОТОБ нь ОУИТБС-ын Стандартын дагуу шаардагдаж буй нөхцөл байдлын талаарх мэдээлэл жишээ нь төрийн өмчит компаниудын асуудлууд зэргийг харгалзан анхаарал хандуулахгүй буй мэт санагдаж буй бөгөөд тухайн асуудлуудад хангалттай хэмжээнд анхаарсанаар өргөн хүрээний оролцогч талуудын сонирхолд нийцэх юм. Энэхүү тайланд тодруулан дурдсан ОУИТБС-ын тайлагналд буй гол орхигдож буй зүйл нь мэдээллийн чанар болон төрийн өмчит компаниудын мэдээллийг ил тод болгохтой холбоотой байна. ОУИТБС-ын Тайлангийн төслийг боловсруулахад оролцох ОТОБ-ын оролцоо нь хязгаарлагдмал, ОУИТБС-ын Стандартаар тавигдсан шаардлагуудад хандан ажиллах нь бага байна.

Монгол улс нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай болохын хувьд салбарын удирдлага, төрийн оролцоо болон салбарын хэтийн төлвийн талаар үндэсний хэмжээний, идэвхтэй хэлэлцүүлэг өрнөж байна. Энэхүү хэлэлцүүлэгт оруулах ОУИТБС-ын хувь нэмэр нь үндсэндээ мэдээлэл түгээх арга

³ 2016 оноос хойш хурлын тэмдэглэлүүдийг хөтөлж ирсэн ч хэвлэн нийтлээгүй.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хэмжээ, семинар зэрэг хэлбэрээр, голдуу сум, аймгийн түвшинд явагдаж байна. ОУИТБС-д өөрийн тайланг илгээж буй компаниудын тоо хурдтай өсөж буй тул ОТОБ нь ихэнх тохиолдолд тодорхой нэг бүлэгт хандан маш их хэмжээний мэдээллийг бэлтгэн хүргэж байна. 4 аймаг, 12 суманд зориулан ОУИТБС-ын Хураангуй тайланг санаачилгын сүүлийн хоёр тайланд (2013 болон 2014) тулгуурлан гаргасны зэрэгцээ Ажлын алба нь компаниудыг эзэмшиж буй тусгай зөвшөөрлөөр нь газрын зураг хэлбэрээр интерактив мэдээллийг порталд оруулсанаар хэрэглэгчид компанийн төлсөн татвар, хураамжийг байршлаар нь хайх боломжийг олгожээ. Уул уурхайн салбартай холбоотой хэлэлцүүлгүүдэд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцож байна. Анхлан гарч байсан ОУИТБС-ын тайлангуудаар ихээхэн хэмжээний зөрүү илэрч авлигатай холбоотой байж болох мөрдөн шалгалт⁴ хийгдсэний зэрэгцээ тайлангаар илэрч буй зөрүүний хэмжээ тасралтгүй буурч ирсэн нь 2006 онд 4 тэрбум төгрөг байсан (3.52 сая ам доллар⁵) зөрүү 2014 онд 581 сая (322,000 ам доллар⁶) болж буурсанаас харж болно.

Олон нийтэд мэдээлэл түгээх болон зөвлөлдөх арга хэмжээний үеэр олон нийтийн зүгээс орон нутгийн захиргаанд төлж буй шууд төлбөрүүд, лиценз олголт болон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлуудын талаар ихээхэн сонирхож буй юм. 2012 онд Засгийн газрын тогтоол гарсанаар олборлох үйлдвэрлэл бүхий бүх аймаг, сумдад орон нутгийн ОТОБ буюу дэд зөвлөл байгуулах үүргийг ноогдуулсан ч эдгээр орон нутгийн дэд зөвлөлүүдийн санхүүжилтэд зориулан албан ёсоор хөрөнгө хуваарилахгүй байна. Эдгээр ОУИТБС-ын дэд зөвлөлүүдийг дөнгөж байгуулж, сум бүрт хараахан үүсгэн байгуулагдаагүй буй ч үйл ажиллагаа явуулж буй олон сумдад дэд зөвлөл нь сумын орлогын ашиглалтын талаарх гурван талын хэлэлцүүлгийн гол механизм болоод байна. ОУИТБС нь уул уурхайн салбарын удирдлагын талаарх гурван талт хэлэлцүүлгийн платформыг ханган өгч байна. Энэ нь тодорхой нэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээлэл болон уул уурхайн салбараас орох орлогын зарцуулалтын талаарх санаа зовнилоо илэрхийлэх, төр дэхь төлөөлөлд санал хүсэлтээ хүргэх суваг байдлаар ашиглагдаж байна.

Орон нутгийн түвшин дэхь идэвхтэй хэлэлцүүлэг өрнөж буй ч үндэсний түвшинд, Улаанбаатар хотод хийгдэхгүй байна. ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд өндөр түвшний шийдвэр гаргагч нар гишүүнээр ажиллаж буй ч ОУИТБС-ын хэлэлцүүлэг болон бодлого боловсруулах үйл явц хоорондын уялдаа холбоо сул байна. Үүний нэгэн адил олборлох үйлдвэрлэлийн салбар болон иргэний нийгэм ОУИТБС-ын Стандарт дахь төрийн бодлогод тулгараад буй асуудлуудад чухал үүрэг бүхий зүйлс дээр төвлөрөхөөс илүүтэйгээр компаниудын төлсөн төлбөр болон Засгийн газрын хүлээн авсан төлбөр, хураамжийг нэгтгэн тулгахад л гол анхаарлаа хандуулж байна. ОУИТБС-ын Монгол улс дахь хэрэгжилт нь олборлох үйлдвэрлэлийн засаглалын асуудал ихээхэн сонирхол татсан асуудал болох энэхүү улсад ач холбогдолтой үйл явц хэдий ч олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаарх нотолгоонд суурилсан хэлэлцүүлгийг дэмжих бүрэн боломж потенциалыг хараахан бодитоор хэрэгжүүлээгүй байна.

Цаашдын боломжуудыг харвал ОУИТБС-ын тайлагналыг Засгийн газар болон компанийн системд нэвтрүүлэн хэвшүүлэх томоохон орон зай байна. Монгол улсад хэрэгжүүлж буй Цахим тайлагналын системийн хоёрдугаар шат нь ОУИТБС болон голлох төрийн байгууллагууд (татвар, уул уурхай зэрэг асуудлыг хариуцсан) хоорондын мэдээллийн системийг автоматжуулах зорилготой тул ОТОБ болон оролцогч талууд, ялангуяа төрийг төлөөлж буй талууд, чанарын баталгаажилтын үр дүнтэй журам

⁴ <http://ph-eiti.org/document/nw-day-1/Philippines-Manila-Mongolia-EITI-2006-2013.pdf>

⁵ 2006 оны ханшийг oanda.com сайтад мэдээлсэнийн дагуу 1 ам.долларыг 1134 төгрөгийн дундаж ханштайгаар авсан

⁶ 2014 оны ханшийг oanda.com сайтад мэдээлсэнийн дагуу 1 ам.долларыг 1802 төгрөгийн дундаж ханштайгаар авсан

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зааврыг гарган хэрэгжүүлэхэд төвлөрөн ажиллах шаардлагатай байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын хувьд ч ОУИТБС-ын хүрээнд ил тод болгож буй мэдээллийн баталгаажуулалтыг байнгын аудит, нийтэд зориулан гаргах санхүүгийн тайлан зэрэгтэй уялдуулах өргөн боломжуудыг ханган ашиглах шаардлагатай байна.

Зөвлөмжүүд

Доор үргэлжлэн дурдсан буй тайлан нь ОТОБ-ийн зүгээс хэрэгжүүлж болох онцлог шинэтгэлийн талаар зөвлөмжүүдийг багтааснаас гадна доорх хэсэгт Монгол улсын хувьд ОУИТБС-ын илүү үр дүнтэй ашиглахад дэмжлэг болохуйц стратегийн чиглэл бүхий зөвлөмжүүдийг жагсаан орууллаа.

1. ОУИТБС-ын засаглалын институцын бүтэц, бүрэлдэхүүнийг эргэн харж, үйл ажиллагааны түвшин дэхь бүтэц дэхь төлөөллийн тоог бууруулан, энэ шатан дахь хуралдаануудын давтамжийг нэмэгдүүлж, эдгээр хийгдсэн хэлэлцүүлгийн (түр ажлын хэсгүүдийг оруулаад) талаарх тайлагналыг сайжруулах талаар судлан үзэх шаардлагатай байна.
2. Гурван талт оролцогч бүлэг нь олборлох салбарын ямар асуудлыг шийдэхэд, хэрхэн дэмжлэг болох талаар сайтар судлан үзэх шаардлагатай байна. Ингэснээр ОУИТБС-ын зорилтуудыг илүү тодорхой болгож, хянан үзсэн ажлын төлөвлөгөөг тухайн зорилтуудын гүйцэтгэлд хандуулан өөрчлөх хэрэгтэй.
3. Мэдээлэл түгээх болон оролцогч талуудтай зөвлөлдөх механизмуудыг эргэн харж, ОУИТБС-ын хэлэлцүүлэг нь үндэсний хэмжээний зөвлөлдөх, хэлэлцэх арга хэмжээнүүд болон ОТОБ-д шүүд оролцоогүй голлох талуудын гол эрэлт хэрэгцээн дэхь хамаарлыг сайжруулсан байдлаар албан ёсны болгох шаардлагатай.
4. ОТОБ нь төлбөрийн (үүнд мөнгөн бус орлого, тээвэрлэлтийн орлого, бараа солилцоо болон дэд бүтэцтэй холбоотой шилжүүлэг зэрэг мөн багтана) материаллаг байдлын босгыг эргэн харж ил тод болгож буй мэдээллийн иж бүрэн байдал болон тайлангийн чанар хоорондын тэнцлийг хангах нэн шаардлагатай байна. ОТОБ нь хараат бус нэгтгэлтэй холбоотойгоор Үндэсний статистикын хороотой тайлангийн маягтуудад шинэчлэлт хийх журмуудыг гарган, эдгээрийг олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай. ОТОБ нь мөн хараат бус нэгтгэлийн үйл ажиллагаа нь дараагийн ОУИТБС-ын тайланд дээр иж бүрэн байдлын үнэлгээг хийж гүйцэтгэхийг мөн багтаан оруулах хэрэгтэй байна.
5. 2016 оны санхүүгийн жилд хамрах ОУИТБС-ын тайланг бэлтгэхдээ ОТОБ болон Хараат бус нэгтгэгч (аудитор) нь төр болон компаниудын зүгээс гарган өгч буй мэдээллийн чанарын баталгаажилтыг хангахад зориулан бодит, прагматик хандлагыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. ОТОБ Үндэсний аудитын газар (ҮАГ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Хараат бус нэгтгэгч болон олборлох үйлдвэрлэлийн салбарыг ОУИТБС-д төлөөлж буй гишүүдтэй хамтран үр дүнтэй чанарын баталгаажилтын орчин, хүрээллийг бий болгох чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай. ОТОБ нь дараагийн тайлан дээр ажиллах Хараат бус нэгтгэгчийг эртнээс сонгон шалгаруулж, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа эхлэхээс өмнө эдгээр асуудлуудыг судлан үзэх хангалттай хугацаа гарган өгөх шаардлага үүсээд байна.
6. Цаашид гаргах ОУИТБС-ын тайланг бэлтгэхдээ ОТОБ нь тухайн тайлангийн жилд олгосон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрлийн тоог тодорхой болгон, албан ёсны журам заавар, үйл явцаас гажсан арга ажиллагааг тодруулан гаргах шаардлагатай. ОТОБ нь мөн компаниудын зүгээс тусгай

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зөвшөөрөл авах хүсэлт гаргасан огноог дараагийн тайлан гарахаас өмнө олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай. Засгийн газрын зүгээс энэхүү мэдээллийг тусгай зөвшөөрлийн цахим системийн нэг хэсэг болгож ч болох юм.

7. ОУИТБС-ын дараагийн тайланг бэлтгэхдээ ОТОБ нь бенефициар өмчлөлийн талаарх төрийн бодлогын талаар тайланд тодорхой дурдаж, хууль ёсны өмчлөлийн талаарх мэдээллийг тайланд багтаан оруулахыг баталгаажуулах шаардлагатай.
8. Цаашид ОУИТБС-ын тайланг бэлтгэхдээ ОТОБ нь тухайн тайлант жилийн төрийн өмчит компаниудын орлого болон өөрийн хөрөнгөөр хийж буй хөрөнгө оруулалт, төрийн өмчит компани болон салбар компаниуд дээрх төрийн хувь эзэмшилд гарч буй өөрчлөлт зэрэгтэй холбоотой үйл ажиллагааг илүү тодорхой болгож, төр болон төрийн өмчит компаниудын зүгээс уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад олгосон зэээл, зээлийн баталгааны талаар иж бүрнээр хамруулах шаардлагатай байна. Мөн уул уурхайн салбарт ямар нэгэн нөхөн олговор буюу татаас (дотаци), эсвэл олборлох салбар дахь төрийн өмчит компанийн зүгээс төсвийн шинж бүхий ямар нэгэн санхүүгийн зарцуулалт хийж буй эсэх зэргийг харгалзан үзэх шаардлагатай байна.
9. Цаашдын ОУИТБС-ын Тайланг бэлтгэхдээ, өөрийн гаргаж буй мэдээллийн иж бүрэн байдал, үнэн зөв байдалд (найдвартай байдал) Хараат бус нэгтгэгч үнэлгээ хийж, үүнд Хараат бус нэгтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын тойм, тухайн гаргаж буй үнэлгээний хязгаарлалтуудыг дурдаж байхыг ОТОБ анхааран, баталгаажуулж байх хэрэгтэй.
10. Дараагийн ОУИТБС-ын тайланг бэлтгэхдээ ОТОБ нь төрийн өмчит компаниудаас орон нутагт шууд хийгдэж буй төлбөр болон орон нутаг дахь шилжүүлгийг мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө төлбөрийн төрөл хоорондын ялгаа заагийг тодорхой болгосон байх шаардлагатай байна. ОТОБ нь тухайн тайланд аймаг болон сумдад хийгдэж буй уул уурхайн салбарын орлогын шилжүүлгийг харуулах томъёог оруулсанаар орон нутагт төсөвлөсөн болон бодитоор хийгдсэн гүйцэтгэлийн хоорондын зөрүүнд үнэлгээ хийх боломжийг ханган өгөх шаардлагатай.
11. ОУИТБС-ын дараагийн тайланг бэлтгэх мэдээлэл цуглуулах үйл явцыг эхлэхээс өмнө ОТОБ нь заавал болон сайн дурын нийгмийн чиглэлтэй зардлыг тодорхой ялган зааглах талаар зөвшилцсөн байх шаардлагатай. Үүний хүрээнд мөн заавал хийгдэх нийгмийн зардлаас үр шим хүртэгч төрийн бус талуудыг заавал тайлагнах мөнгөн бус нийгмийн зориулалт бүхий төлбөрүүдийг тайлагнах замаар тодруулах шаардлагатай.
12. Монгол улс дахь нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо өндөр буй холбогдуулан ОТОБ нь хүн амын томоохон хэсгийг өөрийн хэлэлцүүлэгт татан оролцуулах сонголтот алтернатив арга замуудыг судлан үзэж болох юм. Нийгмийн сүлжээний аргачлалуудыг ашиглан онлайн хэлбэрээр илүү их мэдээлэл түгээх үйл ажиллагааг явуулсанаар ОУИТБС-тай холбоотой хэлэлцүүлгүүдэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ОУИТБС-ын мэдээллийг шуурхай түгээх, Ажлын төлөвлөгөө болон Жил тутмын тайлан зэрэг гол баримт бичгүүдэд олон нийтийн оролцоог сайжруулах боломжтой болно.
13. Дараагийн жил тутмын үйл ажиллагааны тайланг бэлтгэхдээ ОТОБ нь өргөн хүрээний оролцогч талуудтай зөвлөлдөн ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилт, хэрэгжилтийн үзүүлж буй нөлөөллийн талаар үнэлгээ хийх.
14. ОТОБ нь ОУИТБС-ын тайлангуудад үндэслэн зөвлөмжүүдийг боловсруулан гаргах, эдгээр

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх чиглэлд идэвхтэй үүргийг гүйцэтгэх эсэхийг судлан үзэх шаардлагатай байна.

15. ОТОБ нь цаашид олборлох салбарын ил тод байдлыг төрийн системд нэвтрүүлэн хэвшүүлэх, ОУИТБС-ын мэдээллийг илүү давтамжтайгаар, байнга хэвлэн нийтлэх, түгээх алхамуудыг авч хэрэгжүүлэх нь зөв юм. Цахим тайлагналын төслийн хоёрдахь хэсгийн хүрээнд ОТОБ нь ОУИТБС-ын стандартын дагуу ил тод болгох шаардлагатай ямар мэдээллийг хэдийн олон нийтэд хүртээмжтэй болгосон, ямар мэдээллийг байнга ил тод болгоогүй буй талаар судалгаа хийж болох юм. Мөн ОУИТБС-ын илүү их мэдээллийг нээлттэй мэдээллийн форматтайгаар түгээх боломжуудыг ч мөн судлан үзүүлштэй.

Зураг 1 – Үнэлгээний карт

ОУИТБС-ЫН ШААРДЛАГУУД		Ахицын түвшин				
		Ахиц гараагүй	Ахиц хангалттай бус	Ихээхэн ахиц гарсан	Хангалттай	Шаардлагаас давсан түвшинд хүрсэн
Ангилал	Шаардлагууд					
ОУИТБС-ын процесст тавих	Засгийн газрын оролцоо (#1.1)					
	Компанийн оролцоо (#1.2)					
	Иргэний нийгмийн оролцоо (#1.3)					
	ОТОб-ын удирдлага болон үйл ажиллагаа (#1.4)					
	Ажлын төлөвлөгөө (#1.5)					
Тусгай зөвшөөрөл болон гэрээ	Эрх зүйн орчин (#2.1)					
	Лиценз олголт (#2.2)					
	Лицензийн бүртгэл (#2.3)					
	Гэрээ хэлцлийг ил тод болгох бодлого (#2.4)					
	Бенефициар өмчлөл (#2.5)					
Олборлолтод хяналт тавих	Төрийн оролцоо/эзэмшил (#2.6)					
	Хайгуулын мэдээлэл (#3.1)					
	Олборлолтын мэдээлэл (#3.2)					
Орлого цуглуулах	Экспортын мэдээлэл (#3.3)					
	Иж бүрэн байдал (#4.1)					
	Мөнгөн бус орлого (#4.2)					
	Бартерын зохицуулалт (#4.3)					
	Тээвэрлэлтийн орлого (#4.4)					
	Төрийн өмчит компаниудын шилжүүлэг (#4.5)					
	Орон нутгийн шууд төлбөр (#4.6)					
	Задаргааны түвшин (#4.7)					
Орлогынхуваарилалт	Мэдээллийн цаг хугацаа (#4.8)					
	Мэдээллийн чанар (#4.9)					
Нийгэм-эдийн засгийн хувь нэмэр	Орлогын менежмент болон хуваарилалт (#5.1)					
	Орон нутгийн шилжүүлэг (#5.2)					
	Орлогын зарцуулалт (#5.3)					
Үр дүн ба нөлөө	Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт (#6.1.a)					
	Сайн дураар тайлагнах нийгмийн зарцуулалт (#6.1.b)					
	Төрийн өмчит компаниудын төсвийн шинжтэй зардал (#6.2)					
	Эдийн засагт оруулсан хувь нэмэр (#6.3)					
	Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)					
	Мэдээлэл олдох боломж (#7.2)					
	Зөвлөмжүүдийн биелэлт (#7.3)					
	ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийн үр дүн ба нөлөө (#7.4)					

Танилцуулга

ОУИТБС-д нэгдэн орох шатны тухай товч танилцуулга

2005 оны 10 дугаар сард Монгол улсын парламент болох УИХ-ын Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар Монгол улс ОУИТБС-д нэгдэхийг дэмжиж, Монгол улсын Засгийн газарт тус санаачилгад нэгдэх чиглэлийг өгчээ. 2006 оны 1 дүгээр сарын 4-ны өдрийн Монгол улсын ЗГ-ын хуралдаанаар Монгол улс ОУИТБС-д нэгдэхийг батлан, тогтоол гаргаснаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэлтэй буйгаа баталгаажуулж, зохион байгуулалт, институцын суурийг анхлан тавьсан байна. Монгол улсын Засгийн газрын 2006 оны #1 тоот тогтоолоор ОУИТБС-ын үйл ажиллагааг хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулан, бүрэлдэхүүнийг нь баталжээ. Ерөнхий сайд асан С.Баяр мөн олон тооны хэлсэн үг, ярилцлагадаа ОУИТБС-ын тухай дурдаж, ЗГ-ын 2006 оны #1 дүгээр тогтоол сонингуудад нийтлэгдсэн байна.

Засгийн газрын #1 тоот тогтоолоор ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн төлөөллийг заавал оруулах тухай заасан байна. Үндэсний зөвлөлийн гүйцэтгэх ажлын чиг үүрэгт “Төр, олборлох салбар болон иргэний нийгмийн тэгш төлөөлөлтэй байна” хэмээн заажээ. Улмаар Монгол улсын Засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн хооронд байгуулагдсан Харилцан ойлголцлын санамж бичиг нь хамтран ажиллах Засгийн газрын хүсэл эрмэлзлэлийг бүрэн дүүрэн баталж, ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцогч талуудын бүлгийн гүйцэтгэх 9 үүрэг хариуцлагын жагсаалтыг гарган, бүлэг нэг бүрт (Засгийн газар, иргэний нийгэм болон компаниуд) хамаарах 4 үүргийг мөн тодорхойлжээ.

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн чиг үүргийн 4 дүгээр заалтад дурдсанаар Үндэсний зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд байх юм. Үүний үндсэн дээр Монгол улсын Ерөнхий сайдын Ахлах зөвлөх Б.Эрдэнэсүрэнг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилжээ. Харилцан ойлголцлын санамж бичгийн 10 дугаар зүйлээр мөн ОУИТБС-ын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх Ажлын албыг байгуулсан ба улмаар 2007 он тус Ажлын албыг бодитоор байгуулан ажиллуулж эхэлжээ. ОУИТБС-ын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг (хамаарах төсөв зардал, хэрэгжих хугацааг тусгасан) боловсруулан, 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлуулсан байна. Энэхүү ажлын төлөвлөгөө яам, агентлаг болон ТББ зэрэг нийт 6 байгууллагын вебсайт дээр тавигджээ.

Хэрэгжилтийн зорилтууд болон ажлын төлөвлөгөөнд гарсан ахиц дэвшил

2016 оны ажлын төлөвлөгөөнд дурдсан 4 зорилт⁷ нь ОУИТБС-ын шаардлагуудад нийцсэн бол 2015⁸ болон 2014⁹ онуудын ажлын төлөвлөгөө нь ОУИТБС-ын 7 шаардлагатай ижил байжээ. 2016 онд дэвшүүлсэн зорилтууд нь мөн үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлд нийцсэн, үүнд олборлох салбарын мэдээллийг төрийн байгууллагууд хооронд харилцан уялдуулах, үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах, оролцогч талуудын хоорондын харилцан итгэлцлийг сайжруулах

⁷ Монголын ОУИТБС 2016 оны Ажлын төлөвлөгөө, <http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/wokplanandreport/Mongolia%20EITI%202016%20Workplan%20in%20English.pdf>

⁸ Монголын ОУИТБС 2015 оны Ажлын төлөвлөгөө, <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>

⁹ Монголын ОУИТБС 2014 оны Ажлын төлөвлөгөө, http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITIM_POA_2014en.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зэрэг тэргүүлэх чиглэлтэй байна. Тухайн төлөвлөгөө нь 2015 онд Монгол улсад хийгдсэн түршилтын баталгаажуулалт болон ОУИТБС-ын тайлангуудаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд мониторинг хийсэн тайлан¹⁰ зэрэг ОУИТБС-ын тайлан үнэлгээгээр тогтоосон чадавхийн сул талууд, саад бэрхшээлийг шийдэхүйц үйл ажиллагааг багтаажээ. Үүний тоонд оролцогч талуудад зориулсан сургалтын үйл ажиллагаа, төрийн зүгээс ОУИТБС- гаргасан мэдээлэлд аудит хийлгэх, ОУИТБС-ын мэдээллийн порталыг бусад төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох зэрэг үйл ажиллагаа багтаж байна.¹¹ 2016 оны Ажлын төлөвлөгөө нь мөн ОУИТБС-ын тайлагналын хамрах хүрээ, үүнд тайлан гаргаж буй компанийн тоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын гарган өгсөн мэдээлэлд аудит хийх, уул уурхайн тусгай зөвшөөрөл олгосон огноог ил тод болгох, олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудад судалгаа хийх зэрэг цар хүрээнд хамаарах олон ажлыг тусгасан байна. 2016 оны ажлын төлөвлөгөөний Хэсэг 10.2 нь ОУИТБС-ын тайлан гаргахад тулгарч буй эрх зүйн саад тотгоруудыг даван туулах зорилго бүхий Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төвлөрсөн байна.

2013, 2014, 2015 болон 2016 онуудын ажлын төлөвлөгөө нь үйл ажиллагаа нэг бүрээр хэрэгжих тодорхой цаг хугацааг багтаажээ. 2013 онд ОУИТБС-ын Ажлын албанаас мэдээлсэнээр төлөвлөсөн 42 ажлын 33 (80%) хэрэгжсэн бол хэрэгжээгүй үйл ажиллагааны хамгийн гол нь “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хуулийг батлуулах болон телевизийн цуврал бүтээх зэрэг ажлууд байв¹². 2014 онд ажлын албанаас тайлагнаснаар нийт төлөвлөсөн 65 ажлын 42 (65%) нь бүрэн хэрэгжсэн бөгөөд төлөвлөсөн гол ажлаас Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, бүсийн бага хурал зохион байгуулах, телевизийн цувралыг нэвтрүүлэх зэрэг ажлууд биелээгүй ажээ.¹³ Харин 2015 оны байдлаар төлөвлөсөн 50 ажлын 47 нь биелжээ.¹⁴ ОУИТБС-ын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэх, хуулийн төслийг батлагдсаны дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд, хандив тусламж, хөрөнгө оруулалтын талаарх хэлэлцүүлэг хийх зэрэг ажлууд биелээгүй байна.

ОУИТБС-ын тайлагналын түүх

2006- 2014 оны санхүүгийн жилд Монгол улс нь ОУИТБС-ын нийт 9 тайланг бэлтгэн гаргасан бөгөөд одоогоор 2015 оны санхүүгийн жилд хамаарах 10 дахь тайланг бэлтгэж байна. 2006 оны анхны тайлан нь уул уурхайн 35 компанийн гарган өгсөн мэдээллээс бүрдэж байсан бол 2013 оны санхүүгийн жил нийт уул уурхай, газрын тос болон байгалийн хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1198 компани тайлан гаргасан байна. 2008-аас 2011 оны хооронд Монгол улс нь ОУИТБС-ын тайланг хоёр жилийн хоцрогдолтой гаргаж байжээ (Жишээ нь 2009 оны тайланг 2011 гаргах мэтээр). Гэхдээ 2012 онд ОТОБ нь ОУИТБС-ын 2010 болон 2011 оны хоёр тайланг багтаан гаргаснаас хойш ОУИТБС-ын тайланг нэг жилийн хоцрогдолтой гаргах болжээ (2014 тайланг 2015 оны 12 дугаар сард нийтэлсэн). Эдгээр тайлангуудын тухай нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт Г дээр харуулсан.

¹⁰ ОУИТБС-ын Ажлын албанаас гарган өгсөн, хэвлэн нийтлэгдээгүй.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Анхлан ОУИТБС-ын тайлан гаргах 4 маягыг боловсруулан, Үндэсний статистикийн хорооны дарга болон Сангийн сайдын 2007 оны 4 дүгээр сард хамтарсан тушаалаар батлан, улмаар 2008 оны 3 дугаар сард эргэн харж, дараа нь 2011 онд нэмэлт өөрчлөлт хийж, нийт 7 маягт болгон нэмэгдүүлжээ. Мөн маягтуудыг 2014 оны 1 дүгээр сар болон 2015 оны 12 дугаар саруудад эргэн харж Монгол улсын олборлох салбарын бүхий бүх материаллаг төлбөр, орлогыг хамруулжээ.

Төр, иргэний нийгэм болон компаниудын оролцооны тойм

Одоогийн ОТОБ болон Үндэсний зөвлөл нь 2006 оны 5 дугаар сард батлагдаж, улмаар цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэж байсан (хамгийн сүүлд 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр шинэчлэгдсэн¹⁵) Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны журмын хүрээнд ажиллаж байна. ОТОБ-гийн гишүүд жилд 2-3 удаа цуглан хуралдаж буй бол Үндэсний зөвлөлийн хуралдаан жилд нэг удаа болж байна. Хурлуудын тэмдэглэлийг Монголын ОУИТБС-ын вебсайт дээр нийтэлж байна. ОТОБ нь хэд хэдэн түр ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан ч тухайн ажлын хэсгүүдийн Гүйцэтгэх ажлын тодорхойлолт/даалгавар байхгүй, ажлын хэсгүүдийн хуралдааны тэмдэглэлүүдийг хэвлэн нийтлээгүй байна. Одоо ажиллаж буй ОТОБ болон Үндэсний зөвлөлийн гишүүдийн жагсаалтыг Хавсралт А дээр тусгасан.¹⁶

Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн анхдагч үе шатууд нь хурдан шуурхай үйл ажиллагаа болон хүртээмжтэй байдлаараа онцлог байна. Сүүл үедээ ялангуяа 2012 оноос хойш ОТОБ болон Үндэсний зөвлөлийн гишүүдийн хурлын оролцоо нь тогтворгүй болж иржээ. Ялангуяа төр болон иргэний нийгмийг төлөөлөн сонгогдсон гишүүд өөрсдөө бус өөрийн төлөөллийг орондоо оролцуулах болсон нь түр орлох этгээдийг томилох нь тэр бүр нийцтэй байхаа больсон байна. Мөн байнга өрнөж буй улс төрийн хүрээнд дэх өөрчлөлт нь Үндэсний зөвлөлийн уулзалтуудыг зохион байгуулахад нөлөөлж буй бөгөөд жишээ нь Ерөнхий сайд болон Сангийн сайд нар 2011 оноос хойш Үндэсний зөвлөлийн хуралд биечлэн оролцоогүй ажээ. Үндэсний зөвлөл нь 2014 онд огт хуралдаан хийгээгүй (хэдий 2015 онд 2 удаа хуралдсан ч) бөгөөд учир нь ОТОБ-ийн дарга нь зургаан сарын түршид үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн байжээ. Гэсэн ч төрийн голлох агентлагууд, компаниуд (ихэнхдээ томоохон) болон олборлох салбарт ажиллаж буй иргэний нийгмийн бүлгүүд нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцож иржээ.

Олборлох салбарын гол онцлогууд

Дэлхийн Банкны мэдээллээс үзвэл¹⁷, Монгол улсад 80 гаруй эрдэс агуулсан 6000 гаруй орд газар байна. Эдгээрийн тоонд дэлхийд хоёрдугаарт орох зэсийн нөөц болон дэлхийн 4 дүгээр эрэмбэлэгдэх нүүрсний орд багтаж байна. Монгол улс нь мөн алт, төмрийн хүдэр, цайр, уран, жонш болон газрын тосны томоохон нөөц бүхий улс юм. Тус улсад хайгуулын үйл ажиллагаа бүрэн хийгдээгүй, одоогоор дөнгөж 400 гаруй орд газар тогтоогдсноос 160 дээр нь олборлолт хийгдэж байна. Уул уурхайн салбар нь тус улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч бөгөөд 2014 оны байдлаар уул уурхайн салбар нь ДНБ-ний 17.1%, төсвийн орлогын 25.8%, экспортын орлогын 89%-ийг бүрдүүлж байна.¹⁸ Голлох экспорт нь зэс, алт, молибден, нүүрс, төмрийн хүдэр, жоншны баяжмал

¹⁵ Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны журмыг санаачилгын вебсайт дээрээс үзэж болно (http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITI_National_Council_TOR_in_English.pdf)

¹⁷ 34 (х.20) Дэлхийн Банк (2007/11), Өсөлтийн индикатор: Монголбн кейс - <http://siteresources.worldbank.org/INTDEBTDEPT/Resources/468980-1206974166266/4833916-1206974192224/lanchovichinaGooptuwps4396.pdf>

¹⁸ Монголын ОУИТБС-ын 2014 оны тайлан.

болон түүхий газрын тос зэрэг бүтээгдэхүүнээс бүрдэж буй юм.

2009 оноос Хятад руу хийгдэх коксжих нүүрсний экспорт ихээхэн нэмэгдсэн нь Монгол улсын энэхүү супер циклын оргил үеээс эхэлсэн эрдэс бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдалд хөтөлсөн билээ. Зэс нь урт хугацаанд Монгол улсын гол экспортын бүтээгдэхүүн байсан бөгөөд 1974 онд нээгдсэн Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр нь 2006 оныг хүртэл ДНБ-ний 40 орчим хувийг бүрдүүлж байв. Эрчим хүчний нүүрсний хувьд төрийн өмчийн оролцоо бүхий Багануур болон Шивээ Овоо зэрэг уурхайд нүүрс олборлон, үйл ажиллагаа явуулж буй 4 цахилгаан станцыг хангадаг бол 100 000 гаруй албан бус ашигт малтмал олборлогчид (нинжа) орлого багатай, гэр хорооллын хэрэгцээг хангаж байна. 2000 оны дунд үеэс эхлэн МАК болон ЭмСиЭс зэрэг Монголын үндэсний уул уурхайн компаниуд боловсруулаагүй түүхий коксжих нүүрс Хятад улс руу экспортлож эхэлсэн бол 2009 оноос эхлэн төмрийн хүдрийн экспорт эхэлжээ. Үйлдвэрлэлийн хэмжээгээр зэсийн үйлдвэрлэл бууран хоёрдугаарт бичигдэх болсон нь Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ 2012 онд 517,000 тонн болж буурсантай холбоотой бол алтны үйлдвэрлэл 2009-2011 онуудад шороон ордод олборлолт хийхийг хориглосон, Бороогийн уурхайн нөөц буурсан зэргээс үүдэн 5703 кг хүртэл буурчээ.

2008-аас 2011 оны хооронд нүүрс олборлолт гурав дахин өсөж, ихэнх хэсгийг нь БНХАУ-д экспортлож байв. Нүүрсний салбарын өсөлттэй зэрэгцэн Рио Тинтогын 6.2 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт бүхий Оюу Толгойн зэс-алтны уурхай 2009 оноос үйл ажиллагаа эхлүүлэн тус улсын эдийн засгийн өсөлтийг дэлхийд тэрүүлэх өндөр хэмжээнд буюу 2011 онд 17.3%, 2012 онд 12.3% хүргэжээ. 2012 оны 5 дугар сард гадаадын хөрөнгө оруулалтын эсрэг гэж тооцогдох шинэ хууль гарсан хугацаа нь бараа бүтээгдэхүүний үнийн уналт болон эрэлт буурсантай зэрэгцэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, эдийн засгийн өсөлт удаашрах болжээ. Монгол улсын хувьд өөрийн нүүрсний бодлогын талаар, ялангуяа 7.42 тонн тэрбум эрчим хүчний 1.4 тэрбум тонн коксжих нүүрсний нөөц төрийн өмчит Эрдэнэс Таван Толгой компанийн мэдэлд буй Таван Толгойн уурхайтай холбоотой асуудлаар эргэлзээтэй мессежийг дэлхий дахинд илгээсэн юм. БНХАУ-д хийгдэх коксжих нүүрсний экспортын оргил үе болох 2011- 2012 онуудад Засгийн газрын хувьд үндсэн бодлогодоо өөрчлөлт гаргаснаар хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлэх болжээ. 2011 онд АНУ-ын Пийбоди, Шенхуа болон Оросын төмөр замын хамтарсан консорциумд олгосон Таван Толгойн ордыг ашиглах эрхийг цуцалсан бөгөөд Хятад болон Солонгосын талуудын зүгээс шалгараагүй хэмээн гомдол гаргаснаас үүдэн энэхүү байдал үүсжээ. Ингэснээр төрийн өмчит Эрдэнэс Таван Толгой компани оператор компаниудтай гэрээ хийн, Баруун болон Зүүн Цанхи дээр олборлолт хийж буй цорын ганц компани болжээ. Хэдий дэд бүтцийн хувьд хүндрэлтэй буй ч зэсийн экспорт жил тутам 30 орчим хувиар нэмэгдэж, улмаар Оюу Толгойн уурхайн экспорт Эрдэнэтийг давж гарах болжээ. Хайгуулын үйл ажиллагаа ч үндсэндээ зэс дээр төвлөрч байна. Хэдийгээр үнэ нь бүрэлтэй байсан ч металлургын эрдсийн БНХАУ-д хийх экспорт байнга өсөлттэй байв.

Засгийн газрын зүгээс эдийн засгийн өсөлтийг төсвийн зарцуулалтаар дамжуулан тогтвортой хадгалж байсан ч 2015 онд гэхэд ДНБ дөнгөж 2.3% өсөж, төсвийн хүндрэлтэй нүүр тулгараад байна (2016 онд ДНБ бүтээгдэхүүний өсөлт 1%-иас бага байна хэмээн тооцож байна)¹⁹. Дээрх шалтгаанаас үүдэн Монгол улсын эдийн засаг хүндрэлтэй нүүр тулах болжээ. 2014 оны 1 дүгээр сард Эрдэс баялагийн салбар дахь төрийн бодлогыг батлан гаргаж, үүний зэрэгцээ Ашигт малтмалын болон Газрын тосны хуулиудад тодорхой өөрчлөлтүүдийг 2014 оны 6 дугаар сард хийжээ. Эдгээр

¹⁹ <http://www.adb.org/countries/mongolia/economy>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зохицуулалтууд нь үндсэндээ тусгай зөвшөөрөл олголт болон үүл уурхайн үйл ажиллагааны байгаль орчны тал дээр түлхүү төвлөрсөн байна. 2014 оны 1 дүгээр сард Ашигт малтмалын хуулинд хийсэн өөрчлөлтөөр алтан дээр тогтоосон байсан 5%-ийн рояалтыг бууруулан зах зээлийн үнээс хамааран 1-5%-ийн шатлалтай болгон, Монгол Банкнд худалдсан алтанд 2.5%-ийн рояалти авах болсон нь нөөц өсгөх зорилго бүхий арга хэмжээ байв. 2016 оны 6 дугаар сард болсон хууль тогтоох байгууллагын сонгуулиар өмнө нь 2012 оныг хүртэл засгийн эрх барьж байсан Монгол ардын нам (хуучин Монгол Ардын Хувьсгалт Нам) ялжээ²⁰

Баталгаажуулалтын үйл явцын талаарх тайлбар

ОУИТБС-ын Олон улсын Удирдах хороо Норвегийн Осло хотод болсон өөрийн 33 дугаар хуралдаанаар Монгол улсыг оруулаад нийт 15 улсад 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн баталгаажуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх шийдвэр гаргасан юм.

1. Баталгаажуулалт нь ОУИТБС-ын чухал нэгэн хэсэг юм. Энэхүү үйл явц нь тухайн улс дахь ОУИТБС-ын хэрэгжилт нь Стандартын заалтуудад нийцэж буй эсэх дээр хөндлөнгийн үнэлгээг бүх оролцогч талуудад гарган өгөх зорилготой. Түүнчлэн Баталгаажуулалтын тайлан нь тухайн баталгаажуулалтад хамрагдаж буй орон дахь ОУИТБС-ын үзүүлж буй нөлөө, Стандартын дагуух үйл ажиллагааны хэрэгжилт, хэрэгжилтээс авсан сургамж болон оролцогч талуудын зүгээс илэрхийлсэн асуудлууд, ОУИТБС-ын цаашдын хэрэгжилтэд зориулан талуудын гаргасан зөвлөмж зэргийг багтаадаг.

Баталгаажуулалтын үйл явцын талаар ОУИТБС-ын Стандартын Бүлэг 4: Баталгаажуулалт хэсэг дээр дурдсан²¹.

2. Баталгаажуулалтын үйл явц. 2016 оны 2 дугаар сард ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь шинэчлэгдсэн Баталгаажуулалтын системийг батлан гаргасан. Энэхүү шинэ систем нь доор дурдсан гурван үе шаттай байна:

1. Олон улсын Ажлын албаны зүгээс мэдээлэл цуглуулах
2. Өөрийн ажлаа Олон улсын Удирдах зөвлөлд шууд тайлагнах хараат бус Баталгаажуулагчийн хийх чанарын баталгаажилтын үйл ажиллагаа
3. Удирдах зөвлөлийн шийдвэр.

2016 оны 5 дугаар сард Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын шаардлагуудыг үнэлэх дэлгэрэнгүй зааварчилгааг агуулсан [Баталгаажуулалтын журмыг](#) гаргасан. Үүний зэрэгцээ Удирдах зөвлөл нь мөн Олон улсын Ажлын албаны зүгээс мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх стандарчлагдсан үйл явцыг заасан [Баталгаажуулалтын үйл явц](#) болон Баталгаажуулагчийн стандартчилагдсан Ажлын удирдамжийг мөн гаргасан юм. Өмнөхийн адил доор дурдсанчлан талуудын оролцооны өргөн боломжийг хангажээ.

Баталгаажуулалтын журамд “ОТОб-ийн зүгээс баталгаажуулалтын хүрээнд тодорхой зорилт эсвэл үйл ажиллагааг үнэлэхэд онцгойлон анхаарал хандуулахыг хүсэх тохиолдолд энэ талаар ОТОб-ын хүсэлт гаргасны дагуу хийнэ” хэмээн заажээ. Монголын ОУИТБС-ын ОТОб нь Цахим тайлагнал болон орон нутгийн хэрэгжилт гэсэн асуудлууд дээр тусгайлан харгалзан үзэж, анхаарах хүсэлтийг гаргасан юм.

²⁰ Файнаншл Таймс (30 June 2016), “Mongolia opposition scores landslide election victory”, <http://www.ft.com/cms/s/0/fc03c8c8-3e66-11e6-8716-a4a71e8140b0.html#axzz4DRX5OA7M>

²¹ <https://eiti.org/validation> хаягаар мөн үзнэ үү.

3. Олон улсын Ажлын албанаас мэдээлэл цуглуулах. [Баталгаажуулалтын журмын](#) дагуу, Олон улсын ажлын албаны үйл ажиллагаа нь гурван үе шаттайгаар явагдсан:

1. Баримт бичгийн судалгаа. 2016 оны 6 дугаар сарын 4-17-ний өдрүүдэд болон 7 дугаар сарын эхэнд Олон улсын ажлын алба нь тухайн улсын ОУИТБС-ын Стандартуудын хэрэгжилтийн талаарх боломжит баримт бичигт судалгаа хийсэн бөгөөд эдгээрийн тоонд доор дурдсан баримт бичгүүд багтсан:

- ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө болон төсөв, мэдээлэл, харилцаа холбооны төлөвлөгөө зэрэг бусад төлөвлөлтийн баримт бичгүүд;
- ОТОБ-ийн ажлын журам, Гүйцэтгэх ажлын тодорхойлолт, хурлын тэмдэглэлүүд;
- ОУИТБС-ын тайлангууд болон тойм тайлан болон цар хүрээ тогтоох судалгаа зэрэг нэмэлт мэдээлэл;
- Мэдээлэл, харилцаа холбооны материалууд;
- Жилийн тайлан; болон
- ОУИТБС-ын хэрэгжилт, баталгаажуулалттай хамаарал бүхий бусад мэдээлэл.

Энэхүү ажил нь хамааралтай хэмээн өөрсдийн үзсэн асуудлаар ямар нэгэн баримт бичиг, мэдээлэл танилцуулахаар уригдсан оролцогч талуудтай хийх анхдагч хэлэлцүүлгийг мөн багтаасан. [Үнэлгээний журмын](#) дагуу олон улсын Ажлын алба нь 2016 оны 7 дугаар сарын нэгний өдөр буюу баталгаажуулалт эхэлсэн өдрөөс хойш хийж гүйцэтгэсэн ямар нэгэн үйл ажиллагааг баталгаажуулалтын энэхүү хэсэгт хамруулаагүй болно.

2. Газар дээр ажиллах. Монгол улсад Олон улсын Ажлын албаны төлөөлөгч 2016 оны 7 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд ажилласан. Энэхүү айлчлал нь 2016 оны 7 дугаар сарын 15-16-ны өдөр Монгол улсад зохион байгуулагдсан АСЕМ-ын дээд хэмжээний үулзалтын²² өмнөх хуралдаанууд болох иргэний нийгмийн чиглэлийн Ази-Европын ард түмний чүүлгантай²³ давхцсан. Тухайн хугацаанд энэхүү олон улсын арга хэмжээ зохион байгуулагдаж байсан нь төрийн байгууллагуудыг төлөөлөх оролцогч талуудтай биечлэн үулзах боломжийг хязгаарлаж байсан ч иргэний нийгмийн байгууллагуудын олон тооны төлөөлөлтэй үулзан, санал бодол солилцох өргөн боломжийг нээн өгсөн билээ. Энэхүү айлчлалын дараа 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монгол улсын УИХ-ын сонгууль болсон. Айлчлалын хүрээнд хийгдсэн бүхий л үулзалтууд Улаанбаатар хотод хийгдсэн. Олон улсын ажлын алба нь ОТОБ болон бүлгийн гишүүдтэй, Хараат бус нэгтгэгч болон бусад голлох оролцогч талуудтай үулзсан бөгөөд үүний зэрэгцээ оролцогч талуудын бүлэгт хамаарах шаардлагатай ч бүрэн хэмжээгээр, шууд байдлаар хамрагдаж ажиллахгүй буй тухайн талуудын төлөөлөлтэй мөн үулзсан болно.

ОТОБ-тэй хийсэн үулзалтаас гадна Ажлын албаны төлөөлөл нь тус бүлгийн гишүүдтэй (төр, компани болон иргэний нийгэм) мөн тусгайлан үулзалтуудыг ганчаарлан болон бүлэг байдлаар хийж, энэхүү арга хэмжээний үеэр оролцогч талууд өөрийн санал бодлыг бүрэн илэрхийлэх боломжийг ханган ажилласан. Мөн тухайн ярилцсан зүйлсийн нууцлалыг хадгалах тухай гаргасан хүсэлтийг мөн хүндэтгэн, даган мөрдсөн.

²² <http://www.aseminfoboard.org/events/11th-asem-summit-asem11>

²³ <http://www.aepf.info/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Уулзах шаардлагатай оролцогч талуудын нэрсийг жагсаалтыг Монголын ОУИТБС-аас гарган өгсөн бөгөөд үүнд мөн Олон улсын Ажлын алба өөрийн санал, тайлбарыг өгч эцэслэсэн. Олон улсын Ажлын алба нь хамаарах бүхий л оролцогч талуудтай уулзан санал солилцох бүхий л арга хэмжээг авсан ч Монголын ОУИТБС-ын ОТОБ-ийн гишүүн зарим төрийн байгууллага болон компаниудын төлөөлөл энэхүү уулзалтад оролцоогүй. Түүнчлэн ОУИТБС-ын тэргүүлэгч талтай уулзахаар Олон улсын Ажлын албаны зүгээс гаргасан хүсэлт биелэгдээгүй. Гэсэн ч Ажлын албаны зүгээс энэхүү баталгаажуулалтын тайлан нь ОУИТБС-ын үйл явцад оролцож буй голлох талуудын үзэл бодлыг тусгасан хэмээн үзэж байна.

7 дугаар сард хийсэн анхны айлчлалын үеэр орчуулагчаар х. А.Нургүл²⁴ ажилласан бөгөөд орчуулагчаар дамжуулан үйл ажиллагаа явуулахад Үндэсний зөвлөл болон ОТОБ-т хамаарах гурван тал татгалзаагүй.

3. Тавигдаж буй шаардлагуудыг хангах чиглэлд гарсан ахиц дэвшлийн тайлан. Дээр дурдсан зөвлөлдөх арга хэмжээний үр дүнд үндэслэн Олон улсын Ажлын алба нь энэхүү тайланг бэлтгэн гаргасан бөгөөд Баталгаажуулалтын журмын дагуу тавигдаж буй шаардлагуудыг биелүүлэхэд гарсан ахиц дэвшлийн талаарх анхдагч үнэлгээг хийсэн болно. Үнэлгээний журмын дагуу энэхүү тайлан нь шаардлагуудыг даган мөрдөж, биелүүлж буй талаарх эцсийн нэгдсэн дүгнэлтийг хийгээгүй болно. Хараат бус баталгаажуулагчийн зүгээс чанарын баталгаажилт хийхээс өмнө тайланг ОТОБ-т гарган өгч санал авна.

Олон улсын ажлын албаны баг нь Сэм Бартлетт (Sam Bartlett), Дивеке Роган (Dyveke Rogan), Татьяна Седова (Tatiana Sedova) болон Алекс Горди (Alex Gordy) нараас бүрдэж байна.

4. Хараат бус баталгаажуулалт. ОУИТБС-ын Стандартын дагуу ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь Баталгаажуулалтын хороогоор дамжуулан өөрийн ажлын үр дүнг Удирдах зөвлөлд тайлагнах үүрэг бүхий Баталгаажуулагчийг²⁵ томилон ажиллуулна. Тухайн томилогдсон Баталгаажуулагч нь Ажлын албанаас хийсэн анхдагч мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь Баталгаажуулалтын зааварчилгааны дагуу хийгдсэн эсэхийг үнэлнэ. Үүнд: шаардлага нэг бүрээр хамаарах бичиг баримтуудыг судлах нарийвчилсан бичиг баримтын судалгаа, шаардлага нэг бүрээр Ажлын албанаас хийх анхан шатны үнэлгээ, болон газар дээр нь судлан шалгах эрсдэлд суурилсан хандлага болон оролцогч талуудтай зөвлөлдөх зэрэг арга хэмжээ багтана. Удирдах зөвлөлийн зүгээс тодорхой шаардлагууд дээр Баталгаажуулагчид хандан газар дээр нь шалгах хүсэлт гаргаж болно. Баталгаажуулагч нь шаардлагатай тохиолдолд Ажлын албаны гаргасан тайлан дээр нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл тайлбар гаргана. Улмаар Баталгаажуулагч нь Удирдах зөвлөлд хүргүүлэх тайлангийн товч тоймыг (Баталгаажуулалтын тайлан) бэлтгэн гаргана. Энэхүү тайланд заалт нэг бүрээр ханган биелүүлж буй талаарх Баталгаажуулагчийн үнэлгээ агуулагдах бөгөөд харин даган мөрдөж буй эсэх дээрх нэгдсэн дүгнэлтийг энэхүү тайланд тусгахгүй. Дараагаар нь тухайн улсын ОТОБ-т хандан Баталгаажуулалтын тайланд хамаарах өөрсдийн саналыг ирүүлэх хүсэлтийг гаргах юм.

5. Удирдах зөвлөл судлан үзэх болон шийдвэр гаргах. Үйл явцын эцсийн шат нь ОУИТБС-ын Удирдах зөвлөл баталгаажуулалтын тайланг судлан үзэж, эцсийн шийдвэрийг гаргах юм. Баталгаажуулалтын хороо нь Баталгаажуулагчийн гаргасан үнэлгээ болон ОТОБ-ээс өгсөн бусад санал зэргийг хянан үзнэ. Баталгаажуулалтын хороо нь тухайн улсын ОУИТБС-ын шаардлагуудыг

²⁴ Утас: М: +976 99187463, E: Jltka2002@yahoo.com

²⁵ Тайлан бэлтгэн гаргах үеэр сонгон шалгаруулалтын үйл явц үргэлжлэн явагдаж байсан, <https://eiti.org/node/7118> хаягаар үзнэ үү.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

даган мөрдөж, биелүүлж буй талаарх өөрийн зөвлөмжийг ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хүргүүлнэ. Удирдах зөвлөл нь шаардлагуудыг хангаж буй эсвэл хангаагүй эсэх, мөн тухайн улсын нийт биелэлт, даган мөрдөлтийг тодорхойлох эцсийн шийдвэрийг ОУИТБС-ын Стандартын 8.3.a.ii заалтын дагуу гаргана. Шаардлага 8.8 дээр заасны дагуу гаргасан шийдвэрийг давж заалдах үйл явц мөн байна.

Хэсэг I – ОТОБ-ийн хяналт

1. ОТОБ-ийн хяналт

1.1 Тойм

Энэ бүлэг нь ОУИТБС-ын үйл явц дахь төрийн оролцоо, хяналт, оролцогч талуудын оролцоо, ОУИТБС-ын хэрэгжүүлэх орчин болон ОТОБ-ын үйл ажиллагаа, ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөтэй холбоотой хэсгүүдийг агуулсан.

1.2 Үнэлгээ

ОУИТБС-ын үйл явц дахь Засгийн газрын оролцоо (#1.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Монгол улс нь 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Осло хотод болон Олон улсын удирдах хорооны 3 дугаар хуралдаанаар ОУИТБС-ын нэр дэвшигч орон хэмээх статусыг авсан анхны 15 орны нэг юм.²⁶ Монгол улсын Засгийн газар нь 2006 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр #1 тоот тогтоол гарган ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрмэлзлэлтэй буйгаа зарласнаас хойш ОУИТБС-ын үйл ажиллагааг дэмжин ажиллаж иржээ. Засгийн газрын зүгээс ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр өөрийн эрмэлзлэлийг хэд хэдэн удаа илэрхийлж ирсэн бөгөөд үүний жишээнд 2015 оны 11 дүгээр сарын 3-ний өдөр зохион байгуулагдсан Үндэсний форум дээр Уул уурхайн сайд Р.Жигжид “Монгол улс нь ОУИТБС-ыг салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг татахад чухал үүргийг гүйцэтгэнэ хэмээн үзэж буй бөгөөд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байна” хэмээн мэдэгдэж байв²⁷. Мөн Үндэсний форумын танилцуулга товхимол дээр Монгол улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Монгол улс нь ОУИТБС-ын тогтолцоо болон үнэт зүйлийг бүрэн хүлээн зөвшөөрч, Засгийн газрын зүгээс шинээр хуулийн төсөл боловсруулан УИХ-д өргөн бариад байна” хэмээн дурдсан байна²⁸. 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдөр шинээр томилогдсон УИХ-ын дарга М.Энхболд (МАН-ын дарга²⁹) 2006-2007 онуудад Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааныг даргалан хийлгэж байсан ба тэрээр ОУИТБС-ыг дэмжигч хэмээн иргэний нийгэм үзэж байна.

Монголын ОУИТБС-ын хэрэгжилтийн талаарх гурван талын харилцан ойлголцлын санамж бичигт талууд 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан бөгөөд энэхүү баримт бичигт Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах бүх талуудын үйл ажиллагааны зөвлөмжийг багтаасан байна.³⁰ 2006 онд тухайн үеийн Ерөнхий сайд М.Энхболд Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн даргаар томилогдон, ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан явуулах болсон байна. Улмаар Сангийн сайд болон Уул уурхайн сайд нарыг Үндэсний зөвлөлийн дэд даргаар томилон, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ОТОБ-ын даргаар Ерөнхий сайдын ахлах зөвлөх Д.Батбаяр ажиллаж эхэлжээ.

ОУИТБС-ын үйл ажиллагааг хянан зохицуулах үүрэг бүхий өндөр түвшний удирдах хороо болох

²⁶ <https://eiti.org/node/7171>

²⁷ ОУИТБС-ын Үндэсний форумын тэмдэглэл, 2015 оны 11 дүгээр сарын 3 <http://www.eitimongolia.mn/en/node/4879>.

²⁸ Үндэсний форумын товхимолыг үзнэ үү 2015/11/3.

²⁹ Lee Cashell (6 July 2016), ‘Mongolia’s election – a protest vote for good’, <http://blogs.ft.com/beyond-brics/2016/07/06/mongolias-election-a-protest-vote-for-the-good/>

³⁰ ОУИТБС-ын вебсайт дээр буй (http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/MoU_Mongolia_EITI.pdf).

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Үндэсний зөвлөл болон ОУИТБС-ын стандартуудын хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах эрх бүхий зохицуулах чиг үүрэгтэй зөвлөлдөх бүтэц болох ОТОБ-т төр засгийн өндөр албан тушаалтнууд сонгогдон ажиллаж эхэлжээ. Үндэсний зөвлөл дэхь төрийн төлөөлөлд Ерөнхий сайд, Уул уурхайн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн сайд, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга, Монгол улсын Ерөнхий аудитор, Үндэсний статистикын хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дарга болон Төв аймгийн Засаг дарга зэрэг албан тушаалтан багтаж байна³¹. Харин ОТОБ дэхь төрийн байгууллагын төлөөлөлд Ерөнхий сайдын Ахлах зөвлөх, Татварын ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Ашигт малтмалын газрын дарга, Газрын тосны газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэсийн дарга, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга, Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яамны Байгалийн нөөцийн газрын дарга болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч нар багтаж байна³².

Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн анхдагч үе нь эрч хүч болон хүртээмжээр онцлог байжээ. Саяхан буюу үндсэндээ 2012 оноос хойш Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын гишүүдийн оролцоо бүүрч иржээ. Тодорхой хэлбэл иргэний нийгмийн байгууллагууд, төрийн төлөөлөл болох гишүүд биечлэн хуралд оролцох нь цөөрч, өөрсдийн өмнөөс бусад ажилтнаа томилон илгээх болсон ба ийнхүү түр орлон оролцох хүнийг сонгохдоо ч тогтвортой бус, янз бүрийн ажилтныг томилон явуулж байна. Хэдийгээр шийдвэр гаргах болон хяналтын чиг үүргийг Үндэсний зөвлөл хэрэгжүүлж буй ч улс төрийн хүрээнд ойр давтамжтайгаар гарч буй өөрчлөлтүүд нь мөн Үндэсний зөвлөлийн хуралдаануудыг зохион байгуулахад нөлөөлж байна. Жишээ нь 2012 оноос хойш ажилласан Ерөнхий сайд болон Сангийн сайд нар Үндэсний зөвлөлийн хуралд биечлэн оролцож байгаагүй ажээ. 2014 онд Үндэсний зөвлөлийн хуралдаан хийгдээгүй (хэдий 2015 онд 2 удаа хуралдсан ч) бөгөөд учир нь шинэ засгийн газар байгуулах ажил удаашран, саатсанаас үүдэн ОТОБ-ийн дарга байхгүй байж, Засгийн газар бүрдэж дуусах хүртэл шинэ дарга томилогдоогүй байна. Гэсэн ч ОУИТБС-ын үйл ажиллагаанд төрийн голлох байгууллагуудын төлөөлөл оролцоор иржээ.

ОУИТБС-ын зүгээс ихээхэн дэмждэг ил тод байдлыг төрийн тогтолцоонд уялдуулан, хэвшүүлэхийн тулд Засгийн газрын хувьд урт замыг түүлжээ. 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын #80 дугаар тогтоолоор ОУИТБС дахь төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгон тогтоосон байна. Энэхүү тогтоолд мөн 2011 онд гарсан ОУИТБС-ын журмуудад хийсэн өөрчлөлтийг тусган нэмэлт өөрчлөлт оруулж 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Засгийн гарын #222 тоот тогтоолыг шинээр гарган төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг дахин тодорхойлсон байна. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-нээс³³ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бол Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс³⁴, Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрөөс³⁵ эхлэн хэрэгжиж эхэлжээ.

ОУИТБС-ын стандартад шаардсан мэдээллийг тодорхой төрийн байгууллагууд байнга ил тод болгож

³¹ ҮЗ-ийн гишүүдийн нэр, Хавсралт А.

³² ОТОБ-ийн гишүүдийн нэрс, Хавсралт А.

³³ <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un-dpadm/unpan047231.pdf>

³⁴ http://www.iaac.mn/pdf/law_en/8_on_glass_accounts.pdf

³⁵ Хуулийн тойм <http://www.ashidavocates.mn/files/publications/transparency%20law%20implementation%20rules.pdf> and [http://www.ey.com/Publication/vwLUAssets/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003/\\$FILE/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003.pdf](http://www.ey.com/Publication/vwLUAssets/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003/$FILE/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003.pdf)

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

байна. Жишээ нь Сангийн Яам аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон ашигт малтмалын нөөцийн төлбөрийн нэгдсэн дүнг улирал тутам мэдээлдэг тусдаа вебсайтыг³⁶ ажиллуулж байна. Сангийн яам нь мөн цахим тайлангийг веб хуудас³⁷ ажиллуулахын зэрэгцээ өөрийн вебсайт дээр Ил тод байдал³⁸ гэсэн хэсгийг мөн ажиллуулж буй юм. 2013 оны 2 дугаар улирлаас хойш Ашигт малтмалын газар нь бүтээгдэхүүн нэг бүрээр үйлдвэрлэлийн тоо хэмжээ, экспорт болон импортын дүнг нэгдсэн журмаар мэдээлэх сар тутмын тайлан бэлтгэн гаргаж байна. 2014 оноос эхлэн Ашигт малтмалын газар энэхүү мэдээг долоо хоног тутам гаргах болж, хэвлэл мэдээлэлд хандан мэдээлэл хийж байна. Татварын ерөнхий газрын дурдсанаар ОУИТБС хэрэгжиж эхлэхээс өмнө одоо ил тод болоод буй тухайн мэдээлэл нийтэд огт түгээгдэж байгаагүй ажээ.

2007- 2010 онуудад Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийг Дэлхийн Банкны Олон талт донорын итгэлцлийн сангаас бүхэлдээ санхүүжүүлж байсан бөгөөд 2006-2009 оны санхүүгийн жилийг энэ дэмжлэг хамарч байна. 2010 оноос хойш Монгол улсын Засгийн газраас ОУИТБС-ын тайланд зориулан харьцангуй тогтвортой хэмжээний санхүүжилтыг төсвөөс гаргах болсон бөгөөд 2012 онд 201.1 сая, 2013 онд 183 сая, 2014 онд 220.1 сая, 2015 онд 260 сая төгрөгийн санүүжилт хуваарилаад байна. Гэхдээ бодит байдал дээр 2015 онд зөвхөн Хараат бус нэгтгэгчийн төлбөрт зориулсан 169 сая төгрөгийг л шилжүүлсэн нь тухайн үеийн төсвийн хямралаас үүдсэн юм. Дэлхийн Банкны Олон талт донорын итгэлцлийн сан нь нэгтгэл тайлантай холбоогүй бусад үйл ажиллагааг санхүүжүүлж буй бөгөөд 2015 оны санхүүжилт болох 280.000 ам долларын санхүүжилтыг 2 дугаар сард хийсэн байна³⁹. Мөн гүүрэн санхүүжилт болон 46,450 ам долларыг Австралийн Засгийн газраас 2014 оны 8 дугаар сард мөн хийжээ. Энэхүү санхүүжилт нь ихээхэн шаардлагатай байсан бөгөөд учир нь Олон талт донорын итгэлцлийн сангийн санхүүжүүлсэн 250,000 ам долларыг 2014 оны 2 дугаар сар гэхэд бүрэн зарцуулсан байсан, дараагийн санхүүжилт нь 2015 оны 2 дугаар сард л ирж ирэх байсан юм. 2015 оны 12 дугаар сард Олон талт донорын итгэлцлийн сан дэлхий даяар хаагдан, Дэлхийн Банкны олборлох үйлдвэрлэлийн хөтөлбөрийн дэмжлэг үзүүлэх төслөөс хийгдэх 450.000 ам долларын санхүүжилтын шинэ гэрээг эцэслэн батлах үйл явц удааширсантай холбоотойгоор ОУИТБС-ын хэрэгжилт нь 2016 оны 7 дугаар сарыг хүртэл санхүүжилтын асуудалтай нүүр тулжээ. Ийнхүү саад тулгарсаны улмаар ОУИТБС-ын Ажлын албаны ажилтнуудын цалин 7 сарын хугацаанд буюу 2016 оны 8 дугаар сарыг хүртэл төлөгдөлгүй саатжээ.

Хараат бус нэгтгэгчийн зүгээс төрийн байгууллагуудын ихэнх нь нэгтгэлд хамрагдах мэдээлэл илгээж буй ч төв болон орон нутгийн хоёр байгууллага нэгтгэл хийх шатанд шаардлагатай мэдээлэл гарган өгөх хүсэлтэд нь хариу ирүүлээгүй, 2014 оны ОУИТБС-ын тайланд мэдээлэл өгөөгүй бөгөөд эдгээр нь Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Ховд аймаг байжээ. 2013 оны ОУИТБС-ын тайланд 6 төрийн байгууллага хүсэмжилсэн мэдээллийг гарган өгөөгүйн тоонд Гаалийн ерөнхий газар, Сүхбаатар болон Баянгол дүүргүүдийн татварын албад, Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Өмчийн харилцаа, газрын алба багтаж байна.

Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар нь олон нийтэд мэдээлэл хүргэх, түгээх үйл ажиллагааны голлох оролцогч талууд бөгөөд ОУИТБС-ын Нээлттэй өдөр болон нийслэл, орон нутагт зохион байгуулж буй арга хэмжээнд тогтмол оролцож байна.

³⁶ <http://www.iltod.gov.mn/>, Монгол хэл дээр.

³⁷ <http://119.40.100.204/EReport/>, Монгол хэл дээр.

³⁸ <https://www.mof.gov.mn/%D1%88%D0%B8%D0%BB%D1%8D%D0%BD-%D0%B4%D0%B0%D0%BD%D1%81%D1%88%D0%B8%D0%BD%D1%8D/?lang=en>

³⁹ 2014 жилийн тайлан

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагуудыг ОУИТБС-д төлөөлдөг хэд хэдэн төлөөлөгчийн дүрдсанаар нэг талаас иргэний нийгмийн зүгээс тавьж буй шаардлага, нөгөө талаас үндэсний аюулгүй байдалд хамааралтай мэдээллийн нууцлал зэргээс үзсвэл Засгийн гарын зүгээс ОУИТБС-ыг “зоригтой” хэрэгжүүлж байна хэмээн үзжээ. Хэдий Засгийн газрын зүгээс ОУИТБС-ын дэмжинэ гэдгээ олон нийтэд хандан мэдэгдэж байсан ч ярилцлагад хамрагдсан олборлох үйлдвэрлэлийн зарим төлөөллийн зүгээс Засгийн газрын ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд гаргаж буй хүчин чармайлтын түвшинг үнэлэхдээ ихэнхдээ Засгийн газар санаачилгыг “төсөл” гэсэн үүднээс хардаг хэмээн үзжээ. Хэд хэдэн донор байгууллагуудын үзэж буйгаар төрийн байгууллагууд болон Уул уурхайн яамтай хамтран ажиллах явцад нь ОУИТБС-тай хамтран ажилладаг талаар хэзээ ч дурдагдаж байгаагүй гэсэн байна. Тэдний үзэж буйгаар Монгол улсын өндөр албан тушаалтнууд ОУИТБС-ын үйл явцыг ердөө л “журам нь байгаа болхоор л хийж буй” үйл ажиллагаа хэмээн үздэг бол харин иргэний нийгмийн зүгээс ОУИТБС-ыг өөрөөр авч үздэг байна. Донор байгууллагын төлөөллийн хэлсэнээр МАН-ын Засгийн газар ажиллаж байх үед ОУИТБС-ын хэрэгжүүлэх эрмэлзлэл нь 2012-2016 онд Ардчилсан намын Засгийн газар ажиллаж байсан үетэй харьцуулбал илүү байсан ажээ. Монголын ОУИТБС-ын мэдээлсэнээр Засгийн газар бүрэн бүрдэх, ОТОБ-ын даргыг томилох хүртэл нийт 5 сарын хугацаа орсон тухай дурдаад энэхүү нөхцөл нь 2014 оны 8 дугаар сард Засгийн газрыг огцруулсанаас үүдсэн хэмээн үзэж буйгаа илэрхийлсэн. 2014 оны 11 дүгээр сарыг хүртэл Засгийн газар эмхлэгдэн байгуулагдаагүй тул Ажлын албаны зүгээс 8- 12 дугаар сарын хооронд үүссэн саадыг тодорхой шалтгаантай/үндэслэлтэй хэмээн үзсэн бөгөөд ОУИТБС-ийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын хүсэл эрмэлзлэлд эргэлзэхгүй буйгаа хэлж байв.

ОТОБ дэх иргэний нийгмийн байгууллагын нэг төлөөллийн үзэж буйгаар ОУИТБС-ын Ажлын албыг төсөл хэрэгжүүлэх нэгж хэмээн зарим талууд үздэг нь “санаачилга” хэмээн үг нэрэнд нь орсонтой холбоотой ба энэ нь Засгийн газрын зүгээс ОУИТБС-ыг албан ёсны, байнгын хэмээн үзэхгүй буйн нэг шалтгаан хэмээн үзжээ. Хэлэлцүүлэгт оролцсон иргэний нийгмийн бүхий л төлөөлөл 2016 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн ОТОБ-ын хуралдаан дээрх ОТОБ-ын дарга, Ерөнхий сайдын Ахлах зөвлөх Б.Батбаярын (Баабар) хандлага болон өгч буй тайлбаруудын талаар ихээхэн санаа зовниж буйгаа илэрхийлж байв⁴⁰. ОТОБ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзвэл Б.Батбаяр нь иргэний нийгмийн байгууллагуудыг юм үзээгүй гол буруутан хэмээн нэрлэж, өөрөө Ерөнхий сайдын ахлах зөвлөхөөр АСЕМ дуустал ажиллах тул ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох сонирхолгүй буйгаа хэлж байжээ.⁴¹

ОТОБ дэх төрийн төлөөллийн зүгээс сүүлийн жилүүдэд ОУИТБС-ын санхүүжилт нь байнга давтан гарч буй гол сорилт болоод буйг дурдсан. Гэхдээ түүний хэлж буйгаар Засгийн газар нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бүрэн хүсэлтэй буй бөгөөд Монгол улсын хувьд нээлттэй улс гэдгийг дурдсан. Улс төрийн өөрчлөлтүүдийг сорилт хэмээн үзэхгүй буй бөгөөд төрийн байгууллагуудын төлөөллийн тайлбарлаж буйгаар шийдвэр гаргалт нь харьцангуй тогтвортой УИХ-д хамаарах тул гарч буй өөрчлөлтүүдийг сорилт хэмээн үзэх нь учир дутагдалтай хэмээн үзжээ.

Засгийн газрын хэмжээнд үүдэн гарч буй улс төрийн өөрчлөлтүүдээс ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцох байдалд үзүүлж буй нөлөөллийн талаар хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага дурдсан ба Ерөнхий сайд байнга өөрчлөгдөж буй нь Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн даргын үйл

⁴⁰ Хэвлэгдээгүй, Ажлын албанаас гарган өгсөн.

⁴¹ Хэвлэгдээгүй, Ажлын албанаас гарган өгсөн.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ажиллагаа, хуралдаануудад сөргөөр нөлөөлж буй бөгөөд учир нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх нь ОТОБ-ийг даргалдаг тул энэхүү бүлгийн дарга байнга өөрчлөгдөж буй ажээ. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс мөн 2016 оны 1-6 дугаар саруудад ОТОБ-ыг даргалж байсан ноён Б.Батбаяр (Баабар) нь иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог эсэргүүцдэг талаар 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн ОТОБ-ийн хуралдааны тэмдэглэлээс иш татан баримттайгаар хэлж байв. Иргэний нийгмийн байгууллагын нэг төлөөллийн зүгээс одоогийн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Сэлэнгэ аймагт хувьдаа алтны уурхайтай тул Үндэсний зөвлөлийг даргалахад ашиг сонирхлын зөрчилдөөн үүсэж магад хэмээн болгоомжилж байв.

Уулзалтад хамрагдсан төрийн байгууллагын ихэнх төлөөлөл нь ОУИТБС дахь төрийн байгууллагуудын оролцоо нь санаачилгын үйл явцыг хэвшүүлэн хэрэгжүүлэх бус харин тайлангийн маягтуудыг бөглөн илгээх байдлаар л хангагдаж байна хэмээн үзсэн. Гэхдээ ОТОБ дэхь төрийн байгууллагын нэг төлөөллийн үзэж буйгаар Монгол улсын Ерөнхий сайд Үндэсний зөвлөлийг даргалдаг, Ерөнхий сайдын ахлах зөвлөх нь ОТОБ-ийг даргалж буй тул төрийн бүх байгууллагуудад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хүргэж буй хэмээн тайлбарлажээ.

ОТОБ дэхь төрийн байгууллагуудын зарим төлөөлөл хэлэхдээ тэд 2015 он 11 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд болсон Үндэсний форумд оролцсон ч олон нийтэд мэдээлэл түгээх зэрэг үйл ажиллагаанд огт оролцож байгаагүй гэжээ. Гэхдээ Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээнд төрийн байгууллагын гишүүд өөрсдийн төлөөллөө (өөрсдөө бус) илгээх хандлагатай болсон ч (ялангуяа хол байдаг тул Улаанбаатар хотоос гадна) бүх оролцогч талуудын бүлэг байнга оролцдог хэмээн хэлсэн. Ашигт малтмалын газар болон Татварын ерөнхий газар зэрэг томоохон байгууллагууд эдгээр үйл ажиллагаанд голдуу оролцдог бол яамд тэр бүр оролцдоггүй гэж ажлын алба, төрийн байгууллагуудын зарим төлөөлөл үзэж байна. Иргэний нийгмийн нэг төлөөллийн хэлж буйгаар зарим тодорхой төрийн байгууллагууд олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаанд оролцдог ч тэдний оролцоо нь идэвхтэй бус, зүгээр л оролцох үүргээ л биелүүлсэн хэлбэртэй байдаг ажээ. ОТОБ дэхь иргэний нийгмийн төлөөлөл гишүүний үзэж буйгаар Засгийн газар нь мэдээлэл түгээх, сурталчлах ажилд илүү хувь нэмэр оруулж чадах ба жишээ нь төрийн өмчит Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр дамжуулан энэхүү туслалцааг хэрэгжүүлж болно хэмээн үзсэн байна.

Төрийн байгууллагын хэд хэдэн төлөөлөл ОУИТБС-д тайлан гарган өгөх үүрэг бүхий 35 төрийн байгууллагуудын мэдээллийг гаргуулан (ихэнхдээ цаасан хэлбэрээр) нэгтгэн хүргүүлэхэд Сангийн яам тэргүүлэх үүрэгтэй оролцдог, мөн 2015 онд Цахим тайлангийн системийг эхлүүлсэн нь тайлан гаргадаг бүх байгууллагууд мэдээллээ цахим хэлбэрээр оруулж байх боломжийг хангасан зэргийг тэмдэглэн хэлж байв. Төрийн байгууллагуудыг төлөөлсөн цөөн тооны гишүүдийн хэлж буйгаар төрийн бүх байгууллага ОУИТБС-ын тайлан хариуцсан ажилтныг томилох, компанийн бүргэлийн дахин давтагдашгүй дугаарыг ашиглан тайлан гаргах үйл ажиллагааг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн. Компанийн төлөөлөл нэг хүний хэлсэнээр гаалийн байгууллагын төлөөлөл Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн хуралдаанд хэзээ ч хүрэлцэн ирж оролцож байгаагүй ажээ.

Анхдагч үнэлгээ

Олон улсын ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс нь энэхүү шаардлагыг хангахад хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан байна. Засгийн газар нь ОУИТБС-ын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийх зэрэг үйл явцад идэвхтэй, үр дүнтэйгээр оролцон ажиллаж байна. Оролцогч талууд нь мэдээлэл түгээх, сурталчлах болон олон нийтийн хэлэлцүүлэг зэрэг зарим арга хэмжээнд оролцож байна. Засгийн газрын зүгээс ОУИТБС-ын

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хэрэгжилтэд зориулсан санхүүжилт хуваарилж байна. Гэхдээ мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаанд Засгийн газрыг төлөөлөх байгууллагууд бүрэн хэмжээнд оролцохгүй буй мөн ОУИТБС-ын хэрэгжилтийг санхүүжүүлэхэд саад тотгор тулгарч буй зэрэг нь санаа зовоохуйн хэмжээний асуудал болж байна. ОТОБ дэхь төрийн байгууллагуудын төлөөлөл нь ОУИТБС-ын мэдээллийг түгээх үйл явцаа сайжруулах, арга хэмжээнүүдэд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх талаар судлан үзэж, арга хэмжээ авах шаардлагатай байна. Засгийн газар нь ОУИТБС-ын санхүүжилтын асуудлыг судлан үзэж, урт хугацаанд тогтвортой байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ОУИТБС-ын үйл явц дахь компаниудын оролцоо (#1.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцыг дэмжин урагшлуулах зорилгоор хэд хэдэн эрх зүйн заалтуудыг батлан хэрэгжүүлж буй бөгөөд эдгээрийн хүрээнд компаниуд ОУИТБС-ын тайлангаа гарган төрийн байгууллагуудад төлсөн татвар, төлбөрөө тайлагнаж байх, мөн санхүүгийн жил дууссанаас хойш нэгдүгээр улиралд багтаан нийт үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг гарган өгч байх шаардлагыг тавьж буй юм. Эдгээр хууль тогтоомжуудад доорх багтаж байна:

- Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар зүйл⁴² дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйлдвэрлэл болон борлуулалт, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн тухай мэдээллийг дараа оны нэгдүгээр улирал дуусахаар өмнө тайлагнаж байх.
- Ашигт малтмалын хуулийн 48.9 дүгээр зүйл⁴³ дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төлсөн ашигт малтмалын нөөцийн төлбөрийн дүнг хамаарах татварын албанд тухайн он дууссанаас хойш дараа сарын 20-ны дотор гарган өгөх.
- 2009 онд батлагдсан Цөмйн энергийн хуулийн 28.6.4 дүгээр зүйл⁴⁴ дээр ураны тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүтээгдэхүүн борлуулалт, улс болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн мэдээллээ жил тутам олон нийтэд нээлттэй мэдээлж байх.
- 2014 онд шинэлэгдэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн 36.1⁴⁵ дүгээр зүйл дээр гэрээт байгууллагууд нь хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, гарсан зардал, төлсөн нөөцийн төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тоо хэмжээ, улс болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, шагнал урамшуулал болон төрийн байгууллагуудад төлсөн үйлчилгээний хөлс зэргийг дараа оны эхний улиралд багтаан гарган өгөх үүрэгтэй. Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий байгууллагууд нь энэхүү мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэнэ.
- (2014) Ашигт малтмалын хуулийн 66.1.2 дугаар зүйл дээр тус хуулийн 48.1-48.10 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлээгүй бол ноогдуулах хариуцлагыг заасан. Энэ заалтын дагуу буруутай иргэнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, аж ахуйн нэгжид 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулахаар заажээ.
- 2014 оны 1 дүгээр сард батлагдсан 2014-2025 онд баримтлах Эрдэс баялагийн салбарын

⁴² http://www.charltonsmine.com/images/stories/Overseas_Law/Mongolia/minerallawsofmongolia.pdf

⁴³ http://www.charltonsmine.com/images/stories/Overseas_Law/Mongolia/minerallawsofmongolia.pdf

⁴⁴ <http://legal-policy.mn/uploads/files/1437032892-85658440.pdf>

⁴⁵ <http://english.pam.gov.mn/content/11370.shtml>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

төрийн бодлогод⁴⁶ ил тод, хариуцлагатай уул уурхайг дэмжин хөгжүүлнэ хэмээн заажээ.

- 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулиар⁴⁷ компаниуд Монгол улсын хөрөнгө оруулалтын газарт бүртгүүлсэн бүртгэлээ олон нийтэд нээлттэй ил тод болгохоор заасан байна.

Засгийн газрын зүгээс мөн Ил тод байдлын тухай хуулийн төслийг санаачилсан бөгөөд энэ нь ОУИТБС-д эрх зүйн үндэслэл бий болгож, олборлох салбарын удирдлага дахь бусад асуудал болон тусгай зөвшөөрөл олгох, гэрээ хэлцэл хийх болон худалдан авалт зэрэг үйл явцын ил тод байдлыг хангах зорилготой юм. Тус хуулийн төслийг Хууль зүйн яам 2014 оны 5 дугаар сард зөвшөөрөн, 2014 оны 10 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн ч УИХ нь 2016 оны 7 дугаар сарын байдлаар төслийг хэлэлцэн батлаагүй байна.

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд нь ОУИТБС-ын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ОТОБ дэхь компанийн төлөөлөл болох Монголын уул уурхайн үндэсний ассоциацаар дамжуулан идэвхтэй үүргийг гүйцэтгэж иржээ. ОТОБ-ын засаглал болон үйл ажиллагаан дахь салбарын компаниудын оролцооны тухайн нэмэлт мэдээллийг энэхүү үнэлгээний ОТОБ-ийн засаглал болон үйл ажиллагаа (Шаардлага #1.4) гэсэн доорх хэсэгт оруулсан.

Монгол улсад ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниудын ихэнх нь ОУИТБС-ын тайланд хамрагдан, тайлангаа гаргаж байна. Хэдийгээр ОУИТБС-ын 2014 оны тайлангуудын нэгтгэлд 236 компанийг хамруулсан ч 2014 оны байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан 1573 компанийн 988 нь өөрсдийн материаллаг төлбөрийг ОУИТБС-д тайлагнасан байна.⁴⁸ 2014 оны нэгтгэлд хамруулсан компаниудын 7-гоос бусад нь тайлангийн маягыг бөглөн ирүүлсэн байжээ. Энэхүү ОУИТБС-ын тайлангийн иж бүрэн байдлыг хангах хамрагдалт, оролцооны ач холбогдлын талаар энэхүү Тайлангийн 2 дугаар хэсэгт оруулсан.

2014 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Ашигт малтмалын хуулийн 66.1.2 дугаар зүйлд тус хуулийн 48.1-48.10 дугаар заалтад заагдсан тайлагнах үүргээ биелүүлээгүй компаниудад хариуцлага тооцох тухай заасан байна. Гэхдээ тухайн заалтуудын аль нэгийг зөрчсөний улмаас компанид торгууль ноогдуулж болох үндэслэл нь ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй явдал байх ч компаниудыг тэр бүр торгодоггүй учир нь бусад заалтуудын дагуу хэдийн торгууль хүлээсэн байдаг тул торгууль ноогдуулах боломжгүй болдог байна. 2014 оны ОУИТБС-ын тайланд Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас тайлан гаргаагүй компаниудын нэрийг өдөр тутмын сонингоор зарлажээ.

Ороцлогч талуудын санал бодол

Олборлох үйлдвэрлэлийг төлөөлсөн хэд хэдэн хүн хэлэхдээ тэдэнд компаниудыг тайлан гарга гэж шаардах эрх мэдэл байхгүй ч Монголын уул уурхайн үндэсний ассоциацын гишүүн бус компаниудыг хамруулан иж бүрэн тайлагнал хангах зорилгоор ажиллах хүсэлт сонирхолтой буйгаа илэрхийлсэн. ОУИТБС-ын Ажлын албанаас хэлэхдээ ОТОБ нь тайлан гаргаагүй компаниудын нэрсийг нийтлэхээр шийдсэн бөгөөд энэ нь зарим талаар үр дүнтэй болсоныг дурдсан. Компаниудын нэрийг өдөр тутмын сонингуудаар зарласны дараа хэд хэдэн компани ОУИТБС-ын шаардлагуудыг даган мөрдөж эхэлжээ. Харин Ажлын албаны үзэж буйгаар олон тооны жижиг компаниуд тусгай зөвшөөрөл авсан ч хамтран ажиллах томоохон компани олох хүртэл хүлээзнэж идэвхгүй, үйл ажиллагаа явуулахгүй

⁴⁶ <http://en.mongolianminingjournal.com/content/54797.shtml>

⁴⁷ <http://www.mram.gov.mn/pdac/law/en/2.pdf>

⁴⁸ ОУИТБС-ын 2014 оны тайлангийн Хэсэг 2.3.1.2 (хуудас 18) дээр үзнэ үү.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

буй ажээ. Тиймээс Ажлын албаны дүгнэлтээр тэдгээр жижиг компаниуд нь ОУИТБС-ын тайланд хамрагдах шаардлагын талаар мэдэхгүй, тэр ч байтугай Ашигт малтмалын тухай хуулийн талаар ч мэдлэг сул байна. Олборлох үйлдвэрлэлийг төлөөлсөн хэд хэдэн хүний хэлж буйгаар төрд төлсөн төлбөрөө ил тод тайлагнахыг компаниудад шаардсан 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйл нь үр дүнгүй гэж үзэж буй ч сүүлийн жилүүдэд тайлан гаргагч компаниудын тоо нэмэгдсээр иржээ. Иргэний нийгмийн төлөөллийн зүгээс Ашигт малтмалын хуулийн заалтыг зөрчсөн үндэслэлээр компаниудыг дараалан торгох боломжгүй тул компаниуд торгууль хүлээхгүй, ОУИТБС-ын тайлангаа ч гаргахгүй буй учир шалтгаан болж байна хэмээн үзжээ. Баталгаажуулалтын судалгаанд хамрагдсан газрын тос болон байгалийн хийн чиглэлийн компаниуд хэлэхдээ Ашигт малтмалын тухай хууль нь ашигт малтмал олборлож буй компаниудад хамааралтай тул ОУИТБС-ын тайлан гаргах нь газрын тосны салбарын хувьд 2015 оныг хүртэл цэвэр сайн дурын байсан бол 2014 онд Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсанаар Засгийн газарт төлсөн төлбөрөө ил тод мэдээлэх шаардлага тавигдаж эхэлжээ. Олборлох салбарын бүх төлөөлөл хэлэхдээ ОУИТБС-ын тайлан гаргахад эрх зүйн ямар нэгэн саад тотгор байхгүй хэмээн үзжээ.

Олборлох салбарыг төлөөлсөн нэг төлөөлөгчийн үзэж буйгаа Монголын уул уурхайн үндэсний ассоциац нь ОУИТБС-ын чиглэлээр Ажлын хэсэг байгуулан ОТОБ болон Үндэсний зөвлөлд төлөөлөлгүй компаниудтай хийх хэлэлцүүлэг, зөвлөлдөх арга хэмжээг илүү сайжруулах зөвлөмжийг өгч байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн нэг байгууллагын зүгээс ОУИТБС-ын үйл ажиллагаан дахь компанийн оролцоо, тайлагналаас илүү ОУИТБС-ын тайланд мэдээлэл гарган өгөх чиглэлээр зарим асуудлууд буйг тэмдэглэн хэлсэн. Уул уурхайн салбарын хэд хэдэн төлөөлөл хэлж буйгаар ОУИТБС-ын тайлангаа илгээсэн л бол оролцоо нь боллоо гэж компаниуд үздэг байна. Гэхдээ Оюу Толгой, Сентерра Гоулд зэрэг томоохон компаниудын хувьд ОУИТБС-ын үйл ажиллагаа нь хаана явагдаж буйгаас хамааран мэдээлэл түгээх үйл ажиллагаанд хамрагдан оролцдог бол Уул уурхайн ассоциац нь энэ чиглэлээр чадавхийн хувьд асуудалтай байдаг ажээ. Иргэний нийгмийн төлөөлөл олборлох салбарыг төлөөлсөн гишүүдийг олон тооны жижиг компаниудыг бүрэн төлөөлдөг гэж үзэхгүй буйгаа хэлж байв. Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаанд оролцохдоо, ялангуяа Улаанбаатар хотоос гадуур буй тохиолдолд ОТОБ-ын гишүүн бус өөр хүмүүсийг явуулах хандлагатай болсон ч олборлох үйлдвэрлэлийн төлөөлөл эдгээр арга хэмжээнд ямартай ч төлөөллөө оролцуулдаг ажээ. Уул уурхай болон газрын тосны компаниуд эдгээр үйл ажиллагаанд оролцдог ч тухайн арга хэмжээ зохион байгуулж буй нутагт үйл ажиллагаа явуулж буй эсэхээс оролцоо нь хамаардаг ажээ. Газрын тосны компаниудын төлөөлөл үзэхдээ мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагааг Ажлын алба дангаар хариуцан хийвэл илүү дээр бөгөөд учир нь компанийн хувьд ийм арга хэмжээнд оролцох бол удирдлагын зөвшөөрөл заавал шаарддагддаг ажээ. Газрын тосны компаниудын хувьд мөн ийм арга хэмжээнд оролцоход нэр хүндийн эрсдэл үүсдэг бөгөөд харьцангуй сөрөг нэр хүнд бүхий уул уурхайн компаниудтай хамтдаа арга хэмжээнд оролцож байх нь эрсдэлтэй хэмээн үзэж байна. Гэхдээ газрын тос, байгалийн хийн компаниуд үйл ажиллагаа явуулж буй, Бүтээгдэхүүн хуваах гэрээний талбайтай аймаг орон нутагт арга хэмжээ зохион байгуулагдах тохиолдолд ийм төрлийн арга хэмжээнд оролцож ирсэн хэмээн ОУИТБС-ын Ажлын алба үзэж байна.

Иргэний нийгмийг төлөөлсөн нэг гишүүний үзэж буйгаар компаниуд нь Засгийн газрын үйлдлийг дагах хандлагатай буй бөгөөд ОТОБ дээр зөвхөн төрийн байгууллагуудын хамтаар л оролцох сонирхолтой хэмээж байна. Уулзан зөвлөлдсөн иргэний нийгмийн бүх байгууллагуудын зүгээс ОУИТБС-ын тайлан гаргах явдлыг Засгийн газрын тайлан гаргах үйл явцтай адил компаниуд заавал гүйцэтгэх үүрэг болгох хэрэгтэй гэж үзэж байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс гаргаж буй анхдагч үнэлгээгээр Монгол улс нь энэхүү шаардлагыг хангах чиглэлээр хангалттай ахиц дэвшлийг гаргажээ. Компаниуд нь ОУИТБС-ын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд идэвхтэй оролцож, бүс нутгийн түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийг хийх, мэдээлэл түгээх сурталчлах зэрэг ажилд өөрийн төлөөллийг оролцуулж байна. ОУИТБС-ын үйл ажиллагаанд олборлох салбарын компаниудын оролцоог хязгаарласан ямар нэгэн эрх зүйн саад байхгүй.

ОУИТБС дахь иргэний нийгмийн оролцоо (#1.3)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Монгол улсад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг идэвхтэй, үр дүнтэй үйл ажиллагааг явуулдаг иргэний нийгмийн сүлжээ үүсэн бий болоод буй бөгөөд үүнд доорх байгууллагууд багтаж байна:

- Нээлттэй нийгэм форум⁴⁹, Нью-Йорк хот дахь Нээлттэй нийгэм сангийн дэмжлэгтэй салбар байгууллага;
- Хил хязгааргүй алхам ТББ⁵⁰, Монгол улсын ардчилсан хөгжилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах зорилго бүхий байгууллага;
- Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнгийн Монгол дахь салбар, олон улсын, ашгийн бус хүрээлэн (Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн нь 2015 онд гэрээний нэгдсэн портал байгуулах үйл ажиллагаанд Улаанбаатар хот дахь өөрийн салбараар дамжуулан дэмжлэг үзүүлсэн);
- Хонгор нутгийн дуудлага, орон нутгийн ТББ;
- Тогтвортой хөгжийн төлөө хариуцлагатай уул уурхайн санаачилга, Монгол улсын ашгийн бус хүрээлэн;
- Монголын байгаль орчны иргэний зөвлөл, байгаль орчны асуудлаар үйл ажиллагаа явуулдаг 750 гаруй ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн эвсэл;
- Ил тод сан⁵¹, төсвийн хяналтын чиглэлээр ажилладаг ТББ;
- Зориг Сан⁵², ашгийн бус ТББ;
- Төлсөн авсан нийтэл (ТАН) эвсэл⁵³, дээрх болон өөр бусад нийт 29 байгууллагын нэгтгэсэн эвсэл.

Үзэл бодлоо илэрхийлэх: ОУИТБС-ын асуудлаар үзэл бодлоо илэрхийлэхэд ямар нэгэн байдлаар ОУИТБС-ын зүгээс тогтоосон цензур, хязгаарлалт байхгүй. Монгол улс нь өөрийн бүс нутагтаа үг хэлэх эрх чөлөөний хувьд ихээхэн өндөр хэмжээнд эрэмбэлэгддэг. Тус улсыг Фрийдом Хаус байгууллагаас “чөлөөтэй” хэмээн дүгнэдэг ба нийт эрх чөлөөний хувьд 1.5, иргэний эрх чөлөөгөөр 2, улс төрийн эрхээр 1 гэсэн дүнг 2015 онд өгсөн (1 хамгийн сайн, 7 хамгийн муу) нь өмнөх хоёр

⁴⁹ <http://www.forum.mn/>

⁵⁰ <https://swbm.wordpress.com/>

⁵¹ <http://www.ilzasag.mn/>

⁵² <http://zorigfoundation.org/>

⁵³ <http://www.publishwhatyoupay.org/members/mongolia/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

жилийн үзүүлэлттэй ижил байна.⁵⁴ АНУ-ын Төрийн департаментын дурдсанаар 2014 оны Монгол улсын хүний эрхийн тайланд⁵⁵ зааснаар хүний эрхийн гол асуудал нь авлига, шүүхэд нөлөөлөх гадны нөлөө болон гэр бүлийн хүчирхийлэл зэрэг багтаж байна. Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх арга хэмжээн дээр ярилцсанаас үзвэл эдгээр нь иргэний нийгмийн байгууллагууд салбарын засаглалын асуудлыг ил тод нээлттэйгээр хэлэлцэхэд ямар нэгэн саад тотгор учруулахгүй байна. ТАН эвсэлтэй хийсэн ярилцлагаар ОУИТБС-тай холбоотойгоор олон нийтийн зүгээс шүүмжлэл гарч байсан тохиолдлуудын тухай дурджээ. Жишээ нь 2015 оны хавар ТАН эвслийн зүгээс Засгийн газар олон нийтийг хамарсан баярын өмнө Таван Толгой орд газрыг ашиглах асуудлаар Япон, Хятадын хамтарсан консорциумтай (Шенхуа болон Сумитомо корпораци) гэрээ хийх гэж буйг эсэргүүцэн олон нийтэд хандсан мэдэгдэл гаргаж⁵⁶, ОУИТБС-ын шаардлагын (энэ нь стандартад дурдагдаагүй ч) дагуу энэхүү гэрээг ил тод хийх ёстой хэмээн мэдэгдсэн байна. Энэхүү кампанит ажлын үр дүнд Засгийн газар тухайн гэрээг хийгээгүй байна. Ерөнхийдөө Үндэсний зөвлөл болон ОТОБ дээр ОУИТБС-ын үйл явцын талаарх шүүмжлэлүүд гарч байжээ. Монгол улсын бусдын нэр хүндэд халдахыг эрүүгийн гэмт хэрэг гэж үздэг ба хийсэн мэдэгдэл нь үнэн бодитой байсан ч ТББ-үүд болон ОУИТБС дахь тэдний оролцоотой хамааралтайгаар бусдын нэр төр халсан хэмээн буруутгасан ямар нэгэн бодит тохиолдол байхгүй. ТАН эвсэлийн хэд хэдэн гишүүний дурдсанаар хэвлэл мэдээлэл нь иргэний нийгмийн байгууллагуудыг ихээхэн шүүмжилдэг ба иргэний нийгмийн байгууллагууд нь нэр төрд халдах явдалд өртөж буй ч ийм төрлийн олон нийтийн хэлэлцүүлэг нь үзэл бодлоо илэрхийлэхэд нь иргэний нийгэмд саад тотгор учруулахгүй байна.

Үйл ажиллагаа: Иргэний нийгмийн байгууллагуудыг ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцоход ямар нэгэн байдлаар эрх зүй, зохицуулалт, захиргаа болон бодит байдлаар тулгарсан саад тотгор байхгүй, суурь эрхэд нь хязгаарлалт үгүй байна. Дээр дурдсан Фрийдом Хаус байгууллагын эрэмбээр эвлэлдэн нэгдэх эрхийг хуулиар баталгаажуулсан ба иргэний нийгмийн байгууллагууд нь төрийн ямар нэгэн хөндлөнгийн оролцоогүйгээр үйл ажиллагаа явуулж байна. ТАН эвсэлтэй хийсэн ярилцлагаар хүний суурь эрхэд тулгарсан ямар нэгэн аюул байхгүй, Монгол улс нь ардчилсан эрх чөлөөний өргөн хүрээний уламжлал бүхий улс юм. 2016 онд Иргэний нийгмийн протокол, Үнэлгээний журам болон зааварчилгааг 2015 оны 11 дүгээр сард гаргасан иргэний нийгмийн байгууллагуудын хүсэлтээр Монгол хэлэнд орчуулсан байна.

Эвлэлдэн нэгдэх: ОУИТБС-ын үйл явцад оролцож буй иргэний нийгмийн бүлгүүд нь чөлөөтэйгээр харилцан бие биетэйгээ болон ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ОТОБ-т ямар нэгэн хамааралгүй бусад байгууллагууд, олон улсын байгууллагатай чөлөөтэй хамтран ажиллаж байна. 2006 онд анхлан байгуулагдаж, 2015 оны 11 дүгээр сарын байдлаар 29 гишүүн бүхий ТАН эвсэл нь 2013 онд анхлан гаргаж байсан блогод⁵⁷ вебсайт⁵⁸ (Монгол хэл дээр) болж 2013 онд өргөжин, өөрийн гишүүдтэйгээ үндсэндээ цахим шуудангаар харилцаж байна. Тус эвсэлийн Удирдах зөвлөл нь 7 гишүүнтэй бөгөөд эдгээрийн гуравны нэг нь жил бүр солигддог ажээ. Эвсэл нь жилд дөрвөн удаагийн уулзалтыг хийдэг. 2008 онд байгуулагдсан 700 гаруй гишүүнтэй Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь⁵⁹ анхлан энгийн ТББ-үүдэд сүлжээ байсан бол 2015 онд гишүүнчлэлийн төлбөр бүхий бүтцэд шилжсэн байна. Байгаль орчны иргэний зөвлөл нь өөрийн үндсэн харилцаа холбоонд вебсайт

⁵⁴ <https://freedomhouse.org/report/freedom-world/2015/mongolia>

⁵⁵ <http://www.state.gov/j/drl/rls/hrrpt/2014/eap/236460.htm>

⁵⁶ ИНБ-уул УИХ хууль батлахдаа баярын өмнө баталж, иргэдийн хяналтыг буруулдаг гэж үзэж байна.

⁵⁷ <https://sites.google.com/a/eiti.mn/tan-evsel/info-in-english-1/info-in-english>

⁵⁸ <http://pwyp.mn/>

⁵⁹ БОИЗ-ийн сайт <http://www.mecc.mn/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ашигладаг⁶⁰ ба гишүүдтэйгээ цахим шуудангаар холбоотой бйдаг. ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөл нь нягт харилцаатай, зарим байгууллагууд аль алинд нь гишүүнчлэлтэй байдаг ажээ. ТАН эвсэл нь орон нутгийн түвшинд Иргэний зөвлөлийн гишүүн байгууллагуудад чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. ТАН эвсэл нь тухайн хоёр эвсэлд үл багтдаг, ОУИТБС-ын ОТОБ болон Үндэсний зөвлөлд ажиллах сонирхол бүхий ТББ-уудад хандсан мэдээлэл харилцааны үйл ажиллагаа явуулдаг ч үүний үр дүнд дээрх хоёр байгууллагаас бусад өөр байгууллага ОУИТБС-ын бүтцэд нэр дэвшүүлсэн явдал хараахан гараагүй байна.

Оролцоо: Иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл явцын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ОТОБ-ын хурал, Иргэний нийгмийн форум, мэдээлэл түгээх үйл ажиллагаа болон байдлаар хамрагдан оролцож иржээ. ОТОБ-ын хуралдаан болон Үндэсний зөвлөлийн хурлын тэмдэглэлээс харвал⁶¹ сүүлийн жилүүдэд иргэний нийгэм нь идэвхтэй оролцоотой байж, иргэний нийгмийн хувьд олборлох салбартай хамаарах асуудлаар бүрэн оролцох чадавхи бүрэлдэн тогтсон болохыг харуулж байна.

ТАН эвсэл нь ТАН болон Иргэний зөвлөлийн гишүүн бус ТББ-уудад хандсан үйл ажиллагаа явуулдаг болохыг цохон дурдаж байв. Сүүлийн жилүүдэд ТАН эвсэл нь бусад ТББ-уудыг (жишээ нь эмэгтэйчүүдийн ТББ, ардчиллын ТББ) ОТОБ болон Үндэсний зөвлөлд суудалтай болохыг урьж байсан ба энэ нь ОУИТБС-ын Стандартын дагуу ил тод болгох үйл ажиллагааг өргөн хүрээнд бий болгоход чухал шаардлагатай юм.

Төрийн шийдвэр гаргалтад оролцох: Иргэний нийгмийн төлөөллүүдийн зүгээс тэдний гаргасан бүхий л зөвлөмжүүдийг хууль тогтоогчид бүрэн хүлээн авдаггүй хэмээн гомдоллож байсан ч тэдний хувьд ОУИТБС-ын үйл явц нь олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах болон төрийн шийдвэр гаргалтад нөлөөлөхийг бүрэн хангах боломж тэдэнд буй юм. ТАН эвсэлийн үзэж буйгаар тэдэнд шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжгүй гэж үзэж буй бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь түсгай зөвшөөрөл олгох болон бүтээгдэхүүн хуваах болон бусад гэрээ хэлцэл дээр төвлөрч буй юм. Үүний хүрээнд тодорхой жишээнүүдийг тэд гарган ирсэн нь 2015 оны эхэнд Таван Толгой дээр хийгдэж байсан гэрээг ТАН эвсэлийн оруулсан хувь нэмрийн хүчинд зогсоож чадсаныг дурдаж байв (Дээр үзнэ үү). Иргэний нийгмийн байгууллагууд нь мөн 2006 оны Ашигт малтмалын тухай хуулинд 48.10 дугаар зүйлийг оруулахад лобби хийсэн нь шийдвэр гаргалтад амжилттай оролцож, нөлөөлсөн сайн жишээний нэг юм. 2015 оны 7 дугаар сард батлагдсан Нийтийн сонсголын тухай хууль мөн иргэний нийгмийн байгууллагууд шийдвэр гаргалтад оролцох боломжийг илүү нээн өгсөн хууль бөгөөд төв болон орон нутгийн түвшинд гарч буй бүхий захиргааны шийдвэрийг олон нийтээр хэлэлцүүлж байх шаардлагыг хуулиар тавьсан байна. Иргэний нийгэм нь мөн ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлийн үйл ажиллагааны журам, хамрах хүрээг тодорхойлоход ихээхэн идэвхтэй оролцсон байна (Доор үзнэ үү). Хамгийн сүүлд гэхэд иргэний нийгмийн байгууллагууд нь уул уурхайн компани болон орон нутгийн хооронд хийгдэх Орон нутгийн хөгжлийн гэрээний загварыг боловсруулахад саналаа тусгуулжээ. Хэдийгээр иргэний нийгмийн гаргасан саналыг анхлан боловсруулсан Орон нутгийг хөгжүүлэх гэрээний төсөл дээр оруулаагүй байсан ч Монголын үндэсний уул уурхайн ассоциацтай хамтран Хууль зүйн яаманд гомдол гаргаснаар тэдний өгсөн саналын заримыг Засгийн газрын баталсан эцсийн хувилбарт багтаан оруулжээ. Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь мөн “сүүдрийн ногоон парламент” байгуулан, олон нийтийн санал бодлыг парламентын шийдвэрт тусгуулах үйл ажиллагааг явуулж байна.

⁶⁰ <http://www.mecc.mn/>

⁶¹ Харилцаа холбооны стратегийн хэлэлцүүлэг, 2014/3/11.

Оролцогч талуудын санал бодол

Олборлох салбарыг төлөөлсөн хэд хэдэн төлөөлөл Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь сүүлийн жилүүдэд (ойролцоогоор 5 жилийн өмнө) Засгийн газрын санхүүжилтээр зарим ажил хийж байсан гэж хэлсэн ч ТАН эвсэлийн үзэж буйгаар энэ нь иргэний нийгмийн байгууллагуудын ОТОБ дэхь бусад талуудаас үл хамаарах байдалд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлээгүй ажээ. Олон тооны иргэний нийгмийн байгууллагуудаас 2015 онд УИХ-д өргөн барьж, хэлэлцэж буй ТББ-уудын ил тод байдлын тухай хуулийн төсөл нь 2015 оны 8 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн дагуу компаниудад үзүүлсэн татварын өршөөлтэй ижил санаатай, гэхдээ давхар стандарт бий болгосон хууль хэмээн үзэж байна. Өргөн барьсан ТББ-ын тухай хуулиар өөрийн санхүүгийн тайланг Татварын ерөнхий газарт гарган өгч, жил тутам өөрийн татвараас чөлөөлөгдөх статусыг батлуулж байх шаардлагыг биелүүлээгүй ТББ-ыг татан буулгах заалт оржээ. Үүнийг татвар төлөөгүй компаниуд нэг удаа Татварын ерөнхий газарт мэдэгдсэнээр татварын өршөөлд хамрагдах боломжийг хангасан Эдийн засгийн ил тод байдлын тухай хуультай харьцуулбал давхар стандарт бий болгосон хууль хэмээн иргэний нийгмийн байгууллагууд шүүмжилж байна. Гэхлээ тухайн компаниуд нь өмнөө нь төлөөгүй татвараа л өршөөлгөн, ямар нэгэн байдлаар эргэн шалгах аас чөлөөлөгдөх бол харин ТББ-уудын хувьд татвараас чөлөөлөгдөх статусаа жил тутам баталгаажуулж байх нь хэвийн асуудал хэмээн зарим донор байгууллагууд үзэж байна. ТББ-уудын тухай хуулийн төсөлд заасан өөр нэгэн заалт нь ТББ-ууд татан буугдахгүйн тулд үүсгэн байгуулсан бүх хүний гарын үсгийг цуглуулах үүргийг хүлээсэн ч зарим хүмүүсийг эргэн олох боломжгүй байгаа юм. Хэлэлцүүлэгт оролцсон зарим талуудын үзэж буйгаар Монгол улсад бүртгэгдсэн 11 000 ТББ-ын 50% нь энэхүү хуулийн дагуу татан буугдах эрсдэлтэй байна. Мөн Монгол улсад бүртгэгдсэн ТББ-ын тоог зарим тооцоогоор 27 000⁶² хүрсэн хэмээн үзэж байна. Гэсэн ч ихэнх донор байгууллагын хэлсэнээр иргэний нийгмийн байгууллагуудын үзэл бодлоо илэрхийлэх байдал сайн, харин зарим ТББ болон ихэнх хэвлэл мэдээлэл нь улс төрчид, бизнесменүүдтэй холбоотой байдаг ажээ. Нэр төр гутаахыг (тухайн мэдээлэл үнэн байсан ч) эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж буй явдал нь өөртөө цензур тавих байдлыг бий болгож байж болох юм. Нэр төр гутаасан хэмээх нэхэмжлэл бүхий хэд хэдэн хэрэг байсан ч эдгээрийн аль нэг нь ОУИТБС-тай холбоотой гэж тэмдэглэгдээгүй ажээ.

Өмнө нь ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгч байсан байгууллагын төлөөлөл үзэхдээ иргэний нийгмийн байгууллагууд нь ОУИТБС-ын хэрэгжилттэй холбоотой шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой бөгөөд жишээ нь 2014 оны ОУИТБС-ын тайланг блэтгэж байхад Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яамнаас олгосон байгаль орчны 250 гаруй тусгай зөвшөөрлийн 120-ийг нь ил тол болгох хүсэлт гарган амжилтад хүрч байжээ.

ОУИТБС-ын Ажлын албанаас хэлэхдээ мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаанд, ялангуяа хөдөө орон нутагт, биечлэн бус харин ОТОБ-ийн болон Үндэсний зөвлөлийн бус талуудыг нилээн төлөөлүүлэх хандлага нэмэгдэж буй ч иргэний нийгмийн оролцогч тал нь ийм төрлийн үйл ажиллагааны хамгийн идэвхтэй оролцоо бүхий тал байна. Гэхдээ ТАН эвслийн хэд хэдэн гишүүд мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаанд Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүд хангалттай оролцдоггүй тухай мэдэгдэж байв.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс хийж буй анхдагч үнэлгээгээр Монгол улс нь энэхүү шаардлагыг

⁶² ОТОБ-ын дарга Б.Батбаярын 2016 оны 4 сарын 22-ны хурал дээр хэлсэнээр. АХ-ын 4 дүгээр хурлын тэмдэглэл, 2016/4/22, нийтлэгдээгүй. (2016 оны 7 сарын 9-ны байдлаар).

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

биелүүлэхэд хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан гэж дүгнэж байна. Иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийхэд бүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцож байна. Оролцогч талууд нь мэдээлэл түгээх болон сурталчлах үйл ажиллагаа, олон нийтийн хэлэлцүүлэг зэрэгт тэр дундаа орон нутагт болж буй арга хэмжээнд оролцож байна. ОУИТБС дахь иргэний нийгмийн оролцооны бодит орчин бүрдэн тогтжээ. ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог 2 иргэний нийгмийн эсвэл нь ОУИТБС-ын асуудлаар өөрсдийн мэдээлэх, сурталчлах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр судлан үзэж, ОУИТБС-ын хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх болмжийг эрэлхийлэх нь зүйтэй. ТАН эвслийн шинэ вебсайт⁶³ (зөвхөн Монгол хэл дээр) нь хамгийн сүүлд 2016 оны 5 дугаар сард шинэчлэгдсэн ба 2013, 2014, 2015 онуудын ТАН эвслийн ажлын төлөвлөгөөг багтаажээ. Хэийгээр Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь Засгийн газрын (Уул уурхайн яам, Байгаль орчны яам) санхүүжилтээр, зарим чиг үүргийг нь төлбөртэй гүйцэтгэж байсан гэж хэлж байсан ч энэ нь иргэний нийгмийн байгууллагын хараат бус байдалд нөлөө үзүүлээгүй байна.

ОТОб-ийн засаглал болон үйл ажиллагаа (#1.4)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОТОб-ын бүрэлдэхүүн, гишүүнчлэл: Монгол улсад ОУИТБС-ын хэрэгжилтийг үндсэн хоёр бүтэц удирдан чиглүүлдэг нь ОТОб болон Үндэсний зөвлөл юм. Ихэнх өдөр тутмын үйл ажиллагааг ОТОб-ын зөвшөөрсөнөөр Ажлын хэсэг эрхлэн явуулдаг бол Үндэсний зөвлөл нь улс төр, бодлогын дэмжлэг үзүүлэх болон үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хүлээдэг. ОТОб болон Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлүүдэд хийсэн шинжилгээ болон оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх үйл ажиллагааны үр дүнд ОТОб нь шийдвэр гаргах үүрэгтэй харин үүнийг Үндэсний зөвлөл батлах үүргийг хүлээж байна. Тиймээс доор дурдсан үнэлгээ нь ОТОб дээр түлхүү суурилсан болно.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл нь 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр байгуулагдсан бөгөөд 2016 оны 6 дугаар сарын байдлаар нийт 30 гишүүнтэй буй ба жагсаалтын Хавсралт А дээр харууллаа⁶⁴. Тус зөвлөлд Засгийн газрыг төлөөлсөн 10 гишүүн буюу Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг болон Уул уурхайн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яам, УИХ-ын Төсвийн байнгийн хорооны төлөөлөл, Монгол улсын Ерөнхий аудитор, Үндэсний статистикийн хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дарга болон Төв аймгийн Засаг дарга нар багтаж байна.

ОУИТБС-ын ОТОб нь 2006 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан бөгөөд 2016 оны 6 дугаар сарын байдлаар 33 гишүүнтэй байна (Жагсаалтыг Хавсралт А дээр үзнэ үү).⁶⁵ ОТОб-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд ОТОб-ийн дарга болон Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Батбаяр (Баабар) болон Үндэсний зөвлөлд гишүүнчлэл бүхий төрийн яамдын харьяа агентлагуудын төлөөлөл багтаж байна. 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр анхлан батлагдсан Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны журмын 25 дугаар зүйл дээр Үндэсний зөвлөлийг Засгийн газрын эрх мэдлийн хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Уул уурхайн яамны чиг үүргийн хүрээнд байгуулагсан

⁶³ <http://pwyp.mn/>

⁶⁴ Олон улсын Ажлын алба нь төрийн төлөөлөл 9 сар гэхэд солигдож магад гэж үзэж байгаа.

⁶⁵ ҮЗ болон АХ-ын гишүүдийн нэр, холбоо барих хаяг ОУИТБС-ын вебсайт дээр байгаа (<http://www.eitimongolia.mn/en/national-council> and <http://www.eitimongolia.mn/en/working-group>). Мөн Хавсралт А дээр үзэж болно.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

байна.⁶⁶

ОТОб-ийн бүрэлдэхүүнийг Монголын ОУИТБС-ын ОТОб-ийн журамд тусгасан байдаг ба тус журмыг 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Үндэсний зөвлөл баталж, хамгийн сүүлд 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулжээ.⁶⁷ 2007 оны 3 дугаар сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Засгийн газрын 80 дугаар тогтоолоор ОУИТБС-ын үйл ажиллагаанд хамаарах төрийн байгууллагуудын гол чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.⁶⁸ ОУИТБС-ыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, Засгийн газар, иргэний нийгэм болон компаниудын хамтын ажиллагааг бий болгох тухай гурван талын Харилцан ойлголцлын санамж бичгийг 2007 оны 4 дүгээр сард гаргаснаар ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох талуудыг тодорхойлсон байна.⁶⁹ 2012 оныг хүртэл Үндэсний зөвлөл болон ОТОб-ын гишүүдийг Ерөнхий сайдын захирамжаар санал болгож байсан ч⁷⁰ Засгийн газрын 222 дугаар тогтоолоор Ерөнхий сайд гишүүдэд нэр дэвшүүлэх болж харин томилох эрхийг нь Уул уурхайн үндэсний ассоциац болон ТАН эсвэл, Монголын байгаль орчны иргэний зөвлөлд шилжүүлсэн байна. ОТОб-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл дээр Засгийн газрын тогтоолд заасан ижил тооны гурван талын төлөөлөлтэй байх зарчмыг мөн баталгаажуулжээ.⁷¹ Эдгээр бүтэц дэхь төрийн байгууллагуудын төлөөлөл нь тухайн бүтцүүдийн дарга нар, дэд дарга нар болон Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг мөн гүйцэтгэж байна. ОТОб-ын үйл ажиллагааны журам дээр ТББ-уудын гишүүнчлэлийн ямар нэгэн шалгуур болон төрийн төлөөлөл давуу эрх мэдэлтэй байх тухай дурдагдаагүй байна. Үндэсний зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйл дээр иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөлийн хуралдаанаас сонгоно гэж тусгайлан заасан бол салбарын төлөөллийг уул уурхай, газрын тосны компаниуд тэдний гэрээт компаниудын дундаас сонгоно гэсэн бол ОТОб-ийн ажиллах журамд оролцогч талуудын бүлэг бүрийн ахлах төлөөлөл буюу Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал болон ТББ-уудын эвслийн зохицуулагч хэмээн дурджээ. Эдгээр ахлах төлөөлөл нь ОТОб-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх үүргийг хүлээдэг.

Засгийн газрын хувьд Засгийн газрын 222 дугаар тогтоол нь дээрх хоёр бүтцэд төрийн байгууллагууд болон тэдгээрийн төлөөлөл болж орох албан тушаалтныг заасан байна. 222 дугаар тогтоолын 5 дугаар зүйл дээр (онлайн үзэх боломжтой⁷²) Монгол улсын Ерөнхий сайд нь төрийн байгууллагууд, хууль тогтоох байгууллагуудын Үндэсний зөвлөл болон ОТОб-т ажиллах төлөөллийг томилох үүргийг хүлээнэ хэмээн тодорхойлжээ. Тиймээс эдгээр албан тушаалтнуудад шинэ хүн томилогдох бүрт ОУИТБС-ын бүтцүүдэд буй гишүүд солигдож буй бөгөөд энэ талаар ОУИТБС-ын Ажлын албанд заавал мэдэгдэж байх шаардлагагүй юм (иргэний нийгэм болон салбарын гишүүдийг томилох журамтай харьцуулбал эсрэгээр).

Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мөн гэрээт компаниуд бүхий 120 гаруй гишүүн бүхий Монголын уул уурхайн үндэсний ассоциац нь олборлох салбарыг төлөөлөх гишүүдийг нэр дэвшүүлэх үүргийг хүлээдэг. Тус байгууллагын гишүүнчлэлийн

⁶⁶ ҮЗ-ийн журам (http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITI_National_Council_TOR_in_English.pdf).

⁶⁷ Ажлын хэсгийн журам (http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/ToR_of_MSWG_Mongolia_EITI.pdf)

⁶⁸ Монгол хэл дээр, ОУИТБС-ын вебсайт дээр (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/80%20-%202007.03.28.pdf>).

⁶⁹ Санамж бичиг ОУИТБС-ын вебсайт дээр байгаа

(http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/MoU_Mongolia_EITI.pdf)

⁷⁰ Анхлан нэр дэвшүүлэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг 2010 оны Баталгаажуулалтын тайлангийн Хэсэг 3-7 (х.6-10) дээр үзнэ үү - <https://eiti.org/files/Mongolia%20Final%20Validation%20Report.pdf>

⁷¹ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/ToR_of_MSWG_Mongolia_EITI.pdf

⁷² http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/Government_Resolution_222_English.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хувьд нийт гишүүдийн бараг хагас нь уул уурхайн салбарт үйлчилгээ үзүүлэгч компаниуд буй, мөн Монгол улсад 1000 гаруй компани тусгай зөвшөөрөл эзэмшиж буйтай харцуулбал хэт бага байна. Уул уурхайн үндэсний ассоциац нь гишүүн бус компаниуд ОУИТБС –д тайлан гаргах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор өөрийн гишүүдээр хязгаарлалгүйгээр мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагаа явуулж байна. 2012 оныг хүртэл Уул уурхайн үндэсний ассоциац нь Үндэсний зөвлөл болон ОТОБ дэхь олборлох салбарын төлөөлөлд нэр дэвшүүлэх бүрэн эрхийг эзэмшиж байсан байсан ч үүний дараа Ажлын албаны зүгээс Газрын тосны газартай харилцан зөвлөлдсөний үндсэн дээр газрын тосны хоёр компанийг (Петро Чайна Дачин Тамсаг болон Петроматад) Үндэсний зөвлөл болон ОТОБ-т ажиллуулах болжээ. Засгийн газрын 222 дугаар⁷³ тогтоолоос өөр салбарын төлөөллийг нэр дэвшүүлэх талаарх ямар нэгэн бичгээр гарсан дүрэм байхгүй тул 222 дугаар тогтоолын дагуу Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч нь компаниуд болон уул уурхайн, газрын тосны чиглэлийн холбоодын төлөөллийг нэр дэвшүүлэн томилуулж байна. Жил тутмын 1 дүгээр сарын сүүлийн Лхагва гаригт болдог ерөнхий чуулганаараа Уул уурхайн үндэсний ассоциац нь өөрийн гишүүдээс ОУИТБС-ын санаачилгын бүтцэд ажиллахын сонирхож буй талаар хүсэлтийг нь авдаг байна. Хэдийг хангалттай тоогоор сонирхлоо илэрхийлдэггүй ч Уул уурхайн үндэсний ассоциац нь боломжит өрсөлдөгч нарыг сонгож, том болон жижиг компанийн төлөөллийг тэнцвэртэй оруулж, мөн төрөл бүрийн ашигт малтмалын компаниудыг багтаахыг зорьдог ажээ. Гэхдээ Уул уурхайн үндэсний ассоциац нь нэр дэвшүүлэхээс өмнө компаниудад хандсан мэдээлэл өгөх арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй болохыг салбарын зарим төлөөлөл уулзалтын үеэр дурдаж байв. Уул уурхайн үндэсний ассоциац нь ОУИТБС-ын Ажлын албатай хамтран аль нэг гишүүн нь хуралдаан дээр давтан хүрэлцэн ирэхгүй бол тэднийг солих арга хэмжээг авдаг болжээ. Уул уурхайн салбарын төлөөлөлд шинэчлэл хийсэн хамгийн сүүлийн жишээг доор харууллаа (газрын тосны компаниудын төлөөлөл 2012 оноос хойш өөрчлөгдөөгүй):

- 2012 оны 9 дүгээр сар: Үндэсний зөвлөл болон ОТОБ-т буй уул уурхайн бүх 9 компанийн төлөөллийг сольсон.
- 2014 оны 2 дугаар сар: Үндэсний зөвлөл болон ОТОБ-т буй буй уул уурхайн 9 компанийн төлөөллийг сольсон.
- 2014 оны 6 дугаар сар: Үндэсний зөвлөл болон ОТОБ дээр нэг өөрчлөлт хийгдсэн нь ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа Ерөнхийлөгч болж дэвшсэнээр ОТОБ-ээс Үндэсний зөвлөлд шилжин ажиллах болсон.
- 2014 оны 12 дугаар сар: Үндэсний зөвлөлийн нэг гишүүн солигдсон.

Монголын алт үйлдвэрлэгчдийн холбоог төлөөлөн ОТОБ-т ажиллаж байсан С.Бүрэнтогтох түс холбоон дахь ажлаасаа 2015 онд гарсан ч 2016 оны 1 дүгээр сарын дуустал түүний орны хүн холбоон дээр томилогдох хүртэл ОТОБ-ийн гишүүний үүрэгт ажлаа гүйцэтгэсэн байна.

Иргэний нийгмийн оролцооны хувьд ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөл нь ОТОБ дэхь иргэний нийгмийн төлөөллийг нэр дэвшүүлдэг байна. Мөн тухайн бүтцүүдийн хамаарах журмуудад нэг гишүүний ажиллах дээд хугацаа эсвэл хязгаарыг заагаагүй. Ерөнхий сайд С.Батболдын гаргасан Засгийн газрын 222 дугаар тогтоол дээр “иргэний нийгмийн эвсэл” (тогтоол дээр шууд нэр дурдан заагаагүй ч байнга ТАН эвсэл байсаар ирсэн) хэмээн заасан бөгөөд энэхүү эвсэл нь Үндэсний зөвлөлд 8, ОТОБ дээр 9 суудлыг хянаж харин тогтоолд заасан “байгаль орны иргэний нийгмийн

⁷³ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/Government_Resolution_222_English.pdf

эвсэл” (Тогтоол дээр шууд заан дурдаагүй ч Байгаль орчны иргэний зөвлөл энэ үүргийг гүйцэтгэж буй) нь Үндэсний зөвлөл болон ОТОБ дээр тус бүр 2 суудалтай байна. Байгаль орчны иргэний зөвлөлийн хувьд Үндэсний зөвлөл болон ОТОБ-д ажиллах өөрийн гишүүн ТББ-ыг сонгох ямар нэгэн бичгээр гаргасан дүрэм журам байхгүй. ТАН эвсэлийн Удирдах зөвлөлийн дүрэмд ОУИТБС-ын бүтцэд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэнэ, мөн тухайн асуудлыг эвсэлийн Удирдах зөвлөл 2 жил тутам эргэн авч үзнэ хэмээн заасан байдаг бөгөөд мөн хоёр жил тутам ТАН эвсэлийг төлөөлсөн 7 гишүүний гурав нь заавал солигдож байх шаардлагыг тавьсан байна.⁷⁴ Хамгийн сүүлд Үндэсний зөвлөл болон ОТОБ-д шинээр сонгогдох гишүүдийг нэр дэвшүүлэхдээ ТАН эвсэлийн зохицуулах хорооны 2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар нууцаар санал хураан тодруулсан байна.⁷⁵ Тус хуралдаанаар иргэний нийгмийг төлөөлөн ОУИТБС-ын бүтцэд ажиллах гишүүдийн үр чадварын талаар (объектив байдал, судалгаа дүн шинжилгээ хийх чадавхи болон санал бодлоо илэрхийлэх чадвар гэх мэт) хэлэлцжээ. Харин Байгаль орчны иргэний зөвлөлийн хувьд нэр дэвшүүлэхдээ өөрийн гишүүн бус байгууллагуудад хүрч ажиллаж байгаагүй ажээ. ТАН эвсэлийн хувьд нэр дэвшүүлэхээс өмнө бусад ТББ-уудад хандан, нэр дэвшүүлэх талаар мэдээлэл түгээдэг нь ТАН эвсэлд нэгдэхийг үрих зорилгын мөн агуулж буй бөгөөд энэ нь ТАН эвсэлийн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ОУИТБС-ын үйл явцад оролцохоос гадна эвсэлийн эгнээг өргөжүүлэх гэсэн заалтын хүрээнд хийгдэж байна.

ТАН эвсэл нь үндсэндээ хоёр удаагийн сонгон шалгаруулах үйл явцыг хийдэг ба юуны өмнө эвсэл нь “олборлох салбарын талаарх мэдлэгтэй”⁷⁶ хүмүүсийг тодорхойлох ба үүнийг албан бус сонгуулийн үйл ажиллагаатай цуг хийдэг ба харин эдгээр хоёр төрлийн гишүүдийн хооронд ямар нэгэн тогтоосон хязгаар байхгүй байна. Байгаль орчны иргэний зөвлөлийн нэр дэвшүүлэх асуудлыг Сүлжээний удирдах зөвлөлөөс гурван жилийн хугацаагаар сонгогдон ажилладаг Гүйцэтгэх захирал тушаал гарган, түүний сонголтоор шийддэг ч Үндэсний зөвлөл болон ОТОБ-т ажиллах гишүүдийг нэр дэвшүүлэхэд ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөлийн хүлээх үүргийг заасан 222 дугаар⁷⁷ тогтоолын 6 дугаар заалтаас өөр баримтлах ямар нэгэн дүрэм, журам байхгүй буй юм. ТАН эвсэл нь Үндэсний зөвлөл болон ОТОБ-т өөр өөр гишүүдийг илгээн ажиллуулж буй бол эдгээр хоёр бүтэц дэхь Байгаль орчны иргэний зөвлөлийн хоёр гишүүн нь хувь хүн нь өөрчлөгдсөн ч гэсэн тус зөвлөл дэхь албан тушаал нь огт өөрчлөлтгүй буй юм. ТАН эвсэл нь үндсэндээ дээрх хоёр бүтцэд буй өөрийн гишүүдийг үндсэндээ доор дурдсанчлан хоёр жил тутамд сольж байна:

- 2013 оны 5 дугаар сар: Үндэсний зөвлөл дэхь бүх 8 гишүүн болон ОТОБ дэхь бүх 9 гишүүнийг сольсон.
- 2015 оны 7 сар: Хоёр бүтэц тус бүр дээр өөрийн 3 гишүүнийг өөрчилсөн.

Үндэсний зөвлөл болон ОТОБ дэхь Байгаль орчны иргэний зөвлөлийн төлөөлөл илүү ойр ойрхон солигдож иржээ. Байгаль орчны иргэний зөвлөлийн Гүйцэтгэх захирал нь ОУИТБС-ын Ажлын албанд өөрийн төлөөллийг өөрчилсөн тухай албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй ч хамгийн сүүлд хийгдсэн өөрчлөлтийн талаар мэдэгдсэн албан бичигт (2015 оны 11 дүгээр сард) тус зөвлөлийн Ерөнхийлөгч гарын үсэг зурсан нь тогтсон журмаас бага зэрэг хазайсан хэрэг байв. Хамгийн сүүлд доорх өөрчлөлтүүд хийгдсэн байна:

⁷⁴ <https://drive.google.com/file/d/0B-z15B6VRn2iQk5EX3RJVFqVFU/view> ТАН эвсэлийн ерөнхий хуралдааны тэмдэглэл (хэвлэгдээгүй).

⁷⁵ ТАН Зохицуулах хороо, 2015/3/31, ТАН эвсэлээс гарган өгсөн.

⁷⁶ ТАН эвсэлтэй хийсэн уулзалтаас.

⁷⁷ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/Government_Resolution_222_English.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

- 2014 оны 11 дүгээр сар: хоёр гишүүнийг өөрчилсөн.
- 2014 оны 12 дугаар сар: хоёр гишүүнийг өөрчилсөн.
- 2015 оны 1 дүгээр сар: хоёр гишүүнийг өөрчилсөн.
- 2015 оны 11 дүгээр сар: Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн нэг нэг гишүүнийг өөрчилсөн.
- 2016 оны 4 дүгээр сар: Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн нэг нэг гишүүнийг өөрчилсөн.

Хоёр эвсэл нь нь нэр дэвшүүлэх үйл ажиллагаа эхлэхээс өмнө дангаараа зөвхөн өөрийн гишүүдийн талаар л цахим шуудангаар хоорондоо харилцдаг ажээ.

Үйл ажиллагааны журам/ ажлын тодорхойлолт: ОТОБ-ийн Үйл ажиллагааны журмыг хамгийн сүүлд 2012 оны 4 дүгээр улиралд өөрчлөн, 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр ОТОБ баталгаажуулсан байна⁷⁸. Ажлын журманд оруулсан гол өөрчлөлт нь ОТОБ-ийн уулзалтуудыг ээлжлэн даргалах болон хэрэв шаардлагатай бол хуралдааныг цахим хэлбэрээр хийж болох тухай тусгажээ. Энэхүү өөрчлөлтийн дагуу хуралдааныг ээлжлэн даргалах нь 2014 оныг хүртэл үргэлжилсэн бөгөөд тухайн оны 3 дугаар сард ОТОБ-ын хуралдааныг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөлөл болох Н.Алгаа, 1 дүгээр сард Уул уурхайн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Нэргүй нэр даргалан явуулжээ. Харин 12 дугаар сард Ерөнхий сайдын ахлах зөвлөхөөр Б.Дэлгэрмаа томилогдсоноос хойш зохион байгуулагдсан хуралдаануудыг ээлжлэн даргалах нь зогсож (2015 оны 5 болон 10 дугаар саруудад), ахлах зөвлөх өөрөө хуралдаануудыг даргалан хийх болжээ. Харин Б.Дэлгэрмаа солигдсоноос хойш Ахлах зөвлөхөөр томилогдсон Б.Батбаяр 2016 оны 4 дүгээр сард зөвхөн нэг удаагийн хурлыг даргалан явуулжээ.

Ажлын хэсгийн журмын 8-44 дүгээр зүйл дээр дотоод засаглал болон үйл явцуудын талаар дурдсан байдаг. 9 дүгээр зүйл дээр хуралдааныг ОТОБ-н даргын зөвшөөрлөөр хийнэ хэмээн заасан ч хуралдааны давтамж эсвэл хуралдаан зарласан тухай урьдчилан мэдээлэх хугацаа зэргийг заагаагүй. Хуралдаануудыг ОТОБ-ийн даргын зөвшөөрлөөр хийж буй бөгөөд дарга эзгүй үед Үндэсний зөвлөл эсвэл ОТОБ-ын гишүүнийг томилон ажиллуулна. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдааны бэлтгэл ажлыг хариуцна. Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн ажиллах журмын аль аль нь хуралдааны давтамжуудын тухай дурдаагүй, зүгээр л “шаардлагатай тохиолдолд” хэмээн заажээ.

ОТОБ-ийн ажиллах журмын 13 дугаар зүйл дээр хурлын хэлэлцэх асуудлууд, хамаарах баримт бичгүүдийг хурлын өмнө гишүүдэд 4-өөс доошгүй өдрийн өмнө тараах ба 16 дугаар зүйл нь хуралдаан хүчин төгөлдөр болоход шаардлагатай ирцийг заасан байна. Нийт гишүүдийн дийлэнх нь хүрэлцэн ирж, оролцсон тохиолдолд хуралдаан хүчин төгөлдөрт тооцогдоно. ОТОБ-ийн ажиллах журмын 18 дугаарт зааснаар хурлын тэмдэглэлийг хийж, үүнийг ОТОБ-ийн нарийн бичгийн эсвэл Ажлын хэсгийн ажилтан гарын үсэг зуран баталгаажуулна. Тус журмын 3 болон 8.4 дээр зааснаар оролцоот шийдвэр гаргах ба үүний арга замуудыг төлөөлөгчдийн ахлагч нар тохиролцох, эксперт эсвэл түр ажлын хэсэг байгуулан асуудлыг дахин судлах зэрэг боломжуудыг хангасан байна. Зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд санал хураан шийдэх тухайн ямар нэгэн заалт байхгүй, энэ тохиолдолд зөвшилцөх заалт байхгүй буй нь тухайн шийдвэрт ямар нэгэн байдлаар талууд санал нийлэх шаардлагыг үүсгэж байна. ОТОБ-ийн журмын 8.4 дээр хэлэлцэх асуудалд хурал эхлэхээс өмнө нэмэлт санал оруулах хүсэлт гаргаж болох ба энэхүү саналыг бичгээр гарган, өөрийн төлөөлж буй бүлгийн саналыг авсан байх шаардлагатай юм.

⁷⁸ Сэдэв V (х.15-17) Ү3-ийн 10 дугаар хурлын тэмдэглэл (2012/11/28), http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_10_2012.11.28.pdf

Ажлын хэсгийн ажиллах журмын 12, 25- 28 дугаар заалтад ОТОБ-ийн үүрэг роль, хариуцах зүйлс болон бусад шаардлагуудыг дурдсан ба мөн тайлан гаргах үйл явц дахь ОТОБ-ийн хяналт хийх үүргийг дурдсаны тоонд Хараат бус нэгтгэгчийн гүйцэтгэх ажлын тодорхойлолтыг зөвшилцөх, Хараат бус нэгтгэгчийг томилох, үйл ажиллагааг нь хянах, жилийн ажлын төлөвлөгөөний төслийг гаргах зэрэг олон үйл ажиллагааг багтаажээ. Харин ОТОБ-ийн ажлын журамд иргэний нийгмийн бүлэг болон компаниудтай хамтран мэдээлэл түгээх үйл ажиллагааг явуулах тухай ямар нэгэн заалт байхгүй. Гэхдээ ОУИТБС-ын Ажлын албаны вебсайт дээр дурдсанаар мэдээлэл түгээх үйл ажиллагаа нь Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааны байнгын нэг хэсэг нь ажээ. Ажиллах журам нь оролцогч талын бүлэг нэг бүрийн зүгээс нэр дэвшүүлэхдээ бусдын зүгээс гаргасан санал болон дарамтаас хараат бус байхыг баталгаажуулсан, мөн үзэл бодлын олон талт байдлын талаар заасан заалт үгүй байна.

Мөн ОТОБ-ийн гишүүд нь өөрийн үүрэгт ажлыг хийж гүйцэтгэх чадавхийн тухай дурдсан, үүнийг баталгаажуулсан заалт байхгүй.

Хэдий ОУИТБС-ын стандартад тусгагдаагүй ч ОТОБ-ийн ажиллах журам нь ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчлийн талаар аль ч засаглалын баримт бичигт заагаагүй байна. Эцэст нь бүлгийн гишүүдийн зүгээс нууцлал бүхий мэдээлэлтэй хэрхэн харилцах тухай заалт байхгүй.

ОТОБ-ийн ажиллах журамд тодорхой сэдвээр ажиллах, эргэн ОТОБ-д тайлагнах түр ажлын хэсгийн талаар шууд заасан зүйл байхгүй ч 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл нь 2015 онд хийгдсэн 2013 оны ОУИТБС-ын тайлангаар гарсан зөвлөмжүүд нэг бүрээр байгуулсан 5 ажлын хэсгийн тухай заажээ. Гэхдээ эдгээр ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын даалгавар байхгүй эсвэл байгаа ч энэ нь олон нийтэд нээлттэй бус байна. Практик дээр эдгээр ажлын хэсгийн уулзалтуудын тэмдэглэлийг ОУИТБС-ын Ажлын албанаас л авч болох ба Олон улсын ажлын албаны ойлгож буйгаар эдгээр тэмдэглэлийг авах хүсэлтийг өмнө нь аль ч талаас гаргаж байгаагүй ажээ.

ОТОБ нь ОТОБ-ын гишүүд аялалаар явах үед олгох томилолтын мөнгө, төлбөртэй холбоотой бодлогоо ил тод болгох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. 4 дүгээр сард ОУИТБС-ын хамаахалтай албан томиллод баримтлах Сангийн Яамнаас гаргасан журмыг санаачилгын вебсайт⁷⁹ дээр байршуулжээ. Эдгээр дүрмийг одоо ОУИТБС-ын хүрээнд даган мөрдөж буй бөгөөд гишүүдэд төлж буй өөр ямар нэгэн төрлийн талбар байхгүй.

Хуралдааны оролцоо, ирц: Үндэсний зөвлөл нь 2006 болон 2016 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 14 удаа хуралдсан бол ОТОБ нь мөн хугацаанд 40 удаа хуралдсанаас 2013 онд 3 удаа, 2014 онд 2 удаа, 2015 онд 3 удаа, 2016 оны эхний хагаст 1 удаа хуралдаад байна.⁸⁰ ОТОБ-ийн уулзалтууд эхэндээ Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн байранд явагддаг байсан ч иргэний нийгмийн зүгээс салбарын төлөөллийн байранд хуралдах нь зохисгүй гэж үзсэний дүнд хурлыг Уул уурхайн яаман дээр хуралдуулах болжээ. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс Үндэсний зөвлөлийн хэд хэдэн хуралдаан дээр төрийн байгууллагыг төлөөлөн сонгогдсон албан тушаалтнууд өөрсдөө буй харин өөр хүн томилон явуулах болсон эсвэл өөрсдөө оролцсон ч оролцооны түвшин нь тааруу болсоныг тэмдэглэн хэлж байв.⁸¹

⁷⁹ <http://eitimongolia.mn/en/regulations>

⁸⁰ 2016 оны 7 сарын 1-ний байдлаар.

⁸¹ Жишээ нь ҮЗ нь 2012/11/20 нд Ажлын даалгавар хэлэлцсэн. Topic V (pp.15-17) ҮЗ-ийн 10 дугаар хурлын тэмдэглэл (2012/11/28), http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_10_2012.11.28.pdf

Бодит байдал дээр Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн хуралдаанууд дахь иргэний нийгмийн байгууллагуудаагуудын оролцоо мөн л ойр орхон өөрлөгдөж ирсэн бөгөөд жишээ нь ТАН эвсэл хэлэхдээ ихээхэн уян хатан байдалтай ажилладаг бөгөөд бүх гишүүд нь хурлаас өмнө өөрсдийнхөө баримтлах байр суурин дээр зөвшилцөж, хэлэлцүүлгийн үеэр зохистой үр дүнд хүрэхээр эрмэлздэг байна. Мөн сонгогдсон гишүүд өөрсдийнхөө оронд төлөөллөө илгээн оролцуулахдаа ОУИТБС-ын Ажлын албанд заавал урьдчилан мэдэгдэж байх тухай Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан талаар үндсэндээ ойлголт дутмаг, бүх гурван талын төлөөлөл мэдэгдэж байх шаардлагагүй хэмээн үзэж байна. Бодит байдал дээр ОУИТБС-ын Ажлын алба нь Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн бүх гишүүдтэй утсаар холбогдож хурлын зарыг түгээдэг бөгөөд өмнөх өдөр нь мөн дахин баталгаажуулан мэдээлдэг байна.

Хэдий Үндэсний зөвлөлийн хэд хэдэн хуралдаанаар (Хамгийн гол нь 2012 оны 11 дүгээр сарын 28-ны хуралдаанаар) Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн гишүүдийн хуралдаанд оролцсон ирцийг ОУИТБС-ын вебсайт дээр нийтлэх тухай хэлэлцсэн ч энэ нь бодит хэрэг дээр хэрэгжээгүй байна. Ажлын алба нь өмнө хийгдсэн бүхий л хуралдааны ирцийг Эксел файлаар хадгалж байна.

Орчуулга: Англи хэлнээс Монгол хэлэнд орчуулахад зарим онцлог хүндрэлүүдтэй нүүр тулгарч буй юм. Зарим тохиолдолд Монгол хэл дээрх нэг үг Англи хэл дээрх хэд хэдэн өөр утгыг илэрхийлж болох ба жишээ нь дэмжих (encouragement/support), сурталчлах (promote/advertise) болон хариуцлага (accountability/responsibility) гэх мэтээр орчуулагдаж болно. НҮБ-ын зүгээс 2014 онд засаглалын нэр томъёоны толь гарган accountability хэмээх Англи үгэнд дүйцэх Монгол тайлбарыг гаргасан байна. Гэхдээ энэхүү үг нь тэр бүр хэрэглэгдэхгүй тул Монгол улсын хувьд тухайн үндсэн утга нь тийм ч өргөн хүрээний ойлголт бий болгоогүй буй юм. Үүний нэгэн адил transparency хэмээх үг нь Монгол хэл дээр гурван үгээр орчуулагдаж буй юм. Илүү өргөн хүрээнд авч үзвэл Монгол улсын хувьд шинээр хэрэглэгдэж буй шинэ үг хэллэгийн утгын талаар бүрэн хэмжээнд зөвшилцөлд хүрээгүй буй тул Засгийн газраас гол хэрэгдэж буй үгсийг хэрхэн бичих, ямар утгаар ойлгох тухай тодруулах тусай комиссыг ч ажиллуулах болжээ. Адам Смит Интернейшнл байгууллага нь 2013 оны ОУИТБС-ын стандартыг Монгол хэлэнд орчуулуулсан болон Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага 2016 оны стандартын орчуулгыг 2016 оны 3 дугаар сард хийлгэж, мөн иргэний нийгмийн протокол болон үнэлгээний журмыг орчуулсан байна.

Ороцогч талуудын санал бодол

ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцдог бүх гурван оролцогч талын хэд хэдэн төлөөллийн зүгээс Үндэсний зөвлөл нь үндсэндээ билэг тэмдэгийн чанартай бөгөөд Уул уурхайн сайдаас өөр төрийн өндөр албан тушаалтнууд хуралдаанд бараг биечлэн ирдэггүйг дурдаж байв. Ерөнхий сайд болон Сангийн сайд нар өнгөрсөн 4 жилийн хугацаанд Үндэсний зөвлөлийн хуралдаанд огт оролцоогүйг мөн хэлж байв. ОУИТБС-ын Ажлын албанаас Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа ажиллаж байх үед ОТОБ-ийн хурлыг талууд ээлжлэн даргалахаа больсон ч энэ талаар албан ёсоор зарлаагүй байна. Уулзан зөвлөлдсөн бүхий л оролцогч талуудын хэлж буйгаар ОТОБ нь үр дүнтэй шийдвэр гарган, ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдаж буй гол бүтэц болж байна. Иргэний нийгмийн бүх төлөөлөл үндсэндээ шийдвэрийг ОТОБ дээр гаргадаг ба үүнийг Үндэсний зөвлөл зүгээр л баталгаажуулдаг гэдэгтэй санал нэгдэж байна. Хамаарах баримт бичгүүдийг урьдчилан илгээдэг ч төрийн байгууллагыг төлөөлсөн зарим хүмүүсийн хэлж буйгаар цаг хугацаа шахуу ажлын ачаалал их байдгаас хамааран тэр болгон өөрсдийн саналыг өгч чаддаггүй ажээ. Бодит хэрэг дээр ОУИТБС-ын Ажлын алба нь хуралдааныг нэг долоо хоногийн өмнө төлөвлөн, хуваарь гаргаж, гишүүдэд хуралдааны хөтөлбөрийн төсөл, хамаарах баримт бичгүүдийн цахим шуудангаар 4-өөс доошгүй

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хоногийн өмнө урьдчилан илгээдэг ажээ. ОУИТБС-ын тайлангийн төслийг ч товлосон уулзалтаас 4-өөс доошгүй хоногийн өмнө цаасан хэлбэрээр мөн хүргүүлдэг ажээ. Иргэний нийгмийн зарим хүмүүсийн зүгээс хэдийгээр боломжтой хэмээн талууд зөвшөөрсөн ч хөтөлбөрийн төсөл дээр нэмэлт сэдэв оруулах нь хүндрэлтэй гэж дүгнэж байна. Үүний шалтгаан нь тухайн хөтөлбөрийг гурав хоногийн өмнө илгээдэг тул нэмэлтээр хэлэлцэхээр санал болгон оруулах сэдэвт хамаарах мэдээлэл, материалыг цуглуулан бэлтгэхэд цаг хүрэлцээтэй бус байдаг ажээ. Иргэний нийгмийн зарим төлөөллийн зүгээс иргэний нийгмийн байгууллагууд нь хурлын хэлэлцэх асуудлуудыг илгээхээс өмнө зарим нэмэлт материалыг бэлтгэж болох ч иргэний нийгмийн чадавхийн асуудлаас үүдээд энэхүү асуудал хүндрэлд ордогыг цохон тэмдэглэсэн. Компаниуд болон Засгийн газрын төлөөлөл нь ОУИТБС-ын хамааралтай үүргээ биелүүлэхэд тулгарч буй чадавхитай холбоотой ямар нэгэн асуудлын талаар тусгайлан дурдаагүй.

Олборлох салбарын компаниудыг төлөөлсөн зарим төлөөллийн үзсэнээр Үндэсний зөвлөл, ОТОБ-ийн аль аль нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулдаггүй, зөвшилцөлд суурилсан шийдвэр гаргалт нь байнга хүндрэлтэй нүүр тулдаг нь тал бүрийг төлөөлсөн олон тооны гишүүдтэйгээс (нэг талаас 11) шалтгаалдаг тул энэхүү тоог бууруулан Ашигт малтмалын газар болон Татварын ерөнхий газар зэрэг гол байгууллагуудыг л үлдээх хэрэгтэй гэж үзэж байна. Ажиллах журам нь Үндэсний зөвлөл болон ОТОБ дээр зөвхөн зөвшилцөлд суурилан шийдвэр гаргана хэмээн заасан ч үүнийг бодит байдал дээр хүндэтгэн хэрэгжүүлдэггүй, иргэний нийгмийн зүгээс бодит байдал дээр Засгийн газар болон компани нэг тал болдог гэж шүүмжилж байна. Өмнө нь ОУИТБС-ын Хараат бус нэгтгэлийг хийж байсан нэг байгууллагын төлөөллийн зүгээс уул уурхайн компаниуд нь ОУИТБС-ын тайланг бэлтгэн гаргахад хамгийн идэвхтэй байдаг ба жишээ нь хамрах хүрээ тодорхойлох шийдвэр гаргахад хамгийн их хувь нэмэр оруулан, санал өгдөг ажээ. Тухайн талын хэлсэнээр нэгтгэл хийсний дараа илэрсэн зөрүүн дээр үндэсний зөвлөл, ОТОБ болон Ажлын алба ихээхэн анхаардаг тул ОУИТБС-ын тайлангийн мэдээллийн өргөн хүрээний нөхцөл байдлын тухай мэдээлэлд анхаарахыг нь сарниулдаг гэж үзжээ. Уул уурхайн компанийн нэг төлөөллийн зүгээс (ОТОБ-ын гишүүн бус) үндсэндээ ОУИТБС-ын саначилга дахь компанийн оролцоо ихээхэн доогуур, Уул уурхайн үндэсний ассоциац л бүхий л салбарыг хэрэг дээрээ дангаар төлөөлж байна гэж үзсэн байна. Компаниуд нь үндсэндээ мэдээлэл цуглуулах шатан дээр л ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцдог ажээ.

Үндэсний зөвлөл дээр санал хураах тухай зүйл заалт баримт бичгүүдэд байхгүй ч олборлох салбар болон иргэний нийгмийн төлөөлөл нь бодит байдал дээр санал хураалт явагддаг гэж хэлж байв. Салбарыг төлөөлсөн зарим төлөөллийн хэлж буйгаар тэд ОТОБ-ын хуралдаанууд дээр санал нийлэхгүй буйгаа тэр бүр илэрхийлдэггүй учир нь энэ нь явагдаж буй үйл явцыг удаашруулахад хүргэдэг хэмээн үздэгээ илэрхийлж байсан. Үндэсний зөвлөл, ОТОБ-ийн хурлууд дээр ч санал хураалт явагдаж байсан нотолгоо байна. Хуралдааны тэмдэглэлүүдэд хийсэн дүн шинжилгээнээс харвал ОТОБ нь 2015 оны 3 дугаар сарын 11-ний хуралдаан дээр Хараат бус нэгтгэгчид төлөхөөр хуваарилсан зардлаас үлдсэн мөнгийг хуваарилах асуудлаар санал хураасан байна.⁸² Хамгийн сүүлд 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ОТОБ нь гол асуудлуудаар санал хураах системийн тухай хэлэлцсэн ба тухайн хуралд 33 гишүүний 11 нь л оролцсон тул санал хураалт хэрхэн хийх талаар санал хураах боломжгүй болжээ.⁸³ Гэхдээ ОТОБ нь 2016 оны 4 дүгээр сарын 22-ны хурлаар 33 гишүүний 16 нь ирсэн байсан ч⁸⁴ санал хураан шийдвэр гаргажээ. Үндэсний зөвлөл нь 2012 оны 11

⁸² http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/AH_35_2015.03.11_en.pdf

⁸³ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/AH_39_20151211_en.pdf

⁸⁴ ОТОБ-ын 40 дүгээр хурлын тэмдэглэл, 2016/4/22, нийтлэгдээгүй (2016 оны 7 сарын 9-ны байдлаар).

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

сарын 28-ний⁸⁵, 2013 оны 12 сарын 23-ны⁸⁶, 2015 оны 1 сарын 13-ны⁸⁷, 2015 оны 6 сарын 4-ний⁸⁸ хуралдаанууд дээрээ санал хураалт явуулсан тухай тэмдэглэл дээр тусгажээ. Дээрх бүх тохиолдолд хуралдааны тэмдэглэлд тухайн хурлаас гарсан ерөнхий үр дүнг тусган, хэдэн хувийн саналаар батлагдсан талаар тэмдэглэсэн байна. ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгчээр ажиллаж байсан байгууллагын зүгээс ОТОБ-ийн хурал дээр санал хураах нь хэвшсэн хэм хэмжээ болсон ба харин зөвшилцөлд бүрэн хүрэлгүй, үндсэндээ хоёр оролцогч тал л үндсэн шийдвэрийг гаргаж буй талаар хэлсэн. Жишээ нь 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлээс харвал иргэний нийгмийнн талаас эсэргүүцэж байсан ч Үндэсний зөвлөл нь 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай хэмээн үнэлжээ. 2016 оноос эхлэн бүх техникийн ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлүүдийг хөтөлж ирсэн ч Ажлын албаны хэлж буйгаар тухайн тэмдэглэлүүдийг вебсайт дээр байрлуулдаггүй ажээ.

Олборлох салбарын зарим төлөөлөл Олборлох үйлдвэрэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан зарим өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай тухай дурдсан ба жишээ нь Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийг нэгтгэн нэг бүтэц болгох, Ажлын албаны үүрэг ролийг өргөтгөн, илүү өндөр чадавхитай болгох зэрэг асуудлыг хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан. Засгийн газрыг ОТОБ-т төлөөлж буй нэг төлөөлөл 2016 онд УИХ-ын сонгууль болсон ч өргөн барьсан хуулийн төсөл дээр ахиц дэвшил гарч буйг тэмдэглэн хэлсэн. УИХ-ын анхны хэлэлцүүлгээр орж, хэлэлцэх эсэхийг нь шийдсэн тус хуулийн төсөл дээр УИХ-ын Ажлын хэсэг томилогдож, шинээр сонгогдсон УИХ-ын гишүүд үргэлжлүүлэн ажиллаж байна. Гэхдээ иргэний нийгмийн төлөөллийн үзэж буйгаар шинээр сонгогдсон УИХ-ын гишүүд нь тэрхүү хуулийг хялбархан буцааж болох ажээ. Гэвч шинээр сонгогдсон УИХ-ын дарга (2016 оны 7 сарын 8-ны өдөр томилогдсон) М.Энхболд (Олонх болсон МАН-ын дарга)⁸⁹ 2006-2007 онуудад Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга байхдаа ОУИТБС-ыг дэмжиж байсан тул тус хуулийг голлон дэмжих хүн хэмээн тооцогдож байна.

Иргэний нийгмийн зарим төлөөллийн үзэж буйгаар улс төрийн түвшинд байнга гарч буй өөрчлөлт нь Засгийн газрын төлөөлөл ОУИТБС-ын хурлуудад тогтвортой оролцоход саад учруулж буй ажээ. Оролцогч талуудын зүгээс хуралдаанд үргэлжлүүлэн оролцохгүй, ялангуяа төрийн төлөөллийн оролцоо тогтвортой бус буй талаар зарим хүмүүс хэлж байсан ч иргэний нийгмийн төлөөллийн оролцоонд гарч буй байнгын өөрчлөлтийн талаар ч мөн дурдаж байв. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс 2015 болон 2016 онд ОТОБ-ийн хуралдааны төр, компаниудын оролцооны талаар хэлэхдээ тухайн хуралдаан дээр нийт гишүүдийн 60-аас доош хувь нь оролцсон хэмээн мэдэгдэж байв. ОТОБ-ийн хурал нь үндсэндээ иргэний нийгмийнхэн ирдэг, иргэний нийгмийн хурал шиг болсон гэж зарим хүмүүс үзэж байна. Компаниудын зарим төлөөллийн хэлсэнээр иргэний нийгмийн байгууллагууд нь хурал бүр дээр ээлжлэн ротацийн байдлаар оролцож буй нь мэдээлэлтэйгээр шийдвэр гаргахад саад болж байна хэмээн үзжээ. Үүний зэрэгцээ иргэний нийгмийнхэн сүүлийн жилүүдэд иргэний нийгмийн оролцоо мэдрэгдэхүйц сайжирсан гэж үзэж байна. ОУИТБС-ын Ажлын албаны хэлсэнээр Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын гишүүд өөрсдөө оролцохгүй, харин төлөөллөө илгээж байсан тохиолдол хэд хэд гарсан нь тэдний сонгогдсон зорилгод үл нийцэж байна хэмээн үзэж байна. Ажлын албаны зүгээс мөн хэлэхдээ Засгийн газрын

⁸⁵ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_10_2012.11.28.pdf

⁸⁶ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_11_2013.12.23.pdf

⁸⁷ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_12_20150113_en.pdf

⁸⁸ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_13_20150604_en.pdf

⁸⁹ Лий Кашел (2016/7/6), 'Сонгуулийн тухай мэдээ', <http://blogs.ft.com/beyond-brics/2016/07/06/mongolias-election-a-protest-vote-for-the-good/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

төлөөлөл Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн хуралдаанд оролцох нь сайн байсан ч МХЕГ-ын төлөөлөл хурлуудад огт оролцоогүй байна. Ажлын албаны зүгээс МХЕГ өөрийн тухайн асуудал хариуцах хүнийг томилоогүй тул тус газартай харилцахад ихээхэн хүндрэлтэй байдаг ажээ. Төрийг төлөөлсөн нэг хүний хэлж буйгаар Үндэсний зөвлөл болон ОТОБ-д буй оролцоо нь Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, гааль, Татварын ерөнхий газар, Үндэсний статистикийн газар болон Уул уурхайн яамны хувьд маш сайн байдаг ажээ. Нийтээр нь авч үзвэл Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн хурлуудад хамгийн чадавхи бүхий төрийн төлөөлөл оролцож буй ажээ.

ОУИТБС-ын Ажлын албаны ажилтны хэлсэнээр Монголын байгаль орчны иргэний зөвлөл өөрт хамаарах Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийн гишүүдийг байнга өөрчилж буй нь асуудал үүсгэдэг ба зарим тохиолдолд сар тутамд өөрчилж буйг мэдэгдсэн зөвлөлийн өөр өөр албан тушаалтны гарын үсэг бүхий албан бичиг ирсээр буй ажээ. Зөвлөл нь өөрийн вебсайт дээрээ ч өөрийн гишүүдийг байнга сольж буй тул өөрчлөлт хийх болсон шалтгаан нь тодорхойгүй буй юм. Ажлын албаны үзэж буйгаар Байгаль орчны иргэний зөвлөлд гарч буй өөрчлөлт нь дотоодынх нь сөргөлдөөнөөс болж буй бөгөөд оролцогч талын дотоод асуудлаас хол байх хүсэлтэй буйгаа илэрхийлж байв. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн ТАН эвсэлийн захидалд дурдсан Үндэсний зөвлөл болон ОТОБ дэхь өөрийн төлөөлөл гурван ТББ-ыг өөрчлөх захидал явуулсан бөгөөд 2016 оны 7 дугаар сарын байдлаар үүнийг Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга хараахан батлаагүй байсан. Ямартай ч иргэний нийгмийн байгууллагууд хэлэхдээ шинэ 6 иргэний нийгмийн байгууллагыг Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга батлах эсэхээс үл хамааран ОТОБ болон Үндэсний зөвлөлд 2016 оны 7 дугаар сараас хойш ажиллуулахаа мэдэгдээд байна. Иргэний нийгмийн зарим төлөөллийн үзэж буйгаар 2006 онд гарсан Монголын ОУИТБС-ыг анхлан байгуулсан тогтоолоор талууд харилцан зөвшилцөлд хүрч, Ерөнхий сайд нь оролцогч талуудын санал болгосон гишүүнийг ёсчлон батална хэмээн ойлголцсон, тухайн 2006 оны тогтоолыг 2012 оны 222 дугаар тогтоолоор хүчин төгөлдөр бус болгосон хэмээн үзэхгүй буйгаа илэрхийлсэн. Ажлын албаны зүгээс ч иргэний нийгмийн зүгээс Үндэсний зөвлөл болон ОТОБ-т нэр дэвшүүлэн ажиллуулахад Ерөнхий сайдын зөвшөөрөл шаардлагагүй хэмээн үзэж буй тул Ажлын албанаас гишүүд өөрчлөгдсөн тухай мэдээлсэнээр шинэ гишүүд ажиллаж эхлэх боломжтой хэмээн үзэж байна. Иргэний нийгмийг төлөөлөн ОТОБ-д буй нэг гишүүн олон жилийн туршид мэдээлэл түгээх үйл ажиллагаа хийсний дараагаар Шинэтгэлийн төлөөх эмэгтэйчүүд ТББ 2016 оны 7 дугаар сард ТАН эвсэлд гишүүнээр нэгдсэн тухай мэдэгдсэн.

ОУИТБС-ын удирдах хоёр бүтэц дэхь газрын тос, байгалийн хийн компаниудын төлөөлөл анхлан тэднийг нэр дэвшүүлэн оруулсан шалтгааныг сайн санахгүй буй бөгөөд харин үйлдвэрлэл болон хайгуулын шатанд буй нэг, нэг компанийг оруулсан нь Монгол улс дахь салбарын бүтцийг харгалзсан хэрэг хэмээн таамаглаж байна. Газрын тосны нэгэн төлөөлөл хэлэхдээ Петро Чайна Дачин Тамсаг компанийг 2007 онд оруулсан нь тус компани Монгол дахь анхны газрын тос үйлдвэрлэгч компани болсонтой холбоотой хэмээжээ.

Олборлох үйлдвэрлэлийг төлөөлсөн хэд хэдэн хүн шийдвэр гаргалтыг үр дүнтэй болгох, авч хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын хэмжээг багасгах хэрэгтэй хэмээн зөвлөж байв. Иргэний нийгэм болон компанийн хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ ОТОБ нь ОУИТБС-ын тайлагналтай холбоотой техникийн асуудлаар ярилцахгүй байна хэмээн үзжээ. Хэд хэдэн донор байгууллагаас ОТОБ-ийн зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтэд хяналт тавих нь вакуум орчинтой болсон бөгөөд ОТОБ нь эрх зүйн зөрүүтэй байдал зэрэг өргөн хүрээний асуудал бус харин санхүүгийн нэгтгэл, тулгалтад л түлхүү анхааран хэлэлцэх болсныг дурдаж байв. Төлөөлөгчид мөн компаниуд нь ОУИТБС-ын үйл явцаас илүүтэй хэрэгжилтэд нь түлхүү сонирхолтой

буйгаа илэрхийлж байв.

Орон нутгийн дэд зөвлөлүүдэд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн бүлгийн үзэж буйгаар Үндэсний зөвлөл болон ОТОБ дахь иргэний нийгмийн төлөөлөл нь тэдэнтэй харилцан зөвлөлдөх нь бүүрч байна хэмээн үзэж байна. Орон нутгийн хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага үзэхдээ Улаанбаатар болон хөдөө орон нутагт буй иргэний нийгмийн байгууллагууд хоорондын харилцаа холбооны гол арга нь цахим шуудан болон утас болохыг хэлж байв. Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын гишүүдийн хооронд бодит хэрэг дээр харилцан зөвлөлдөх ямар нэгэн механизм байхгүй, тэр ч байтугай хэвлэл мэдээлэл олон нийттэй зөвлөлдөх механизм тухайн хоёр бүтцэд байхгүй хэмээсэн. Олборлох салбарын төлөөлсөн зарим хүмүүсийн үзэж буйгаар Үндэсний зөвлөл болон ОТОБ-ээс гадуур ОУИТБС дахь компаниудын төлөөллийн талаар ямар нэгэн харилцан зөвлөлдөх үйл ажиллагаа явагддаггүй ажээ. Тэдний үзэж буйгаар салбарыг төлөөлсөн оролцогчид нь Уул уурхайн үндэсний ассоциацийн гишүүнчлэлийн тухай цахим шуудангаар заримдаа мэдээлэл авахаас өөр бараг мэдээлэл түгээх үйл ажиллагаа байхгүйг хэлж байна. Уулзан ярилцсан газрын тос болон байгалийн хийн компаниуд нь тэднийг төлөөлж буй гишүүд нь ОУИТБС-ын холбоотой асуудлаар тэдэнтэй хэзээ ч хэлэлцэн, зөвлөлдөж байгаагүй хэмээн хэлж байв. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс Үндэсний зөвлөл болон ОТОБ-д салбарыг төлөөлсөн гишүүд нь компаниудын бус харин өөрсдийн эрх ашгийг л төлөөлдөг хэмээн шүүмжилсэн.

Ихэнх иргэний нийгмийн байгууллагаас ОТОБ-ийн хуралдааныг Уул уурхайн яаман дээр хийж буйд сэтгэл дундуур буйгаа илэрхийлсэн ба тэнд хийхэд цагийн хязгаартай тул хуралдааныг Нээлттэй нийгэм форум дээр хийж болохыг ёдурдаж байв. Иргэний нийгмийг байгууллагууд мөн Үндэсний зөвлөлийн хурлыг үндсэндээ Ерөнхий сайд бус харин Үндэсний зөвлөлийн нарийн бичиг, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа де-факто удирдаж байна хэмээн үзсэн. Энэ нь өмнө тогтсон байсан (гурван жилийн өмнө) Ерөнхий сайд нь Үндэсний зөвлөлийн хурлыг нээгээд хуралдаан даргалах эрхийг Дэд дарга болон Уул уурхайн сайдад шилжүүлдэг байснаас эсрэг нөхцөл байдал юм.

Анхдагч үнэлгээ

ОТОБ нь байгуулагдаж, өөрийн хэлэлцэн томилсон гишүүнчлэлтэй, оролцогч талуудын бүлгүүдийн төлөөлөлтэй үйл ажиллагаа явуулж буй бөгөөд тус бүтцийн үйл ажиллагаанд ямар нэгэн саад тогторч байхгүй. Хэдийгээр ОТОБ дэхь иргэний нийгмийн төлөөллийг нэр дэвшүүлэх үйл явцад ТАН эвсэл болон Байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүдээс бусад байгууллагууд хамрагдах нь хязгаартай ч хоёр эвсэлийн гишүүн бус ТББ-уудын зүгээс ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж, энэхүү хүсэлтэд ямар нэгэн байдлаар саад учруулсан нотолгоо байхгүй байна.

ОТОБ-ийн үйл ажиллагааны журам нь ОУИТБС-ын Стандартад заасан шаардлагуудыг хангахад чиглэсэн ч оролцогч талуудын зүгээс зарим талаар бодит байдал дээр энэхүү чиглэлээс хазайсан, ялангуяа санал хураалт дээр ийм тохиолдолд болдог талаар тодруулан ярьж байв. ОУИТБС-ын ОТОБ-ийн гаргаж буй тодорхой шийдвэр нь аль нэг бүлэг нь эсэргүүцсэнээс үл хамааран нөгөө хоёр бүлгийн саналаар дэмжигддэг бөгөөд жишээ нь мэдээллийн чанарын баталгаажилтын журам дээр энэ байдал гарсан байна. ОТОБ-ийн гишүүдийн оролцоо мөн тогтвортой бус өөрөөсөө өөр хүмүүсийг төлөөлүүлэн илгээх нь түгээмэл болжээ. МХЕГ-ын оролцоо хангалтгүй, хүссэн хэмжээнд хүрэхгүй буй нь гол асуудал, санаа зовоох зүйл болоод буй бөгөөд ялангуяа тус байгууллага нь Засгийн газрын орлогыг яам, агентлагуудын түвшинд (доор буй Мэдээллийн чанар хэсгийг үзнэ үү) баталгаажуулахад гүйцэтгэх үүрэг өндөртэй юм. Олон улсын Ажлын албаны үзэж буйгаар эдгээр сул талууд нь ОУИТБС-ын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, ОУИТБС-ын тайлагналын техникийн асуудлаар,

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ялангуяа мэдээллийн чанарын асуудлаар талуудын хяналт бүрэн бус байхад хүргэж байна. Тайлангийн техникийн талыг судлах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах түр ажлын хэсгүүд байгуулагдсан ч тэдний хийсэн хэлэлцүүлэг, гаргасан шийдвэр нь тодорхойгүй, жишээ нь төсвийн чанартай зарцуулалтын тодорхойлолт (Шаардлага 6.2), мэдээллийн чанарын баталгаажуулалт (Шаардлага 4.9) болон орон нутагт шууд хийсэн төлбөрийн нэгтгэл (Шаардлага 4.6) зэрэг дээр бүр ч тодорхойгүй буй юм.

Эдгээр асуудлуудыг харгалзан үзэж Олон улсын Ажлын албаны зүгээс хийж буй анхдагч үнэлгээ нь Монгол улс энэхүү шаардлагыг хангахад ихээхэн ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэж байна. ОТОБ нь оролцогч талын бүлэг бүрт өөрсдийн дотоодод нэр дэвшүүлэх болон төлөөлөх үйл явц, журмыг тодорхой болгон, үйл явц дахь оролцоо, ил тод байдлыг сайжруулахыг даалгах шаардлагатай. ОТОБ болон Үндэсний зөвлөл нь тухайн хоёр бүтцийг нэгтгэх (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан) талаар судлан үзэж, ОУИТБС-ын үйл явцад хяналт тавихыг баталгаажуулахуйц гишүүнчлэл болон хуралдааны хуваарийг зөвшилцөх нь зүйтэй гэж үзэж байна. МХЕГ-ийн дэмжлэг болон оролцоог хангах нь дээр дурдсан асуудлуудаас үүдсэн гол тэргүүлэх чиглэл болоод байна.

Ажлын төлөвлөгөө (#1.5)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын Ажлын албан нь ерөнхийдөө ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан гаргаж, тухайн төлөвлөгөөг ОТОБ дээр хэлэлцэн, өөрчлөлт оруулан тухайн хурлаараа батлан гаргадаг байна. ОУИТБС-ын вебсайт дээр буй⁹⁰ ОУИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөөг ОТОБ 2015 оны 12 дугаар сарын 11-н өдрийн⁹¹ хуралдаанаараа хэлэлцэн, 2015 оны 12 сарын 19-ны өдөр⁹² болсон Үндэсний зөвлөлийн хурлаар баталжээ.

ОУИТБС-ын хэрэгжилтийн үндсэн 4 зорилтыг ОУИТБС-ын зарчмуудтай холбосон ч олборлох салбарын ил тод байдлыг сайжруулах зэрэг үндэсний тэргүүлэх чиглэлтэй мөн холбон өгсөн байна. Тус төлөвлөгөөнд дөрвөн зорилтын үндэслэлийг тайлбарлан оруулжээ. Хэдийгээр жилийн ажлын төлөвлөгөөний төлөвлөсөн 4 дэхь үр дүн нь ОУИТБС-ын тайланг бодлогын түвшинд ашиглах гэж буй ч тухайн ажлын төлөвлөгөө нь салбар дахь үндэсний тэргүүлэх чиглэл зэргийг тусгасан баримт бичиг, эвсэл бодлоготой ямар нэгэн холбоос (link) байхгүй байна. Гэхдээ энэ нь 2015⁹³ болон 2014⁹⁴ оны ажлын төлөвлөгөөтэй харьцуулбал сайжирсан хэрэг бөгөөд тэдгээр нь ОУИТБС-ын 7 шаардлагатай яг ижил, олборлох салбар дахь үндэсний тэргүүлэх чиглэл зэргийг дурдаагүй байсан билээ.

Монгол улс дахь ОУИТБС-д тулгарч буй сорилтуудын нэгэнд хандсан 2016 оны ажлын төлөвлөгөө нь ОУИТБС-ын тайлагналын иж бүрэн байдлыг хангах, илүү олон тооны материаллаг компаниудыг

⁹⁰ Монголын ОУИТБС-ын вебсайт дээр бий:

<http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/wokplanandreport/Mongolia%20EITI%202016%20Workplan%20in%20English.pdf>

⁹¹ ОТОБ-ын 39 дүгээр хурлын тэмдэглэл, 2015/12/11,

http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/AH_39_20151211_en.pdf

⁹² ҮЗ-ийн 15 дугаар хурлын тэмдэглэл, 2015/12/18,

http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_15_20151218_en.pdf

⁹³ Монголын ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө 2015,

<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>

⁹⁴ Монголын ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө 2014,

http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITIM_POA_2014en.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

тайлан гаргуулах чиглэлээрх семинар зэрэг арга хэмжээг зохион явуулах, цахим тайлангийн системд бүрэн шилжих зэрэг иж бүрэн тайлагналд хандсан арга хэмжээг төлөвлөжээ. Илүү өргөнөөр авч үзвэл ажлын төлөвлөгөө нь өмнө хийгдсэн ОУИТБС-ын тайлан, баталгаажуулалтаас гарсан зөвлөмжүүдийг түлхүү хэрэгжүүлэх үйл ажиллагааг багтаасан ба 10.1-10.5 дугаар бүлэг нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноог ил тод болгох, олборлох салбар дахь төрийн оролцоог судлах, туршилтын баталгаажуулалтын үеэр тодорхойлон гаргасан мэдээллийн орхигдлын талаар Засгийн газрыг төлөөлсөн талуудтай хэлэлцүүлэг хийх, Монгол улсын ОУИТБС-ын засаглалыг эргэн судлах зэрэг үйл ажиллагааг тусгажээ. Ажлын төлөвлөгөө нь цаг хугацаатай, хэмжин үнэлэхүйц үйл ажиллагааг тусгасны зэрэгцээ ч компаниудад зориулсан сургалт, орон нутгийн дэд зөвлөл болон иргэний нийгмийн (Үйл ажиллагаа 2.4, 2.5 болон 5) чадавхийн болон эрх зүйн асуудлыг шийдэхэд чиглэсэн үйл ажиллагааг тусгажээ. Мөн төлөвлөгөөнд Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар зүйлийн хэрэгжилтэд (Засгийн газарт хийсэн төлбөрөө ил тод болгохыг шаардсан) мониторинг хийх үйл ажиллагаа (1.4), мөн өргөн барьсан буй хуулийн төслийг батлуулах чиглэлээр УИХ-д хандсан үйл ажиллагааг (10.1- 10.3) мөн оруулжээ. Ажлын төлөвлөгөөнд оруулсан оролцогч талуудын оролцоог сайжруулах чиглэлийн үйл ажиллагаа нь тайлагналтай холбоотой байгаа бөгөөд оролцогч талуудын хяналт, ОУИТБС-ын үйл явц дахь оролцоог хангахад зорьсон үйл ажиллагаа бус мэт харагдаж байна.

2016 оны ажлын төлөвлөгөө нь тодорхой төслүүдэд (жишээ нь цахим тайлангийн 2 дугаар шат гэх мэт) үл хамаарах бүх үйл ажиллагааны зардал, санхүүжилтын эх үүсвэрийг (үндсэндээ Дэлхийн Банк, ЕСБХБ болон Засгийн газар) тодорхой дурджээ. Төлөвлөгөөнд мөн ОУИТБС-ын хамрах салбарыг ОУИТБС-ын стандартад заасан хүрээнд өргөтгөх, үүнд онлайн гэрээний вебсайт байгуулах (Үйл ажиллагаа 10.4.2), ОУИТБС-ын онлайн порталыг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох (Үйл ажиллагаа 3.1-3.3) зэргийг багтаажээ.

2014 оны 10 дугаар сарын 10-ны ОТОБ-ийн хуралдаанаар хэлэлцэгдэж, Үндэсний зөвлөлийн 2015 оны 1 сарын 13⁹⁵-ны 12 дугаар хурлаар батлагдан, ОУИТБС-ын вебсайт⁹⁶ дээр тавигдсан ОУИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө нь хэмжих боломжтой, цаг хугацаа бүхий үйл ажиллагаа, мөн ОУИТБС-ын тайлан болон бусад үнэлгээгээр тодорхойлон гаргасан чадавхийн сул талуудтай хамаарах үйл ажиллагааг төлөвлөн оруулжээ.⁹⁷ Төлөвлөгөөнд дурдсан үйл ажиллагаа нь тодорхой оролцогч талын бүлгийн чадавхийг бэхжүүлэхтэй холбоотой буй ба харин өмнөх ОУИТБС-ын тайлангуудын зөвлөмжүүдэд ерөнхий байдлаар хандсан байна.⁹⁸

2013, 2014, 2015 онуудын ажлын төлөвлөгөө нь үйл ажиллагааг гүйцэтгэж дуусах тодорхой цаг хугацааг тусгажээ. 2013 онд Ажлын албанаас төлөвлөсөн нийт 42 үйл ажиллагаанаас 33 нь биелсэн (88%) хэмээн мэдэгдсэн ба гэхдээ эдгээрээс хуулийн төслийг эцэслэн батлуулах болон телевизийн цуврал бүтээх⁹⁹ гэсэн гол үйл ажиллагаанууд биелээгүй. 2014 оны хувьд нийт төлөвлөсөн 65 ажлын 42 нь биелсэн (65%) гэж мэдээлж буй ч Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг

⁹⁵ Үндэсний зөвлөлийн 12 дугаар хуралдааны тэмдэглэл, 2015 оны 1 сарын 13, (Монгол хэл дээр, http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/UZ_12_2015.pdf)

⁹⁶ Англи хэл дээр (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>) болон Монгол хэл дээр (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015mn.pdf>).

⁹⁷ Монголын ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө 2015 (хуудас 1), <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>.

⁹⁸ 2015 оны ажлын төлөвлөгөө (хуудас.2-3), <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

батлуулах, бүсийн бага хурал зохион байгуулах болон телевизийн хөтөлбөрийг нийтэд хүргэх¹⁰⁰ зэрэг ажлууд биелээгүй байна. 2015 оны ажлын төлөвлөгөөнд хийсэн судалгааг 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдөр нийтэлсэн ба тус судалгаанд дурдсанаар 2015 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн 50 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүгд биелсэн гэж үзсэн ч хүлээгдэж байсан зорилтууд нь хангагдаагүй байна.¹⁰¹ Зорилтуудаа хангаагүй биелсэн үйл ажиллагааны тоонд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах болон ОУИТБС-ын Баталгаажуулалтад амжилттай хамрагдах зэрэг багтаж байжээ.

Оролцогч талуудын санал бодол

ОУИТБС-ын Ажлын албанаас мэдэгдэхдээ 2016 оны ажлыг төлөвлөгөөг боловсруулах үйл явц нь хэвийн журам, дүрмийн дагуу явагдсан ба Ажлын алба эхний төслийг 2015 оны 11 дүгээр сард бэлтгэн, үүнийг ОТОБ-ийн гишүүдээс санал авахаар хүргүүлэн, улмаар ОТОБ нь 12 дугаар сарын 12-гны өдөр хэлэлцэн баталсаны дараа Үндэсний зөвлөлд өргөн барьж 12 сарын 18-ны өдөр эцэслэн батлагджээ. Иргэний нийгмийн төлөөллийн үзэж буйгаар ОТОБ болон Үндэсний зөвлөлийн уулзалтын хоорондын хугацаанд цахим шуудангаар төлөвлөгөөнд оруулах саналаа хүргүүлжээ.

Үндсэндээ иргэний нийгмээс ирүүлсэн Ажлын төлөвлөгөөний төсөлд өгсөн саналыг нь ОТОБ-ийн хурлын өмнө цахим шуудангаар хүлээн авч тусгасан ба компаниудын зүгээс ОТОБ-ын хурал дээр өөрсдийн саналыг голлон гаргасан болохыг Ажлын хэсгээс мэдээлсэн. Талуудын өгсөн санал нь чадавхийг бэхжүүлэх, орон нутагт мэдээлэл түгээх, компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах чиглэлд түлхүү төвлөрсөн байв. Засгийн газрын төлөөллөөс өгсөн саналууд нь үйл ажиллагааны цаг хугацаа, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн уялдуулах, орон нутгийн ОУИТБС-ын дэд зөвлөлүүдийг бэхжүүлэх зэрэг асуудлууд байсныг Ажлын алба болон уулзан ярилцсан төрийн байгууллагын төлөөлөл хэлж байв. Уул уурхайн салбарын зарим төлөөллийн хэлсэнээр тэд зөвхөн компаниудад шууд хамаарал бүхий үйл ажиллагаан дээр л санал өгсөн ба ерөнхий санал гаргах нь ажлын төлөвлөгөөнд үр дүн үзүүлэхгүй хэмээжээ. Уулзаж ярилцсан газрын тос, байгалийн хийн компаниуд нь 2016 оны ажлын төлөвлөгөөг судлан үзсэн талаар дурдаагүй харин иргэний нийгмийн байгууллагууд л боломжит санхүүжилтыг өөрсдийн үйл ажиллагаанд чиглүүлэхийн тулд хамгийн их саналыг гаргасан хэмээн үзэж байв.

Иргэний нийгмийн зүгээс өмнөх жилүүдтэй харьцуулбал 2016 оны ажлын төлөвлөгөө харьцангуй сайжирсан хэмээн үзсэн ба тэдний зүгээс ОУИТБС-ын мэдээллийг ашиглах, орон нутгийн дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарсан байна. Ажлын албанаас мэдээлсэнээр 2016 оны ажлын төлөвлөгөөг ТАН эвсэлийн зүгээс сайшаасан нь орон нутагт мэдээлэл түгээх үйл ажиллагааг түс эвсэл тэргүүлэн ажиллах болсонтой холбоотой гэж үзэж байна. Компанийг төлөөлсөн хүмүүсийн хэлсэнээр 2016 оны төлөвлөгөөг тэд сайшааж, биелэгдэх боломжгүй хүслийн жагсаалт мэт байсан өмнөх төлөвлөгөөнөөс харьцангуй бодитой болсоныг үнэлжээ. Тэдний зүгээс цаашид хийсвэр зорилт, шалгах хуудас зэрэг зүйлсээс илүү биелэгдэх боломжтой зорилтуудыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Иргэний нийгмийн зарим төлөөллийн үзэж буйгаар 2016 оны ажлын төлөвлөгөө нь өмнөхөөс сайн болж, уул уурхайн салбарын чухал үед үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлийг тусгасан байна.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Тэдний хэлсэнээр 2015 оны 11 дүгээр сард болсон ОУИТБС-ын Үндэсний форум нь тэргүүлэх чиглэл, зөвлөмжийг ихээр цуглуулсан бөгөөд энэхүү форумгаас гарсан үр дүн нь ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна. ТАН эвсэлийн төлөөллийн хэлсэнээр тус эвсэл нь төлөвлөгөөний төслийг өөрийн гишүүдэд илгээн санал авсан ч эвсэлд үл хамаарах бусад иргэний нийгмийн байгууллагуудаас санал авах үйл ажиллагаа хангалтгүй хийгдсэн гэж хэлжээ.

Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн төлөөлөл 2016 оны ажлын төлөвлөгөөг харьцангуй сайн байсан ч 2016 оны эхний улиралд төсвийн асуудлаас үүдэн хэрэгжилт нь тааруу байсан гэж үзжээ. Иргэний нийгмийг төлөөлөн ОТОБ-т ажиллаж буй хэд хэдэн төлөөллийн зүгээс 2016 оны ажлын төлөвлөгөөг эхний улиралд хэрэгжүүлэхэд тулгарсан асуудлуудыг дурдаж байсан ба бүхий л үйл ажиллагааг хамаарах санхүүжилттэй нь холбоогүй, холбох шаардлагагүй бөгөөд эдгээр нь ажлын хэсгийн уулзалт, Хараат бус нэгтгэгчийн ажлын даалгаварыг боловсруулах болон ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зэргийг хамруулсан. Төсвийн хомсдол үүссэн ч ОТОБ нь тийм төрлийн үйл ажиллагаа явуулах боломжуудыг ашиглах шаардлагатай байсан гэж зарим нь үзэж байна. Иргэний нийгмийнхэн мөн ажлын төлөвлөгөө бүр дээр хариуцах хүмүүсийг зааж өгөөгүй нь асуудал үүсгэж, үүнээс үүдэн ОТОБ-ийн гишүүд эдгээр ажлыг Ажлын хэсэг хийх мэтээр ойлгож байсан тул биелэгдээгүй үйл ажиллагааны хариуцлагыг хүлээх боломжгүйг хэлж байв. Иргэний нийгмийн төлөөлөл ОТОБ-д ажиллаж буй хэд хэдэн гишүүн Ажлын албаны үйл ажиллагааг, ялангуяа 6 сарын цалингүй ажилласан Ажлын албыг өндрөөр үнэж байв. Мөн өөр хэд хэдэн иргэний нийгмийн төлөөлөл 2016 оны эхний хагаст ОУИТБС-ын холбоотой үйл ажиллагаа болох сургалтууд болон ННФ-ын гэрээний онлайн портал зэрэг үйл ажиллагааг явуулсан гэж мэдээлжээ.

Анхдагч үнэлгээ

Олон улсын ажлын албанаас хийж буй анхдагч үнэлгээгээр Монгол улсын хувьд энэхүү шаардлагыг биелүүлэх чиглэлд хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан байна. 2016 оны ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө нь олон нийтэд хүртээмжтэй, төлөвлөгөөний зорилтууд нь үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна. Ажлын төлөвлөгөө нь мөн ОУИТБС-ын тайлан болон баталгаажуулалтаас гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тусгайлсан үйл ажиллагааг багтаажээ. 2015 оны 11 дүгээр сарын эхэнд болсон ОУИТБС-ын Үндэсний форум дээр хийгдсэн хэлэлцүүлгийг ажлын төлөвлөгөөг боловсруулахад анхаарсан ба Үндэсний форум дэр яригдсан 2020 оныг хүртэлх урт хугацааны төлөвлөгөө гаргах үйл ажиллагаа мөн хийгдэж байна. Харин гурван тал нэг бүртэй өргөн хүрээнд зөвлөлдөөгүй нь гол асуудал болж байна. ОТОБ нь 2017 оны ажлын төлөвлөгөөг бэлтгэхдээ гурван ороцлогч талын саналыг илүү өргөн хүрээнд, улмаар тэднээс цаашир хүрээнд гаргуулан авахад анхаарах шаардлагатай. Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд саад тулгарч буй нь эрх зүйн болон санхүүжилтын асуудлаас үүдсэн тул байж болох асуудал хэмээн үзэж байна.

Хүснэгт 1 – Үнэлгээний тойм хүснэгт: ОТОБ-ийн хяналт

ОУИТБС-ын заалтууд	Гол үр дүнгийн тойм	ОУИТБС-ын заалтуудыг биелүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшилийн талаарх Олон улсын ажлын албаны үнэлгээ (Заавал шаардсан заалтууд дээр бүрэн биелэгдсэн байх)
ОУИТБС дахь засгийн газрын оролцоо (#1.1)	Засгийн газар нь ОУИТБС-ын хэрэгжүүлэх бүрэн хүсэл эрмэлзлэлтэй, үйл ажиллагаанд	Хангалттай ахиц дэвшил

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

	оролцдог, Засгийн газар төлөөлөл ОТОБ-д ажиллаж байгаа	
ОУИТБС дахь компаниудын оролцоо (#1.2)	Олборлох салбарын компаниуд нь ОУИТБС-ын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийхэд оролцдог. Салбарын төлөөлөл нь мэдээлэл түгээх болон олон нийтийн хэлэцүүлгийг дэмжин урамшуулах чиглэлээр хүчин чармайлт гаргадаг. ОУИТБС дахь үйл ажиллагаанд компаниудын оролцоонд ямар нэгэн эрх зүйн саад тотгор байхгүй.	Хангалттай ахиц дэвшил
ОУИТБС дахь иргэний ниймийн оролцоо (#1.3)	Иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийхэд оролцдог, мөн мэдээлэл түгээх болон олон нийтийн хэлэцүүлгийг дэмжин урамшуулах чиглэлээр хүчин чармайлт гаргадаг. ОУИТБС дахь иргэний нийгмийн оролцоог хангасан орчин бүрдсэн.	Хангалттай ахиц дэвшил
ТОТБ-ийн засаглал, үйл ажиллагаа (#1.4)	ОТОБ нь хамаарах талуудын төлөөллийг багтаасан ба бүх оролцогч талууд бүрэн хэмжээнд төлөөлөлтэй. ОТОБ-ын ажиллах журам, ажлын даалгавар нь ОУИТБС-ын Стандарт дахь шаардлагуудад хандсан, ихэнх тохиолдолд эдгээрийг даган мөрдсөн буй ч шийдвэр гаргалт нь зарим тохиолдолд санал хураалтаар гарч байна. Зарим голлох шийдвэрийг ОТОБ болон Үндэсний зөвлөл дэхь бүх талуудын дэмжлэгтэйгээр гаргадаггүй байна. ОТОБ нь жилд ойролцоогоор 3 удаа хуралддагын зэрэгцээ хэд хэдэн түр ажлын хэсэг үйл ажиллагаа явуулж буй ч тэдгээр ажлын хэсгийн тэмдэглэлийг хөтлөхгүй байна. Түр ажлын хэсгүүд дээр хийгдсэн хэлэлцүүлгийн үр дүнгүүд, ОТОБ-ын гол цар хүрээний асуудлууд болон мэдээллийн баталгаат байдлын талаарх гарсан шийдвэр тодорхойгүй байна. ОТОБ-ын журамд ОТОБ нь мэдээлэл түгээх	Тодорхой ахиц дэвшил

	үйл ажиллагаа явуулахдаа иргэний нийгэм болон компаниудтай хамтран явуулахыг шаардсан ямар нэгэн заалт байхгүй.	
Ажлын төлөвлөгөө (#1.5)	ОТОб нь 2016 оны ажлын төлөвлөгөөндөө ОУИТБС-ын тайлан болон баталгаажуулалтаас гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан. Үндсэндээ хэрэгжилт нь хэвийн, гэхдээ заримдаа тулгарч буй буй асуудлууд байна.	Хангалттай ахиц дэвшил

Зөвлөмжүүд:

1. ОТОБ нь ОУИТБС-аар дамжуулан бодит үр дүн бүхий хэлэлцүүлгийг хэрхэн хийх, үүнийг үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлтэй холбох болон оролцогч талуудын бүлгийн оролцоог илүү идэвхжүүлэх талаар судлан үзэх шаардлагатай.
2. ОТОБ нь оролцогч талын бүлэг нэг бүрийг дотроосоо нэр дэвшүүлэх үйл ажиллагааг журамлах, ингэснээр ТАН эвсэл, Байгаль орчны иргэний зөвлөл болон Уул уурхайн үндэсний ассоциацийн гишүүн бус байгууллагуудад төлөөлөө оруулахаар нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх боломжийг хангах талаар үүрэг болгох шаардлагатай байна.
3. ОТОБ нь Үндэсний зөвлөл болон ОТОБ-ийг нэгтгэн (хуулийн төсөл дээр туссаны дагуу), гишүүнчлэл болон хуралдааны хуваарийн талаар тохирон, ОУИТБС-ын үйл явц дахь үр дүнтэй хяналтыг бий болгох чиглэлээр ажиллах хэрэгтэй байна.
4. ОТОБ нь 2017 оны ажлын төлөвлөгөөг бэлтгэхдээ оролцогч талуудын бүлгийн саналыг илүү өргөн хүрээнд авах талаар судлан үзэх шаардлагатай байна.
5. ОТОБ нь төрийн хамаарах байгууллага бүр ОУИТБС-ын асуудалд хариуцсан ажилтныг томилох талаар төрийн байгууллагуудтай ярилцан, тэдний үйл ажиллагааг тогтворжуулан, чадавхийг нь бэхжүүлэх талаар судлан үзүүштэй.
6. Монголын уул уурхайн үндэсний ассоциац нь ОУИТБС-ын үндэсний зөвлөл болон ОТОБ-д ажилладаггүй компаниудтай илүү өргөн хүрээнд зөвлөлдөх чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллах талаар судлан үзэх шаардлагатай байна.
7. ОТОБ нь өөрийн журмыг эргэн харж зөвхөн нийт гишүүдийн дийлэнх олонх оролцож буй тохиолдолд бус харин оролцогч талуудын бүлгүүдийн тодорхой тооны төлөөлөл оролцож буй бол ирц хүрсэнд тооцохоор өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэхүү журам нь мөн ОТОБ болон Ажлын албаны үүрэг ролийг илүү сайтар тодорхойлон гаргах шаардлагатай.
8. ОТОБ нь өөрийн Үйл ажиллагааны журамд ОТОБ-ийн гишүүд мэдээлэл түгээх үйл ажиллагаанд иргэний нийгмийн бүлэг болон компаниудын хамтаар оролцохыг дэмжсэн заалт оруулах талаар судлан үзэх шаардлагатай байна. ОТОБ нь мөн өөрийн журамд өөрчлөлт оруулан ёс зүйн дүрэм оруулах эсвэл ашигт сонирхлын зөрчилдөөн, мэдээллийн нууцлалтай холбоотой заалтуудыг нэмэлтээр оруулах талаар судлан үзэх шаардлагатай байна.
9. ОТОБ нь түр ажлын хэсгүүдийн гүйцэтгэх үүрэг болон засаглалын асуудлуудыг илүүтэй тодорхой болгох шаардлагатай.
10. Засгийн газрын зүгээс ОУИТБС-ын санхүүжилтын асуудлын эргэн судлан, урт хугацааны тогтвортой байдлыг хангах ёстой.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Хэсэг II – ОУИТБС-ын ил тод байдал

2. Гэрээ хийх болон тусгай зөвшөөрөл олгох

2.1 Тойм

Энэхүү Бүлэг нь олборлох салбарын эрх зүйн орчин, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, гэрээ бенефициар өмчлөл болон олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх ОУИТБС-ын шаардлагуудын хэрэгжилтийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан. Энэ хэсэгт дурдсан хуудасны тоо нь 2014 оны ОУИТБС-ын тайлан¹⁰² болон 2013 оны ОУИТБС-ын тайлангийн¹⁰³ Англи хэл дээрх хувилбарын хуудасны тоог зааж буйг анхаарна уу.

2.2 Үнэлгээ

Эрх зүйн орчин (#2.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын 2014 оны тайланд олборлох салбарын эрх зүйн орчны талаарх тойм мэдээллийг дурдсан бөгөөд үүнд хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын талаарх тайлбарыг багтаажээ. Энэхүү тайланд хамгийн сүүлд хийгдсэн шинэтгэл болох 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хууль болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл зэрэг төлөвлөгдөөд буй хууль тогтоомжийн талаарх мэдээллийг мөн оруулсан байна. Санхүү/төсвийн орчны талаарх товч мэдээлэл нь зөвхөн нөөцийн төлбөр, гэнэтийн ашгийн татвар, үүний ноогдуулах хувь хэмжээ зэргийг дурдсанаас бус бусад хамаарах татвар, төлбөрийн түвшний талаар мэдээлэл ороогүй байна. Дэлгэрэнгүй хэсэгт санхүү/төсвийн бууралтын талаах мэдээллийг оруулаагүй Бүлэг 2.2.1 (хуудас 16) дээрх хоёр хэсэгт орон нутгийн болон Засгийн газрын орлогыг тусад нь хуваан харуулжээ. Хэсэг 5.1.3.1 (хуудас 61-63) нь олборлох салбарыг хариуцсан төрийн байгууллагуудын талаарх тайлбараас бүрдэж байна.

2013 оны ОУИТБС-ын тайланд дурдсан эрх зүйн болон зохицуулалтын орчны тухай тайлбарт хамаарах Засгийн газрын мөрийн хөтөлбөр, уул уурхайн салбарын хууль тогтоомжуудын тухай (хуудас 28-29, хуудас 57-58, болон хуудас 58-60) дурдсан ч “Урт нэртэй хууль” зэрэг хэд хэдэн чухал ач холбогдол бүхий хууль тогтоомжуудын тухай дурдаагүй байна (Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль). Газрын тос, байгалийн хийн салбарт баримтлах хууль тогтоомжийн тайлбарыг (хуудас 59-60, хуудас 64-65), санхүү/төсвийн шилжүүлгийн түвшин болон хамаарах төрийн байгууллагуудын үүрэг, ролийн талаар тайланд дурдсан ч (хуудас 54-55) тухайн тайланд алт болон зэсээс бусад бүх ашигт малтмалын нөөцийн төлбөрийн 30%-ийг шууд орон нутгийн төсөвт шилжүүлж байх талаар ямар нэгэн тайлбар оруулаагүй байна¹⁰⁴. Хэдийгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ихээхэн чухал үүрэгтэй ч энэ бүтцийн талаар ганцхан удаа (хуудас 64) дурдсан, шинээр хийж буй бүх Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын

¹⁰² <http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Final%20report%20EITI%20Mongolia%202014%20en.pdf>

¹⁰³ <http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Final%20report%20EITI%20Mongolia%202013%20en.pdf>

¹⁰⁴ х.13, Дэлхийн Банк (2011), “Орон нутагт ОУИТБС-ыг хэрэгжүүлэх нь”,

<http://siteresources.worldbank.org/INTOGMC/Resources/EITI-WBMiningSectorWEB.pdf>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ордтой холбоотой хориг тавих тус байгууллагын эрхийн талаар тайлбарлаагүй байна.¹⁰⁵ Харин энэхүү эрхийн талаар ОТОБ-д үйл ажиллагаа явуулж буй газрын тос, байгалийн хийн компаниуд, Газрын тосны газартай хийсэн зөвлөлдөх арга хэмжээний үеэр дурдаж байжээ. 2013 оны ОУИТБС-ын тайлан нь мөн 2014 онд хэрэгжүүлсэн шинэтгэлийн талаарх мэдээллийг оруулсан байна (хуудас 58, хуудас 63-64).

Оролцогч талуудын санал бодол

Олборлох салбарын буюу уул уурхай, газрын тосны компаниудын төлөөллийн үзэж буйгаар 2014 оны ОУИТБС-ын тайланд эрх зүйн болон төсөв/санхүүгийн орчны талаар тайлбарлан оруулсан хэсэгт үндсэндээ дэлгэрэнгүй, үнэн зөв мэдээлэл багтсан хэмээн үзэж байна. Энэ талаар харилцан хэлэлцсэний үр дүнд салбарын төлөөллүүдийн зүгээс эрх зүйн орчны практикаас гажсан зөрчил зэрэг нэмэлт мэдээллийг мөн оруулах хэрэгтэй гэж үзсэн ба энэ нь сүүлийн жилүүдэд хурдацтай чвагдсан өөрчлөлтөөс үүдсэн санал юм. Иргэний нийгмийн хэд хэдэн байгууллагын зүгээс зохицуулалтын орчны талаар, ялангуяа Урт нэртэй хуулийн талаар илүү их мэдээллийг 2014 оны ОУИТБС-ын тайланд оруулах хэрэгтэй гэж хүсэлт гаргасан ч 2014 оны тайланд буй тайлбар мэдээлэл нь өмнө хийгдэж байсан тайлангуудаас хавьгүй нарийн, бодитой буйд сэтгэл ханамжтай байгаагаар илэрхийлсэн. Засгийн газар болон салбарыг төлөөлсөн хэд хэдэн төлөөллийн үзэж буйгаар эрх зүйн орчны талаарх танилцуулгыг бэлтгэхэд тэд идэвхтэй оролцоогүй, энэ үүргийг Хараат бус нэгтгэгчид даатгасан хэмээн мэдээлж байв.

Анхдагч үнэлгээ

Олон улсын ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү шаардлагыг биелүүлэх чиглэлээр хангалттай хэмжээнд дэвшил гаргасан хэмээн үнэлж байна. Хамаарах хууль тогтоомжуудын хэрэгжилт, тулгарч буй сорилтууд болон учирч буй зөрчлийн талаар илүү өргөн хүрээнд хэлэлцсэнээр ОУИТБС-ын тайлан нь илүү сайн бэлтгэгдэх юм. ОТОБ нь мөн эрх зүйн болон төсөв/санхүүгийн орчноос бодит байдал дээр зөрүүтэй хэрэгжиж буй зөрлүүдийн талаар иж бүрнээр тайлбарлан оруулах болон ОУИТБС-ын тайланг олон нийтийн, олборлох үйлдвэрлэлийн салбарынхны мэдлэгийг нэмэгдүүлэхэд ашиглах талаар судлан үзүүштэй.

Тусгай зөвшөөрөл хуваарилалт (#2.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын 2014 оны тайланд тухайн оны 7 дугаар сараас эхлэн тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон хориг тавигдсанаар тухайн онд нийт 171 тусгай зөвшөөрөл олгосоныг дурджээ (хуудас 65). ОУИТБС-ын тайлан нь эдгээр шинээр шинээр олгосон тусгай зөвшөөрлийг хүлээн авсан талуудын тухай мэдээлэл оруулаагүй ч энэхүү мэдээллийг Ашигт малтмалын газрын кадастрын онлайн систем¹⁰⁶ эсвэл ОУИТБС-ын мэдээллийн сангаас¹⁰⁷ үзэж болох ажээ. Тайлан дээр мөн 2014 онд шилжилт хөдөлгөөн хийгдсэн бүх тусгай зөвшөөрлийг хүснэгт байдлаар Хэсэг 5.2.1.1 (хуудас 96-97) дээр тусгай зөвшөөрлийн нэр, талбайн нэр, шилжүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэртэй хамт тусгасан байна. Тусгай зөвшөөрөл олгох журам, үүнд зөвшөөрөл олгох болон шилжүүлэх журам, тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээдэд тавих стандарт техникийн болон

¹⁰⁵ Жишээ болгон хуудас 86 “Монгол улсын уул уурухайн салбарын эдийн засгийн шинжилгээ” хэсгийг үзнэ үү,” <ftp://ftp.repec.org/opt/ReDIF/RePEc/ibf/gjbres/gjbr-v4n4-2010/GJBR-V4N4-2010-8.pdf>

¹⁰⁶ <https://cmcs.mram.gov.mn/cmcs>

¹⁰⁷ <http://e-reporting.eitimongolia.mn/portalMap/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

санхүүгийн шалгуурыг Хэсэг 5.2.1 (хуудас 92-98) дээр тусгажээ. Тусгай зөвшөөрөл олгох тендэр сонгон шалгаруулалтын үйл явцын талаар тавигдах шаардлагуудын хамтаар тусгажээ. Тайлангийн энэхүү хэсэг дээр нэг онцлог тусгай зөвшөөрөлд тогтсон журмын баримтлаагүй тухай дурдсан байна. 2014 онд олгосон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн бүх тусгай зөвшөөрөл дээр журамд үл заагдсан ямар нэгэн үйлдэл явагдсан эсэх талаарх ямар нэгэн тайлбар байхгүй.

2014 оны ОУИТБС-ын тайлан нь мөн газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрөл олгох үйл вцын талаарх мэдээллийг мөн оруулжээ. Газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгодог ба үүнд тавигдах шаардлагыг Хэсэг 5.1.5.2 (хуудас 85) дээр дурджээ. Хэсэг 5.2.2 (хуудас 99-103) нь газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг дурдаж үүнд үйл явцын талаарх тайлбар, өргөдөл гаргагчдад тавигдах санхүү, техникийн шаардлагуудыг жагсаажээ. Мөн тусгай зөвшөөрөл олгосон нэг тохиолдлыг кейс судалгаа болгон тогтсон журмаас гажин тусгай зөвшөөрөл олгож буй тохиолдлыг мэдээлсэн байна. Гэхдээ ОУИТБС-ын тайлан дээр 2014 онд шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан эсэх нь тодорхой харагдахгүй байна. Хэсэг 5.1.5.2 (хуудас 85) дээр дурдсанаар Сансарын геологи хайгуул ХХК өөрийн Номгон 9 талбайд хийсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргийг Өмнөд Монголын Петролеум ХХК-д шилжүүлсэн тухай мэдээлсэн ч Сансарын геологи хайгуул ХХК-тай анхлан Бүтээгдэхүүн хуваах гэрээг хэзээ байгуулсан болохыг мэдээлсэнгүй. Хэвлэл мэдээлэлд гарсанаас үзвэл Сансарын геологи хайгуул ХХК болон Засгийн газар анх Бүтээгдэхүүн хуваах гэрээг 2014 оны 2 дугаар сард¹⁰⁸ байгуулан гарын үсэг зурсан байна. Бусад Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийгдсэн журамд үндэслэн¹⁰⁹ харвал Номгон 9 талбайг өрсөлдөөнт шалгаруулалтаар олгосон байгаа ч үүнийг ОУИТБС-ын 2014 оны тайланд тодорхой дурдаагүй байна. Энэхүү талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхэд санал гарган оролцсон өрсөлдөгчдийн талаар ОУИТБС-ын тайланд дурдаагүй. Мөн хэсэг 5.2.2 (хуудас 99-103) дээх Ажлын алба болон ОТОБ нь 2014 онд Номгон 9 талбайд тусгай зөвшөөрөл олгосон үйл явцыг бүс харин ДонгШен Петролеум Группд 2010 онд олгосон газрын тос үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн үйл явцыг тайлбарлан оруулсан шалтгаан нь тодорхой бүс байна. Тус тайлан нь 2014 онд ямар нэгэн газрын тос, байгалийн хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээг 2014 онд олгосон эсвэл шилжилт хөдөлгөөн хийгдсэн эсэхийг заасангүй.

2010-2104 онуудын хооронд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл (хайгуулын болон ашиглалтын) олгох үйл ажиллагааг хориглосон байсан тул 2014 онд ямар нэгэн зөвшөөрөл олгогдоогүй харин 2013 онд газрын тосны зөвшөөрөл олгогджээ. Үүний нэгэн адил, 2013 онд тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн хийгдээгүй бөгөөд Ашигт малтмалын хуулиар шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосон байжээ (2014 оны 7 сард нэмэлт өөрчлөлт орсон). 2013 оны ОУИТБС-ын тайлан нь шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй байх хориг үйлчилж буй талаар дурдаагүй. Тус тайланд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох журмыг (хуудас 58-59), мөн газрын тосны тусгай зөвшөөрлийн журмыг (хуудас 65) тайлбарласан ч аль ч салбарт сонгон шалгаруулалт хийхэд баримталсан санхүүгийн болон техникийн шалгуурын талаар мэдээлэл багтаагаагүй ажээ. Тайланд мөн 2013 онд хийгдсэн газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар мэдээлэл оруулсангүй.

Мөн тусгай зөвшөөрөл олгох системийн үр дүнтэй, үр бүтээмжтэй байдал зэрэг нэмэлт мэдээлэл эсвэл ОУИТБС-ын тайланд хамаарах санхүүгийн жилээс өмнө олгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл (хэдий ОУИТБС-ын стандартаар заавал шардагдаагүй ч) зэрэг нэмэлт мэдээлэл тайланд ороогүй ажээ.

¹⁰⁸ InfoMonglia (2014/2), 'ЗГ Сансарын геологи хайгуул компанитай БХГ хийлээ', <http://www.infomongolia.com/ct/ci/7396>

¹⁰⁹ ПТГ-ын вебсайтыг үзнэ үү - <http://english.pam.gov.mn/content/14192.shtml>

Оролцогч талуудын санал бодол

Монголын ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгчээр ажиллаж байсан нэг байгууллагын төлөөллийн зүгээс ОТОБ нь 2014 онд шинээр олгосон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн тусгай зөвшөөрлийн тухай 2014 оны тайланд зориулан мэдээлэл цуглуулахаас өмнө ямар нэгэн байдлаар хэлэлцээгүй ажээ. Хараат бус нэгтгэгч нь Ашигт малтмалын газраас кадастрын мэдээлэл авч тухайн авсан мэдээллээ ОУИТБС-ын 2013 оны тайлантай харьцуулан үзсэнээр 2014 онд олгогдсон шинэ тусгай зөвшөөрлийн тоог гаргажээ. Хараат бус нэгтгэгчид ОТОБ-наас 2014 онд шинээр газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ хийгдсэн эсэх дээр ямар нэгэн мэдээлэл өгөөгүй ажээ. Нэгтгэгч нь Газрын тосны газраас авсан мэдээллээ 2014 оны тайланд оруулсан байна.

Иргэний нийгэм, компанийг төлөөлсөн хэд хэдэн хүн 2014 оны ОУИТБС-ын тайланд шинээр олгосон хэмээн дурдсан тусгай зөвшөөрлийн тоо нь буруу хэмээн үзэж байна. Шинээр тусгай зөвшөөрөл олгох хориг 2014 оны 7 дугаар сард цуцлагдсан ч үндсэндээ 2015 оны 1 дүгээр сараас л шинээр олгогдож эхэлжээ. Төлөөллийн үзэж буйгаар шинээр тусгай зөвшөөрөл олгохоос илүүтэйгээр шүүхийн шийдвэрийн дагуу нийт 56 тусгай зөвшөөрлийг анхны эзэмшигчдэд нь буцаан олгосон байна. Шинээр тусгай зөвшөөрлийг хориглосон нь хуучин лицензийг буцаан олгоход хамаарахгүй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Салбар болон засгийн газрын төлөөллийн зүгээс 2014 онд шинээр газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийгдсэн эсэх дээр ямар нэгэн тайлбар өгөөгүй.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, гэхдээ ОУИТБС-ын 2014 оны тайланд дурдагдаагүй процедурын талаар иргэний нийгмийнхэн мэдээлэл өгсөн ба тусгай зөвшөөрлийн талбай давхацсан талбайд хоёр компани өргөдөл гаргахад хамгийн цөөн өргөдөл гаргаж байсанд нь өгдөг ба энэ нь тусгай зөвлөл олгох заавал (сонголтот) баримтлах үзүүлэлт хэмээн тооцдог байна. Мөн түрүүлж ирсэнд нь түрүүлж олгох зарчмаар дугаар олгодог тул интернетийн хурд сайтай нь давуу талтай байдаг ажээ. Иргэний нийгмийн үзэж буйгаар 2014 оны ОУИТБС-ын тайлан нь тусгай зөвшөөрөл авахдаа аймаг, сумын захиргаатай зөвлөлдөн зөвшөөрөл авах 30 хоногийн тухай дурдаагүй бөгөөд энэхүү 30 хоногийн хугацаанд Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрөл олгохоор болсон ч орон нутаг татгалзах боломжтой, компанийн зүгээс үүнд давж заалдах боломж хаалттай байна.

Засгийн газрын төлөөлөл, мөн зарим иргэний нийгмийн үзэж буйгаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд дүрэм журмыг баримтлаагүй явдал ихээр гараагүй ба шилжүүлэхэд ч гэсэн ийм зүйл 2014 онд ажиглагдаагүй ажээ. Уул уурхайн салбарын хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ төрийн байгууллагын зүгээс илэрхийлсэн саналыг итгэхгүй гэж үзэхэд тусгай зөвшөөрөл олгоход ямар нэгэн зөрчи гараагүйд өөрөөр хэрхэн итгэж болох талаар асууж байв. Хэрэв компани нь тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар гомдол гаргасан бол л зөрчил үүссэн гэж үзнэ хэмээн тэдгээр төлөөлөл үзсэн. Оролцогч талуудын зүгээс 2014 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхэд баримталсан журам, дүрмийн талаар ямар нэгэн тайлбар гаргаагүй. Газрын тос байгалийн хийн компаниуд ДонгШен компанитай 2010 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхэд баримталсан журмыг ОУИТБС-ын 2014 оны тайланд оруулсан шалтгааны талаар мэдэхгүй байв. Энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь үндсэндээ шинэ гэрээ бус харин шинэчлэл хийсэн хэрэг байсан гэж тус компанийн төлөөлөл хэлж байв.

Анхдагч үнэлгээ

Монгол улсын зүгээс энэхүү шаардлагыг биелүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд Олон улсын Ажлын албаны зүгээс өгөх үнэлгээ нь тус улс энэ чиглэлд тодорхой ахиц дэвшил гаргасан

байна хэмээн дүгнэж байна. Хэдийгээр ОУИТБС-ын 2014 оны тайланд 2014 онд ашигт малтмал, гарын тосны тусгай зөвшөөрлийг хэрхэн олгосон, ямар шилжилт хөдөлгөөн хийгдсэн болохыг дурдаагүй ч түр цуцалсан байж байгаад 2014 онд эзэмшигчидэд нь буцаан олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг буруу ангилан шинээр олгосон тусгай зөвшөөрөл хэмээн оруулжээ.

Энэхүү тайлан нь тусгай зөвшөөрөл олгох журам, техникийн болон санхүүгийн шалгуур зэрэг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд баримтлах шалгуурыг, мөн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхэд баримтлах шалгуур зэргийг багтаажээ. ОУИТБС-ын Стандартаар хэрэгжиж буй журам дүрмээс гадуур тусгай зөвшөөрөл олгосон, шилжүүлсэн эсэх дээр мэдээлэл гаргасан байхыг шаарддаг юм. Тус тайланд ашигт малтмалын нэг, газрын тосны нэг гэрээний талаар мэдээлэл дэлгэрэнгүй оруулсан ба 2014 онд олгогдсон бүх тусгай зөвшөөрөл дээр энэ мэдээлэл оруулаагүй байна. Стандартаар “тухайн санхүүгийн жилд олгосон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн бүх тусгай зөвшөөрөл” хэмээн дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. ОТОБ нь мөн ирээдүйд гаргах ОУИТБС-ын тайлангууд нь тухайн жилд хийгдсэн газрын тосны гэрээ болон ашигт малтмалын бүх тусгай зөвшөөрлийг багтааж, журам зөрчин хийгдсэн ямар нэгэн тусгай зөвшөөрөл олголтыг тодруулан, тухайн жилд олгосон ашигт малтмал болон газрын тосны тусгай зөвшөөрөл олгоход баримталсан журмын талаар мөн тайланд оруулж байх шаардлагатай.

Тусгай зөвшөөрлийн бүртгэл (#2.3)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын 2014 оны тайлан нь өмнө гарч байсан тайлангуудаас илүү иж бүрэн мэдээллийг агуулжээ. Тайлангийн 5.1.4.1 (хуудас 65-67) болон Хавсралт 14 (хуудас 207-264) нь 2014 оны байдлаарх тусгай зөвшөөрлийн тойм мэдээллийг багтаасан ба үүнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, зөвшөөрлийн дугаар, хамаарах ашигт малтмал, талбайн нэр, байршил, олгосон огноо дуусах хугацааг багтаажээ. Хэсэг 5.1.6 (хуудас 87-89) ураны салбарыг хамруулан энэ салбарт олгоод буй 57 тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл өгчээ. Тайланд дурдсан мэдээлэл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, зөвшөөрлийн дугаар, хамаарах ашигт малтмал, талбайн нэр, байршил, олгосон огноо дуусах хугацааг хамарсан байна. Харин ашигт малтмалын болон ураны тусгай зөвшөөрлийн мэдээлэл дээр өргөдөл гаргасан огноо болон талбайн солбицолууд байгаагүй. Хэсэг 5.2.1.3 (хуудас 98) дээр Ашигт малтмалын газрын онлайн кадастрын үйлчилгээний тухай дурдан, хамаарах холбоосыг оруулжээ. Кадастрын үндсэн мэдээллийг үнэ төлбөргүй авч болох ч Шаардлага 2.3-т хамаарах бараг бүх мэдээлэл, өргөдөл гаргасан өдрөөс бусад солбицол зэргийг авахын тулд бүртгэлийн төлбөр төлөх шаардлагатай байна.

Хэсэг 5.2.2.3 (хуудас 103) дээр газрын тос болон байгалийн хийн салбарын тусгай зөвшөөрлийн бүртгэлийн талаарх тойм мэдээлэл агуулжээ. Энэ хэсэгт 22 Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх Газрын тосны газрын мэдээллийн холбоос (үнэ төлбөргүй) буй бөгөөд хамаарах мэдээлэл нь тусгай зөвшөөрлийн талбайн нэр, бүсийн код, газрын тосны газрын вебсайт дээрх газрын зураг болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын оруулсан солбицол, өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, үргэлжлэх хугацаа болон үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүн зэрэг мэдээлэл байхгүй. Тайлан дээр мөн Монголын ОУИТБС-ын цахим тайлангийн системийн тухай мэдээлж, газрын тосны 20 лицензтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосны дотор тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр, талбайн хэмжээ, эзэмшигч, олгосон огноо болон дуусах хугацаа зэргийг вебсайт дээр олон нийтэд нээлттэй байршуулсан бол өргөдөл гаргасан огноо, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл болон солбицол зэргийг оруулаагүй байна.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

2013 тайлан нь лицензийн ил тод байдлыг сайн хангажээ. Хавсралт 13¹¹⁰ дээр тус улс дахь тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын жагсаалтыг хамруулсан (бүх 250 компани нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болохын хувьд багтсан, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тос болон ашигт малтмалын бүх тусгай зөвшөөрлийг харуулсан). Бүлэг 6.5.3 (хуудас 100) дээр 2013 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд гарсан өөрчлөлтийг болон тусгай зөвшөөрөл давхацсан болон буцаасан шалтгаан зэргийг мэдээлжээ. Хүснэгт 19 (хуудас 36) нь хүчин төгөлдөр буй 21 Бүтээгдэхүүн хуваах гэрээг харуулан үүнд тусгай зөвшөөрлийн нэр, олгосон огноо, хамаарах Засгийн газрын тогтоол, эзэмшигчийн нэр, эзэмшигчийн хамаарах улс, тусгай зөвшөөрлийн төрөл (хайгуул/олборлолт) зэргийг мэдээлсэн байна. Энэхүү мэдээлэл нь нийт 3029 тусгай зөвшөөрөл дээр гарсан бөгөөд энэ нь нэгтгэлийн хамрах хүрээнд багтсан 250 компанитай харьцуулбал маш иж бүрэн мэдээлэл болж байна. Гэхдээ График 17 (хуудас 62) дээр 2013 онд нийт 3118 идэвхтэй тусгай зөвшөөрөл буй хэмээн дурдсан (хайгуулын 1815, ашиглалтын 1303) байна. 2013 оны ОУИТБС-ын тайлан нь уул уурхайн кадастрын цахим систем боловсруулах чиглэлээр хэрэгжин, 2014 онд дууссан Дэлхийн Банкны төслийн талаарх тойм мэдээллийг мөн оруулжээ.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагын төлөөллийн зүгээс тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноог кадастрын мэдээлэл дээр ил тод болгоогүй бөгөөд харин дотоод хэрэгцээнд энэхүү мэдээлэл боломжтой (гэхдээ олон нийтэд хаалттай) тул энэ мэдээллийг 2016 оны ОУИТБС-ын төлөвлөгөөнд оруулан, нээлттэй болгохоор төлөвлөж буйг дурдсан (Үйл ажиллагаа 10.4.1). Тусгай зөвшөөрөл олгох болгонд кадастрын мэдээлэлд шинэчлэл оруулдаг бөгөөд гэхдээ өргөдөл гаргах тоиолдол бүрт энэ шинэчлэл хийгдэхгүй байна. Цаашид кадастр дахь өргөдөл гаргасан огноог ил тод болгох төлөвлөгөөтэй буй ба гэхдээ энэхүү ажлыг хэрэгжүүлэх өдрийг тогтоогоогүй, мөн одоо ажиллаж буй кадастрын бүтцэд өөрчлөлт оруулахын тулд Дэлхийн Банктай зөвшилцөх шаардлага гарч болно.

Уулзалтад хамрагдан оролцсон газрын тос, байгалийн хийн компаниуд нь Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн солбилцолтой хамаарах ямар нэгэн нууцлал байдаг эсэхийг мэдэхгүй байсан бөгөөд эдгээр солбилцлыг гэрээ нэг бүрийн хавсралт дээр оруулсан байдаг ч энэ талаар мэдээлэхгүй буй нь үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбоотой байж магад гэж үзэж байна. Гэхдээ Бүтээгдэхүүн хуваах гэрээг нууцлалтай хэмээн тооцдог болохыг хэлж байв (2016 оны 7 сарын байдлаар). (Доор буй гэрээний ил тод байдлын талаар үзнэ үү). 2006 оноос хойш нээлттэй газрын тос, байгалийн хийн талбай дээр өргөдөл хүлээн авсан даруйдаа Газрын тосны газраас өөрийн вебсайт дээр хэвлэлийн мэдээ гаргадаг болсон ба тодорхой хугацаанд сонирхож буй бусад этгээдийг өргөдлөө өгөхийг урьдаг болсон хэмээн тус байгууллагын төлөөлөл мэдэгдсэн. Ийм байдлаар өргөдөл гаргасан хугацааг ил тод болгосноос гадна хэвлэлийн мэдээ бүр дээр заасан буй хугацаанаас эргүүлэн тооцох замаар өргөдөл гаргасан өдрийг мэдэхэд хялбар хэмээн хэлж байна (30 хоног хасаж тооцон). Гэхдээ эдгээр төлөөллийн хэлж буйгаар хуучин хийгдсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний огноог эргэн гаргах боломжгүй бөгөөд ялангуяа үйлдвэрлэлийн шатанд орсон, Газрын тосны газар вебсайтаар болохоос өмнө 1990-ээд онд хийгдсэн гэрээн дээр одоо ингэж тооцоход хэцүү болсон байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү шаардлагыг биелүүлэх чиглэлээр боломжит тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргасан хэмээн үнэлж байна. Хэдий 2014 оны ОУИТБС-ын тайлан

¹¹⁰ Хавсралт 13 нь вебсайт дээр тайлангаас тусдаа тавигдсан (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/2013%20Report%20annex%20EN.zip>) (хэт олон хуудастай тул)

болон Ашигт малтмалын газрын вебсайт дээр ихэнх ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл багтсан ч тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан огноо байхгүй байна. ОТОБ-ийн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноог ил болгох талаар тусгасан байна. ОТОБ нь Ашигт малтмалын газартай хамтран ажиллаж бүхий л ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан хугацааг ил тод болгох чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. ОТОБ нь мөн өргөдөл гаргасан болон олгосон огноо дуусах огнооны хамтаар кадастрын мэдээлэл дээр олон нийтэд нээлттэй болгон, төрийн байгууллагуудын ашиглаж буй тусгай зөвшөөрлийн мэдээллийн сантай уялдуулах чиглэлээр ажиллах шаардлагатай.

Газрын тос, байгалийн хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ОУИТБС-ын цахим тайлангийн системээр дамжуулан гаргасан ч өргөдөл гаргасан огноо, тусгай зөвшөөрлийн солбицол зэрэг мэдээлэл байхгүй. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн солбицол нь тухайн гэрээн дээр текст хэлбэрээр байгаа ба эдгээрийг 2016 оны 8 дугаар сард нээсэн ННФ-ын гэрээний портал дээр тавигдана хэмээн үзэж буй бөгөөд одоогоор энэхүү мэдээлэл олон нийтэд ил тод бус байна. 2006 оноос хойш байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд өргөдөл гаргасан огноог эргэн тооцож болох ч тэр хугацаанаас өмнө хийсэн гэрээний хувьд (ялангуяа 1990-ээд онд) олон нийтэд нээлттэй бус байна. Газрын тос, байгалийн хийн гэрээ болгонд хамаарах бүтээгдэхүүнийг тусгайлан дурдаагүй ч энэ нь мар бүтээгдэхүүнийг зааж буй нь ойлгомжтой юм.

Гэрээний ил тод байдал (#2.4)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын 2014 оны тайланд гэрээний ил тод байдлын тухай төрийн бодлого болон бодит үйл ажиллагааны талаарх мэдээллийг багтаажээ. Хэсэг 5.5.2.1 (хуудас 122-123) дээр гэрээний ил тод байдлын талаарх Засгийн газрын бодлогыг дурдахдаа үндсэн 4 гол хамаарах хууль тогтоомжийг цохон дурдсан байна (Газрын тосны хууль, Ашигт малтмалын хууль, Цөмийн энергийн тухай хууль болон Концессын тухай хууль). Эрдэс баялагийн салбар дахь төрийн бодлогын баримт бичиг нь төр болон хувийн хэвшлийн санхүүжилт бүхий бүх геологийн судалгаа, хайгуул болон боловсруулах үйл ажиллагааг ямар нэгэн эрх зүйн саад тотгоргүй бол бүх түвшинд ил тод болгоно хэмээн заажээ. Мөн тус баримт бичгээр хөрөнгө оруулагч болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд хийсэн Орон нутгийн хөгжлийн гэрээ нь ил тод байхыг заасан байна. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулиар “төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагууд нь концессын гэрээ болон хамтарсан компани байгуулах бүх гэрээг олон нийтэд ил тод болгоно” хэмээн заасан ч бүхий л гэрээг бус харин гэрээний заалтуудын талаарх мэдээллийг л ил болгохоор заасан байна. Гэхдээ Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2 дээр ил тод болгох нь тухайн аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг сонирхолд хор хохирол учруулах, зах зээлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөөлөлөх бол, эсвэл тухайн мэдээлэл нь зах зээлийн онцлог давуу талд хамаарах эсвэл мэдээлэл нь байгууллага, аж ахуйн нэгжийн нууцлал бүхий үйл ажиллагаанд хамаарах бол мэдээллийн нууцлалыг хамгаалах тухай заажээ.

Тайлангийн Хэсэг 5.5.2.2 (хуудас 123-124) дээр гэрээний ил тод байдлыг хангаж буй арга ажиллагааны талаар дурдсан байна. Өнөөгийн байдлаар нийт 12 гэрээг олон нийтэд ил тод болгоод буй бөгөөд эдгээрийн 11 нь орон нутгийн захиргаа болон уул уурхайн компаниудын хооронд хийгдсэн гэрээ байна. Харин үлдэх нэг гэрээ нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ юм. Гэрээний ил тод байдлыг дэмжих зорилгоор Хараат бус нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлангийн маягтуудаар

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

дамжуулан төр болон орон нутгийн зүгээс уул уурхайн компанитай гарын үсэг зурсан гэрээний талаар ил тод болгох хүсэлтийг гаргасан байна. Нийт материаллаг төлбөр төлсөн 42 компанийн 32 нь эргэн тайлан явуулж 167 гэрээний (хавсралт 32, хуудас 317-2-325) тухай мэдээлэл хүргүүлсэн ч зөвхөн хоёр л компани (Ноён гар ХХК болон Андын Тэмүүлэн ХХК) өөрсдийн хийсэн гэрээг бодитоор иж бүрнээр ил тод болгожээ. Бусад олон нийтэд нээлттэй буй 10 гэрээ нь 2014 оны ОУИТБС-ын тайлангаас өмнө ил тод болсон гэрээнүүд байна. ОУИТБС-ын тайлан дээр мөн 2014 оноос хойш хийх Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон ашигт малтмалтай холбоотой гэрээнийн загвар дээр нууцлалын заалтыг хассан тухай мэдээлжээ.

ОУИТБС-ын 2013 оны тайлан дээр гэрээний ил тод байдалтай холбоотой төрийн бодлогод буй алдаа, зөрчилтэй үйл явцын талаар дэлгэрэнгүй тусгасан ч энэ тайланд гэрээний ил тод байдалтай холбоотой төрийн бодлогын ямар нэгэн баримт бичгийг оруулаагүй байна. Хэсэг 2.4.3 (хуудас 14) болон 8.4 (хуудас 112) дээр гэрээний ил тод байдлын талаар төрийн байгууллагууд харилцан зөрүүтэй ойлголттой, зарим нь эргэлзээтэй буй талаар (Уул уурхайн яам, Газрын тосны газар) дурдсан бол мөн компаниуд ч энэ чиглэлийн төрийн бодлогын талаар мөн адил хэмжээнд мэдлэгтэй буйг цохон тэмдэглэжээ. ОУИТБС-ын 2013 оны тайлан нь мөн орон нутагтай хийсэн гэрээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулжээ. Хавсралт 14 (хуудас 114) нь орон нутгийн захиргаадтай хийсэн нийт 153 гэрээний талаар оруулсан нь нэгтгэлд хамрагсан 250 компанид хамаарах гэрээ юм.

2013 оны ОУИТБС-ын тайлан дах гэрээний ил тод байдлын тухай мэдээллийг ОТОБ мөн судлан үжээ. 2015 оны 1 дүгээр сард байгуулагдсан гэрээний ил тод байдлын тухай ажлын хэсгийн хүрээнд Газрын тосны газартай хамтран ажилласны дүнд 2014 онд батлагдсан Газрын тосны хуулийн дагуу боловсруулсан шинээр байгуулагдах Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвараас нууцлалын заалтыг хассан байна. 2015 он гарсанаас хойш байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гурван гэрээ нь энэхүү загварын дагуу байгуулагдсан тул эдгээрийг ил тод болгох шаардлагатай юм. Газрын тосны газар нь гэрээний ил тод байдлыг хангах хүсэл эрмэлзлэлтэй буйгаа мэдэгдсэн ч хуучин хийгдсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээрх нууцлалтай холбоотой заалтууд нь тухайн гэрээг ил тод болгох боломжгүйд хүргэж буйг мэдээлсэн. Тус газраас мөн ажлын хэсэгт гэрээг ил тод болгосноос үүдэх нөлөөллийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн ба учир нь хуучин хийсэн гэрээний нөхцлүүдийг, ялангуяа санхүүгийн нөхцлүүдийг ил тод болгосноор бусад шинэ гэрээ хийж буй тал ижил нөхцлийг шаардах тул Монгол улсын хувьд ашиггүй хэмээн үзэж байна. ОТОБ-ын гэрээний ил тод байдлын ажлын хэсэг энэ асуудлаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий газрын тос, байгалийн хийн компаниудтай уулзан ярилцсан бөгөөд тэдгээр комданиас бичгээр зөвшөөрөл гаргуулан авахаар хичээж байна.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагыг төлөөлсөн ОТОБ-ийн нэг гишүүн засгийн газрын зүгээс гэрээний ил тод байдлыг ерөнхийдөө дэмжиж буй хэмээн хэлсэн. Тэрээр гэрээний ил тод байдлын талаарх эрх зүйн шаардлагуудын тоог дурдаад мөн томоохон уул уурхайн төслүүд дээр УИХ-ын чуулганаар гэрээ нь батлагдах ёстой тул гэрээний хэлцэл хийгдэх үйл явц нээлттэй явагдаж, мөн Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагын бүх гэрээ болон зарцуулалт нь ил тод байхыг шаардаж байна (гарын үсэг зурсанаас хойш 5 хоногийн дотор).

Олборлох салбар болон иргэний нийгмийн байгууллагуудыг төлөөлсөн хэд хэдэн хүний үзсэнээр зөвхөн томоохон уул уурхайн төслүүд л Засгийн газартай гэрээ хийдэг бөгөөд үүнийг тогтворжилтын гэрээ хэлбэрээр хийдэг бол жижиг төслүүдийн хувьд тусгай зөвшөөрлийн нөхцлөөр л

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

зохицуулагддаг. Иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлсэнээр зөвхөн цөөн тооны уул уурхайн гэрээ байгаа тул уул уурхайн компаниуд болон орон нутаг хоорондын гэрээг түлхүү ил тод болгох хүсэлт гаргажээ. 2016 оноос эхэлсэн Орон нутгийн хөгжлийн гэрээ, үүний заалтуудыг ил тод болгох нь чухал хэмээн иргэний нийгмийн байгууллагууд үзэж байна.

Талуудын мэдээлсэнээр гэрээний ил тод байдлын тухай ажлын хэсэг 2016 онд хоёр удаа хуралджээ. Эхний хурал болон 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар ННФ-ын гэрээний ил тод байдлын порталын тухай дотоод асуудал хэлэлцсэн бөгөөд харин 5 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар Уул уурхайн яам, Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий компаниудын төлөөлөл оролцож 2016 оны байдлаар хүчин төгөлдөр буй 24 гэрээг ил тод болгох тухай ярилцсан байна. Газрын тосны компаниудын хувьд зарчмын хувьд гэрээгээ ил тод болгохыг зөвшөөрсөн ч санхүүгийн нөхцөл, ТЭЗҮ зэрэг мэдээллийн хувьд татгалзаж буй ба ажлын хэсгийн мэдээлсэнээр тухайн компаниудад 2016 оны 6 сарын 15-наас өмнө гэрээгээ ирүүлэх хугацаа заасан ч 7 сарын 1-ний байдлаар ямар ч компани гэрээгээ ирүүлээгүй байна. Уулзалтад хамрагдсан газрын тос, байгалийн хийн компаниудын төлөөлөл хэлэхдээ шинээр хийгдэж буй гэрээний талууд нь тухайн гэрээг ил тод болгохыг зөвшөөрч буй бол (дээрх хэсгийг нууцлан) харин 1990-ээд оны үед гарын үсэг зурагдсан гэрээний тал нь тэдний гэрээг шинэ загварт оруулах хүртэл хүлээнэх саналтай буйгаа хэлжээ. Тухайн төлөөллийн хэлсэнээр хуучин гэрээнүүдийг Газрын тосны газар 2016 оны эцэс гэхэд шинэ загварт оруулах бөгөөд ингэснээр шинэ загвар нь гэрээг ил тод болгох шаардлага тавих юм. Мөн ил тод болгох нь эрх зүйн үүрэг болгох эсэх дээр их зүйл шаалтгаална гэдгийг олон хүн хэлж байлаа.

Иргэний нийгмийн зүгээс гэрээний портал байгуулах нь 2014, 2015 болон 2016 онуудын ажлын төлөвлөгөөнд тусгагдаж байсныг хэлж байв. Мөн 2014 онд Засгийн газар олон компаниудтай хийсэн уулзалтын үеэр гэрээний ил тод байдлыг талаар нэгдсэн ойлголтод хүрсэн ч өнөөгийн байдлаар зөвхөн хоёр л гэрээ ил тод, 2016 оны 6 сарын байдлаар Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд ил тод болоогүй байна. Тиймээс чадавхийг бэхжүүлэх, олон нийтэд хандсан арга хэмжээг зохион байгуулан тухайн компаниудад дарамт үзүүлэх хэрэгтэйг хэлж байв. Иргэний нийгмийн нэг төлөөллийн хэлж буйгаар 2016 оны 5 дугаар сарын хурлаар засгийн газар болон компаниудын төлөөлөл гэрээний ил тод байдлын давуу талуудын талаарх ойлголтоос буцаж, гэрээний нууцлалын тухай илүүтэй ярих болжээ. Гэхдээ төлөөллийн хэлж буйгаар Бүтээгдэхүүн хуваах гэрээнд буй нууцлалын заалтууд нь санхүүгийн нөхцөл зэрэг гэрээний тодорхой хэсэгт л хамаарах ба бусад хэсэгт үл хамаарна хэмээн үзэж байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улсын хувьд энэхүү шаардлагыг ханган биелүүлэх талаар хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан хэмээн үнэлж байна. ОУИТБС-ын тайланд дурдсан гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлогыг тодруулах тухай зөвлөмжүүдийг идэвхтэй хэрэгжүүлэн, 2015 онд боловсруулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвараас нууцлалыг заалтуудыг хассан байна. Мөн 2016 оны 8 дугаар сард гэрээний шинэ портал ажиллаж эхлэх ба энэ нь төрөл бүрийн 100 гаруй гэрээ (хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдлын болон орон нутгийн хөгжлийн) тавигдахаар төлөвлөгдөж байна. ОТОБ нь Газрын тосны газартай хамтран ажиллаж өмнө хийгдсэн гэрээг шинэ загварт хөрвүүлэх болон гэрээний ил тод байдалтай хамаарах эрх зүйн үр дагаварыг сайтар тодорхой болгох шаардлагатай юм.

Бенефициар өмчлөгчийг ил тод болгох (#2.5)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Монголын ОУИТБС нь 2014 оноос хойш бенефициар өмчлөлийг ил тод болгох үйл ажиллагааг 2014 оноос хийж байна. Бенефициар өмчлөлийн талаар судлан мэдэх эхний алхамын хүрээнд 2013 оны ОУИТБС-ын тайлангийн хамрах хүрээ нь компаниудаас тэдний эрх зүйн өмчлөлийн тухай шаардлагыг багтаажээ. 2014 оны 3 дугаар сарын 11-ний өдөр болсон ОТОБ-ийн хурлаар Монгол улсын Үнэт цаасны тухай хуулийн 4.1.26 дээр заасан бенефициар өмчлөлийн тодорхойлолтыг баримтлахаар талууд зөвшөөрсөн байна. 2013 болон 2014 онд ОУИТБС-ын тайлангууд нь нийт 2015 болон 26 компанийн хууль ёсны өмчлөлөгчийг ил тод болгосон нь компаниудас авсан мэдээлэл дээр үндэслэжээ. 2016 онд ОУИТБС-ын стандартад шинээр тусгагдсан бенефициар өмчлөлийн шаардлагын дагуу (#2.5) ОТОБ нь хэлэлцүүлэг өрнүүлэх 2016 оны 4 дүгээр сарын 22-ны хурлаараа Уул уурхайн яамны Санхүү, нягтлан бодох бүртгэлийн газрын дарга, ОТОБ-ийн гишүүн Н.Энхбаяраар ахлуулсан бенефициар өмчлөлийн техникийн ажлын хэсгийг байгуулжээ.¹¹¹ Энэхүү ажлын хэсгийн 20 гишүүнд Хууль зүйн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикын газар, Монголын хөрөнгийн бирж, Ашигт малтмалын газар, Улсын бүртгэлийн газар, Газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Эрдэнэс Монгол ХХК болон бусад 3 уул уурхайн компани болон иргэний нийгмийн 4 байгууллагын төлөөлөл багтсан байна. Мөн ННФ нь Монгол орны нөхцөл дэхь бенефициар өмчлөлийн талаарх судалгаа хийж буй бөгөөд энэхүү судалгааны дүнг 2016 оны 8 дугаар сард нийтлэхээр төлөвлөж байна. Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн мөн бенефициар өмчлөлийг ил тод болгох замын зураглал боловсруулах чиглэлээр нэг долоо хоногийн сургалтыг 2016 оны 8 дугаар сард хийхээр төлөвлөж байна.

ОУИТБС-ын 2014 оны тайлан нь бенефициар өмчлөлийг ил тод болгох тухай төрийн бодлогын талаар мэдээлэл оруулаагүй ч тайлан гаргах үйл явцын хүрээнд нийт 236 компаниас өөрийн бенефициар өмчлөгчийг ил болгох хүсэлтийг хүргүүлжээ. Энэхүү хүсэмжилсэн мэдээллийн тоонд тайлангийн маягтын хүрээнд гурван түвшний хууль ёсны эзэмшлийн тухай мэдээллийг уул уурхайн болон газрны тосны компаниудаас хүссэн байна. Хараат бус нэгтгэгч нь ОТОБ-тэй 2015 оны 7 сарын 7-ны өдөр хийсэн эхлэлийн семинар дээр эхний шатанд 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшиж буй өмчлөгчийг, дараагийн шатанд багадаа 25%-ийн, улмаар сүүлийн шатанд хамгийн багадаа 51%-ийн хувьцаа эзэмшигч этгээдийг ил тод болгохоор тохирсон байна.¹¹² Тайлангийн маягтын “нэмэлт мэдээлэл” гэсэн өмнө дурдсан хэсэгт 2014 оны ОУИТБС-ын тайланд зориулан өөрчлөлт оруулж, доорх мэдээллийг оруулах зааварчилгааг нэмэн оруулжээ:

- (i) Бенефициар өмчлөлийн тодорхойлолт
- (ii) ОУИТБС-ын туршилтын тайлангийн маягтууд
- (iii) Өмчлөлийн гурван түвшний босгыг тогтоох (боломжтой бол)
- (iv) Вебсайтаар холбож өгөх (хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд дээр)

Нийт материаллаг төлбөр бүхий 236 компаниас 30 компани нь хууль ёсны эзэмшигчийн тухай мэдээллийг гарган ирүүлсэнийг Хавсралт 21.а (хуудас 305-314) дээр оруулсан ч нийт материаллаг төлбөр бүхий 236 компаниас 30 компани нь эцсийн бенефициар өмчлөгчийн тухай мэдээллийг ирүүлээгүй байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай шинэ хуулийг УИХ 2015 оны 5 дугаар сард батлан гаргасан ба энэ хуулинд анхны төсөл дээр байсан хуулийн этгээдийн бенефициар өмчлөгчийг олон нийтэд нээлттэй байлгах заалт ороогүй байна. Энэ талаарх мэдээлэл шаардлагатай бол тусгай

¹¹¹ ОТОБ-ын хурлын тэмдэглэл, 2016 оны 4 22, хэвлэгдээгүй.

¹¹² Эхлэлийн тайлан, Хавсралт 1 ба 5, KPMG 2014.

хүсэлт гарган авах ба мэдээлэл өгөхөөс татгалзах үндэслэлүүдийг мөн заасан байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл нь тухайн салбарын компаниуд өөрийн бенефициар өмчлөгчийг ил тод болгохыг шаардаж буй юм.

Оролцогч талуудын санал бодол

ОТӨБ-ийн байгуулсан Бенефициар өмчлөлийн ажлын хэсэгт төрийн байгууллагыг төлөөлөн ажиллаж буй нэг төлөөллийн хэлсэнээр бенефициар өмчлөлийг ил тод болгох талаарх төрийн бодлого хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд тодорхой (Үнэт цаасны хуулийн дагуу), мөн төрийн албан хаагчид энэ талаараа мэдээлэх үүрэгтэй (Авлигын эсрэг хууль) боловч бусад компаниудтай хамаарах бодлого нь өнөөг хүртэл тодорхойгүй буйг хэлж байна. Төрийн байгууллагуудыг төлөөлсөн хэд хэдэн хүний үзэж буйгаар ОУИТБС-ын стандартад заасан өмчлөлийн цар хүрээ нэмэгдсэн ч үүнийг биелүүлэх хангалттай эрх зүйн үндэслэл одоогоор байхгүй байна. ОУИТБС-ын тодорхой орчин, хүрээллийг бий болгохын тулд төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоо шаардлагатай. Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөллийн хэлсэнээр тус холбооны гишүүд үндсэндээ уул уурхайн компанийн бодит эзэмшигчийг ил тод болгохыг дэмжиж буй ч энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь ихээхэн сорилттой байна хэмээж байна. Томоохон компаниуд энэ талаар дэмжих боловч Монгол дахь уул уурхайн салбарын дийлэнхийг бүрдүүлж буй жижиг компаниудад хүрч ажиллах нь хэцүү байна гэж үзжээ.

Анхдагч үнэлгээ

Одоогийн байдлаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудад бенефициар өмчлөлийн асуудлаар ажиллах шаардлага тавигдаагүй буй юм. Гэсэн нь ОТӨБ нь энэ чиглэлээр зарим үйл ажиллагааг явуулсаны тоонд 2013 болон 2014 оны тайлангийн маягтуудад энэ талаар асуулга оруулсан байна. Үүнээс гарсан үр дүнг Монголын ОУИТБС-ын вебсайт дээр инфографик байдлаар тоймлон харуулжээ. ОТӨБ нь мөн бенефициар өмчлөлийн асуудлаар ажлын хэсэг байгуулж, 2017 оны 1 сарын 1 гэхэд гурван жилийн замын зураг-ажлын төлөвлөгөөг гарган, ОУИТБС-ын стандартын 2.5.b.ii дээр заасан шаардлагыг хангахаар ажиллаж байна. Хэдий бенефициар өмчлөлийн тухай мэдээллийг хангалттай хэмжээнд ил тод болгоогүй, ихэнх мэдээлэл нь хууль ёсны өмчлөгчийг дурдсан ч ОТӨБ нь энэ асуудалд бодитоор анхаарал хандуулан, үе шаттай хандлагаар мэдээлэл ил тод болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2016 оны стандартын 2.5 дугаар шаардлагыг хангах бэлтгэл ажил болгон, ННФ-ын 2016 оны 8 дугаар сард хийсэн судалгааны үр дүнд үндэслэн Засгийн газар нь энэ чиглэлээрх өөрийн бодлогыг тодорхой болгох шаардлагатай юм.

Төрийн оролцоо (#2.6)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлангийн 5.4 хэсэг (Хуудас 110-115) дээр олборлох үйлдвэрлэл дэхь төрийн оролцоог тайлбарлан, энэ нь материаллаг орлогыг нэмэгдүүлдэг гэдгийг тэмдэглэсэн.

5.4.2 хэсэгт (Хуудас 111) уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 21 төрийн өмчит компанийн талаар нарийвчилсан мэдээллийг оруулсан. 5.4 хэсэгт (хуудас 115) дээр газрын тос болон байгалийн хийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компани байхгүй ч ГТГ нь энэ салбар дахь төрийн ашиг сонирхол, тэр дундаа төсөл бүр дэх төрийн өмчлөлийг хариуцдаг талаар дурдан оуулсан байна.

2014 оны ОУИТБС-ын тайланд тэмдэглэснээр төр болон төрийн өмчит компанийн хоорондох санхүүгийн харилцаа нь “ихэнхдээ” Хүний хөгжил сангийн тухай хуулинд захирагддаг (хуудас 110)

байна. Энэхүү хуулинд зааснаар ногдол ашгаас болон төрийн өмчит компани гэх мэтийн стратегийн чухал ашигт малтмалын үйлдвэрлэлийн лиценз эзэмшдэг байгууллагуудын хувьцаа борлуулсанаас олох орлогыг Хүний хөгжлийн санд шилжүүлэх шаардлагатай гэж заасан. Энэ хуульд бас стратегийн ордыг ашиглах зорилгоор авсан урьдчилгаа төлбөр болон зээлийн тодорхой хэсгийг Хүний хөгжлийн санд оруулна гэж заасан. 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар төв болон орон нутгийн засаг захиргааны эзэмшдэг компаниуд төсөв санхүү хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу аймгийн ИТХ-аас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр хувьцаа гаргах замаар хөрөнгөө нэмэгдүүлэх буюу аль нэгэн гуравдагч этгээдээс зээл авахгүй гэж заасан.

Ашигт малтмалын газраас олборлох салбарын нийт 21 төрийн өмчийн компани дахь төрийн оролцоог ил тод болгосон (хуудас 111-12) боловч эдгээр төрийн өмчийн компаниуд нь газрын тос, хий, уул уурхайн компаниуд дахь өөрийн эзэмшлийг ил тод болгох шаардлага тавигдаагүй байна. Үүний адилаар 5.4 дүгээр хэсэгт (хуудас 110-115) дээр 2014 онд төрийн өмчийн компаниуд болон тэдгээрийн салбаруудын эзэмшилд ямар нэгэн өөрчлөлт гарсан талаар тодорхой нарийвчилсан мэдээлэл гаргаагүй байна. Эдгээр мэдээлэл нь Хараат бус нэгтгэгчийн эхлэл тайлан болон ОТОБ-ийн цар хүрээ тогтоох шийдвэр гаргах хурлын протоколд ч байхгүй ажээ. ОУИТБС-ын тайланд дахин хөрөнгө оруулалт болон хуримтлагдсан ашгийн талаар ямар нэгэн бодлогыг ил тод мэдээлээгүй байна. Үүний адилаар лиценз эзэмшигч компаниуд дахь төрийн эзэмшлийн хувьцаатай холбоотой нөхцлийг мөн ил тод болгоогүй ажээ.

5.4.5 (хуудас 119) зүйлд төрийн өмчит компаниудад өгөх зээл, зээлийн баталгааны талаарх тайлбарыг хийсэн байна. Эрдэнэс Таван Толгой болон Шивээ Овоо гэсэн хоёр төрийн өмчит компаниуд нь зээлтэй холбоотой зээлийн нэр/дугаар, зээлийн гэрээний хугацаа, зээлийн хэрэглээ, дүн болон холбогдох талууд гэх мэт мэдээллийг ил болгосон. Түүнчлэн бүх төрийн өмчит компаниудаас мэдээлэл цуглуулах үе шатанд ирүүлэхийг шаардсан зээл, зээлийн баталгааны талаар нарийвчилсан мэдээллийг нэгтгэлийн шатанд багтаасан гэж мэдэгдсэн ч хоёр төрийн өмчит компаний аль аль нь төрөөс ямар нэгэн зээл аваагүй бөгөөд засгийн газраас зээл, зээлийн баталгаатай холбоотой ямар нэгэн нууцалсан мэдээлэл байхгүй гэдгээ мэдэгдсэн байна. 2014 оны ОУИТБС-ын тайланд аливаа зээл болон зээлийн баталгааны талаарх мэдээллээ ирүүлээгүй аливаа төрийн өмчит компанийг тусгайлан нэрлээгүй байна.

2013 оны ОУИТБС-ын тайланд дурьдсанаар 99 компани төрийн өмчлөлд байдаг (хуудас 45) ба эдгээр 99 компаний 11 дээр л 2013 онд өмчлөлийг нь өөрчилж хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан гэж мэдээлжээ. Гэвч энэ 99 компаний хэд нь олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг талаар тодорхойгүй байна. Төрийн өмчит компани болон Засгийн газрын хоорондын санхүүгийн харилцааг тайланд ердөө л хэсэгчлэн дурьдсан. Төрийн өмчит компани болон засгийн газрын хооронд хөрөнгө шилжүүлэх, хуримтлагдсан ашиг, дахин хөрөнгө оруулалт, гуравдагч талын санхүүжилтийн талаарх журмыг ил тод тайлбарлаагүй. Зээл, зээлийн баталгааны талаар нарийвчилсан мэдээлэл мөн оруулаагүй байна. Төрийн өмчит компаниуд болон олборлох үйлдвэрлэл явуулдаг бусад компаниудад зээл олгох болон зээлийн баталгааны талаар ямар ч мэдээлэл байхгүй. 2013 онд Хөгжлийн банкнаас¹¹³ Эрдэнэс Таван Толгойд олгосон 200 сая ам.долларын зээлийн талаар дурьдаа ч үгүй. 47 болон 49 дүгээр хуудсууд дээр засгийн газраас стратегийн орд газруудад 34% хувьцаа гаргах/санхүүжүүлэх арга замын талаар ямар нэгэн зүйл

¹¹³ Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн хийсэн ЭТТ-н тухайн судалгааг үзнэ үү, http://eri.mn/ERI_TT.pdf. See also IMF (March 2014), Article IV Consultations, (p.6), available on <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2014/cr1464.pdf>.

дурьдаагүй байна.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн төлөллийн хэлсэнээр Төрийн өмчийг зохицуулах үүрэгтэй Төрийн өмчийн хороо нь төрийн өмчит компаниудын талаар, ялангуяа төрийн өмчит компаниуд болон засгийн газрын хоорондох санхүүгийн харилцааг зохицуулдаг дүрэм журмын талаар мэдээлэл хадгалдаг агентлаг ажээ. Эдгээр мэдээллийг ил тод болгох тал дээр ямар нэгэн эрхзүйн саад бэрхшээл байхгүй. Зарим засгийн газрын төлөөллүүдийн хэлснээр Компаний тухай хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг хууль нь санхүүгийн харилцааг зохицуулдаг дүрэм журмыг багтаадаг ч эдгээр нь бодит байдал дээр өөрөөр хэрэгжих практик байгаа эсэх талаар тодорхойгүй байна. Оролцогчдын хэлсэнээр ОТОБ дээр энэ талаар хэлэлцээгүй байна.

АНУ-н Төрийн департаментаас 2015 оны Хөрөнгө оруулалтын орчны тайландаа уул уурхайн ашиг орлого болон үйл ажиллагааны менежментийн хувьд төрийн хөрөнгө эзэмшигчийн үүрэг тодорхойгүй байна гэдгийг онцлон тэмдэглэсэн¹¹⁴. Энд дурьдсанаар төрийн өмчит компаниуд нь өөрийн төртэй харилцах санхүүгийн харилцааг зохицуулах дагаж мөрдөх хуультай, стандарттай байх шаардлагатай ч олон улсын шилдэг туршлага институцилэгдээгүй тул маш олон төрийн өмчит компаниуд Монголын хуулийг л автоматаар дагаж мөрддөг байна. Энэхүү тайланд дурьдсанаар бас төр нь эзэмшигчийнхээ хувиар санхүүгийн үүргээ биелүүлэх чадвартай холбоотой хөрөнгө оруулагчийн нөхцөл байдал болон хамааралгүй зардлаас шалтгаалан ирээдүйн уул уурхайн салбарын ашиг орлого өөрчлөгдөх эрсдлийн талаар, түүнчлэн засгийн газрын ашиг орлого, уул уурхайн үйл ажиллагаанаас үүсч болох үүрэг хариуцлагаа биелүүлэх чадварын талаар хөрөнгө оруулагчдын байр суурийг авч үзсэн.¹¹⁵

Бодит байдал төрийн өмчит компаниудын талаар мэдээлэл олж авахад саадтай байдаг нь төрийн хүнд суртлаас шалтгаалан төрийн оролцооны талаар мэдээлэл олддоггүй гэдгийг Хараат бус нэгтгэгчдээс онцлон тэмдэглэсэн. 2014 онд Төрийн өмчийн хороо нь Оюу Толгой болон Таван Толгойгоос бусад ихэнх төрийн өмчит компаниуд, “тодорхой уурхайн хөрөнгүүд”, болон АНУ-н Төрийн Департаментаас заасанчлан ураны үйлдвэрүүд, хөрөнгө зэргийг удирдан зохицуулж байна¹¹⁶. Иргэний нийгмийн төлөөллийн тэмдэглэснээр төрийн өмчийн компаниудын эзэмшил нь ялангуяа 2012-2016 оны Эвслийн засгийн газрын үед (Төрийн өмчийн хороо, Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн Яам, Эрдэнэс Монгол гэх мэт) маш олон төрийн байгууллагуудад хуваагддаг байсан байна. Энэ нь ашиг орлого олдог төрийн өмчийн компаниудыг удирдах сонирхолтой өөр өөр намынхан дээрх төрийн байгууллагуудыг удирдаж байсантай холбоотой, Эвслийн засгийн газрын бодлоготой холбоотой байсан гэж иргэний нийгмийн төлөөлөгч тэмдэглэн хэлжээ. Иргэний нийгмийнхний хэлсэнээр ЭТТ дахь төрийн өмчлөлийн хэмжээ тодорхойгүй байсан: 2011 онд монголын иргэдэд хөрөнгийн 10%-ийг өгсөн байснаа засгийн газар эдгээр хувьцааны ихэнхийг 2016 оны 6 сард болсон хууль тогтоох байгууллагын сонгуулиас нэг долоо хоногийн өмнө¹¹⁷ эргүүлэн

¹¹⁴ АНУ Төрийн департамент (2015/6), Монголын хөрөнгө оруулалтын орчин 2015, <http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

¹¹⁵ АНУ Төрийн департамент (2015/6), Монголын хөрөнгө оруулалтын орчин 2015, <http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

¹¹⁶ АНУ Төрийн департамент (2015/6), Монголын хөрөнгө оруулалтын орчин 2015, <http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

¹¹⁷ Файнаншл Таймс (2013/1/24), ‘Mongolia coking coal mine troubles mount’, <http://www.ft.com/cms/s/0/1883afe8-6622-11e2-b967-00144feab49a.html#axzz4Dp84CvFQ>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

худалдаж авсан нь ЭТТ дахь төрийн өмчлөл 2011 оноос өөрчлөгдсөн гэдгийг харуулж байна¹¹⁸.

Монгол улсын Засгийн Газраас нь аажимдаа дээрх худалдан авсан хувьцааны зарим хэсгийг эргүүлэн Монголын компаниудад худалдсан ч иргэдээсээ худалдан авсан хувьцааны хэмжээ тодорхойгүй байжээ¹¹⁹. Зарим төрийн болон иргэний нийгмийн ххэлж буйгаар 2016 оны 1 сард хийсэн зарим өөрчлөлт гарсан ба Төрийн өмчийн хороог татан буулгаж үүрэг хариуцлагыг нь Эрдэнэс Монголд шилжүүлсэн нь Олон улсын Санхүүгийн Корпораци болон Азийн Хөгжлийн Банкны тусламжтайгаар¹²⁰ (2016 оны 3 сард Эрдэнэс Монголын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 35 сая ам долларын тусламж үзүүлэхээр тохиролцсон) төрийн өмчийн компаниудыг өөрчлөх ажлын нэг хэсэг байжээ. Өмнөх ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгч болон ОТОБ-ын гишүүний хэлсэнээр ОТОБ нь 2014 оны тайланд зориулан мэдээлэл цуглуулахаас өмнө Монгол дахь олборлох компаниудад засгийн газар болон төрийн өмчит компаниудаас зээл олгох болон баталгаа гаргуулах талаар ОТОБ дээр ямар нэгэн хэлэлцүүлэг өрнөөгүй ажээ. Салбар болон засгийн газрын төлөөлөгчид төрөөс болон төрийн өмчит компаниудаас олборлох компаниудад ямар нэгэн зээл олгодог талаар ямар ч мэдлэггүй байсан ч нэмэлт зээл буюу баталгаа байгаа эсэх талаар мэдэх боломжгүй байсан хэмээн өөрсдийн саналаа хэлсэн.

Анхдагч үнэлгээ

Олон улсын ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс дээрх шаардлагыг хангах чиглэлээр хангалтгүй ахиц дэвшил гаргасан байна. 2015 оны ОУИТБС-ын тайланд олборлох үйлдвэрлэл дэх төрийн оролцооны талаар дурьдсан боловч энэ нь Шаардлага 2.6-д нийцэхүйц мэдээллийг ил тод тайлагнаагүй байна. Тайланд төр хувьцааных нь дийлэнх хэсгийг нь эзэмшдэг 21 олборлох компаниудын жагсаалтыг гарган төрийн өмчийн компаниуд болон Засгийн газар хоорондын санхүүгийн гүйлгээг зохицуулдаг дүрэм журмуудын хэсгийг, тэр дундаа ногдол ашиг болон гуравдагч талын зээл, зээл болон зээлийн баталгааны талаарх зарим мэдээллийг л багтаажээ. Гэхдээ олборлох төрийн өмчит компаниуд буюу тэдгээрийн салбаруудын эзэмшилд 2014 онд ямар нэгэн өөрчлөлт гарсан эсэх талаар тодруулаагүй, зээл болон зээлийн баталгааны талаар ил тод болгосон мэдээлэл нь иж бүрэн эсэх нь тодорхойгүй хэвээр байна. Компани бүр дэхь төрийн өмчийн эзэмшлийн нөхцлийг ил тод тайлагнаагүй, төрийн өмчит компаниудын ашиг болон дахин хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль дүрмүүдийг тайланд оруулаагүй байна.

ОТОБ нь засгийн газар болон төрийн өмчит компаниудын зүгээс олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад компаниудад зээл олгох буюу зээлийн баталгаа гаргаж буй талаар Сангийн Яам болон Монгол Банктай ярилцан хэлэлцэж, төрийн өмчит компаниудад олгосон засгийн газрын шүүд зээл, төрийн өмчийн банкуудын зээл болон гуравдагч талуудаас олгох зээлийн талаар тодруулаагүй харагдаж байна. Олон улсын Ажлын албаны ойлгож буйгаар төрийн өмчит Төрийн Банк¹²¹ 2014 онд уул уурхайн компаниудад нийт 2.6 тэрбум төгрөгийн зээл олгосон ч тухайн жилийн тайланд нь дурдсанаар энэ нь нийт олгогдсон зээлийн 1%-д ч хүрэхгүй байжээ¹²². АНУ-ын Төрийн Департаментаас гаргасан тооцооллоор ЭТТ дахь гуравдагч талын олгосон нийт зээлийн

¹¹⁸ The UB Post (13 June 2016), 'Cabinet to buy back Erdenes Tavan Tolgoi shares from the public',

<http://theubpost.mn/2016/06/13/cabinet-to-buy-back-erdenes-tavan-tolgoi-shares-from-the-public/>

¹¹⁹ Форбс (25 February 2015), 'Mongolia's endless legal flexibility', <http://www.forbes.com/sites/jonspringer/2015/02/25/day-828-mongolias-endless-legal-flexibility/#7a64a3f943ed>

¹²⁰ АНУ Сангийн яам, Сарын мэдээ, 2016/3, <https://www.treasury.gov/resource-center/international/development-banks/Documents/March%202016.pdf>

¹²¹ Төрийн банкны вебсайт, <https://www.statebank.mn/w/en/m285>

¹²² х.80, Төрийн банкны жилийн тайлан, 2014 https://www.statebank.mn/w/content/2015/11-26/Statebank%20Annual%20report%202014%20Eng_baga.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хэмжээ нь л гэхэд 2015 онд 700 сая ам доллар байсан ч энэхүү зээл нь төр болон хувийн хэвшлийн зээлдүүлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг байгаа юм¹²³. Монгол улсын Хөгжлийн Банк нь 2015¹²⁴ оны сүүлээс Шилэн дансны веб хуудсандаа явцын санхүүгийн тайлангаа нийтэлж эхэлсэнтэй холбогдуулан зээлийн багцын талаарх зарим мэдээллийг ил тод өгдөг болсоноор зарим зээлийн үнэлгээний агентлагууд нь Засгийн газар нь тус банкыг дэд бүтэц, тээвэр, уул уурхай зэрэг салбаруудад зээл олгох гол хэрэгсэл байгууллага болгон ашиглана хэмээн хүлээх болсон¹²⁵. Хөгжлийн түншүүд нь Монгол Улсын Хөгжлийн Банк зэрэг төрийн өмчийн компаниудын хяналт бага буй явдлаас үүдэлтэй санхүүгийн эрсдлийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлж байжээ¹²⁶.

Олборлох салбарын үүрэг роль, төрийн өмчит компаниудад, тэр дундаа олборлох салбарт өгч буй төсвийн бус их хэмжээний санхүүжилт зэргийг харгалзан үзвэл төрийн оролцоог иж бүрнээр үнэлэн үзэх нь Монголын хувьд маш чухал юм. ОТОБ нь ОУИТБС-н нөлөөллийг нэмэгдүүлэх арга болон өргөн хүрээт шинэчлэлийг дэмжих арга хэрэгсэл болгон төрийн өмчит компаниудын шинэчлэлт техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллах асуудлыг тооцон үзэх шаардлагатай.

Хүснэгт 2 – Үнэлгээний тойм хүснэгт: Гэрээ хийх болон тусгай зөвшөөрөл олгох

ОУИТБС-ын заалт	Гол үр дүнгийн тойм	Ахиц дэвшилд хийсэн Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээ
Эрх зүйн орчин (#2.1)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь хамаарах хууль тогтоомж, зохицуулалт болон санхүүгийн нөхцөл байдлыг хамарсан байна.	Ахиц дэвшил хангалттай
Тусгай зөвшөөрөл олголт (#2.2)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь тусгай зөвшөөрөл олгох, гэрээ хийх эрх олгох зэрэгтэй хамаарах хэрэгцээтэй мэдээллийг багтаасан ч олгосон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн тусгай зөвшөөрлийн тоо тодорхойгүй байна. Тайлан нь мөн лиценз олгох журмыг зөрчсөн явцын талаар мэдээлэл агуулаагүй байна.	Ахиц дэвшил тодорхой хэмжээнд гарсан
Лицензийн бүртгэл (#2.3)	Шаардлага 2.3-ын ихэнхийг ОУИТБС-ын тайланд багтаасан эсвэл олон нийтэд Ашигт малтмалын газрын кадастрын системээр дамжуулан ил тод болгожээ. Гэхдээ лиценз авах өргөдөл гаргасан огноо нь	Тодорхой хэмжээний ахиц дэвшил

¹²³ АНУ төрийн департамент (2015/6), Mongolia Investment Climate Statement 2015, <http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

¹²⁴ Дэлхийн Банк, (2015/11) , <http://pubdocs.worldbank.org/en/920971447119845335/meu-nov2015-en.pdf>

¹²⁵ Moody's (2015/11/3), Support for Development Bank of Mongolia to remain strong,

https://www.moody's.com/research/Moodys-Support-for-Development-Bank-of-Mongolia-to-remain-strong--PR_337354

¹²⁶ Дэлхийн Банк (2015), Төсвийн удирдлагын тайлан, <http://www.adb.org/sites/default/files/linked-documents/49210-001-sd-02.pdf>

	ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр байхгүй. Газрын тос, байгалийн хийн салбарт өргөдөл гаргасан огноо, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн болон талбайн солбицол зэрэг мэдээлэл хамрагдаагүй байна.	
Гэрээний ил тод байдал (#2.4)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлогыг тайлбарлаж, бодит байдал дээр хэрхэн ил тод болгож буй тухай тойм мэдээлэл оруулжээ. ОТОБ-ын зүгээс гэрээний портал боловсруулах үйл ажиллагаа явагдаж буй, мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний шинэ загварт өөрчлөлт оруулан нууцлалын заалтыг хасаж, бүх гэрээ ил тод байх заалтыг оруулсан байна.	Ахиц дэвшил хангалттай
Бенефициар өмчлөлийг ил тод болгох (#2.5)	ОТОБ нь бенефициар өмчлөлийн дэлгэрэнгүй мэдээллийг нарийн судлах чиглэлээр үйл ажиллагаа явуулан, ОТОБ-ийн хэд хэдэн хурал дээр хэлэлцэн, анхдагч үйл ажиллагааг буюу хууль ёсны эзэмшигчийг (зарим талаар бенефициар өмчлөлийг багтаасан) ил тод болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байгааг 2013 болон 2014 оны тайланд тусгажээ.	
Төрийн оролцоо (#2.6)	2014 оны ОУИТБС-ын тайланд төрийн өмч бүхий 21 компанийн мэдээллийг, зарим компанийн санхүүгийн шилжүүлгэд баримталдаг журам дүрэм (төр болон компанийн хоорондын шилжүүлэг) болон зээл, зээлийн баталгааны талаар дурджээ. Гэхдээ төрийн өмчит компаниудын хуримтлагдсан ашиг, хөрөнгө оруулалттай хамаарах журам, дүрмүүдийг багтаасангүй. Тайлан нь мөн олборлох салбар дахь үйл ажиллагаа явуулж буй компанийн эсвэл тэдний салбарын эзэмшилд 2014 онд гарсан өөрчлөлтийг дурдаагүй мөн олгосон зээл, зээлийн баталгааны талаарх мэдээлэл нь иж бүрэн эсэх нь	Ахиц хангалтгүй

	тодорхойгүй байна.	
<p>Зөвлөмжүүд:</p> <p>1. ОТОБ нь эрх зүйн хүрээнд гараад буй тодорхойлолтыг ашиглах, мөн ОУИТБС-ын тайланд бодит хэргээс зөрүүтэй хэрэгжиж буй талаарх мэдээллийг оруулан тухайн тайланг Засгийн газар болон компаниуд дээр үүсээд буй буруу ойлголтыг засан залруулах аргачлал байдлаар ашиглах хэрэгтэй. Хуулийн хэрэглээг тодорхой болгох нь мөн Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтыг дэмжихээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг болно.</p> <p>2. ОТОБ нь мэдээлэл хайж, ОУИТБС-ын тайлан нь тусгай зөвшөөрөл олгох журмаас гадуурх ямар нэгэн асуудлыг тусгасан байх ёстой.</p> <p>3. ОТОБ нь Ашигт малтмалын газар болон Газрын тосны газартай хамтран ажиллаж тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргасан огноо, олгосон огноо болон дуусах хугацааг кадастрын мэдээллийн сан дээр нийтэд хүртээмжтэй болгох хэрэгтэй. ОТОБ нь мөн олборлох салбарын компаниудын мэдээллийн санг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай уялдуудах талаар судлан үзэх хэрэгтэй байна.</p> <p>4. ОТОБ нь Засгийн газар болон төрийн өмчит компаниудын хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан журам, дүрмүүдийг судлан үзэх шаардлагатай байна. ОУИТБС-ын тайлан нь тухайн компани гарч буй, 2012 оноос хойш их гарах болсон төсвийн бус зарцуулалтыг хянахад чухал үүргийг гүйцэтгэж болно.</p> <p>5. ОТОБ нь Газрын тосны газартай хамтран ажиллаж одоогийн Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэ загварт оруулах цаг хугацааг сайтар тодорхойлон, гэрээний ил тод байдлаас үүдэх эрх зүйн үр дагаварыг сайтар судлан үзэх шаардлагатай.</p> <p>6. 2016 оны ОУИТБС-ын Стандартын 2.5 дугаар шаардлагыг биелүүлэх бэлтгэл ажлын хүрээнд болон ННФ-ын судалгааны үр дүнд үндэслэн Засгийн газар нь бенефициар өмчлөгчийг ил тод болгох өөрийн бодлогыг тодорхой болгох хэрэгтэй байна.</p>		

3. Мониторинг болон үйлдвэрлэл

3.1 Тойм

Энэхүү Бүлэг нь хайгуул, үйлдвэрлэл болон экспорттой холбоотой ОУИТБС-ын шаардлагуудын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан.

3.2 Үнэлгээ

Олборлох салбар, үүнд хайгуулын үйл ажиллагааны талаарх тойм (#3.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлан нь олборлох салбарын талаарх тойм мэдээллийг багтаажээ (Хэсэг 5.1, хуудас 47-91). Энэхүү мэдээлэлд олборлох салбарын абсолют болон харьцуулсан үнэ цэнийг дурдаж, уул уурхайн үйлдвэрлэл явагдаж буй гол бүс нутгуудын талаарх мэдээлэл (Хэсэг 5.1.4.3, хуудас 71-73) болон газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл (Хэсэг 5.1.5, хуудас 84-86), мөн уул уурхайн салбар дахь хайгуулын үйл ажиллагааны талаар (хэсэг 5.1.4, хуудас 65, Хэсэг 5.1.4.2, хуудас 68-70) дурдахдаа газрын тос, байгалийн хийн салбарыг мөн (Хэсэг 5.1.5, хуудас 84-86) хамруулсан байна. Хавсралт 15 (хуудас 265-287) дээр 2014 онд хувийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын үйл ажиллагаа болон ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрлийн тухай

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

мэдээлэл багтсан байна. Мөн гар аргаар ашигт малтмал олборлож буй талаарх тойм мэдэллийг Хэсэг 5.1.4.5 (хуудас 79-83) дээр өгсөн бол Хавсралт 17 (хуудас 296-297) нь сум, дүүргүүд, тэдгээрт ажиллаж буй бичил уурхайн талаар мэдээлэл өгчээ (гэхдээ энэ хэсэг дээр үнэ цэнийг дурдаагүй).

Оролцогч талуудын санал бодол

Уулзан ярилцсан салбар болон иргэний нийгмийн төлөөлөл нь 2014 оны ОУИТБС-ын тайлан нь иж бүрэн болсон хэмээн дүгнэж байна. Ялангуяа иргэний нийгмийн зүгээс бичил уурхайн асуудлыг тайланд тусган, сум бүрээр задлан харуулсан нь орон нутгийн дэд зөвлөлийн мэдээллийн хэрэгцээг хангахад чухал хамаарах зүйл хэмээн үзэж байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэ шаардлагыг биелүүлэхэд хангалттай ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэж байна.

Үйлдвэрлэлийн мэдээлэл (#3.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлан нь үйлдвэрлэлийн мэдээллийг иж бүрэн хэмжээнд тусгажээ. Хэсэг 5.1.4.4 (хуудас 74-78) нь үйлдвэрлэлийн хэмжээ, үнийг ашигт малтмал нэг бүрээр гаргасан бол үүнд Монгол улсад үйлдвэрлэж буй 23 төрлийн ашигт малтмал хамрагдсан байна. Хэсэг 5.1.4.3 (хуудас 71-73) дээр нийт тайлан гаргасан 110 компанийн үйлдвэрлэлийн мэдээллийг задаргаатай оруулсан (аймаг, сумаар) ч бүх компанийн мэдээлэл бүрэн ороогүй байна. Ашигт малтмалын үйлдвэрлэлийн дээр бүх төрлөөр нь задаргаа байхгүй, ялангуяа нүүрсэн дээр задаргаа бүрэн бус байна.

Хэсэг 5.1.5.3 болон 5.1.5.4 (хуудас 86-87) нь мөн түүхий гакрын тосны үйлдвэрлэлийн тухай мэдээллийг хэмжээгээр нь харуулжээ. Монгол улсын хувьд байгалийн хийн үйлдвэрлэл байхгүйг шууд дурдаагүй ч Хэсэг 5.1.5.2 (хуудас.85) дээр буй үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үүнтэй холбоотой мэдээлэл нь зөвхөн эдийн засгийн ашигтай бус хэмжээний байгалийн хий илрээд буйг дурдсан байна. Газрын тосны үйлдвэрлэл явуулж буй гурван аймаг, сумдыг дурдаагүй ч газрын тосны үйлдвэрлэл явагдаж буй газар зүйн байршлыг Хэсэг 5.1.5.3 (хуудас 86) дээр буй Бүтээгдэхүүн хуваах гэрээнээс оруулан, газрын тосны хайгуулын талбайн газрын зургийг Хүснэгт 5.1.5.1 (хуудас 84) дээрээс оруулах боломжтой. Газрын тосны үйлдвэрлэлийг нийт үнэ, мөнгөн дүнгээр харуулаагүй ч үүнийг дундаж үнийн мэдээлэл ашиглан хялбархан тооцож болно. Хавсралт 16 (хуудас 288-295) нь ашигт малтмал бүрийн борлуулалт, үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ зэргийг дурдсан байна.

Оролцогч талуудын санал бодол

Компаниуд болон засгийн газрыг төлөөлсөн хэд хэдэн төлөөллийн үзэж буйгаар үйлдвэрлэлийн хэмжээний тухайн мэдээллийн эх сурвалж хооронд зөрүүтэй, мөн ашигласан арга зүй болон мэдээлэл цуглуулсан хугацаа зэргээс хамааран дүн ялгаатай гардаг ч Ашигт малтмалын газрын зүгээс гаргадаг мэдээллийг 2014 оны ОУИТБС-ын тайланд оруулсаныг тэмдэглэжээ. Засгийн газрын зарим төлөөлөл мөн Ашигт малтмалын газар нь нийт 15 бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл болон үнийн мэдээллийг гаргадаг бөгөөд энэ мэдээллийг 2013 оны ОУИТБС-ын тайланд оруулаагүй нь санамсаргүй алдаа болсон гэж үзжээ. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт үнийг тодорхойлох талаар хийсэн ярилцлагад ашигт малтмалын үйлдвэрлэлийн зардал нь нууц, харин борлуулалтын үнэ олон нийтэд нээлттэй буй хэмээн дүгнэсэн. 2015 оноос эхлээд нүүрс болон төмрийн хүдэрт ноогдуулах нөөцийн төлбөрийг гэрээний үнээр тооцох болсон бол бусад бүтээгдэхүүний нөөцийн төлбөрийг жишиг үнийг ашиглан тооцож байна. Тиймээс үйлдвэрлэлийн мэдээллийг тооцон гаргахад ямар

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

нэгэн саад тотгор байхгүй юм. Мөн олон улсын зах зээлийн жишиг үнээр ашигт малтмалын үйлдвэрлэлийг мөнгөн дүнгээр тооцох нь асуудалтай хэмээн талууд ойлголцсон бөгөөд учир нь Монголын гол бараа бүтээгдэхүүний үнэ нь доогуур байдаг оршиж байна (жишээ нь нүүрс гэхэд Австралийн FOB нөхцөлтэй нүүрсний үнийн хагасаас доогуур байдаг).

Анхдагч үнэлгээ

Монгол улсад хамаарах Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс энэхүү шаардлагыг хангахад хангалттай хэмжээний ахиц дэвшил гаргасан хэмээн үзэж байна. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь ашигт малтмал, түүхий газрын тосны үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнийн талаар, бүрэн задаргаа бүхий мэдээллийг бүтээгдэхүүн тус бүрээр нь, мөн боломжтой тохиолдолд бус/аймгаар нь задлан багтаасан байна. Газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээг мөнгөн дүнгээр гаргаагүй ч нийт хэмжээ болон үнийг ашиглан үүнийг тооцон гаргах боломжтой юм.

Экспортын мэдээлэл (#3.3)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайланд өмнөх ОУИТБС-ын тайлангуудыг бодвол ашигт малтмалын экспортын талаар илүү ойлгомжтой, иж бүрэн мэдээлэл өгсөн байна. Бүх үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн нийт мөнгөн дүн болон нийт борлуулалтад эзлэх хувийг, бүх 23 ашигт малтмалаар, бараа нэг бүрээр нь задлан Хэсэг 5.1.4.4 (хуудас 74-78) дээр оруулжээ. Гэхдээ 5.1.4.4 хэсгийн (хуудас 74) 2 дахь зүүлт хэсэгт дурьдсанаар эдгээр борлуулалтын хэмжээ болон үнэлгээг тухайн ашигт малтмалыг дотооддоо буюу гадаад зах зээл дээр борлуулж байгаагаас үл хамааран, ачуулах үед нь бүртгэдэг болохыг дурдсан байна. Хэсэг 5.1.4.4 (хуудас 74) дээр 4 дэхь зүүлт хэсэгт дурдсанаар бүх зэс, нүүрс, төмрийн хүдэр, цайр, молибден, хайлуур жонш, гянт болд, мөнгө, тугалга зэргийг экспортлодог (борлуулалтын тоо хэмжээг экспортоос харна) тул дотооддоо ашигладаг нүүрс, алт, цемент, бутарсан чулуу, тоосго, шохой, хайрга, царцсан лав, шохойн чулуу, гипс, цеолит, элс, нунтаг хайрга, элс болон алеврит зэргийн борлуулалтын хэмжээ болон мөнгөн дүн нь экспортыг илэрхийлэхгүйг заасан байна.

Хэсэг 5.1.4.4 (хуудас 75) дэхь хүснэгтэд Монгол улсын хамгийн их экспортлодог таван ашигт малтмалын хэмжээ болон нийт үнийг харуулжээ. Хэсэг 5.1.5.3 болон 5.1.5.4 (хуудас 86-87) дээр боловсруулаагүй газрын тосны хэмжээ болон нийт мөнгөн дүнг харуулсан. Хэдий эдгээр экспортын тоо баримтууд нь бүх ашигт малтмалын экспортын асуудлыг хөндөөгүй ч үүнийг Хэсэг 5.1.1.3 (хуудас 49) дээр буй Монголын олборлох үйлдвэрийн экспортын 90-ээс дээш хувийг эзэлдэг таван төрлийн ашигт малтмалын экспорт болон үнэлгээг харуулсан схемээс харж болно. Ашигт малтмал болон түүхий газрын тосны экспортын хэмжээ болон үнэлгээг аймаг дүүргээр нь задлан харуулаагүй байна.

Оролцогч талуудын санал бодол

Салбарын төлөөлөл нь ОТОБ дээр ашигт малтмалын экспортын тоо баримтуудын талаар хэлэлцсэн эсэхийг дурдаагүй. Засгийн газрын төлөөллийн баталж байгаагаар АМГ нь ашигт малтмалын экспортын хэмжээ, мөнгөн дүнг тооцож байдаг ч 2014 оны тайлангийн маягтаар 2014 оны тайланд зориулсан борлуулалтын мэдээллийг гарган өгөх хүсэлт гаргасан байна. Компани болон төрийн хэд хэдэн төлөөлөл АМГ болон гаалийн газрын экспортын тооны хооронд маш их зөрүү байгааг хэлж, АМГ нь тухайн жилдээ экспортлосон бүтээгдэхүүний хэмжээг тооцдог бол гаалийн газрын тоо баримт өнгөрсөн жилийн хадгалагдсан экспортын материалын үлдэгдэл болон дээж загвар гэх мэтийн арилжааны бус экспортуудыг бас багтаадаг тул нэмэлт экспортын бүтээгдэхүүнүүд үүсдэг хэмээж байна. Ашигт малтмалын газрын төлөөллөөс гаальд ирж байгаа тоо баримт нь

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

экспортлогчийн өөрийн мэдүүлэг дээр үндэслэх ба нэмж баталгаажуулдаггүй болохоор гаалийн газрын экспортын тоо баримт үндэслэлтэй байж чадах эсэх талаар эргэлзэж буйгаа хэлж байв. Уулзалтад оролцсон салбарын төлөөлөл Монголын гол таван ашигт малтмалын экспорт хэзээ ч өөрчлөгддөггүй ч бага хэмжээний ашигт малтмалын экспортод ихээхэн хэмжээний хэлбэлзэл үүсэж байжээ.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс энэ шаардлагад нийцэхээр хангалттай хэмжээний ахиц гарсан хэмээн үзсэн. 2014 оны ОУИТБС-ын тайланд бүх ашигт малтмалын экспортын хэмжээ болон мөнгөн дүнг багтаагаагүй ч зөвхөн Монголын олборлох үйлдвэрийн экспортын 90-ээс дээш хувийг эзэлдэг таван төрлийн ашигт малтмалын экспорт болон дүнг тооцож үзсэн байна. АМГ нь компаниудын жилд экспортлосон бүх ашигт малтмалын тоо хэмжээ болон үнэлгээг нэг жилийн хоцролттойгоор¹²⁷ гарган өгсөн ажээ. ОТОБ нь АМГ-тай зөвлөлдөн Монгол улсын экспортлож буй бүх ашигт малтмалын хэмжээ болон мөнгөн дүнг ил тод болгох сонголтуудыг судлан үзэж, мэдээллийн портал дээр буй борлуулалтын мэдээлэл дээр болон цаашдын тайлан дээр нэмж оруулах боломжийг хайх зөвлөмжийг хүргэж байна. Экспортын статистик тоо баримтуудын найдвартай байдлыг сайжруулахын тулд холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэлтэй ОУИТБС-ын мэдээллийг тулгахад ОУИТБС-ын мэдээллийг ашиглах боломж бас байж болох юм.

Хүснэгт 3 – Үнэлгээний тойм хүснэгт: Мониторинг болон үйлдвэрлэл

ОУИТБС-ын заалтууд	Гол үр дүнгийн тойм	ОУИТБС-ын заалтуудыг биелүүлэхэд гарсан ахиц дэвшил дэх Олон улсын ажлын албаын үнэлгээ (заавал шаардлагатай заалтууд дээр гаргана)
Олборлох салбарын тойм, үүнд хайгуулын үйл ажиллагааг хамруулах (#3.1)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь олборлох салбарын талаар үүнд албан бус үйл ажиллагаа, өргөн хүрээнд хийгдэж буй хайгуулын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.	Ахиц дэвшил хангалттай
Үйлдвэрлэлийн мэдээлэл (#3.2)	2014 оны тайлан нь ашигт малтмал болон түүхий гарын тосны үйлдвэрлэлийн хэмжээний талаарх мэдээллийг ханган өгсөн. Зарим уурхайн хаана үйл ажиллагаа явуулж буй тухай байршлын мэдээллийг цөөхөн хэд дээр нь гаргасан ч ОУИТБС-ын	Ахиц дэвшил хангалттай

¹²⁷ Хүснэгт 6 (р.25), АМГ (2015), Мэдээллийн хуудас 2015,

http://www.bgr.bund.de/DE/Themen/Zusammenarbeit/TechnZusammenarbeit/Downloads/1094_Circular2015.pdf?__blob=publicationFile&v=2

	мэдээллийн порталаас эдгээр мэдээллийг дэлгэрэнгүй харах боломжтой билээ.	
Экспортын мэдээлэл (#3.3)	ОУИТБС-ын 2014 оны тайлан нь экспортын хэмжээ болон нийт мөнгөн дүнг хамгийн гол 5 ашигт малтмал бүрээр багтаажээ. Ашигт малтмалын газар нь экспортын хэмжээ болон үнийн мэдээллийг, жил бүрээр гаргадаг ба энэ нь нэг жилээс бага хугацааны хоцрогдолтой гардаг.	Ахиц дэвшил хангалттай
<p>Зөвлөмжүүд:</p> <p>1. ОТОБ нь Ашигт малтмалыг газар болон Монгол Банктай харилцан зөвлөлдөж нийт бүтээгдэхүүний экспортын хэмжээ болон мөнгөн дүнгийн мэдээллийг гаргуулан авч байх шаардлагатай. Энэ нь дотоодын бодлогын хэлэлцүүлэг, худалдаа болон үүнээс Монгол улсын төлбөрийн балансд үзүүлэх нөлөөллийн тухай хэлэлцэхэд ихээхэн ач холбогдолтой билээ.</p> <p>2. ОТОБ нь ОУИТБС-ын үйл явцыг төрийн байгууллагууд дээр буй экспортын статистикын найдвартай байдлыг хангах зорилгоор үүнтэй нэгтгэн гаргах боломжийг судлан үзэх шаардлагатай байна.</p>		

4. Орлого төвлөрүүлэх

4.1 Тойм

Энэхүү Бүлэг нь орлогын ил тод байдал, үүнд иж бүрэн байдал, чанар болон ил тод болгож буй түвшин зэрэг хамаарах ОУИТБС-ын шаардлагын талаар судлан үзсэн болно. Мөн тус бүлэгт ОУИТБС-ын зүгээс мэдээлэл бэлтгэн гаргах журам болон процедурыг хэрхэн даган мөрдөж буйг мөн судлан үзсэн.

4.2 Үнэлгээ

Иж бүрэн байдал (#4.1)

Ахиц дэвшлийг баталгаажуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлан дээр ОТОБ болон Хараат бус нэгтгэгч нь 2013 оны тайланд дурдагдсан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хамруулсан ба үүнийг (Хэсэг 8.2.2, хуудас 109) аль компани тайлан гаргах шаардлагатай болохыг тогтоож буй аргачлалыг эргэн харах зорилгоор оруулсан байна. 2014 оны тайланд дурдсанаар материаллаг байдлын тодорхойлолт болон нэгтгэл тайланд хоёр шат бүхий хандлагыг ашиглах тайлбарыг Хэсэг 2.3.1.1 (хуудас 18) болон 3.1 (хуудас 20-21), 3.3.1 болон 3.3.2 (хуудас 28-29) дээр зааж өгсөн байна. ОТОБ нь нэгтгэлийн үйл ажиллагаанд хоёр шатлал бүхий хандлага ашиглахаар тохиролцсон бөгөөд томоохон компани дээр нэг бүрчлэн нэгтгэл хийж харин жижиг компани дээр эрсдэлд суурилсан хандлага ашиглахаар шийдсэн байна. Түүнчлэн ялгаатай хоёр материаллаг босгыг зөвшилцсөн бөгөөд энэ нь төв засгийн газар болон орон нутгийн захиргаад хэмээн ангилагдсан ажээ. ОУИТБС-ын 2014 оны тайлан нь Эхлэлийн семинарын үеэр (2015 оны 7

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

сар) материаллаг босго тогтоох тухай сонголтуудыг харгалзан үзэж, хамрах хүрээний тэлэлтийг зардалтай нь тэнцвэржүүлэх хэрэгцээг анхаарсан байна (хуудас.20).¹²⁸

2014 оны нэгтгэлийн хамрах хүрээнд бүхий материаллаг орлогын үрсгалыг багтаасан ба Шаардлага 4.16 заалтын дагуу нийт 24 орлогын үрсгалыг сонгон эдгээрийг сонгосон үндэслэлээ гаргажээ. Тайланд мөн нэгтгэлд оруулах орлогын үрсгалыг сонгон авсан шалгуурыг 3.3.2 (хуудас.28-29) дээр тайлбарлажээ. ОУИТБС-ын Цахим тайлангийн систем нь нийт 40 орлогын үрсгалаар (төв болон орон нутгийн түвшинд) тайлан гаргахын шаарддаг бол ОТОБ нь Хараат бус нэгтгэгч тэй тохиролцон нэгтгэлд 24 орлогын үрсгалыг хамруулах болсоныг 2.3.1.2 (хуудас.18) дээр дурдсан байна. Үндэсний хэмжээний хамгийн том 15 орлогын үрсгал, орон нутгийн хэмжээний 9 үрсгалыг сонгон авсанаар 2014 оны ОУИТБС-ын тайлан нь үндэсний болон орон нутгийн түвшин дэхь нийт дүнгийн 99%-ийг хамруулах боломжтой болжээ. 2015 ны 8 сарын 4-ний Эхлэлийн тайлангийн Хэсэг 4.4 (хуудас.16) дээр 2011 оны 7 сарын 3-нд анхлан тохиролцсон тайлангийн маягыг цахим системээр дамжуулан анхлан мэдээлэл цуглуулахад болон 2014 оны тайлангийн мэдээлэл цуглуулахад ашигласан байна. Материаллаг орлогын үрсгалын жагсаалтыг 3.4.1.3 (хуудас.33-34) дээр, харин тэднийг сонгох үйл явцын талаар 3.4.1.2 (хуудас.32-33) дээр дэлгэрэнгүй тайлбарлажээ. Хавсралт 3 (хуудас 152-153) нь нэгтгэлд хамрагдсан 28 орлогын үрсгалын жагсаалтыг багтаасан бол 2014 оны ОУИТБС-ын тайлан нь үрсгал нэг бүрийн тайлбарыг оруулаагүй ч гэхдээ энэ мэдээллийг хялбархан онлайн байдлаар олж авах боломжтой.

Үндэсний түвшинд ганцаарчилсан компани дээр нэгтгэл хийх материаллаг босго нь 250 сая төгрөг байхаар тогтжээ. Нийт төлбөр нь 100 саяаас дээш, гэхдээ 250 саяаас доош компаниуд нь эрсдэлд суурилсан хандлагаар сонгогдон нэгтгэлд хамрагдсан. Орон нутгийн түвшинд компанийг дангаар нь нэгтгэн тулгах материаллаг босго нь 30 сая төгрөгөөс дээш 100 сая төгрөгөөс доош байхаар тогтжээ. Энэхүү хандлага нь үндсэндээ нийт 242 компанийг ганцаарчилсан нэгтгэлд хамруулаан (үндэсний хэмжээнд материаллаг босго нь хүрсэн 183 болон орон нутгийн материаллаг босгонд хүрсэн 59), болон 66 компанийг эрсдэлд суурилсан хандлагаар нэгтгэлд хамруулахаар болжээ. Нийт компаниудыг дахин нягтлан үзсэний дараагаар нийт 236 компанийг нэгтгэлд хамруулахаар сонгосон бөгөөд эдгээр нь 2014 оны Засгийн гарын орлогын 98.8%-ийг бүрдүүлж буй компаниуд байна. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь материаллаг босгын эдгээр сонголтуудыг 2015 оны 7 дугаар сард болсон Эхлэлийн семинарын үеэр судлан үзсэн байна.¹²⁹ Материаллаг компаниуд нь ОУИТБС-ын тайланд хэд хэдэн газарт жагсаалт байдлаар орсон бөгөөд үүний нэг нь Хавсралт 7 (хуудас 170-176) юм.

Компани бүрээр тайлагнасан үр дүнг 6.2.3 (хуудас 142-143) дэлгэрэнгүй харуулсан ба 7 компани тайлан гаргасангүй. Тайлан гаргаагүй компаниудыг 4.2.2 (хуудас.43) дээр оруулсан ба эдгээрт доорх компаниуд багтаж байна:

- Эрэлэнс шаширт майнинг ресурсис ХХК
- Оюушенмин ХХК
- Улазан цамхаг ХХК
- Монгол Болгар Гео ХХК
- Спешиаал Майнз ХХК
- Гангар Инвест ХХК
- Ган-Илч ХХК

Компаниудын нийт нийлбэр төлбөр нь 1.051 тэрбум (582,377 ам доллар), тэдний нийт орлогод эзлэх

¹²⁸ Эхлэлийн танилцуулга, КРМГ, 2015/7/7.

¹²⁹ Эхлэлийн танилцуулга, КРМГ, 2015/7/7.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хувийг гаргаагүй ч Засгийн газрын орлогод эзлэх хувь нь 0.064% хэмээн тооцож болно.

Эдгээр 7 компани дээр нэмээд 5 компани эхэн үедээ тайлан гаргасан ч Нэгтгэгчийн зүгээс холбоо барин зөрүүг тайлбарлах нэмэлт мэдээлэл хүсэхэд хариу өгөөгүй ба эдгээрийг 4.2.3.4 (ххудас.44) дээр харуулжээ.

4.2.1 (хуудас 41) дээр буй Хүснэгт нь эхлээд тайлангийн маягтуудыг ирүүлсэн ч зөрүүнээс үүдэн нэмэлт мэдээлэл хүсэхэд гарган өгөөгүй 23 компанид хамаарах нийт төлбөрийн дүнг харуулсан ба: эдгээр компаниуд нь нийт 2,974 тэрбум төгрөг (1.65 сая ам. доллар) эсвэл засгийн газрын нийт орлогын 0.182%-тай тэнцэж байна (тэдний эзлэх хувийг ОУИТБС-ын 2014 оны тайланд оруулаагүй). 23 компанийн нэрийг Хавсралт 4 (хуудас.154-162) дээр оруулсан.

2014 оны тайланд гарган өгсөн мэдээллийн иж бүрэн байдал болон найдвартай байдлыг 4.1.3 (хуудас 41) дүгээр бүлэг дээр байгаа ч хараат бус нэгтгэгч нь гарган өгсөн мэдээллийн иж бүрэн байдлын талаар ямар нэгэн үнэлгээг тайланд оруулаагүй байна. Түүнчлэн тайлан гаргаагүй компаниудын материаллаг байдлыг уул уурхайн салбараас олсон засгийн газрын орлогод эзлэх хувь хэмжээгээр үнэлэн үзээгүй байна. Засгийн газрын олборлох салбараас олсон нийт орлого нь 1632 тэрбум төгрөг болж нэгтгэлд хамрагдалт 96.57%-ийг эзэлж байна.¹³⁰

2014 оны тайлангийн 3.3.3 (хуудас 30) дээр зөрүүний материаллаг босгыг хүлээн авсан категори бүр дээр 100,000 төгрөг (55 ам.доллар) байхаар тогтжээ. 4.1.1 (хуудас 35) болон 4.2 (хуудас 41) дээр нэгтгэлийн үр дүнг тусгасан ба үүнд цэвэр зөрүү 581 сая (үндэсний болон орон нутгаар задалсан) (322,000 ам.доллар) байна. Энэ нь Засгийн газраас анхлан тайлагнасан орлогын 0.03%-тай тэнцэж байна. Анхдагч бохир зөрүү нь 271 тэрбум төгрөг (150.2 сая ам.доллар) нь нэгтгэлийн дараа 581 сая болтол буурсаныг (322,000 ам.доллар) 2.1 (хуудас 13) дээр тайлбарлажээ. 4.2.1 (хуудас 41) дээр хүснэгт нь анхдагч болон эцсийн зөрүүг харьцуулан харуулсан ба үүнийг орлогын урсгал бүрээр задлан харуулсанаас хамгийн өндөр зөрүү бүхий гурван урсгал нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ажилтнуудын нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал, ашигт малтмалын хайгуул/олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөр зэрэг урсгалууд байна.

ОУИТБС-ын 2014 оны тайлан нь олборлох салбараас орлого төвлөрүүлдэг төрийн байгууллагуудыг тодорхойлон 3.4.1.1 (хуудас 32) дээр оруулжээ. Хавсралт 5 (хуудас 163-164) дээр тайлан гаргагч төрийн байгууллага нэг бүрийн тойм мэдээлэл оруулсан ч МХЕГ болон Ховд аймаг Хараат бус нэгтгэгчид ямар ч мэдээлэл гарган өгөөгүй харагдаж байна. ОУИТБС-ын 2014 оны тайлан нь тайлан гаргаагүй төрийн байгууллагуудын материаллаг байдлын үнэлгээ эсвэл тайлан гаргаагүй шалтгааныг дурдаагүй байна. 3.4.1.1 (хуудас 32) дээрээс харахад МХЕГ нь тогууль ноогдуулах эрх бүхий цорын ганц байгууллага тул Хавсралт 3 (хуудас 152-153) дээр заасны дагуу мөнгөн дүн нь 30 сая төгрөг буй тул материаллаг бус гэж үзэж болох юм. Харин Ховд аймгийн орлого тодорхойгүй тул материаллаг бус байх магадлалтай. Бүх материаллаг орлогоор засгийн газрын бүхий л орлогыг харуулсан мэдээллийг Хавсралт 3 (хуудас 152-153) дэрээс үзэж болно.

2014 оны ОУИТБС-ын тайлан нь тайлангийн иж бүрэн байдлын таларх хэд хэдэн зөвлөмжийг гарган өгсөн байна. ОУИТБС-ын цахим тайлагналын системийг хэд хэдэн зүйл дээр эргэн харах зөвлөмж 6.2.1 (хуудас 142), 6.2.7 (хуудас 144) дээр өгөгдсөн ба үүнд мэдээллийн технологийн хяналтын сул талыг анхаарах, тайлан гаргах зааварчилгааг тодорхой болгох зэрэг зөвлөмжүүд байна.

Хэсэг 6.2.3 (хуудас 143) дээр буй зөвлөмжүүд нь олон нийтэд хүрч ажиллах, тайлан гаргагч

¹³⁰ Нэгтгэлийн хамралт 2014 оны тайлан дээр тусгагдаагүй ч үүнийг 17, 48 дугаар хуудсанд буй тоон дээрээс тооцож болно.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

компаниудын чадавхийг бэхжүүлэх зэрэг чиглэлтэй байна. Хэсэг 6.2.4 (хуудас 153) дээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг орлогын гол үрсгалаар задаргаа муу байгааг дурдан энэ нь нэгтгэлд оруулах компанийг сонгоход нөлөөлж буйг тэмдэглэсэн байна. Томоохон татвар төлөгч нар нь олборлох үйлдвэрлэлд зөвхөн багахан хэмжээний үйл ажиллагаа эрхэлдэг байж болох ч нэгтгэл дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч гэдэг утгаар, төрд төлсөн төлбөрийн материаллаг байдлаар сонгогдон багтжээ. Тиймээс энэ хэсэг дээр олборлох салбарын орлогыг бусад салбарын орлогоос ялган салгах орлогын удирдлагын системдээ өөрчлөлт хийхийг засгийн газарт хандан санал болгожээ.

Оролцогч талуудын санал бодол

Өмнө нь Хараат бус нэгтгэгчээр хоёр удаа ажиллаж байсан байгууллагын төлөөлөл хэлэхдээ ОУИТБС-ын 2014 оны тайлангийн эхлэл шатанд анх удаагаа Нэгтгэгч нь ОТОБ-тэй хэлэлцүүлэг хийн, цар хүрээ тогтоох шийдвэр гаргаж байснаараа онцлог байсан гэж хэлсэн ба өмнө нь цар хүрээ тогтоох гол асуудлаар ОТОБ-тэй ямар нэгэн хэлэлцүүлэг явагддаггүй байжээ. Төлөөллийн нэг нь хэлэхдээ 2014 оны нэгтгэл тайлан гаргах Ажлын даалгавар нь өмнөхөөс хамаагүй ялгаатай, эхлэл үе шаттай байхыг шаардсанаар онцлог байсан гэж хэлж байв. Нэгтгэгчийн зүгээс мөн 2014 оны ОУИТБС-ын тайлан бэлтгэхээс өмнө ОУИТБС-ын Ажлын алба, ОТОБ нь цар хүрээг тогтоох үйл ажиллагаа явуулсан ба Нэгтгэгч гэрээ хийсний дараа үүнийг баримтлан ажилласан гэж хэлж байв. 2014 оны ОУИТБС-ын тайлангийн талаар хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага болон Ажлын алба нь Нэгтгэгч нь цар хүрээ тогтооход ганцхан материаллаг байдал, чанарын баталгаа гэсэн сонголтыг санал болгон, үүн дээр зарим гишүүд санал оруулан эцэслэн баталсан байна.

Төрийн байгууллагыг төлөөлсөн хоёр төлөөлөл одоо ашиглаж буй материаллаг босгын талаар шүүмжлэлтэй хандаж байсан ба яагаад тэгж үзсэн нь тодорхойгүй ч хэрэв 1300 компаниас мэдээлэл цуглуулсан тохиолдолд энэ их мэдээллийг нэгтгэн тулгах боломжгүй юм. Салбарын төлөөлөл болох хэд хэдэн хүний үзэж буйгаар хэд хэдэн тохиолдолд материаллаг босгыг эргэн харах санал гаргасаар байсан ба хамгийн сүүлд 2015 оны 11 сарын 3-ны өдрийн Үндэсний форум дээр хүртэл гаргаж байсан байна. Тэдний саналаар хоёр өөр босго тогтоон (хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр нь ангилан) ингэснээр Нэгтгэгч багахан төлбөр төлдөг хайгуулын компаниудын хойноос хөөцөлдөх шаардлагагүй болох ажээ. Уулзаж ярилцсан бүх талууд материаллаг компанийг сонгон авах хандлага нь өмнөх тайлангуудтай харцуулбал хамаагүй сайжирсан гэж үзсэн ба ялангуяа хоёр шатлал бүхий хандлага ашигласан нь зөв гэж үзжээ. Тэдний хэлсэнээр ОТОБ нь 2015 оны 7 сарын 7-ны өдөр эхлэлийн семинарын дараахан энэхүү босгыг цахим шуудангаар дамжуулан баталгаажуулсан байна. Салбарын хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ харьцангуй үйл ажиллагаа багатай хайгуулын компаниуд зөвхөн тусгай зөвшөөрлийн төлбөр л төлдөг ба энэ төлбөрийн хийгээгүй бол тэдний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлдэг байна. Хэлэлцүүлэг хийсний дараагаар төрийн байгууллагын төлөөлөл нь засгийн газрын зүгээс татвар төлбөр авсан хэмээн тайлагнаж буй компанийн тоо нь нөгөө талаас засгийн газарт татвар төлсөн гэж тайлагнаж буй тоотой нийцэхгүй буйг хүлээн зөвшөөрсөн ба харин энэ асуудлаар ОТОБ дээр ямар нэгэн байдлаар хэлэлцээгүй байна. Тэдгээр төлөөллийн хэлсэнээр засгийн газрын зүгээс бүх тусгай зөвшөрөл эзэмшигчээр бүх мэдээллийг ил тод болгоход практик ямар нэгэн саад байхгүй гэж үзжээ.

Орлогын үрсгалыг сонгох материаллаг босгын талаар зарим буруу ойлголт байгаа мэт харагдаж байна. Уулзан ярилцсан олборлох салбарын болон иргэний нийгмийн талууд, өмнөх Нэгтгэгч нар 10 000 төгрөгийн төлбөрийн гүйлгээг жилийн нийт орлогоор гэж үзэж жилийн нийт хэмжээнээс илүүд үзэж байна. Бүх талууд сүүлийн 3 жил орлогын үрсгалыг сонгох материаллаг босго тогтоох ОТОБ-ийн

хурлууд, хэлэлцүүлэгт орж байгаагүй ажээ.

ҮСГ-ын төлөөлөл хэлэхдээ хамгийн сүүлд тайлангийн маягтууд дээр өөрчлөлт хийхдээ 2015 оны 12 сард шийдсэн бөгөөд энд салбарт хамаарах онцлог төлбөрийг төслийн түвшинд суурилан оруулахаар болсон байна (орлогын татвар зэрэг түгээмэл татвар компанийн үндсэн дээр тайлагнагдана). Энэхүү саналыг төрөл бүрийн хороод байнга хэлэлцэж буй бөгөөд ҮСГ нь ҮЗ болон ОТОБ-ийн гаргасан саналуудыг байнга хүлээн тайлангийн маягтад өөрчлөлт оруулж буй талаар тэрээр дурдсан. Тэрээр мөн маягтуудыг ҮСГ болоно Сангийн яам хамтран баталдаг болохыг хэлж байсан.

2014 оны ОУИТБС-ын тайланг цахим тайлагналын системээр дамжуулан гаргаж буй компанийн тоо 987 болтол буурсан байна. АМГ зэрэг төрийн байгууллагатай хийсэн хэлэлцүүлгээр 2014 онд цөөн тооны компани тайлан гаргаж буй шалтгаан нь олон компани үйл ажиллагаагаа зогсоосон зарим нь эрх хүлээн авагчид шилжсэнтэй холбон тайлбарлаж байна. Тусгай зөвшөөрөл бүхий 1500 гаруй компанийн 380 нь өөрийн уулын ажлын төлөвлөгөөг АМГ-т хүргүүлсэн байна. Эдгээрээс 300 нь батлагдан, 78 нь ахин хянагдаж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйлдвэрлэл явуулахгүй байсан ч тусгай зөвшөөрлийн төлбөр хэлбэрээр засгийн газарт төлбөр төлөх шаардлагатай байдаг.

Төрийн хоёр төлөөлөл компани бүр дээр давтагдашгүй дугаарыг төрийн бүх байгууллага хэрэглэх нь олон байгууллагын дундаас олборлох компанийн төлбөрийг олж тогтооход хялбар болгоно хэмээн үзэж байна.

Салбарын төлөөлөл болон иргэний нийгэм нь нэгтгэлд хамрагдсан орлогын урсгалын иж бүрэн байдлын талаар ямар нэгэн санал бодол илэрхийлээгүй. Төрийн нэг төлөөлөл хэлэхдээ бүх л орлогын урсгал хамарсан бөгөөд харин төлбөр бүр дээр материаллаг босго нь 10000 буюу бага байгаа тул ОТОБ нь нэгтгэлд бүх урсгалыг хамруулах хүсэлтэй буйгаа харуулж байна гэж үзэж байна. Төрийн байгууллагын зарим хүмүүс босго ийм доогуур байгаад бухимдаж байсан ба нэгтгэлд хамруулах орлогын урсгалыг сонгох талаар дахин хэлэлцүүлэг хийх хэрэгтэй хэмээн маргаж байсан.

ОТОБ-ийн гишүүд нь Хараат бус нэгтгэгчийн зүгээс иж бүрэн байдлын үнэлгээ гарган өгөх шаардлагатай эсэхийг мэдэхгүй харин ОТОБ нь тайлагналын хамрах хүрээ зэрэг техникийн асуудал бус харин нэгтгэлд ороогүй, зөрүү зэрэг асуудалд түлхүү анхаарах хэрэгтэйг хэлж байсан. Хараат бус нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлангийн мэдээллийн иж бүрэн байдлын талаар үнэлгээг хийх зааварчилгаа өгөөгүй гэж мэдэгдсэн.

Анхдагч үнэлгээ

2014 оны ОУИТБС-ын тайлан нь төлбөр болон компанийн материаллаг босгын тодорхойлолтыг дурдаж тухайн түвшинд яагаад энэхүү босгыг тогтоосон талаар тайлбарласан байна. ОТОБ нь мөн төлбөрийн болон компани босго тогтооход оролцож ирсэн бөгөөд харин материаллаг босго нь нийт төлбөрт хамрах үү эсвэл нэг удаагийн төлбөрт хамрах үү гэдэг дээр сайн ойлголтгүй байна. Орлогын бүх урсгалын жагсаалтыг гаргахын зэрэгцээ ОУИТБС-ын 2014 оны тайлан нь орлогын урсгал бүрийн тайлбарыг багтаагаагүй байна.

Тайлан гаргаагүй компаниудын нэрсийг гарган тэдний төлбөрийн нэгдсэн дүнг загсийн газрын мэдээн дээр үндслэн абсолют утгаар харуулжээ. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь тайлан гаргаагүй компаниудын нийт орлогод эзлэх хувийг үнэлэн оруулаагүй, мөн Нэгтгэгчийн зүгээс ороогүй компанийн төлбөрийн материаллаг байдлыг үнэлээгүй ч боломжит тоон дээр үндэслэн эдгээрийг хялбархан тооцож болхоор байна. Тайлан гаргаагүй компаниудын эзлэх хувь нь их бус байна. Үүний нэгэн адил ОУИТБС-ын тайлан нь тайлан гаргаагүй 2 төрийн байгууллагыг тогтоосон ч ийнхүү

орхигдсон дүнгийн материаллаг байдлыг үнэлж үзээгүй байна (хэдий их биш ч). Хараат бус нэгтгэгчээс тайлангийн мэдээллийн иж бүрэн байдлын тухай өгсөн тайлбар нь тэдний зүгээс хязгаарлагдмал баталгаажуулалт хийж буй хэмээх хариу байсан ч тухайн тайлагналгүй үлдсэн дүнгийн материаллаг байдлыг тогтоох боломжтой юм. Эдгээрийг материаллаг бус гэж үзсэн ч материаллаг орлогын үрсгал сонгон авахдаа бага босго тогтоосноос үүдэн Олон улсын Ажлын албанаас энэхүү шаардлагыг хангах чиглэлээр Монгол улс хангалттай ахиц дэвшил гаргасан хэмээн үнэлж байна. Гэхдээ ОТОБ нь цаашдын босго нь нийт төлбөрт хамрах уу эсвэд нэг төлбөрт хамрах уу гэдгийг сайтар тодруулах шаардлагатай. Мэдээллийн найдвартай байдалтай холбоотой асуудлыг доорх Бүлэг 4.6 дээр оруулсан.

Мөнгөн бус орлого (#4.2)

Ахиц дэвшлийг үнэлэх нь

2014 оны ОУИТБС-ын тайлан нь газрын тосны БХГ-ний бүтцийн талаар 5.5.7 (хуудас 139-140) дээр тодруулан гаргасан байна. Засгийн газар нь БХГ-нээс хамааран өөрт ноогдох ашгийн тосоо авах эрхийг эдэлж буй юм. Одоогоор хүчин төгөлдөр буй, үйлдвэрлэл явагдаж буй 3 БХГ-ний дагуу төрд ноогдох газрын тосыг тухайн хамаарах оператор нь зах зээлд борлуулан олсон орлогыг ГТГ-аар дамжуулан Төрийн санд төлж байна. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь ОТОБ-ын зүгээс энэ чиглэлээр явуулсан хэлэцүүлгийн талаар “Эхлэлтийн семинарын үеэр ГТГ-ийн төлөөлөгч хэлэхдээ одоогийн байдлаар ашгийг компаниуд Төрд бэлэн мөнгөөр төлдөг. Ирээдүйд газрын тосноос олсон ашгийг баррелээр төлөх боломжтой болгох төлөвлөгөө бий гэсэн. Мөн компаниудын олборлосон газрын тосны 100% нь экспортлогддог. Засгийн Газар газрын тос Монголд зардаггүй гэж мэдэгдсэн” хэмээн тайлбарлажээ (хуудас.139). Мөнгөн бус орлогын үрсгалын тайлбарыг 5.5.7 (хуудас 139-140) дээр оруулан, үүний зэрэгцээ төрд ноогдох тосыг борлуулсан мөнгөн орлогыг, хоёр үйлдвэрлэгч болгоноор хуваан харуулсан байна.

Оролцогч талуудын санал бодол

Үндэсний зөвлөлд Засгийн газрыг төлөөлдөг газрын тосны салбарын төлөөлөл Бүтээгдэхүүн хуваах гэрээнд буй мөнгөн бус төлбөрийн талаарх заалтуудыг тайлбарлаж өгсөн. Газрын тосны үйлдвэрлэл эрхлэгчид нь үйлдвэрлэлийн тодорхой хэсгийг мөнгөн бус төлбөр байдлаар төрд шилжүүлэх үүрэгтэй (хэмжээ нь гэрээнээс хамаарах өөр өөр байна) байна. Одоогоор газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гурван гэрээний дагуу үйлдвэрлэл эрхэлж буй бөгөөд тэд төрд ноогдох тосыг зарж борлуулан олсон орлогыг нь ГТГ-т шилжүүлдэг байна. Засгийн газар нь ГТГ-аар дамжуулан нийт борлуулж буй тосны хэмэжээнд хяналт тавьдаг ба гурван тусдаа баримтыг цооног дээр бэлтгэдэг байна. Уул уурхайн эрх зүйн орчин нь мөнгөн бус төлбөртэй холбоотой ямар нэгэн заалт байхгүй. Газрын тосны компаниуд хэлэхдээ Засгийн газарт мөнгөн бус хэлбэрээр орлого оруулдаггүй бөгөөд төрд ноогдох газрын тосыг борлуулан, орлогыг нь шууд Улаанбаатар хотын банкин дахь ГТГ-ын дансанд шилжүүлдэг ажээ.

Төрийн байгууллагын нэг төлөөлөл Эрдэнэс Таван Толгой компани үйлдвэрлэлээ борлуулж, олборлолт хийлгээд тодорхой хэсгийг авч буйг мөнгөн бус орлоготой ижил байж болох бөгөөд гэхдээ бүр мөнгөн бус гэж үзэж болохгүй хэмээн хэлж байсан. Гэхдээ төрд татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр зэрэг байдлаар мөн төлбөр хийж буй юм. Эрдэнэс Таван Толгой зэрэг төрийн өмчит компаниуд нь өөрсдийн үйлдвэрлэх эрхийг бусдад худалдан, борлуулалтаас нь үндэслэн төлбөр авдаг байна. Эрдэнэс Таван Толгойн үйлдвэрлэлээ борлуулж буй талаар ил тод болгоход ямар нэгэн эрх зүйн саад тогтор байхгүй бөгөөд харин тухайн этгээдийн зүгээс мэдээллийг буруу

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хөрвүүлж буйд санаа зовж байсан ба Чалкотой хийсэн нүүрс борлуулах гэрээг түлхүү онцлон холбож буйг хэлж байсан¹³¹.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албанаас үзэж байгаагаар энэхүү шаардлага нь баталгаажуулалтад хэрэглэгдэхгүй. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь БХГ-ний дагуу төрд төлдөг ноогдол ашгийн тосыг хамарсан бөгөөд оператор компаниуд нь тухайн тосыг борлуулаад мөнгөн хэлбэрээр төрд тушаадаг байна. Энэхүү тосыг борлуулан олсон орлогыг ил тод болгон, нэгтгэлд хамруулсан. Уул уурхайн салбарт мөнгөн бус орлогыг хамаарах ямар нэгэн заалт байхгүй бөгөөд энэ нь ОУИТБС-ын стандартаар заавал шаардагдаагүй ч ОТОБ нь 3 БХГ-ний дагуу олгогдож буй мөнгөн бус орлогыг тайланд хамруулахаар судлан үзэж болох юм. Энэ нь одоо үйл ажиллагаа явуулж буй хоёр компанийг хянах талаар хийгдэж буй хэлэлцүүлэгт түлхүү ач холбогдолтой болно гэж үзэж байна.

Бартер болон дэд бүтцийн төлбөр шилжүүлэг (#4.3)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлангийн Хэсэг 5.5.3 (хуудас 125-126) дээр дэд бүтцийн хангалт болон бартерийн гэрээнд 1 тэрбум төгрөг буюу 554 100 ам.долларын материаллаг босго тогтоосон чиг хандлагыг тайлбарласан. Гэхдээ тайлан ирүүлж байгаа компаниуд болон төрийн байгууллагуудын зүгээс дэд бүтцийн хангалт, бартерийн талаар ямар нэгэн тайлан мэдээ гарган ирүүлээгүй гэж дурдсан байна. Терра Энержи ХХК, Өсөх Зоос ХХК, болон Оюу Толгой ХХК гэсэн гурван компани Засгийн газрын аливаа концессээс ангид дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийсэн тухай тайлагнажээ. Төрийн өмчийн таван олборлох компанийн төрийн оролцоог зохицуулдаг төрийн өмчийн Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн зүгээс нийтийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийснээ тайлагнасан байна.

Оролцогч талуудын санал бодол

Олон улсын Ажлын хэсэг нь салбар болон Засгийн газрын оролцогчидтой хийсэн энэхүү ярилцлагаас бартерийн гэрээг ялангуяа өөрсдийн гэрээлэгчдэд төлбөр төлдөг лиценз эзэмшигчид (мөнгөн бус хэлбэрээр) ашигласаар байгаа бөгөөд 2012 оны дунд үед Монголын эдийн засаг доройтож эхлэх үеэс буюу долларын хүрэлцээ муудаж эхлэх үеэс бартерийн гэрээг илүү их ашигладаг болжээ хэмээх ойлголт авсан. Салбарын хэд хэдэн төлөөллийн тэмдэглэн хэлсэнчлэн төрийн өмчийн компаниуд ялангуяа хувийн үйлчилгээ үзүүлэгчдэд гэрээт уурхайн ажлын зардлыг төлөх төлбөрийг бартераар хийдэг байна. Гэхдээ салбарын болон төрийн оролцогчдын аль аль нь Засгийн газарт татвар, хураамж төлөхөд ямар нэгэн бартерын хэлбэр байдаг гэж дурдаагүй байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны анхны үнэлгээгээр ийм шаардлагыг баримтлах хэрэггүй гэж үзсэн. 2014 оны ОУИТБС-ын тайланд дэд бүтцийн хангалт болон бартерийн асуудлыг зохих ёсоор, хангалттай хэмжээнд хамруулсан ч 2014 оны хувьд Монгол улсад эдгээр нь ямар ч хамааралгүй байсан гэж үзсэн.

Тээврийн орлого (#4.4)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

¹³¹ News.mn (9 March 2015), “Чалкогийн өрөөс болж Таван Толгой зогсоод байна”, <http://www.news.mn/r/206199>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

2014 оны ОУИТБС-ын тайлангийн Хэсэг 5.5.8 (хуудас 140) дээр ОТОБ-ийн зүгээс тээвэрлэлтийн ашиг орлогын талаарх баримталсан хандлагыг ерөнхийд нь авч үзсэн ч тусгайлсан материаллаг босго тогтоогоогүй ажээ. Хараат бус нэгтгэгчийн тэмдэглэснээр анхдагч эхлэлийн семинар дээр тодорхой тээвэрлэлтийн ашиг орлогын үрсгалын талаар дурьдаагүй байна¹³². Тайлангийн загварт ийм мэдээлэл оруулах хүсэлт гаргасан тул замын хураамж төлж нүүрс тээвэрлэлтээс олсон ашиг орлогын талаар Эрдэнэс Монгол компаниас авсан мэдээллээ энд оруулжээ. Тээвэр зохион байгуулалтын тайлбар зэрэг нэмэлт мэдээлэл байхгүй ч энэ нь зөвхөн Шаардлага 4.4 дээр л хамаарах юм.

Оролцогч талуудын санал бодол

Ихэнх салбар болон засгийн газрын оролцогчдын мэдээлсэнээр Засгийн газар нь аливаа ашигт малтмал буюу газрын тос, байгалийн хий тээвэрлэснээс ямар нэгэн материаллаг ашиг орлого олоогүй байна. Иргэний нийгмийн байгууллагаас энэ асуудлын талаар өөрсдийн байр сууриа илэрхийлээгүй байна. Гэхдээ газрын тос болон байгалийн хийн компаниудын хэлсэнээр ДонгШен Петролюм нь түүхий нефтийг ихэнхдээ төмөр замаар тээвэрлэсэн бол Петро Чайна компани нь ачаа тээврийн компаниудтай гэрээ байгуулах замаар шууд авто замаар экспортлодог ажээ. Монголын төмөр замыг 50% Монголын Засгийн газрын өмчлөлтэй Монгол-Оросын хамтарсан Улаанбаатар төмөр зам (УБТЗ) ажиллуулдаг. ДонгШенг компаний төлөөлөгчийн тайлбарлаж байгаагаар компани нь ямар нэгэн зуучлагчаар дамжуулалгүй шууд УБТЗ-д төлбөрөө хийдэг ба ачааны жингээс шалтгаалсан тогтсон үнэ тарифтай байдаг байна.

Анхдагч үнэлгээ

Манай анхдагч үнэлгээгээр Монгол улс энэ шаардлагыг хангахын тулд хангалтай хичээл зүтгэл гаргасан гэж үзэж байна. 2014 оны ОУИТБС-ын тайланд материаллаг босгын шаардлагыг (Материаллаг босго 0) хангаагүй ч гэсэн олборлох үйлдвэрүүдтэй холбоотой тээвэрлэлтийн орлогыг уул уурхайн салбартай холбон ил тод болгон харуулсан. Ийм тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаар ямар нэгэн тайлбар байхгүй, тэгээд ч үүнийг үнэлгээнд баримтлан үнэлэлт хийдэггүй. ОТОБ нь боловсруулаагүй нефтийг төмөр замаар тээвэрлэснээс олох ашгийг тооцож үзээгүй ч гэсэн УБТЗ-ыг 2016 оны ОУИТБС-ын Стандартын 2.6 шаардлагын (Төрийн өмчит компани нь бүтнээрээ буюу ихэнх хэсгийг төр эзэмшдэг компани байна) дагуу төрийн өмчит компани хэмээн тооцож болохгүй. Тээвэрлэлтийн ашиг орлогын ач холбогдол цаашдын ОУИТБС-н тайлангуудад нэмэгдэж болзошгүй. Учир нь 2014 онд нүүрс тээвэрлэх дэд бүтцүүдийг (авто болон төмөр зам) засгийн газар эзэмшилдээ байлган хувийн гуравдагч талуудад дээрх дэд бүтцийг ашиглах боломжийг олгосон билээ¹³³. Монгол улсад олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг авто болон төмөр замаар тээвэрлэх асуудал чухал ач холбогдолтой болохоор ОТОБ нь цаашдын ОУИТБС-н тайландаа ТӨК-иудын тодорхойлолтыг илүү тодорхой болгон тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаар нарийвчилсан тодорхойлолт тайлбарыг ашиглах ёстой. Ингэхдээ тээвэрлэлтийн орлогын материаллаг байдлыг илүү тохиромжтой тодорхойлолтод багтаан гаргаж, боловсруулаагүй нефт тээвэрлэлтээс төрийн болон төрийн өмчит компаниудын олж буй орлогыг (хэрэв материаллаг бол) ил тод болгох шаардлагатай.

ТӨК болон Засгийн газар хоорондын шилжүүлэг (#4.5)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

¹³² 4.2.7 (р.14) 2014 Эхлэлийн тайлан.

¹³³ АНУ Төрийн департамент (2015/6), Хөрөнгө оруулалтын орчин 2015, <http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

2014 оны ОУИТБС-ын тайланд тодорхойлсоноор ямар ч төрийн өмчит компани нь 5.5.7 (хуудас 139-140) хэсэгт заасанчлан олборлох үйлдвэрлэл явуулдаг байна. 5.3.1 дээр ТӨК-иас Засгийн газарт өгсөн ноогдол ашгийг харуулсан байна. Засгийн газар нь газрын тосны үйлдвэрлэл эрхлэж буй гурван компаниас мөнгөн бус хэлбэрээр ногдол авдаг ч төрийн нэрийн өмнөөс газрын тосыг хувийн байгууллагууд арилждаг болохоор Сангийн яам нь Газрын тосны газраар дамжуулан бэлэн мөнгөөр борлуулсан орлогийг хүлээн авдаг билээ. Олборлох үйлдвэрт төрөөс оруулсан хөрөнгө оруулалтаас авах ногдол ашгаас Засгийн газарт зориулсан хэсгийг Хавсралт 10 (хуудас 192-200), харин орон нутгийн авах хэсгийг Хавсралт 11 (хуудас 201-203) дэр тус тус, компани бүрээр задлан үзүүлсэн.

Төрийн өмчийн компани нь орон нутгийн удирдлагад засгийн газрын олборлох үйлдвэрлэлээс олсон орлогоос 0.26%-иар тооцон төлбөр¹³⁴ хураамж төлөх бол 2014 оны ОУИТБС-ын тайлангийн 5.4.3 (Хуудас 116-117) хэсэгт заасанчлан өөр өөр суманд байх 8 төрийн өмчийн компани нь орон нутагт эдгээр төлбөрийг шууд төлнө. ОУИТБС-ын тайланд хэрэв төрийн өмчийн компаниуд нь тухайн орон нутагт төлсөн төлбөр хураамжийг зохих ёсоор төлөөгүй талаар ямар нэгэн баримт дурдаагүй ч гаргасан жагаалт нь бүрэн бус байж болохыг шууд бусаар сануулсан. 5.4.3 хэсэгт дурдсан ихэнх төлбөрүүд нь олборлох компаниудад орон нутгаас ногдуулсан татвар хураамжууд байсан бол төрийн болон орон нутгийн ногдол ашиг хэмээн ангилсан төлбөрүүд зөвхөн төрийн өмчийн компаниудад л хамааралтай байсан.

4 төрийн өмчийн компаний орон нутагт (сум болон аймаг) 2013 онд төлсөн төрөл бүрийн шилжүүлгийг Хэсэг 5.4.4 (хуудас 118) хэсэгт жагсаасан. Харин ТӨК-ийн орон нутагт төлсөн төлбөр олон орон нутгийн шилжүүлэг хоёрын ялгаа тодорхой гараагүй байна. 5.4.4 хэсэгт заасан төрийн өмчийн компаний “орон нутгийн шилжүүлэг” нь буруу ангилан оруулсан нийгмийн зарцуулалтыг мөн агуулсан байж болохоор харагдаж байна. Түүнээс гадна 5.4.3 болон 5.4.4 хэсэг дэх хүснэгтийн доор “Хараат бус нэгтгэгч нь байгууллагуудаас тайлагнасан орон нутагт төлдөг татвар хураамжийн зарим нь хэтэрхий өндөр байгааг анхаарсан бөгөөд эдгээрийг баталгаажуулах ямар нэгэн арга хэмжээ аваагүй” хэмээн дурдсан байна.

5.4.4 хэсэг (Хуудас 118) дээр 2011-2013 онуудад төрийн өмчийн компаниудаас засгийн газар шилжүүлсэн шилжүүлгүүдийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн ч 2014 оны талаар огт дурдаагүй ажээ. ОТОБ-ийн хурлын протокол болон оролцогчдын зөвлөгөөнөөс үзвэл ОТОБ нь 2014 оны ОУИТБС-н тайлангийн мэдээ цуглуулахаас өмнө энэхүү ялгааг тооцож үзээгүй байна.

Оролцогч талуудын санал бодол

Эрдэнэс Монгол компанийг төлөөлсөн Засгийн газрын нэгэн төлөөлөл хэлэхдэ ТӨК-ийн санхүүжилтын бүтцийг ил болгоход эрх зүйн ямар нэгэн саад тотгор байхгүй, үүний нэгэн адил Эрдэнэс Монголд эсвэл ТӨХ-нд төлсөн ноогдол ашгийг ил болгоход ч саад байхгүй гэж үзсэн. Уулзалтад хамрагдсан ОТОБ-ийн бүх гишүүд нь ТӨК-ийн орон нутгийн шууд төлбөр болон орон нутгийн шилжүүлэг гэсэн төрлүүд дээр 2014 оны тайлангийн мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө хэлэлцэн, энэ хоёрын ялгааг судлан, гаргах шаардлагатай гэдэгт санал нийлж байлаа.

Анхдагч үнэлгээ

Төрийн өмчит компани болон Засгийн газрын хооронд олон төрлийн өөр өөр шилжүүлгүүд хийгдэж байдаг ч Шаардлага 4.5 дээр хийсэн үнэлгээ нь төрийн өмчит компанид онцгой хамааралтай

¹³⁴ ТӨК-ийн төсвийн чанартай шилжүүлгийн дүнг 4167.369 сая төгрөг хэмээн тооцож болно.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

шилжүүлэгт төвлөрсөн (ноогдол ашиг гэх мэт). Олборлох салбарын бүхий компани, үүнд төрийн өмчит компанид хамаарах хамаарах шилжүүлгийг доорх Шаардлага 4.6 дээр хамруулсан.

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын үүрэг ролийн талаар ОУИТБС-ын тайлан ил тод болгон оруулжээ. 2014 оны тайланд 2011- 2013 онуудад Хүний хөгжлийн санд шилжүүлж байсан хөрөнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан байна. Харин 2014 оны байдлаар энэ шилжүүлгийн тухай ямар нэгэн мэдээлэл оруулаагүй буй тул Олон улсын Ажлын албаны зүгээс үзэж буйгаар тухайн жилд Хүний хөгжлийн санд ямар нэгэн шилжүүлэг хийгдээгүй гэж үзэж байна. Мөн тайланд олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй 21 төрийн өмчит компанийн төлсөн ноогдол ашгийн тухай мэдээлэл мөн ил тод болсон ч эдгээр нь иж бүрэн эсэх дээр ямар нэгэн тайлбар байхгүй. Шаардлага 2.6 дээр дурдсанаар олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх иж бүрэн мэдээллийг гаргах шаардлагатай хэмээн заасан. Түүнчлэн Хараат бус нэгтгэгч нь төрийн өмчит компаниудын ил тод болгосон мэдээллийн чанар, үнэн эсэх дээр санаа зовниж буй талаараа дурдсан байв. Мөн 2014 оны ОУИТБС-ын тайлан нь төрийн өмчит компаниудын нийгмийн зарцуулалтыг “орон нутагт хийсэн төлбөр” хэмээн буруу ангилалд хамруулсан мэт харагдаж байна. Үүнийг анхааран Олон улсын Ажлын алба нь энэхүү шаардлагыг биелүүлэхэд Монгол улс нь тодорхой хэмжээний ахиц гаргасан хэмээн үнэлж байна. ОТОБ нь Эрдэнэс Монгол, Төрийн өмчийн хороо, Сангийн яам зэрэг байгууллагуудтай зөвлөлдөн төрийн өмчийн компаниудын шилжүүлгийг илүү сайн тодорхойлох, материаллаг байдлыг тогтоох болон иж бүрнээр ил тод болгох арга хэмжээг авах шаардлагатай. Одоо хэрэгжүүлж буй арга ажиллагаа, практикыг сайжруулан, ил тод болгох нь Олон улсын санхүүгийн корпорац болон АХБ-ны дэмжлэгтэйгээр Эрдэнэс Монгол компанийн засаглалд хийж буй шинэтгэлд чухал ач холбогдолтой байж, тус компанийг арилжааны шинжтэй, хөрөнгийн удирдлагын компани болгоход (Темасек загварын) үр дүнгээ өгөх юм.

Орон нутгийн шууд төлбөр (#4.6)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын 2014 оны тайлан нь компаниудын зүгээс орон нутагт шууд хийсэн бүхий төлбөрийг иж бүрнээр жагсаан, ил тод болгожээ. Тайлангийн Хэсэг 3.3.2 (хуудас 28-29) дээр 2014 оны нэгтгэлд хамруулах орлогын урсгалыг сонгон авах шалгуурыг дурдсан байна. Нэгтгэлд хамруулахаар нийт 12 төрлийн орлогын урсгалаас хамгийн том гэж болох орон нутагт чиглэсэн орлогын урсгалыг сонгон авсанаар 2014 ОУИТБС-ын тайлан нь орон нутгийн төлбөрийн урсгалын мөнгөн дүнгийн 99%-ийг хамруулжээ. Орон нутгийн төлбөр нь засгийн газрын зүгээс олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан нийт дүнгийн 5.15%-тай тэнцэж байна. Материаллаг орлогын урсгалын жагсаалтыг Хэсэг 3.4.1.3 (хуудас 33-34) дээр харин тэдгээрийг сонгон авсан үйл явцыг Хэсэг 3.4.1.2 (Хуудас 32-33) дээр харуулжээ. Хавсралт 11 (хуудас 201-203) нь компаниудын тайлагнасан орон нутгийн төлбөрийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг багтаажээ.

Хэсэг 5.4.3 (хуудас 116-117) нь нийт 8 төрийн өмчит компанийн зүгээс олон сумдад хийсэн шууд төлбөрийг тайлбарлан, үүнээс 3 компани нь хоёр ангилалд хамаарах шилжүүлгийг тайлагнасан байна. Гэхдээ 2014 оны ОУИТБС-ын тайлан нь “орон нутгийн шууд төлбөр” болон төрийн өмчит компаниудын “орон нутгийн шилжүүлэг” гэсэн хэллэгүүдийг хольж хутгасан мэт харагдаж байна. Төрийн өмчит компаниудын зүгээс орон нутгийн захиргаанд төлж буй татвар, төлбөрийг Хэсэг 5.4.3 дээр жагсаасан ба энэ нь тайлан гаргагч бүх компанид хамааралтай, харин төрийн болон орон нутгийн өмчид хамаарах ноогдол ашиг нь зөвхөн төрийн өмчит компаниудтай хамаатай, дээрх шаардлага 4.5-д заасан төлбөр юм. Хараат бус нэгтгэгч нь Хэсэг 5.4.3 болон 5.4.4 дээр байгаа

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хүснэгтийн доор тэмдэглэл оруулан “KPMG нь дээр дурдсан орон нутагт хийгдсэн төлбөрийн зарим нь компаниудын тайлагнаснаар өндөр дүнтэй буйг анхаарсан болно. Энэхүү тайлагнасан дүн дээр баталгаажуулалт хийгдээгүй” хэмээн зааж өгсөн байна.

Оролцогч талуудын санал бодол

Иргэний нийгмийг төлөөлсөн талууд нь орон нутгийн шууд төлбөрт онцгой анхаарал хандуулдаг бөгөөд орон нутаг дахь мэдээлэл түгээх үйл ажиллагаа болон дэд зөвлөлийн хурлуудад энэ төрлийн мэдээллийн эрлт маш өндөр байдаг. Салбарын төлөөлөл ч мөн ийм төрлийн мэдээллийг ил тод болгох нь үр дүнтэй хэмээн үздэг бөгөөд ингэснээр орон нутгийн иргэд тухайн сумд ажиллаж буй компани ямар хувь нэмэр оруулж буй талаар мэдлэгтэй болдог ажээ. Төрийн байгууллагуудын төлөөлсөн хэд хэдэн хүний үзэж буйгаар орон нутгийн дэд зөвлөлийг байгуулсан нь тустай ажил болж ОУИТБС-ыг хөдөө орон нутагт сурталчилж байна хэмээн тэмдэглэн хэлжээ. Уулзалтад оролцсон ОТОБ-ын гишүүдийн аль ч орон нутгийн шилжүүлэг болон төрийн өмчит компаниудын орон нутаг дахь шууд төлбөрийн ялгааны талаар хөндөн яриагүй, энэ талаар ОТОБ дээр ямар нэгэн байдлаар ярилцаагүй байна.

Анхдагч үнэлгээ

Орон нутагт хийгдэж буй төлбөрийн ОУИТБС-ын тайланд багтаах талаар ОТОБ нь ихээхэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн захиргаанд хийгдэж буй компанийн төлбөрийг ил тод болгож үүнийг төлбөрийн үрсгал бүрээр задаргаатай үзүүлжээ. Гэхдээ ОТОБ нь эдгээр төлбөрийн материаллаг байдлыг үнэлж, орон нутагт шууд хийгдсэн төлбөрт хамаарах босгыг тогтоосон ч төрийн өмчит компанийн “орон нутагт хийсэн шууд төлбөр” болон “орон нутгийн шилжүүлэг” гэсэн төрлүүд дээр будилан аль алиныг нь ил болгосон, гэхдээ орон нутгийн хүлээн авсан дүнтэй нэгтгэн тулгалт хийгээгүй байна. Шаардлага 2.6 дээр ОУИТБС-ын тайланд зориулан төрийн өмчит компанийг маш ойлгомжтой тодорхойлно хэмээн заасан байдаг. Эцэст нь Хараат бус нэгтгэгч нь төрийн өмчит компанийн мэдээлэлд найдахгүй буйгаа илэрхийлсэнийг ажигласан ч Нэгтгэгчийн хувьд энэхүү ил болгосон нь иж бүрэн эсэх дээр үнэлгээ хийгээгүй байна. Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү шаардлагыг хангахад тодорхой хэмжээний ахиц гаргасан хэмээн үзэж байна.

Задаргааны түвшин (#4.7)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Хэсэг 3.2.4 (хуудас 26) дээр ОУИТБС-ын мэдээллийг компани, орлогын үрсгал болон хүлээн авсан төрийн байгууллага бүрээр харуулсан хэмээн заасан ба улмаар цааш төв болон орон нутгийн түвшнээр задран орсон гэж заасан ч 2140 оны ОУИТБС-ын тайлан нь мэдээллийг бодит байдал дээр тайлан гаргагч компани болон орлогын үрсгалаар задлаагүй байна. Гэхдээ энэхүү мэдээлэл нь 2014 оны тайлангийн тойм мэдээллийн маягт болон мэдээллийн портал дээр хүртээмжтэй байна¹³⁵. Хэсэг 3.2.4 (хуудас 26) дээр мөн 2014 оны ОУИТБС-ын тайлан нь төслийн шатанд хүртэл задаргаатай мэдээллийг тусгаагүй хэмээн заасан байна.

Үндэсний зөвлөлийн зүгээс төсөл нэг бүрээр тайлагнах асуудлыг судлан үзсэн бөгөөд олборлох үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг задлан харуулах нь боломжтой

¹³⁵ 2006 2015 оны мэдээлэл санаачилгын мэдээллийн портал дээр байгаа. Үүнийг компанийн нэр болон тусгай зөвшөөрлийн дугаараар үзэж болно. <http://e-reporting.eitimongolia.mn/reportList>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

эсэхийг үнэлэх ажлын хэсгийг 2015 оны 1 сарын 13-ний өдрийн хурлаараа байгуулсан. Энэ нь төсөл бүрээр задаргаатай тайлагнах чиглэлээр авч хэрэгжүүлсэн анхны алхам болжээ.

Оролцогч талуудын санал бодол

Харилцан ярилцсан иргэний нийгмийн байгууллагууд нь дата портал дээр буй мэдээллийн задаргааны түвшинд сэтгэл ханамжтай байсан. Гэхдээ төсөл бүрээр тайлагнах асуудлыг ОТОБ дээр хараахан хэлэлцээгүй буйг үүлзсэн ОТОБ-ийн гишүүд хэлсэн. Төрийг төлөөлөн ОТОБ-д ажиллаж буй нэг гишүүний хэлсэнээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компанийн ихэнх нь нэг л уурхайтай бөгөөд үндсэндээ тэд дефакто төсөл бүрээр тайлагнасан гэж үзэх хэрэгтэйг дурдаж байв. Иргэний нийгмийн нэг төлөөллийн үзсэнээр ОТОБ нь 2015 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг түгээмэл татвараар задаргаа хийн олборлох үйл ажиллагааг олборлох бус үйл ажиллагаанаас нь ялгах аар ажлын хэсэг байгуулсан ч тус ажлын хэсэг нэг л удаа хуралдсан, идэвхгүй буй байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү шаардлагыг хангах чиглэлээр хангалттай ахиц дэвшил гаргасан хэмээн үнэлж байна. 2014 оны тайлан дээр бүх мэдээллийг бүх орлогын урсгалаар оруулахын оронд энэхүү задаргаатай мэдээллийг ОУИТБС-ын мэдээллийн порталд оруулсан байна. Энэхүү портал дээр хайлт хийх боломжтойн зэрэгцээ 2006- 2015 онуудын мэдээлэл байгаа.

Мэдээллийн цаг хугацаа (#4.8)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайланг 2015 оны 12 дугаар сард бэлтгэн гаргаж, улмаар Үндэсний зөвлөл нь 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталгаажуулсан байна. Тайлан гаргагч компаниуд болн төрийн байгууллагууд нь өөрсдийн тайланг ОУИТБС-ын цахим тайлагналын системээр дамжуулан, тухайн санхүүгийн жил дууссанаас хойш гурван сарын дотор гаргах ёстой. (жишээ нь 3 сарын 31-нээс өмнө). Компани болон төрийн байгууллагууд нь 2015 оны 3 сарын 31 гэхэд өөрсдийн тайлан мэдээллээ ирүүлсэн бөгөөд эдгээрийг онлайн байдлаар нэн даруй нээлттэй болгосны зэрэгцээ 2015 оны 8-11 дүгээр саруудад мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хүрээнд нэмэлт маягтуудыг ашиглан мэдээлэл авчээ. 2015 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гэхэд нийт 987 компани цахим тайлангийн системээр дамжуулан тайлангаа гаргасан байв.

Оролцогч талуудын санал бодол

ОТОБ-т ажилладаг иргэний нийгмийн хэд хэдэн төлөөлөл цахим тайлангийн системээр дамжуулан анхдагч мэдээллийг гаргуулан авдаг нь цаг хугацаа хэмнэсэн үйл явц гэж үзсэн ч иргэний нийгмийн байгууллагууд энэхүү мэдээллийг ашиглаж болох эсэх дээр өөр өөр бодолтой байв. Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь тодруулга өгөхдөө мэдээлэл ашиглах боломжтой, харин нэгтгэн тулгалтад хамруулаагүй гэдгийг заавал дурдах шаардлагатайг хэлж байв. Байгаль орчны иргэний зөвлөлийн нэг гишүүн төрийн мэдээлэл сар бүр гараад байхад ОУИТБС-ын мэдээлэл нь тэр давтамжаар гарахгүй буй нь алийг нь ашиглахаа мэдэхгүйд хүргэн төөрөгдүүлж байна гэж хэлсэн.

Анхдагч үнэлгээ

Монгол улсын хувьд энэхүү шаардлагыг биелүүлэх чиглэлээрх ахиц дэвшил нь хангалттай хэмжээнд байна хэмээн Олон улсын Ажлын алба үзэж байна. Цахим тайлагналын систем нь тайланг цаг

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хугацаанд нь гаргахад чухал нөлөөтэй ба одоо санхүүгийн жил дууссанаас хойш 12 сарын дотор багтан нэгтгэл тайлан бэлтгэгдэн гарч байна.

Мэдээллийн чанар (#4.9)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Хараат бус нэгтгэгчийн Ажлын даалгавар: 2015 оны 3 дугаар сард ОТОБ нь Олон улсын ОУИТБС-ын вебсайт дээрх Хараат бус нэгтгэгчийн Ажлын даалгаварын загварыг ашиглан 2014 оны тайлан бэлтгэх нэгтгэгчийг шалгаруулах үндэслэлийг гаргасан байна. Гэхдээ энэхүү загварыг Монгол улсын нөхцөлд тохируулан өөрчлөлт хийлгүйгээр шууд ашиглан тендер зарлажээ.¹³⁶ Мөн загвар Ажлын даалгаварын орчуулга нь бүрэн бус зарим хоосон зай нь хэвээр байсан нь зарим чухал дэлгэрэнгүй мэдээлэл орхигдсоныг харуулж байна. Тендэрт оролцож ялагдсан тал нь Сангийн Яамны Худалдан авах ажиллагааны газарт хэд хэдэн удаа гомдол гарган асуудал шийдэгдсэний дараа 2015 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан байна.

2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө гаргасан өгсөн маягтууд нь Цахим тайлагналын системд ашиглахаар төлөвлөгдсөн байсан тул 2013 оны 12 дугаар сард хамгийн сүүлд зөвшилцсөн маягтуудад үндэслэн ОТОБ нь Хараат бус нэгтгэгчтэй зөвшилцөн нэмэлт мэдээлэл авах зорилгоор багц маягтыг ашиглахаар болжээ (үндсэндээ санхүүгийн болон нөхцөл байдлын тухай мэдээлэл). Эдгээрийг 2015 оны 7 сарын 7-ны өдөр болсон эхлэлийн семинар дээр хэлэлцэж, 8 дугаар сард гарсан эхлэл тайлан дээр зөвшөөрсөн байна. Гэхдээ ОТОБ эсвэл техникийн ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг хэвлэн нийтэлж эдгээр хэлэлцүүлгийг тусгаагүй байна.¹³⁷

Түүнчлэн 2014 оны тайлангийн Хэсэг 2 (хуудас 7) дээр мэдээлэл цуглуулсан тухайн тайлбар өгсөн ба ОТОБ нь мэдээлэл цуглуулахад сонголтот хандлага ашиглаж болохыг зөвшөөрч (Цахим тайлангийн платформыг ашиглах гэх мэт) байсан ч энэ хэсэг дээр Хараат бус нэгтгэгчтэй мэдээллийн үйлдээтэй байдлын талаар ямар нэгэн байдлаар Хэсэг 2.1 (хуудас 7) дээр шаардсаны дагуу (Олон улсын УЗ-ын баталсан загвар ажлын даалгавар) хэлэлцүүлэг хийгээгүй байна. 2015 оны 8 сарын 4-ний өдрийн Эхлэлийн тайлан нь цахим тайлангийн системийн чанарын баталгаажилтын судалгааг оруулаагүй харин 2014 оны нэгтгэл хийх Нэгтгэгчийн ажлын даалгаварын талаар дурдан (Хэсэг 4:5, хуудас 18) байна. Үүнд Нэгтгэгчийн хийсэн компанийг төлөөлөх ахидлын загвар зэрэг цахим тайлангийн системд хамаарах зарим зүйлсийг л багтаажээ.

2014 оны тайлангийн Хэсэг 3 (хуудас 7-8) дээр ОТОБ нь мөн Засгийн газрын нийт орлоготой нийцүүлэн тогтоосон материаллаг байдлын босгын талаарх тайлбарыг (Ажлын даалгаварын 3.4 дээр шаардсан) орхигдуулсан байна. Мөн батлан гаргасан Ажлын даалгавар нь мэдээлэл цуглуулахаас өмнө ОУИТБС-ын ил тод болгохтой холбоотой нууцлалын заалтуудыг багтаах ёстойг мөн анхаарах ёстой. Эхлэлийн тайлангийн Хэсэг 4.6 (хуудас 18) болон 2014 оны тайлангийн Хэсэг 3.2.5 (хуудас 27) дээр ОУИТБС-ын мэдээллийн нууцлалыг хадгалах Нэгтгэгчийн заалтыг тайлбарласан ч энэ нь нэгтгэл хамааран ил тод болгохыг хамаарахгүй. Стандарт ажлын даалгавараас гажсан цөөн хэдэн ялгаатай зүйлсийг ОУИТБС-ын УЗ баталсан ба эдгээрийг Монголын ОУИТБС-ын ОТОБ баталсан ажлын даалгаварын Хэсэг 4 (хуудас 8-9) дээрээс үзэж болно.¹³⁸ Батлагдсан ажлын даалгавар нь мөн загвар даалгавар дээр буй тухайн нэгтгэгч нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт ажиллаж

¹³⁶ <http://www.eitimongolia.mn/en/node/4858>

¹³⁷ Эхлэлийн тайлан болон КРМГ компанийн хийсэн танилцуулгыг үзнэ үү.

¹³⁸ http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/ToR_for_Mongolia_EITI_2015_Report_IA_English_Updated.pdf

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

байсан туршлагатай байх гэсэн шалгуурыг орхисон байна (Хэсэг 4 (хуудас 9-10)). Материаллаг байдал, орлогын үрсгал болон засгийн газар болон аж ахуйн нэгжийн олон талаас ил болгох мэдээлэл зэргийг батлагдсан Ажлын даалгаварт тусгаагүй бөгөөд Нэгтгэгч нь цар хүрээ тодорхойлох судалгаа хийх гэсэн ОТОБ-ын тавьж буй шаардлага нь эдгээр материаллаг байдлын шийдвэрийг энэхүү цар хүрээ тодорхойлох шатанд гаргана гэж ойлгогдож байна.

2016 оны 2 дугаар сарын 3-ны өдөр¹³⁹ ОТОБ-ийн томилсон Үнэлгээний хороо 2015 оны нэгтгэл тайлан гаргах Хараат бус нэгтгэгчийг сонгох тендерийг зарласан бөгөөд үүний өмнө 2016 оны 2 дугаар сарын 1-нд¹⁴⁰ Ажлын даалгаварыг нь баталсан байна. Үнэлгээний хороо нь 7 гишүүнтэй (оролцогч талын бүлэг нэг бүрээс хоёр, Ажлын албанаас нэг: бүгд Сангийн яамны худалдан авалтын сургалтад сууж, гэрчилгээ авсан байх) байна. Гэхдээ тендерт саналаа өгөөд ялагдсан 3-4 өрсөлдөгчийн зүгээс техникийн болон санхүүгийн саналыг үнэлсэн явцтай холбоотой гомдол гарч (талуудын тайлбарыг доор үзнэ үү) Сангийн яамнаас дахин 2016 оны 4 сарын 19-ны¹⁴¹ тухайн Ажлын даалгавар дээрээ дахин тендер зарлахыг үүрэг болгожээ. 2016 оны 6 дугаар сард 2015 оны Хараат бус нэгтгэгчийн гэрээг Улаанбаатар аудит компанитай хийсэн нь тус компанийг 6 дахь удаагаа (сүүлийнх нь 2013 оны тайлан дээр) сонгосон хэрэг болжээ. Үндсэндээ ОТОБ-ын баталсан Ажлын даалгавар нь Олон улсын УЗ-ын баталсан стандарт ажлын даалгаварт суурилсан байна. ОТОБ-ийн зүгээс цар хүрээ тогтоох судалгаа хийх болон 2015 оны тайлан гаргах зэрэг шаардлагыг нэмэлтээр Ажлын даалгаварын Хэсэг 2 (хуудас 3) дээр оруулжээ.

Батлагдсан Ажлын даалгавар нь өмнөх тайлангуудтай адилхан мэдээллийн чанарын баталгааны журмуудыг оруулсан бөгөөд үүнд материаллаг компаниудын шаардлага болон төрийн байгууллагууд өөрийн аудиторос баталгаажуулсан захидал цуг явуулан мэдээллийн найдвартай байдлыг баталгаажуулах зэргийг мөн багтаасан байна. ОТОБ нь УЗ-ын баталсан загварын хэллэгийг тэр хэвээр нь ашигласан ба 2016 оны Ажлын даалгаварын Хэсэг 1.2.3 (хуудас 6) дээр (“ОТОБ нь баталгаажуулалтын захидлыг компанийн аудиторын хэвийн үйл ажиллагаанд хамруулах талаар шат дараатайгаар шийдвэрлэнэ.”) гэж заажээ. Энэ нь ОТОБ-т уян хатан байдлыг ханган чанарын баталгаажуулалтын үйл явцыг Нэгтгэгчтэй хамтаар шат дараатайгаар авч үзэх боломжийг олгоно.

Аудит болон баталгаажуулалтын судалгаа (компаниуд). Хараат бус нэгтгэгч нь 2014 оны ОУИТБС-ын тайлан бэлтгэх эхлэл үе шатанд материаллаг компаниудын аудитын үйл явцын талаар ямар нэгэн судалгаа хийгээгүй байна. Гэхдээ 2014 оны тайлан нь компаниудын хувьд илүү иж бүрэн чанарын баталгаажуулалтын процедурыг танилцуулжээ. Нэгтгэгч нь аудитын үйл ажиллагаа хийгдэж буй практикыг судлан үзэж компаниудын 2013 оны аудитлагдсан санхүүгийн тайланг гаргуулан авсан нь тайлангийн Хэсэг 3.3.4 (х.30) дээр заасны дагуу хийгдсэн байна. Хавсралт 12 (х.204) нь аудитлагдсан санхүүгийн тайлан нь олон нийтэд ил байсан 15 компанийн вебсайт дээрх холбоосыг харуулжээ.

Тайлангийн Хэсэг 2.3.2 (хуудас.18-19) болон Хэсэг 3.3.4.2 (хуудас.30) нь компанийн мэдээллийн чанарын баталгааны процедурын талаар тайлбарласан ба үүнд: ТУЗ-ын дарга эсвэл Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан төлөөллийн захидал, 2014 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн хуулбар (Монгол улсад баримталж буй Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу), болон ОУИТБС-д зориулан аудиторын гарган өгсөн баталгаа зэрэг багтаж байна. Энэхүү аудитын үйл ажиллагаа хэрхэн явагдаж буй судалгаа нь мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө

¹³⁹ <http://eitimongolia.mn/en/node/4883>

¹⁴⁰ (2016/2), Хараат бус нэгтгэгчийн ажлын даалгавар – 2015 оны тайлан -

http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/ToR_for_Mongolia_EITI_2015_Report_IA_English_Updated.pdf

¹⁴¹ <http://eitimongolia.mn/en/node/4894>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

хийгдээгүй тул Нэгтгэгч нь ОТОБ-тэй чанарын баталгаажуултад зориулан аудитлагдсан санхүүгийн тайлангийн хувийг шаардахаар тохирсон. Тайлангийн Хэсэг 2.3.2 (хуудас 19) дээр компаниудаас ирсэн хариуг Хавсралт 4 (хуудас 154-162) дээр компани бүрийн гарган өгсөн мэдээллийн тоймыг оруулжээ. Нийт 236 компаниас:

- 173 нь удирдлагын захидал ирүүлсэн 63 нь ирүүлээгүй.
- 143 нь аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлсэн.
- Нэг ч компани хөндлөнгийн аудиторын хязгаарлагдмал баталгаажуулалтын захидал (ISAE 3000) ирүүлээгүй
- 2 компани ОУИТБС-д гарган өгсөн дүнгийн талаарх тайлан гарган өгсөн. (эдгээр компанийн нэрсийг Хавсралт 4 (хуудас.154-162) дээр оруулсан.

Тайлангийн Хэсэг 4.2.4 (х.45) дээр Хараат бус нэгтгэгчийн үйл ажиллагаанд байсан хязгаарлалтуудыг дурдсан ба жишээ нь “2 компани урьдчилан тохирсон процедурын тайланг гарган өгсөн. Нийт 236 компаниас 143 компани нь жилийн санхүүгийн тайлан болон аудитын тайлан ирүүлсэн” гэх зэргээр дурджээ. Гэхдээ орхигдсон мэдээллийн материаллаг байдлыг үнэлээгүй (жишээ нь Засгийн газрын уул уурхайн салбараас олох орлогод эзлэх хувь гэх мэт) харин даган мөрдөөгүй компанийн эзлэх хувийг л дурдсан байна: “хариу өгсөн 96 компанийн 6 нь санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлт гарган өгсөн нь 90 гаруй хувь баталгаажаагүй аудитын дүгнэлт явуулсан гэсэн үг юм.”(Хэсэг 4.3 (х.45)).

Аудит болон баталгаажуулалтын судалгаа (засгийн газар). ОУИТБС-ын 2014 оны тайлангийн 5.1.3.1 дээр (хуудас 63) УАГ-ын төрийн бүх орлогын дансанд аудит хийх чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн шаардлагуудыг оруулжээ. 2015 оны 1 сараас Шилэн дансны хууль хэрэгжиж эхэлсэнээр төрийн байгууллагууд бүхий л зарцуулалтаа тайлагнах үүрэг хүлээсэн болохыг Хэсэг 5.1.3.2 (хуудас.63) дээр дурдсан байна. Гэхдээ 2014 оны тайлан нь УАГ-ын гаргасан тайлан олон нийтэд нээлттэй буй эсэхийг дурдаагүй байна.

Тайлан гаргагч төрийн байгууллагуудын чанарын баталгаажуулалтын процедур нь мэдээлэл цуглуулах хандлагыг тусгасан ба: Сангийн яам нь засгийн газрын бүх тайланг нэгтгэн гаргах ба шаардлагатай бол тухайн байгууллагаас нэмэлт мэдээлэл гаргуулан авдаг. Засгийн газрын тайлангийн маягууд дээрх чанарын баталгаажуулалтын процедурыг Хэсэг 2.3.2.3 (х.19) болон 3.3.4.3 (х.30-31) дээр дурдсан ба үүнд: нэмэлт мэдээлэлтэй хамт байгууллагын даргын гарын үсэг зурсан захидал өгөх замаар мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг батлах багтана. Сангийн яам нь мөн анхлан гаргасан мэдээлэл дээр баталгаажуулсан захидал авч болох ба энэ талаар Хэсэг 3.3.4.3 дээр дурджээ. (хуудас.30-31). УАГ болон үүний орон нутгийн салбар албад нь ОУИТБС-ын тайлан дээр ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй тул 2014 оны тайлан нь ОТОБ-ын зүгээс УАГ-тай ОУИТБС-ын тайлан дээр хамтран ажиллахаар хичээсэн анхны хүчин чармайлтын үзүүлэлт болж байна. Тайлангийн 3.3.4.3 (хуудас .30-31) дээр энэ талаар тайлбарлажээ:

“Одоогоор УАГ болон орон нутгийн аудитын газрууд нь төрийн байгууллагын ОУИТБС-д тайлагнасан мэдээлэлд ямар нэгэн баталгаажуулалт хийж, тайлан гаргадаггүй. Гэсэн хэдий ч, УАГ-ын зүгээс шаардлагатай нөөц, горим гүйцэтгэх хугацаа хангалттай бол ирээдүйд энэ төрлийн үүргийг гүйцэтгэхэд нээлттэй бөгөөд тэдний хувьд 5 дугаар сарын сүүлээс эхлэн 7 дугаар сарын эхэн хүртэлх хугацааг илүү тохиромжтой гэдгийг мэдэгдсэн. УАГ нь жил бүр өөрийн ажлын төлөвлөгөө хөтөлбөрөө бэлтгэдэг бөгөөд ОУИТБС-ын үйл явцын оролцоог уг хөтөлбөрийн нэг хэсэг болгох боломжтой. Энэхүү үүрэг нь санхүүгийн тайлангийн аудитаас

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

илүү гүйцэтгэлийн аудитын ажлын хүрээнд хамрах магадлалтай ч хүсэлт ирүүлсэн тохиолдолд YAГ-аас энэ талаар авч үзэх боломжтой.”

Эдгээр процедурыг хэрхэн даган мөрдөх талаар Хавсралт 5 (хуудас.163-164) дээр оруулжээ. Нийт 41 материаллаг байгууллагаас 24 нь төлөөллийн захидал гарган өгөөгүй харин Сангийн яам л тайлангийн маягт дээр албан тушаалтан гарын үсэг зурсан баримт гаргаж өгсөн нь тухайн гарын үсэг ямар утгатай болох талаар ямар ч тайлбар байхгүй байв. Тиймээс “Сангийн яамнаас ямар нэгэн төлөөлөл эсвэл баталгаа гарган өгөөгүй” гэж (2.3.2.3,х.19) дурдсан байна. Мэдээллийн үнэн зөв байдал болон иж бүрэн байдлын талаар лавлан асуухад Сангийн яам “орлогын урсгал нэг бүрээр дэлгэрэнгүй хяналт хийдэггүй тул энэ талаарх баталгаа гарган өгөхгүй” гэсэн хариулт өгсөн байна. (3.3.4.3, р.31) Хараат бус нэгтгэгч нь мөн Сангийн яамны төлөөлөл гарын үсэг зурсан уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийн тойм гэсэн баримт бичиг хүлээн авсан талаар Хэсэг 4.2.3.1 (р.43): Цахим тайлангийн системтэй харьцуулахад ямар нэгэн зөрүүтэй мэдээлэл байгаагүй” хэмээн дурдсан байна.

Нэгтгэгчийн үйл ажиллагаанд тулгарсан хязгаарлалтуудыг Хэсэг 4.2.4 (х.45) дээр дурдсан ч 2014 оны ОУИТБС-ын тайлан нь баталгаажилтын процедур дахь орхигдсон мэдээллийн материаллаг байдлыг засгийн газрын нийт орлогод хамааруулан хийсэн үнэлгээг оруулаагүй байна. Сангийн яам нь харилцан зөвшилсөн чанарын баталгааг гарган өгөөгүй тул 2014 оны тайланд буй засгийн газрын бүх мэдээлэл нь чанарын хувьд баталгаагүй болж байна.

2014 оны тайлангаас ч эсвэл ОУИТБС-ын мэдээллийн порталаас ч энэхүү хувь хэмжээг тооцон гаргах боломжгүй бөгөөд учир нь тухайн байгууллагуудын нийт дүн тодорхойгүйд оршино. Эцэст нь 4.1.3 дээр Нэгтгэгч нь мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлын талаар өөрийн тайлбарыг оруулсан нь ОУИТБС-ын тайланд тусгагддаг бодит болон иж бүрэн байдлыг хангаагүй байна.

Засгийн газрын зүгээс ил тод болгосон мэдээллийн найдвартай байдлын талаар 2013 оны тайлангийн 2.4.1.2 (хуудас.11) дээр “баталгаажуулах албан ёсны явц байхгүй” хэмээн зааж, мэдээлэл нь зарим талаар алдаатай байж болохыг дурдсан байна (хэдий материаллаг бус ч). 2.4.2.4 (хуудас.13-14) дээр Хараат бус нэгтгэгч нь “Засгийн газрын гарган өгсөн хүснэгт дээр төрийн нарийн бичиг гарын үсэг зурсан байсан ч нэгтгэгчид гарган өгсөн мэдээлэлтэй холбоотой ямар нэгэн төлөөллийн захидал эсвэл баталгааг гарган өгөөгүй, гарын үсэг нь юуг нотолж буй нь тодорхой байна” гэж тэмдэглэжээ.

8.3 (хуудас 110-111) дээр YAГ-ын зүгээс төрийн байгууллагуудад хийдэг аудитын процедурын тухай тойм мэдээлэл орсон байна. Төрийн байгууллагууд нь энэхүү журмыг зөрчсөн, эсвэл өөр байдлаар аудит хийгдсэн эсэх дээр үнэлгээ байхгүй.

Цаг хугацааны хувьд нийцэхгүй буй нь ОУИТБС-ын тайланд тулгарч буй гол сорилт байсан нь 2013 оны тайлан дээр ч ижил хэмжээнд байжээ. Сангийн яамнаас 2013 оны тайланд зориулан 2014 оны 2 сарын дунд үед засгийн мэдээлэл гарган өгөх үед энэхүү мэдээлэл Ажлын албан дээр хадгалагдаж байгаад дараа нь 3 дугаар улиралд Нэгтгэгч дээр ирсэн байна. Гэтэл YAГ нь 4 сарын 20 гэхэд л аймаг сумдад аудит хийж дуусдаг тул Засгийн газрын нэгдсэн тайлан энэ хугацаанаас хойш гарах хэрэгтэй болно. Тиймээс баталгаажуулалтыг YAГ 2014 оны 2 сарын дундуур гарган өгөх боломжгүй юм.

Нэгтгэлийн өмнөх мэдээллийн нууцлал: Хараат бус нэгтгэгчийн зүгээс мэдээллийн нууцлалыг хадгалах заалтууд нь ОУИТБС-ын 2014 оны тайлан дээр илүү нэмэгдсэн ба цахим тайлангийн системийн мэдээлэл хадгалах аюулгүй байдлын тухай зарим асуудлуудыг 3.2.1.1 (хуудас.22-23) дээр гарган ирсэн байна. Нэгтгэгчийн үзэж буйгаар гол асуудал нь супер хэрэглэгчийн аккаунт бөгөөд энэ

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

нь хүлээн авагч болон илгээгчийн хооронд хүний оролцоо шаардах явдал ажээ.

Энэ талаар Нэгтгэгч нь дэлгэрэнгүй байдлаар 3.2.1.1 (хуудас.22-23) дээр заасан байна:

“Одоогийн цахим тайлангийн мэдээлэл цуглуулах үйл явц нь тайлагнагч компаниуд болон төрийн байгууллагууд мэдээллийн системд нэвтрэх эрхээ авсанаар эхэлдэг. Дараа нь тайлагнасан мэдээллүүд нь цахим тайлангийн өгөгдлийн санд цуглардаг. Мэдээлэл цуглуулах үйл явцын тасалбар болох өдөр МОУИТБС-ын Ажлын Албаны Мэдээллийн Технологи хариуцсан мэргэжилтэн өгөгдлийн сангаас нэгтгэлийн мэдээллийг бэлтгэж Microsoft. Excel форматаар Хараат бус хянагч-нэгтгэгчид хүргүүлдэг. Хараат бус хянагч-нэгтгэгч нэгтгэлийн мэдээллийг бэлтгэж дууссаны дараа нэгтгэлийн мэдээллийг цахим тайлангийн системд дахин оруулдаг. Эцэст нь, бүх хэрэглэгчид компани тус бүрийн анх тайлагнасан болон нэгтгэлийн дараах орлогын үрсгалын мэдээллийг харах боломжтой болно.”

Цахим тайлангийн системийг иж бүрнээр нь шалган үзэх тухай эхний зөвлөмж байсан бөгөөд ингэснээр нууцлал, найдвартай байдлыг хангах юм.

Нэгтгэгч нь Хэсэг 3.2.5 (хуудас.27) дээр өөрийн үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл хамгаалахаар авсан арга хэмжээгээ дурдсан байна:

- Компани болон төрийн байгууллагуудтай зөвхөн ОУИТБС-ын төсөлд зориулан үүсгэсэн тусгай электрон шуудангаар харилцсан бөгөөд энэхүү электрон шууданд нэвтрэх ажилчдын тоо хязгаартай байсан.
- Байгууллагуудаас хүлээж авсан бүх электрон мэдээллүүд нь нэвтрэх эрхийн хязгаарлалттай фолдерт хадгалагдсан.
- Цаасаарх бичиг баримтуудыг хэрэглээгүй үед цоожтой аюулгүй газар хадгалж байсан.
- Байгууллагатай хийгдсэн бүх утасны дүүдлагууд нь хязгаарлагдмал орчинд хийгдсэн.
- ОУИТБС-ын төсөл дээр ажилласан бүх ажилчдад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар удирдамж өгсөн.
- Кэй Пи Эм Жи-ийн бодлого, мэргэжлийн үүрэг хариуцлага, ёс зүйн шаардлагаар бүх ажилчид мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

Нэгтгэл хийхээс өмнө мэдээллийн нууцлалыг хадгалах заалтууд нь 2013 оны тайлан дээр тэр бүр бүрэн хэмжээнд байгаагүй. 2014 оны гарын авлага дээр буй схем нь Ажлын албаны гол үүрэг ролийг харуулсан ба компани болон төрийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулан, ТЕГ болон СЯ-аар дамжуулан нэгтгэж байна. Гэхдээ 2014 оны тайлан дээр зарим асуудлуудыг шийдсэн ба тайлан гаргагчбайгууллагууд өөрсдийн мэдээллээ шууд цахим тайлангийн системд оруулсан. Гэхдээ цахим тайлангийн систем дээр буй ил тод болгох үйл явц нь нэгтгэлгүйгээр шууд вебсайт дээр тавигдах байдлаар хийгдэх ч ОТОБ-ын гишүүн эсвэл тайлан гаргагч байгууллагын зүгээс ямар нэгэн байдлаар асуудал үүсгээгүй байна.

Тойм мэдээллийн маягтыг бүх тайланд зориулан гаргасан ба үүнд Засгийн газрын тайлан¹⁴² болон компанийн тайлан¹⁴³ багтаж байна. Стандартчилсан тойм мэдээний маягтыг дараа нэгтгэн, Ажлын

¹⁴² <http://www.eitimongolia.mn/en/government-reports>

¹⁴³ <http://www.eitimongolia.mn/en/companies-reports>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

албан үүнд үндэслэн¹⁴⁴, вебсайтад зориулан¹⁴⁵ дүрсжүүлэх ажиллагааг явуулна.

Мэдээлэл гаргагчийн санхүүгийн бус мэдээллийг 2014 оны тайлан дээр зохих ёсоор гарган өгсөн ба харин 2013 оны тайлан дээр зохистой байдлаар гараагүй байжээ.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагыг төлөөлөх 2 хүн 2013 болон 2014 оны Хараат бус нэгтгэгчийн Ажлын даалгаварт санал өгсөн гэж хэлсэн ба иргэний нийгмийн хэд хэдэн байгууллага Ажлын даалгаварын талаар цахим шуудангаар санал солилцсон тухай хэлж байлаа. Гэхдээ ОТОБ-ийн гишүүд санал өгөх талаарх ямар нэгэн хүсэл авч байгаагүй байж магад гэж үзжээ. ОТОБ-ын зүгээс Ажлын даалгаварын төсөл дээр бараг санал өгдөггүй бөгөөд үндсэндээ Сонгон шалгаруулах хороо л энэхүү үүргийг гүйцэтгэж байна. Тендерт орж буй нэгтгэгч нарын үндэслэн санал гарсан Ажлын даалгавар нь бүрэн бус байсан гэж зарим санал гаргасан байгууллага хэлж байсан.

2015 оны Нэгтгэгчийг шалгаруулах тендерийн хувьд тендерт ялаагүй тал нь гомдол гаргасан гэж мэдээлсэн.¹⁴⁶ Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага ийнхүү будлиан болсонд санаа зовж буйгаа хэлсэн ба харин салбарын төлөөлөл нь худалдан авалт нь техникийн оноон дээр суурилсан байсан тул сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлж байв. Тэд тайлангийн чанар нь Нэгтгэгчийн чанараас хамаарна гэж үзжээ. Иргэний нийгмийн байгууллагууд нь эхний шатны тендерийг цуцалсантай холбоотойгоор үндэслэлийг нь асууж байсан.

Бүх материаллаг шалгуурт нийцсэн байгууллагуудын аудитын үйл ажиллагааг судлах ажлыг эхлэлийн шатанд хийсэн гэж харагдахгүй байгаа юм. Ярилцлагад хамрагдсан төрийн байгууллагын төлөөлөл энэ талаар хэлэлцэж байсныг санахгүй буй бөгөөд ОТОБ нь үүнийг өөрийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн, Ажлын даалгаварт оруулсан гэж үзэж байна. Иргэний нийгмийн нэг байгууллага Монгол улсад тайлан гаргахад цаг хугацааны хувьд хоцорч байдаг нь асуудал гээд уг нь 6 сар гэхэд нэгтгэл дуусах байтал энэ үед дөнгөж аудитын ажил дуусаж байдаг талаар ярьж байсан. Компанийн ОУИТБС-ын тайлан гаргалт дахь чанарын баталгаажуулалтын асуудлыг эхлэл тайлангийн дараа тохирсон болохыг ярилцсан ОТОБ-ийн гишүүд хэлж байв.

Төрийн байгууллагын нэг төлөөлөл хэлэхдээ 2015 ны хавар СЯ болон YAГ-т хандан албан захидал илгээсэн бөгөөд энэхүү захидалд ОУИТБС-ыг мэдээлэл дээр аудит хийж өгөх хүсэлт тавьжээ. YAГ-ын зүгээс боломжтой хэмээх хариу өгсөн ч зөвхөн ажлын төлөвлөгөөнд орж УИХ-аар хамаарах төсөв батлагдсан тохиолдолд л боломжтой гэж мэдэгдсэн байна. Энэ зардал 2016 улсын төсөвт

¹⁴⁴<https://drive.google.com/folderview?id=0B7tEEAf2PsWEUjllV1g2Zy02MFE&usp=sharing&tid=0B7tEEAf2PsWEaF84YkN2MUI4Y0U>

¹⁴⁵ https://beta.eiti.org/implementing_country/7

¹⁴⁶ Эхний шатанд 4 санал гаргасны нэг нь банкны баталгаан дээрээ буруу огноотой материал өгсөн тул цуцлагдсан байна гэж санал гаргасан этгээдүүд болон Ажлын алба үзэж байна. Гэхдээ анх гарсан тендерийн зар нь энэ буруу огноотой байсан тул ажлын хэсгээс тусдаа мейл илгээн залруулсан байна. Гэтэл нэг компани тэрхүү мейлийг хүлээн аваагүй гэж эсэргүүцсэн байна. Мөн санал гаргасан нэг компани нь өөрийн багт Сангийн яамны ажилтныг оруулсан байсан нь зөрчил үүссэн гэж бас нэг үзсэн байна. Ийнхүү гомдол гаргасан бас нэг шалтгаан нь Үнэлгээний хорооны дарга мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт өгөх гэж байсан ч санал гаргасан нэг талын ахлагч нь Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын захирал байсан тул бас сонирхлын зөрил үүссэн гэж үзжээ. Тиймээс эхний шатыг цуцалсан байна.

2 дугаар шатанд бүгд бие биенийхээ үнийн саналыг мэдэж айсан тул тэдний хооронд техникийн оноо авах дайн өрнөжээ. Хоёр компаниас Үнэлгээний хороо нь нийц 4 техникийн саналыг нэг хоногт багтаан судлах боломжгүй хэмээн гомдол гаргасан (олон зуун хуудас том баримт бичиг) бас нэг талаас зөвхөн техникийн оноон дээр үндэслэн шийдвэр гаргах хүсэлт гаргажээ. Үндсэндээ санал болгосон үнийн дүн нь төсөвлөсөн мөнгөн дүнгээс байнга доогуур байдаг бөгөөд үлдсэнийг нь Сангийн яаманд буцаадаг ажээ. Гэхдээ ийнхүү худалдан авалтад саад гарсан нь үйл ажиллагаанд ноцтой саад учруулаагүй гэж үзсэн..

тусгагдаагүй. ЯАГ нь мөн зөвхөн иж бүрэн хэмжээний баталгаажуулалт хийх ба хэрэв ОУИТБС-ын баталгаажуулалт хийвэл цогцоор нь буюу эхлээд мэдээлэл гарган өгөхөд дараа нь нэгтгэл тайлан дээр хийнэ гэсэн хариулт өгсөн байна. Төрийн төлөөллийн хувьд ингэж дараа нь баталгаажуулах тохиолдолд хүндрэл учруулна гэдгийг мэдэж байжээ. ЯАГ-ын төлөөлөл хэлэхдээ Монгол улс нь INTOSAI (2014 оноос хойш олборлох үйлдвэрлэлийн аудитын чиглэлээр ажиллаж буй) байгууллагын идэвхтэй гишүүн бөгөөд Монгол улс нь нягтлан бодох бүртгэлийн стандартыг нь шууд орчуулан хуулбарлаж хэрэгжүүлдэг байна. ОУИТБС-ын хувьд олборлох салбарын аудитын стандартыг сайжруулахад хувьнэмэр оруулах боломжтой талаар дурдахын зэрэгцээ ЯАГ-ын төлөөлөл мөн ОУИТБС-ын мэдээлэл түгээх үйл ажиллагаанд байнга оролцдог тухай ярьж байсан. Нэгтгэгчийн Ажлын даалгаварыг бэлтгэхэд ЯАГ-ын саналыг авч байх нь чухал бөгөөд ЯАГ нь санхүүгийн аудитаас үйл явцын аудит руу шилжин, олборлох салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж болох юм.

Төрийн байгууллагын төлөөлөл болон өмнө Нэгтгэгч хийсэн нэг байгууллагын төлөөлөл хэлэхдээ засгийн газрын мэдээллийн чанарын баталгаажилт эсвэл төлөөллийн захидал зэрэг нь 2014 оны тайланд ашигласан маягтгууд дээр анх удаа ашиглагдаж буйг хэлж байсан. Өмнө нь Нэгтгэгч нь ОТОБ-оос чанарын баталгаажуулалтын процедураа шууд гаргуулан авдаг байжээ. Гэхдээ өмнө нэгтгэгч байсан байгууллагын төлөөлөл хэлэхдээ Сангийн яам нь гэрчилгээжүүлэх батлах үйл ажиллагаанд оролцож болохгүй бөгөөд харин ЯАГ үүнийг хийвэл илүү сайн сонголт болох ба учир нь ЯАГ нь УИХ-д шууд хамаарах байгууллага юм. Тэдний хэлсэнээр засгийн газрын мэдээллийн талаарх ОУИТБС-ын зөвлөмжүүдийг олон улсын стандартаар нарийн хийх хэрэгтэй гэж үзэж байв. ҮСГ-ын төлөөлөл хэлэхдээ удирдлагын төлөөллийн захидал нь аудитад хандсан мэдээлэл мөн агуулж байдаг ч энэ нь олон улсын сатндарын бус мөн мөнгөн/акруал суурьтай бүртгэл дээр зохисгүй гэж үзэж байсан. ЯАГ-ын төлөөлөл хэлэхдээ цахим тайлангийн системд илгээхээс өмнө мэдээллээ хүлээн авдаг эцсийн цэг нь тул Сангийн яамыг сонгон засгийн газрын мэдээлэлд баталгаажуулалт хийлгэхээр судлан үзэж болох юм.

Төрийн байгууллагыг төлөөлсөн зарим хүмүүсийг хэлж буйгааа чанарын баталгаажилтад өндөр албан тушаалтны гарын үсэг хангалттай гэж үзэж байна. Баталгаажуулалтын мэдээлэлтэй холбоотой нэг гол асуудал нь ЯАГ засгийн газрын орлогод бус харин зарлагад лю аудит хийдэгт оршиж байна. Жил тутам Татварын ерөнхий газарт төвлөрүүлэх татварын хэмжээг нь зааж өгдөг багөөд ЯАГ нь төрийн санд ирсэн татварын ерөнхий газрын тайланг нэгтгэдэг ажээ. Нэгтгэгч болон төрийн төлөөллийн хэлсэнээр Төсвийн орлогын газар нь санхүүгийн тайлантай хамтаар орлогуудыг нэгтгэдэг бөгөөд Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн болон Орлого бүрдүүлэлтийн газрууд нь томоохон татвар төлөгч нараас хүлээн авсан орлогод аудит хийдэг байна. Аймгийн түвшинд Сангийн яамны төлөөлөл орлогоо нэгтгэн мэдээлдэг бол ЯАГ нь зардал болон нэгдсэн орлого дээр л аудит хийдэг ажээ. Иргэний нийгмийн төлөөллийн хэлж буйгаар төрийн байгууллагууд жишээ нь МХЕГ нь эрх зүйн хувьд журам дүрмийг даган мөрдөж буйг шалгах үүрэгтэй бөгөөд үүнд төрийн орлогыг баталгаажуулах ажлыг хийдэг гэж тайлбарлаж байна.

АНУ-ын Төрийн департамент нь ТӨК-иудын дунд олон улсын туршлага, засаглалын зарчмуудыг гажуудуулах явдал их гарч буй талаар мэдээлж буй юм. Энэ нь компанийн засаглал зөв бус, удирдлага, ил тод байдал болон бүртгэлийн хувьд зарим ТӨК болон гадаадын хөрөнгө оруулалтай компаниуд асуудалтай буйг харуулж байна¹⁴⁷.

¹⁴⁷ АНУ-ын Төрийн департамент (2015/6), Хөрөнгө оруулалтын орчин 2015,

Татварын ерөнхий газартай шууд харьцдаг томоохон татвар төлөгчид нь нэр хүндтэй компаниар аудит хийлгэдэг бол жижиг компаниудын хийлгэсэн аудитын чанар нь олон янз байдаг талаар Нэгтгэгч байгууллага хэлж байна. Ихэнх жижиг компаниуд бүтэн тайлан бус богинохон мэдэгдэл гаргуулдаг бөгөөд энэ нь найдаж болохуйн хэмжээнд хүрдэггүй ажээ. Салбарын төлөөллийн зүгээс ОУИТБС-ын тайлан нь итгэлцлийн асуудал бөгөөд ОТ болон ЭсЖиЭс компанитай холбоотой маргаан нь засгийн газар олон улсын аудитын стандартуудын талаар мэдэхгүй буйтай холбоотой гэж үзэж байв.

Өмнө хараат бус нэгтгэгчээр ажилласан компанийн төлөөлөл хэлэхдээ цахим тайлагналын системийн мэдээллийн чанарыг судлан үзэх нь 2014 оны тайлангийн хүрээнд шинээр хамрах болсоныг дурдсан. Төрийн төлөөллийн зүгээс цахим тайлангийн систем нь АМГ, гааль зэрэг байгууллагуудад асуудал үүсгэх болсон ба учир нь тухайн байгууллагууд нь компани дээр дахин давтагдахгүй дугаар ашиглахгүй буйтай холбоотой. Зарим хүмүүс нэгтгэлд хамрагдаж буй компанийн тоог бууруулбал ОУИТБС сайжирна хэмээн хэлж байлаа. Төр болон нэгтгэгч байгууллагын төлөөлөл хэлэхдээ төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдлыг баталгаажуулах боломжгүй, учир нь засгийн газрын тайлагналт чанарын баталгааны асуудал дээр дутмаг гэж үзэж байна. Гэхдээ тэдний зүгээс гарган өгсөн мэдээлэл нь тодорхой хэмжээнд чанарын баталгаатай гэхдээ олон улсын аудитын хэмжээнд хүрэхгүй гэж үзэж байна. УАГ-ын төлөөлөл хэлэхдээ төрийн өөр өөр байгууллагын гаргасан мэдээлэл, жишээ нь АМГ болон ТӨХ-ний мэдээлэл өөр буй нь эдгээрийг нэгтгэн системчлэх шаардлагатайг харуулж байна хэмээн тайлбарласан.

Иргэний нийгэм болон салбарын төлөөлөл зөвхөн ОУИТБС-ын зөвлөмжийг дангаар бус мөн Хараат бус нэгтгэгчийн зөвлөмжийг ч мөн харгалзан үзэх хүсэлтэй ч зөвлөмжийн төсөл дээр санал өгч байх сонирхол байхгүй баына. Салбарын хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ ОУИТБС-ын гишүүдээс санал өгөх нь өргөн хүрээний шинэтгэл бус зүгээр л тайлагналыг сайжруулах зорилготой асуудал гэж үзэж байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албын үнэлгээгээр Монгол улс нь энэхүү шаардлагыг хангахад тодорхой хэмжээнд ахиц гаргасан гэж үзэж байна. ОТОБ нь Хараат бус нэгтгэгчийн Ажлын даалгаварыг хэлэлцэн баталсан нь ихээхэн ахиц болсон байна. Хэдий 2013 оны Ажлын даалгавар нь ОУИТБС-ын УЗ-ийн баталсан жишиг даалгавараас зөрүүтэй байсан ч үүнийг нийтлэхээс өмнө засан сайжруулсан мөн 2015 оны даалгавар дээр талуудын саналыг нь идэвхтэй авсан зэрэг амжилт гарчээ. Тайлангийн маягтуудыг түр ажлын хэсэг болон ОТОБ хамтран эргэн харж, Хараат бус нэгтгэгч нь эхлэлийн семинар дээр танилцуулсан ч энэ талаар одоо ямар нэгэн тэмдэглэл үлдээгүй байна.

Шинэчилсэн тайлангийн маягтуудыг батлах процедур нь ОУИТБС-ын стандартад зааснаас зөрж буй ч ҮСГ болон ХЗЯ эцэслэн баталж буй бөгөөд эдгээр ОТОБ-ын эсрэг ажиллаж, саналын дагуу маягтуудыг батлаагүй саатуулсан гэх ямар нэгэн баримт нотолгоо байхгүй.

2013 болон 2014 оны тайлан нь аудит болон чанарын баталгааны процедурын талаарх тойм мэдээллийг багтаасан ч практикаас зөрж буй асуудлын талаар ямар нэгэн үнэлгээ хийгдээгүй байна. Тойм дээр үндэслэн ОТОБ болон Хараат бус нэгтгэгч нь дараагийн арга хэмжээг зөвшилцсөнийг Хэсэг 3.3.4.2 (хуудас.30) дээр дурдсан байна. Гэхдээ 2014 оны тайлан нь цахим тайлангийн платформын чанарын баталгаажуулалтын талаар дурдаагүй мөн санхүүгийн мэдээлэл цуглуулах

<http://www.state.gov/documents/organization/241879.pdf>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

сонголтот системийг ч харгалзан үзээгүй байна. 2014 оны тайлан нь чанарын баталгаажилт хийгдсэн эсэхийг харуулсан үнэлгээг хийж Нэгтгэгчийн хэлсэнээр тайлан гаргасан 41 байгууллагаас 24 нь (Хавсралт 5, хуудас. 163-164) 263 компаниас 63 нь (Хавсралт 4, рр.154-162) баталгаажуулалт гарган өгөөгүй байна. Гэхдээ ОУИТБС нь эдгээр үлдсэн компани/байгууллагын материаллаг байдлыг үнэлэн үзээгүй, тэдний мэдээллийн баталгаат байдлын талаар ерөнхий үнэлгээг ч ОУИТБС-ын тайланд оруулаагүй байна.

Нэгтгэл хийхээс мөн мэдээллийн нууцлалыг хамгаалах заалт нь 2013 оны тайлантай харьцуулбал илүү сайн байжээ. 2014 оны тайланд цахим тайлангийн системийг ашигласан нь зарим талаар нууцлалыг хангасан ч Хараат бус нэгтгэгчийн зүгээс суурь админ аккаунтын талаар асуудалтай буйгаа илэрхийлж байв. Цахим системд суулгасан чанарын баталгаажуултын шаардлагаас гадна олон тооны төрийн байгууллага болон компаниуд энэхүү шаардлагыг дагахгүй буйг тогтоосон. 2013, 2014 оны нэгтгэлд зориулан олон тооны компаниуд шаардлагатай чанарын баталгааны гэрчилгээ, захидал зэргийг гарган өгөөгүй байна- Хавсралт 4 (хуудас.154-162) 2014 болон нийт компанийн гуравны нэг нь ямар нэгэн баталгаажилтгүй байжээ. Хэсэг 6.2.9 (хуудас.145-146) болон Хавсралт (хуудас.163-164)- 2004 оны тайлан. ОТОБ нь цахим тайлангийн системд суурилуулсан чанарын баталгаажилтын системийг эргэн харах шаардлагатай байна.

2014 оны ОУИТБС-ын тайлан нь 2103 оныхтой харьцуулбал нөхцөл байдлын талаарх мэдээллийг илүү зохистой байдлаар тусгасан байлаа. Дараагийн тайланг бэлтгэхдээ ОТОБ нь тайланг иж бүрнээр бэлтгэх асуудалд анхаарал хандуулан, бүх шаардлагыг ханган Хараат бус нэгтгэгчийн Ажлын даалгавар дээрх бүхий л асуудлыг судлан үзэх шаардлагатай.

Хүснэгт 4 –Тойм үнэлгээний хүснэгт: Орлого төвлөрүүлэлт

ОУИТБС-ын заалтууд	Гол үр дүнгийн тойм	Гарсан ахиц дэвшлийн талаарх Олон улсын Ажлын албаны үнэлгээ
Иж бүрэн байдал (#4.1)	ОТОБ нь материаллаг байдал болон үүний босгын талаар хэлэлцэн тохирсон байна. Нэгтгэгч нь 2014 оны тайлангийн иж бүрдлийн талаар үнэлгээ хийгээгүй ч уншигчид орхигдсон хэсгийн материаллаг байдлыг тогтоон, ОУИТБС-ын тайлангийн иж бүрэн байдлын тухай дүгнэлт хийх боломжтой.	Ахиц дэвшил хангалттай.
Мөнгөн бус орлого (#4.2)	ОУИТБС-ын 2014 оны тайлан нь үйлдвэрлэл явуулж буй БХГ бүхий хоёр компани нь төрд мөнгөн бус хэлбэрээр хамаарах газрын тосыг борлуулан мөнгөн хэлбэрээр олгодог болохыг заажээ (ашгийн тос). Уул уурхайн салбарт мөнгөн бус ямар нэгэн орлого байхгүй. Төрд хамаарах ашгийн тосыг борлуулсан мөнгөн дүнг тайланд оруулсан.	Хэрэглэгдэхгүй шаардлага
Бартер болон дэд бүтцийн	ОУИТБС-ын 2014 оны тайлан нь дэд	Хэрэглэгдэхгүй шаардлага

шилжүүлэг (#4.3)	бүтцийн хангалтын талаар мэдээлэн, ямар нэгэн бартерын гүйлгээ хийдэггүй талаар дурджээ.	
Тээврийн орлого (#4.4)	ОТОб нь уул уурхайн салбар дахь тээвэрлэлтээс орлого хүлээн авдаг эсэхийг судлан үзсэн бөгөөд хэдийгээр материаллаг босго нь бага ч гэсэн Эрдэнэс Монголын олдог орлогыг ил тод болгосон. (0 дүнгээр). ОТОб нь газрын тосны салбарт тээврийн орлого буй эсэхийг судлан үзээгүй мэт харагдаж буй ч стандартын тодорхойлолтын дагуу төрийн өмчит ямар нэгэн компани энэ төрлийн орлого төвлөрүүлээгүй гэж ойлгож байна.	Хэрэглэгдэхгүй шаардлага
ТӨК болон Засгийн газар хоорондын шилжүүлэг (#4.5)	ОТОб нь ТӨК болон Засгийн газар хоорондын шилжүүлгийг судлан үзэж, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 21 ТӨК-иас авсан ноогдол ашгийг ил тод болгожээ. 2014 оны тайлан нь ТӨК-ийн зүгээс орон нутагт хийсэн төлбөрийг мөн хамарсан ч “орон нутаг дахь төлбөр” болон “орон нутаг дахь шилжүүлэг” гэсэн ангиллыг хооронд нь хожж хэрэглэсэн харагдаж байна.	Тодорхой хэмжээний ахиц дэвшил.
Орон нутаг дахь шууд төлбөр (#4.6)	ОТОб нь орон нутгийн шууд төлбөрийн талаар судлан үзэж, үүнийг ил тод болгон 2004 оны тайланд оруулан нэгтгэлд хамруулсан ба, орлогын урсгал бүрээр задлан харуулсан байна. Гэхдээ ТӨК-ийн “орон нутаг дахь шууд төлбөр” болон “орон нутгийн шилжүүлэг” хоёрын хольж ойлгон бүгдийг нь ил тод болгосон ч орон нутаг дахь хүлээн авсан байлдлаар нь нэгтгээгүй байна.	Тодорхой хэмжээний ахиц дэвшил.
Задаргааны түвшин (#4.7)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь бүх мэдээллийг орлогын урсгал, компаниар нь задлан харуулаагүй ч ОУИТБС-ын мэдээллийн портал нь энэ хэмжээний түвшний задаргаатай мэдээллийг хүртээмжтэй болгожээ.	Хангалттай хэмжээний ахиц дэвшил.
Мэдээллийн цаг хугацаат	Цахим тайлагналын систем нь	Хангалттай хэмжээний

байдал (#4.8)	тайланг цаг тухайд нь гаргаж байх болон төлбөрийн нэгтгэхэд ихээхэн тустай буй бөгөөд одоо санхүүгийн жил дууссанаас хойш 12 сард багтаан хийдэг болжээ.	ахиц дэвшил.
Мэдээллийн чанар (#4.9)	ОТОб нь чанарын баталгаажилтын үйл явцын талаар зөвшилцөхөөс өмнө аудитын үйл явцын талаар судлан үзэж байгаагүй ажээ. Мэдээллийн чанарын баталгааны асуудлууд нь (компани болон ЗГ дээр) 2014 оны тайлан дээр их хэмжээгээр байна. 2014 оны тайланг гаргахад ашигласан цахим тайлагналын систем нь ОУИТБС-ын мэдээллийн нууцлалын асуудлыг шийдсэн ч мэдээллийн чанарын баталгаажилтын асуудлыг шийдээгүй байна. 2014 оны тайлан нь чанарын баталгаажилтын тухай тойм мэдээлэл оруулсан ч тайлан гаргагч компани болон төрийн байгууллагын орхигдуулсан мэдээллийн материаллаг байдалд үнэлгээ хийгээгүй байна.	Тодорхой хэмжээний ахиц дэвшил.

Зөвлөмжүүд:

1. ОТОБ нь төлбөрийн материаллаг босгыг эргэн харж (мөнгөн бус орлого, тээврийн орлого, бартер болон дэд бүтцийн шилжүүлэг зэргийг оруулаад) иж бүрэн ил тод болгох болон тайлангийн чанарын хоорондын тэнцлийг хангах шаардлага нэн даруй үүсээд байна. ОТОБ нь мөн Нэгтгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор тайлангийн маягтуудад өөрчлөлт хийх тухай ҮСГ-тай хэлэлцэн тохирох ба энэхүү үйл явцыг олон нийтэд нээлттэй байлгах хэрэгтэй. ОТОБ нь мөн дараагийн тайлан дээр Нэгтгэгчээр иж бүрэн байдлын тухай үнэлгээ хийлгэж байхыг зөвшөөрөн баталгаажуулах шаардлагатай байна.
2. ОТОБ нь цахим тайлагналын системд суусан чанарын баталгаажуулалтын процедурыг эргэн харж тайлан гаргаж буй байгууллагууд шаардлагатай гэрчилгээжүүлэлт хийхэд алдаа гаргах боломжийг бууруулах хэрэгтэй байна.
3. ОУИТБС-ын стандартаар шаардаагүй ч ОТОБ нь БХГ-ний дагуу газрын тос үйлдвэрлэгч хоёр компаниас ашгийн тос болгон Засгийн газрын авч буй тосны хэмжээг оруулах талаар судлан үзэж болох юм. Энэ нь тухайн хоёр үйлдвэрлэгч дээр хяналт тавих болон Монгол улсын ашгийн тосыг борлуулахтай холбоотой хэлэлцүүлэгт ихээхэн үр дүнтэй юм.
4. ОТОБ нь Эрдэнэс Монгол, Төрийн өмчийн хороо болон Сангийн яамтай хамтран ТӨК-ийн зүгээс төрд хийж буй шилжүүлгийн материаллаг байдлыг тодорхойлох, орон нутгийн шууд төлбөрийг илүү ойлгомжтой тодорхойлох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Өнөөгийн арга ажиллагааны ил тод байдлыг сайжруулах нь ОУСК-ийн дэмжлэгээр Эрдэнэс Монголын компанийн засаглалд хийж буй шинэтгэлд нэмэр болж, тус компанийг Темасек загварын активын удирдлагын компани болгон хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.
5. Бүх төрийн байгууллага дээр компанийн дахин давтагдашгүй нэг дугаар хэрэглэх нь тайлан

гаргагч төрийн байгууллагуудын мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг илүү үр ашигтай болгоно.
 6. Монгол улсын уул уурхайн салбарт авто болон төмөр замын тээвэр чухал үүрэгтэйг харгалзан ОТОБ нь олборлох салбартай холбоотой тээврийн зохион байгуулалтыг илүү тодорхой тайлбарлан цаашдын тайлангуудад оруулах, газрын тосны салбар дахь төлбөрийн талаар судлах зэрэг үйл ажиллагааг хийх шаардлагатай байна.

5. Орлогын удирдлага болон хуваарилалт

5.1 Тойм

Энэхүү бүлэг нь орлогын удирдлага болон хуваарилалттай холбоотой ОУИТБС-ын шаардлагын хэрэгжилтийн талаарх мэдээлэлийг агуулсан.

5.2 Үнэлгээ

Орлого хуваарилалт (#5.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайланд төсвийн процессийн тухай тайлбарыг хийсэн байна (хуудас 104-105). Зарим олборлох үйлдвэрүүдийн төлбөрөөс улсын төсөвт багтсан зарим хэсгийн (нөөцийн төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр) тоймыг дурдан (хуудас 105-106) үүнд зарцуулалтыг нь урьдчилан заасан орлогууд болох Орон нутгийн хөгжлийн сан болон Хүний хөгжил санд орох орлогыг мөн багтаажээ. ОУИТБС-ын тайлан нь мөн Сангийн яам болон Монголын ОУИТБС-ын Ажлын албаны ирүүлсэн мэдээллийн үндсэн дээр олборлох үйлдвэрүүдийн төлсөн бүх татвар хураамжийг Татварын ерөнхий хуулийн дагуу жилийн төсөвт оруулан тайлагнадаг тухай тодруулга өгсөн (хуудас 105) байна.

Оролцогч талуудын санал бодол

Сангийн яамны төлөөллийн мэдэгдсэнээр Төрийн санд бүх орлогыг төвлөрүүлэх ажил одоо хир нь үргэлжилсээр байгаа ч олборлох салбарын орлого өөр үрсгал данс руу орж байгаа эсэхийг онцгойлон дурдаагүй. Салбар болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид 2014 оны ОУИТБС-ын тайланд ашиг орлого хуваарилсан байдалд өөрсдийн үзэл бодлоо ямар нэгэн байдлаар илэрхийлээгүй. ОТОБ нь 2014 оны ОУИТБС-ын тайлангийн эхлэл шатанд үүнийг тооцож үзэж, хэлэлцээгүй гэдгийг дурдсан.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын хэсгийн анхдагч үнэлгээгээр Монгол улс энэ шаардлагыг хангах чиглэлээр хангалттай ахиц дэвшил гаргасан гэж үзэж байна.

Орон нутгийн шилжүүлэг (#5.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2011 онд шинэчлэгдэн батлагдсан Төсвийн тухай хуулийн дагуу Орон нутгийн хөгжлийн сан дах олборлох үйлдвэрийн орлоготой холбоотой орон нутгийн шилжүүлгийн систем Монгол улсад 2006 ноос хойш ажиллаж байгаа бөгөөд мөн нөөцийн төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөр цуглуулах

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

тусдаа системийг мөн ажиллуулж байна. Засгийн газарт төлсөн рояалти болон лицензийн хураамжийг сар тутам 4 хувьсагч бүхий тусгай томъёогоор тооцон хамаарах хувийг Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлдэг ба энэ нь орон нутагт уул уурхайн үйлдвэрлэл байгаа, үгүй эсэхээс үл хамааран шилжиж, улмаар аймагт очиж, цаашид сумдад хуваарилагдан очдог ба үүнтэй холбоотой тусгай систем ажиллаж байгаа. Орон нутгийн хөгжлийн сан нь 2014 оны 7 сард шинээр батлагдсан Төсвийн тухай хуулийн дагуу рояалтигаас 5%, Хэсэг 5.3.3 (хуудас 105) дээр заасны дагуу газрын тосны рояалтигаас 30% (БХГ бүхий) авч байгаа бол газрын тос хайх болон ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20%-ийг хот/аймгийн хөгжлийн санд харин 10%-ийг сум/дүүргийн хөгжлийн санд оруулдаг байна. Аймаг, сумдын хэрэгцээнд хийх судалгаан дээр үндэслэн хөгжлийн сангийн хөрөнгийн 60-100%-ийг аймаг, сумдын хэрэгцээнд зориулан шилжүүлдэг. Сум, аймаг руу хийх төлбөрийг тодорхойлох 4 үндсэн шалгуур байгаа ба үүнд: орон нутгийн удирдлагын хөгжлийн индекс; хүн ам; хүн амын нягтрал, алслагдсан байдал, болон газар нутгийн хэмжээ; орон нутгийн татварын санаачлага зэрэг байна.

2014 оны ОУИТБС-ын тайланд орон нутагт заавал хийгдэх шилжүүлэг, тэр дундаа аймаг болон сум руу хийх нэгдсэн дүн бүхий шилжүүлэг зэргийн тайлбарыг өгсөн ч аймаг сум бүр дэхь 2014 онд аймаг, сум нэг бүрт хийгдсэн шилжүүлэгт ашигласан томъёолол багтаагүй байна (хуудас 106-107). Ил тод болгосон орон нутагт хийсэн шилжүүлэг нь олборлох салбарын нийт орлогын 1.17%-тай тэнцэж байна. Дөрвөн хувьсагч нэг бүр дээр ашигласан эх үүсвэрийг мөн оруулсан бөгөөд үүнийг ашиглан тодорхой нэг аймаг, сум 2014 онд хүлээн авах ёстой байсан орлогын хэмжээг тооцон гаргаж болно. 2014 оны тайлан нь орон нутгийн шилжүүлгийн хувьд материаллаг байдал болон босго ашиглаагүй ч Эхлэлийн тайлангийн Хэсэг 4.3.6 (х.16) дээр ОУИТБС-ын орон нутгийн шилжүүлгийн материаллаг байдлыг тогтоох шаардлага болон тайлангийн маягтад орон нутгийн шилжүүлэг оруулах Нэгтгэгчийн саналыг дүрдсэн байна. Хурлын тэмдэглэл болон талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааг судлан үзэхэд 2014 оны тайланд орон нутгийн шилжүүлэгт материаллаг босго тогтоохгүй гэдэг асуудлыг ОТОБ дээр хэлэлцэн судлан үзсэн байна. Тайлангийн 5.3.3.1 (Хуудас 107) хэсэгт 2014 онд аймаг бүрийн Орон нутгийн хөгжлийн сан болон Хүний хөгжлийн санд хийсэн бодит шилжүүлгийн талаар Сангийн яамнаас авсан тоо баримтыг багтаасан ч аймгаас цааш сумруу хийгдсэн бодит шилжүүлгийг багтаагаагүй. Энэхүү тайланд 2014 оны томъёоллоор тооцсон дотоод шилжүүлгийн түвшинг гаргаагүй болохоор тооцоолсон шилжүүлэг болон бодит шилжүүлгийн хоорондох зөрүүг тодорхойлох боломжгүй. Түүнээс гадна 5.3.3.1 (хуудас 107) хэсэгт тэмдэглэсэнээр аймгаас сум руу хийж байгаа шилжүүлгийн тайлагнах маягт нь орсон ч орлого хуваарилах томъёолол нь ороогүй.

5.3.4.2 хэсэг (хуудас 107)-т Орон нутгийн хөгжлийн сан болон орлогын эх үүсвэр, сум болон аймагт хуваарилах ерөнхий процессын талаар тайлбарласан.

Хурлын протокол болон бусад бичиг баримтуудаас үзвэл ОТОБ нь орон нутгийн шилжүүлгийг нэгтгэлд хамруулахгүйгээр шийдсэн гэсэн баримт байхгүй, харин Хараат бус нэгтгэгч нь нэгтгэл хийх гэж оролдсон ч үндсэндээ амжилтгүй болсон байна. Хараат бус нэгтгэгч нь 5.3.3.1 хэсэгт (хуудас 107) заасан олборлох үйлдвэртэй холбоотой шилжүүлэг хүлээн авсан бүх аймгуудын удирдлагатай холбоо барих оролдлогоо тайлбарласан ч зөвхөн Баян-Өлгий болон Хэнтий гэсэн хоёр аймаг л өөрийн орлогоо тайлагнасан байна. Бусад аймгууд яагаад тайлагнаагүй шалтгаанаа тайлбарлаагүй. Энэхүү хоёр аймгийн тайланг Хавсарлт 19 (хуудас 302) дээр хавсаргасан. ОУИТБС-н тайланд орон нутгийн шилжүүлгийн материаллаг байдал, ялангуяа аймгаас орон нутгийн санд шилжүүлэх шилжүүлгийн талаар ямар нэгэн тайлбар өгөөгүй. ОТОБ нь дараагийн ОУИТБС-н тайлангууд дахь орон нутгийн шилжүүлгүүдийн материаллаг талыг тооцон үзэх шаардлагатай бөгөөд дээрх

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

шилжүүлгийг материаллаг бус гэж үзсэн тохиолдолд сайн дураар ил тод болгох ангилалд оруулах боломжийг үнэлэн үзэх шаардлагтай.

Оролцогч талуудын санал бодол

Хараат бус нэгтгэгчид болон ОТОБ-н гишүүдийн үзэж байгаагаар 2014 оны ОУИТБС-н тайлангийн эхний шатанд материаллаг талын тухай хэлэлцээгүй байна. Засгийн газрын зарим төлөөлөгчдийн ярьж байгаагаар орон нутгийн шилжүүлгийн бодит байдал болон энэхүү томьёоллын талаар аймаг болон сумуудын хүлээн авч байгаа тоо хэмжээнд ямар нэгэн зөрүү гарч байгаа эсэх талаар ОТОБ дурьдсангүй. Гэхдээ хувь аймаг, сумууд руу хийж байгаа шилжүүлгийн талаарх мэдээллийг төсвийн гүйцэтгэлийн тайлангаас авах боломжтой бөгөөд Сангийн яамны Аудитын хорооноос санхүүгийн гүйцэтгэлийн талаар сар тутам үнэлгээ хийдэг гэж мэдэгдлээ.

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчийн мэдэгдэж байгаагаар Сангийн яамнаас Орон нутгийн хөгжлийн сан байгуулах тушаал гарган аймаг сумд руу хийх шилжүүлгийг тооцох ерөнхий томьёо гаргасан ч эдгээр шилжүүлгийг тооцоолох томьёо олон нийтэд нээлттэй эсэх нь тодорхойгүй байна. Газрын тосны компаний төлөөлөгчдийн тэмдэглэсэнээр Петро Чайнагийн хоёр үйлдвэрлэлийн БХГ-ний нэгэнд роялтигийн талаар дурдсан бол ДонгШенгийн БХГ бас роялтигийн талаар дурдсан нь эдгээрийг Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлжээ гэсэн үг хэмээн тайлбарласан.

ОТОБ дахь засгийн газрыг төлөөлсөн нэг гишүүн хэлэхдээ 2016 оноос аймгаас сумд руу хийгдэх хоёрдогч төлбөрийн хувьд аймаг, сум нь роялтийн 30%-ийг, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50%-ийг авдаг бөгөөд эдгээр нь аймаг, сумдад хүрээхээс өмнө төвдөө түрүүлээд төлөгдсөн байдаг талаар тайлбарлаж байв.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын хэсгийн анхдагч үнэлгээгээр Монгол улс энэ шаардлагыг хангах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргасан байна. 2014 оны ОУИТБС-ын тайланд орон нутгийн шилжүүлгийг тооцох ерөнхий журмыг өгсөн ч аймаг болон сум руу шилжиж байгаа дүнг тооцох бодит томьёоллыг оруулсангүй. Түүнчлэн бодит болон тооцоолсон шилжүүлгийн зөрүүг ОУИТБС-ын тайланд тусгаагүй. ОУИТБС-ын тайланд Орон нутгийн хөгжлийн сангийн нарийвчилсан тайлбарыг оруулсан ч энэ нь шилжүүлгийн материаллаг талын тухай ОТОБ-ын хэлэлцүүлгийг үүнд холбон, дурдсангүй. Аймгууд руу шилжсэн шилжүүлгийн талаар нэмэлт мэдээллийг хоёрдогч эх үүсвэрт суурилан Сангийн яамнаас¹⁴⁸ авах боломжтой юм. Төсөвлөсөн болон бодит гүйцэтгэсэн төв сангаас аймгууд руу хийсэн шилжүүлгийн талаар мэдээллийг Сангийн яамнаас тухайн хагас жил дууссанаас хойш сарын дотор авах боломжтой. (2013 оноос 2016 оны 1 хагас жил хүртэлх тоо баримтыг Хавсралт Д дээр үзнэ үү). Орон нутгийн хөгжлийн сан¹⁴⁹ вебсайтад 2013 оны (2012 онд Төсвийн хууль батлагдсан) Сангийн яамнаас авсан аймаг болон сумдад хийсэн төсөвлөсөн болон гүйцэтгэсэн шилжүүлгүүдийн тохироогүй тоо баримтуудыг харуулан, тухайн орлогоор цаашид санхүүжүүлсэн зардлын талаарх тоо баримтуудыг холбогдох тайлбаруудын хамтаар багтаажээ. Эцэст нь Төсвийн ил тод байдал: Сангийн яамны вебсайт¹⁵⁰ дахь мэдээлэлд бүх аймгууд руу хийсэн нийт шилжүүлгийн талаар нэгтгэсэн мэдээлэл гаргадаг байна. Гэхдээ эдгээрт тооцоололд ашигласан томьёоллын талаар мэдээлэл олон нийтэд хүртээмжгүй байна.

¹⁴⁸ Жишээ болгон 2013 оны орон нутгийн шилжүүлгийг үзнэ үү, Зураг 3 (.16),ЗГ (2015/6/30), Төвлөрлийг бууруулах, засаглалыг сайжруулах хөтөлбөр, Үе шат 3, Бүрэлдэхүүн хэсэг 3, 2015-2018, <http://cabinet.gov.mn/files/fileres/16010002.pdf>

¹⁴⁹ <http://tusuv-oronnutag.mn/>

¹⁵⁰ <http://www.iltod.gov.mn/> p

Орлогын удирдлага болон зарцуулалтын тухай нэмэлт мэдээлэл (#5.3)**Ахиц дэвшлийг баримтжуулах нь**

2014 оны ОУИТБС-ын тайланд зарцуулалтыг нь тусгайлан заасан орлогын тухай тайлбарласан бөгөөд Хэсэг 5.3.4 (хуудас 107-109) дээр Тогтворжилтын сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хүний хөгжил сан болон Ирээдүйн өв сан (хуулийн төсөл) зарим төрлийн орлого шууд орж байх тусгайлсан хөтөлбөрийн талаар тайлбар өгсөн байна. Хэсэг 5.3.1 болон 5.3.2 (хуудас 104-105) болон Хэсэг 5.3.5 (хуудас 109) хэсгүүд дээр буй төсвийн үйл явцын тойм мэдээлэл нь Үндэсний аудитын газрын 2014 оны төсвийн гүйцэтгэлийн дүгнэлттэй холбогджээ. Засгийн газраас 2018 он хүртэлх урьдчилсан төлөв гаргасныг Хэсэг 5.3.5 (хуудас 109) дээр үзэж болно.

Оролцогч талуудын санал бодол

Ихэнх оролцогчид орлогын менежмент болон зардлын талаар нэмэлт мэдээлэл багтаах талаар ямар нэгэн санал байхгүй гээд тэд Хараат бус нэгтгэгчдээс ОТОБ-ийг оролцуулахгүйгээр дээрх мэдээллийг гаргана гэж хүлээж байсан тухайгаа тэмдэглэн хэлсэн. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагуудын тэмдэглэснээр орон нутгийн дэд түвшинд оролцогчид болох нутгийн удирдлага болон иргэний нийгэм нь сум болон аймгийн түвшинд төвлөрсөн орлогыг хэрхэн ашигласан талаар илүү их мэдээлэл олж авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Гэхдээ ОТОБ нь ОУИТБС-ын тайланг гүйцэтгэл талруу өргөжүүлэх ямар нэгэн санал гаргаагүй болохын энд дурдсан. Засгийн газраас жил тутамд нэмэлт орлогын удирдлагын мэдээллийг гаргадаг ба үүнд төсвийн хүрээнд том тавар төлөгч 100 компанийн орлогын таамаг зэргийг багтаадаг ба үүнийг цаашид Сангийн яамны мэргэжилтний хэлсэнчлэн ОУИТБС-ын цаашдын тайлангийн нэг хэсэг болгон ашиглаж болно.

Анхдагч үнэлгээ

ОТОБ нь 2013 болон 2014 оны ОУИТБС-ын тайлангуудад орлогын менежмент болон зардлын талаар мэдээлэл багтаах зарим оролдлогуудыг хийсэн нь сайшаалтай. Ийм идэвхи зүтгэлүүдийг зөвхөн дэмждэг болохоос үнэлгээ хийхэд ашиглагддаггүй болно. “Төсвийн ил тод байдал: Сангийн Яам¹⁵¹” гэсэн вебсайт байдаг ба энэ нь жилийн батлагдсан төсвийн мэдээллийг агуулж буй талаар дурдсан ба Сангийн яамны вебсайтад¹⁵² төв болон орон нугийн орлогын үрсгалыг багтаасан, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг сар тутам, төв орон нутгаар нь ангилан задалж харуулдаг байна.

Хүснэгт 5 – Тойм үнэлгээний хүснэгт: Орлогын удирдлага болон хуваарилалт

ОУИТБС-ын заалт	Гол үр дүнгийн тойм	Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээ
Орлого хуваарилалт (#5.1)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь орлогыг хэрхэн хуваарилдаг тухай ил тод мэдээлсэн.	Хангалттай ахиц дэвшил гарсан
Орон нутгийн шилжүүлэг (#5.2)	2014 оны ОУИТБС-ын тайланд орон нутгийн шилжүүлгийн тооцоолох ерөнхий томъёог тусгасан ба харин аймаг болон сумдад хийсэн шилжүүлгийг тооцох томъёог оруулаагүй. Бодит болон тооцоолон гарсан шилжүүлэг хоорондын	Тодорхой хэмжээний ахиц дэвшил.

¹⁵¹ <http://www.iltod.gov.mn/>

¹⁵² <http://mof.gov.mn/>

	зөрүүг ил тод болгоогүй.	
Орлогын удирдлага болон зарцуулалтын мэдээлэл (#5.3)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь зарцуулалт нь тусгайлан заагдсан орлогын удирдлагын талаар тусгасан.	
<p>Зөвлөмжүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ОТОБ нь цаашдын тайланд аймаг болон сумдад хийсэн шилжүүлгийг тооцох томъёог оруулах шаардлагатай. 2. ОТОБ нь томъёоны дагуу орон нутаг шилжинэ хэмээн тооцсон дүн болон боит шилжсэн дүнгийн хоорондын зөрүүг ил тод болгон, үүнийг төсвийн өнөөгийн системд үнэлгээ хийх суурь болгож болох юм. 3. ОТОБ нь Хүний хөгжлийн сан болон Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг судлан үзэж болох юм. 4. ОТОБ нь дараагийн тайланд ийм төрлийн орон нутгийн шилжүүлгийн материаллаг байдлыг харгалзан, шилжүүлэг нь материаллаг бус хэмээн тогтоогдох тохиолдолд сайн дурын байдлаар ил тод болгох талаар судлан үзэж болно. 5. Монгол улс нь уул уурхайн салбараас хэт хамааралтай буй талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг хангах зорилгоор ОТОБ нь төсвийн цикл, үйлдвэрлэл, үнийн таамаг болон орлогын тогвортой байдлын талаар мэдээлэл цуглуулан, орлогын таамаглал хийхэд зориулан мэдээлэл цуглуулах талаар судлан үзэж болох юм. 		

6. Нийгэм, эдийн засгийн зарцуулалт

6.1 Тойм

Энэхүү Бүлэг нь нийгэм болон эдийн засгийн чиглэлтэй зарцуулалтад хамаарах ОУИТБС-ын шаардлагын хэрэгжилтийн талаар дурдах болно (төрийн өмчит компаниудын төсвийн чанартай зарцуулалт, нийгмийн зардал болон олборлох салбараас эдийн засагт оруулах хувь нэмэр).

6.2 Үнэлгээ

Нийгмийн зарцуулалт (#6.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайланд зайлшгүй болон сайн дурын нийгмийн зардлуудыг багтаасан. 2015 оны 8 сарын 4-ны өдрийн Эхлэлийн тайлангийн 6.3 зүйл (Хуудас 56) дээр зааснаар уул уурхайн компаниуд Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу заавал нийгмийн зардал жилийн төсөвтөө гаргаж байх ёстой ч Сангийн сайдын 2010 оны #45 тоот тушаалаар¹⁵³ эдгээр зардлуудыг хандив хэлбэрт ангилан үзсэн байна. 2006 оны Ашигт малтмалын хуулийн дагуу уул уурхайн компаниуд өөрсдийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн түвшинд сум, аймгийн захиргаатай гэрээ байгуулан нийгмийн зориулалттай зардлыг үүрэгтэй¹⁵⁴. Үүнээс гадна зарим компаниуд аймаг болон сумандаа сайн дурын үндсэн дээр нийгмийн чиглэлтэй зардал гаргадаг. Гэхдээ 2014 оны тайлан дах зайлшгүй болон сайн дурын зардлын хоорондох ялгаа, заагийг ОТОБ бус харин тайлан гаргаж байгаа байгууллагаас тогтоосон харагдаж байна. Бэлэн мөнгө болон бэлэн бус зардлуудыг тодорхой ялгаварлан тус бүр дэх мөнгөн бус зардлынх шинж байдлыг тайланд оруулжээ.

¹⁵³ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/Order_45_en.pdf

¹⁵⁴ Куйнсландын их сургуулийн гаргасан тайлбарыг доор үзнэ үү - <http://socialsciences.hawaii.edu/conference/demr2015/papers/byambajav-dalaibuyan.pdf>

Хэсэг 5.5.4 (хуудас 127-128) дээр заасны дагуу 2014 онд нийгмийн зардал гаргасан талаараа 236 компанийн 7 нь тайлагнасан байна. Зайлшгүй шаардлагатай нийгмийн зардал нь 11 295 сая төгрөг (6.3 сая ам.доллар) байсан бол сайн дурын зардал нь 670 826 сая төгрөг (371.7 сая ам.доллар) болж байсан нь компаниудын нэг талын тайлангаар нийт нийгмийн зардлын 98.3% нь сайн дурын байсныг харуулж байна. Гэхдээ бусад 229 компаний аль нэг нь 2014 онд ямар нэгэн материаллаг нийгмийн зардал гаргасан эсэх талаар ОТОБ тооцож үзсэн эсэх нь тодорхойгүй байна. ОУИТБС-ын тайлан нь нийгмийн зардлын хүрээг тодорхойлох ба жишээ нь Оюу Толгой¹⁵⁵, Энержи Ресурс гэх мэт гол төслүүдийн гэрээнд зайлшгүй гаргах нийгмийн зардлын заалтуудыг багтаасан байдаг. Хэсэг 5.5.5 (хуудас 129-132) дээр заасан компани нэг бүрийн хөтөлбөр дээр зайлшгүй болон сайн дурын нийгмийн зардлыг тодорхой ялган тогтоосон байхад эдгээр хоёр төрлийг ялгах үндэс суурийг нь тодорхой заагаагүй байна. Энэ нь тайлангийн маягт бөглөж байхдаа компаниуд нь эдгээр зардлуудаа өөрсдөө ангилах шаардлагатай болсонтой холбоотой байж болно.

Мөнгөн болон мөнгөн бус зардлуудыг зайлшгүй буюу сайн дурын нийгмийн зардлуудад нь тодорхой ангилан тайлбарласныг Хавсралт 9 (хуудас 188-191) дээр тодорхой харж болно. Энд нийгмийн зардлын төрлүүдийг тодорхойлон мөнгөн бус зардлын дүнг тооцох талаар тодорхой зааж өгсөн байна. Эцэст нь нийгмийн зайлшгүй зардлыг хүлээн авагсдын ихэнх нь (ихэнхдээ аймаг, суманд) төрийн байгууллагууд байгаа ч тайланд дурдсан нэг хүлээн авагч ТББ-ын үйл ажиллагааны талаар ямар нэгэн нэмэлт мэдээлэл байхгүй байна. (Хавсралт 9, 188-р хуудсанд хүлээн авагч #56 буюу 5.5.5 хэсэг (хуудас 131) дээрх хүснэгтэд заасан нийт зайлшгүй нийгмийн зардлын 2%-ийг авсан).

Оролцогч талуудын санал бодол

2014 оны 7 сард Ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орохоос өмнө, хэд хэдэн төрийн төлөөллийн хэлж буйгаар компаниудаас нийгмийн зардал гаргахыг шаардсан хуулийн заалт байгаагүй ажээ. Ихэнх тохиолдолд орон нутгийн удирдлагаас өөрийн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад хандив өргүүлэхээр дарамт үзүүлдэг ч энэ нь ихэнхдээ дуусдаггүй байнгын үйлдэл, шаардлага болж хувирдаг байжээ. Гэхдээ тогтвортой байдлын/хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газартай байгуулсан Монголиан Энержи, Сентерра, Эрдэнэт, Багануур, Шивээ Овоо зэрэг томоохон компаниуд гэрээгээр заавал нийгмийн чиглэлтэй зарцуулалт хийх үүргийг хүлээсэн байжээ. Ихэнх газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр зайлшгүй нийгмийн зардал шаардаж байсныг компаниуд дурдсан. Газрын тосны компаниудын зүгээс сүүлийн үеийн Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд нь зайлшгүй нийгмийн зардлуудыг багтаадаг ба энэ нь Засгийн газартай хийсэн гэрээний гол нөхцлийн нэг болдог бол 1990-ээд онуудад байгуулдаг байсан гэрээнүүдэд ийм зүйл байдаггүй байжээ. Гэхдээ газрын тос үйлдвэрлэгч 2 компани нь нийгмийн зардлын талаарх нэмэлт протоколуудад гарын үсэг зурсаар ирсэн (Петро Чайна нь орон нутгийн удирдлагуудтай, ДонгШенг нь Газрын тосны газартай) ч зайлшгүй нийгмийн зардлын талаар нэмэлт протокол байсан эсэх нь тодорхойгүй байна. Зайлшгүй нийгмийн зардлыг багтаасан сүүлийн үеийн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр эдгээр зардал нь эргэн төлөгдөх зардал биш гэдгийг газрын тосны компаниудтай хэлж байв. Бүх зайлшгүй нийгмийн зардлуудыг өөр ямар нэгэн хэлбэрээр бус бэлэн мөнгөөр хийдэг байсан гэж засгийн газрын төлөөлөл хэлж байлаа.

Өмнө ажиллаж байсан Хараат бус нэгтгэгчийн тэмдэглэснээр 2014 оны ОУИТБС-ын тайлангийн тоо

¹⁵⁵ Жишээ нь ОТ-н Хөрөнгө оруулалтын гэрээний 7.13-7.15 дээр нийгэм, эдийн засгийн дэд бүтцэд зориулсан заалт байгаа: http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF

баримт цуглуулахаас өмнө ОТОБ нь Монголын олборлох компаниудын зайлшгүй нийгмийн зардлуудын төрөл хэлбэрийн талаар ярьдаггүй байсан байна. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагаас тодорхойлсончлон 2014 оны ОУИТБС-ын тайлангийн эхний үе шатанд зайлшгүй болон сайн дурын нийгмийн зардлын талаар ярьж байсан ч ОТОБ нь мэдээлэл цуглуулахаас өмнө тэдгээрийн ялгааны талаарх эцсийн шийдэлд хүрээгүй байжээ. Хараат бус нэгтгэгчийн тэмдэглэснээр ОУИТБС-ын тайлангийн үеэр нийгмийн зардлын төрлүүдийг ялгах асуудлыг тухайн байгууллагад нь орхидог байсан ажээ. Газрын тосны зарим компанийн хэлсэнээр эдгээрийн ялгаа нь тэдэнд маш чухал ач холбогдолтой болохоор ОТОБ дээр яригддаггүй байсан ч хөрөнгө оруулагчид нь зөвхөн зайлшгүй нийгмийн зардлыг л төлөх хүсэлтэй байсан ч компанийн удирдлагаас орон нутгийн хандивын ач холбогдлыг ойлгон сайн дурын нийгмийн зардлын зарим хэлбэрүүдийг зайлшгүйд тооцон үздэг байжээ.

Хэд хэдэн засгийн газар болон салбарын төлөөллийн тэмдэглэснээр ОУИТБС-ын ангиллыг буруу хийх нь нэгтгэл дээр гардаг зөрүүний нэг гол шалтгаан байжээ. Учир нь компани нь усан хангамж гэх мэт нийгмийн дэд бүтцүүдэд хөрөнгө оруулдаг ч компанийн зүгээс төрийн байгууллагад хандив өгөх нь хууль бус тул хүлээн авсан орон нутгийн захиргаад (сүм болон аймгийн) хүлээн авсанаа барилга эсвэл төлбөр байдлаар хүлээн авсан хэмээн ангиллыг нь өөрчлөн тайлагнадаг байна.

Төр болон салбарын ОТОБ-т төлөөлж буй хэд хэдэн хүний мэдэгдсэнээр 2014 оны 7 сард Ашигт малтмалын хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт нь (42.1 зүйл) бүх компаниудыг Орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулах (орон нутгаас худалдан авалт хийх, орон нутгаас хүний нөөц бүрдүүлэх, байгаль хамгаалах гэх мэт) үүрэг ноогдуулах болсон нь зайлшгүй хийгдэх нийгмийн зардлыг тусгах болжээ. Орон нутгийг хөгжүүлэх гэрээний загварыг 2016 оны эхээр Засгийн газраас баталсан.

Сайн дурын нийгмийн зардлын хувьд хэд хэдэн төр болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид төрийн байгууллагууд нь хүлээн авч болох хандивын хувьд хязгаарлагдмал, ердөө боловсрол, эрүүл мэнд, соёл гэсэн гурван төрлийн байгууллага л хандив авч болох ч хүлээн авагч хувийн байгууллагуудын хувьд ямар нэгэн хязгаарлалт байхгүйг хэлж байв.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс энэ шаардлагыг хангахад тодорхой амжилт гаргасан гэж үзэж байна. Монгол улсад нийгмийн сайн дурын болон зайлшгүй зардлыг тодорхой заагласан ба гэрээгээр заасан бол зайлшгүй, заагаагүй бол сайн дурын гэж ангилна. Жишээ нь Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд тодорхой нийгмийн зардлуудыг зайлшгүй хэмээн заасан¹⁵⁶ бол ихэнх Бүтээгдэхүүн хуваах гэрээнд зайлшгүй нийгмийн зардлыг багтаадаг.

ОУИТБС-ын тайланд компаниудын нийгмийн зардлыг багтаасан ч зайлшгүй буюу сайн дурын нийгмийн зардлуудыг мэдээлэл цуглуулахаас өмнө ОТОБ тогтоохоос илүү тухайн байгууллага өөрөө ангилан тогтоож, тайлагнажээ. Эдгээр зардлуудыг үнэн зөв тайлагнаж байгаа эсэх нь тодорхойгүй байгаагийн дээр 229 компанийн аль нэг нь ч 2014 онд аливаа материаллаг нийгмийн зардал гаргасан эсэх нь тодорхойгүй л байна. Тиймээс тайлангаас харахад эдгээр нийгмийн зардлуудын аль нь зайлшгүй, аль нь сайн дурынх вэ гэдгийг сайтар тогтоох боломжгүй байна. Үүний адилаар засгийн газрын нэг төлөөлөгчийн мэдэгдсэнээр бүх зайлшгүй зардлуудыг мөнгөн хэлбэрээр аргасан хэмээн тайлагнаж байгаа ч 2014 оны ОУИТБС-ын тайланд нийгмийн зардлын төрөл хэлбэр, нөхцөл байдлыг

¹⁵⁶ ОТ-н Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлэг (хуудас 14-15), http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

тодорхой тайлбарлаагүйн улмаас мөнгөн бусаар гарсан зайлшгүй зардал ч байгаа харагдаж байна. ОТОБ, ялангуяа иргэний нийгэм өөрийн нөлөөллийн үйл ажиллагаанд суурилан, тэдгээр зардлыг тодорхой ангилан ялгах замаар сайн дурын болон хуулиар шаардагдсан хувь нэмэр орон нутагт орж, үүнийг иж бүрнээр ил тод болгож байхыг баталагаажуулах шаардлагатай.

Төрийн өмчит компаниудын төсвийн шинжтэй зарцуулалтууд (#6.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУВС болон АХБ-ны зүгээс мэдээлсэнээр Монгол улсад, ялангуяа 2014 онд, Хөгжлийн банкны зарцуулалт буюу төсвийн бус зардал нь ДНБ-ний 6.75%-тай тэнцэж их хэмжээний төсвийн шинж бүхий зардал гарч, орон сууц болон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлсэн нотолгоо байна.¹⁵⁷ Үүнээс гадна төрийн өмчит хоёр нүүрсний уурхай төрийн өмчит цахилгаан станцуудад зах зээлийн үнээс доогуур үнээр нүүрс нийлүүлэн¹⁵⁸ үүнээс гарсан алдагдлын тодорхой хэсгийн улсын төсвөөс нөхөн авдаг гэсэн мэдээлэл мөн буй юм.

2014 оны ОУИТБС-ын тайлангийн Хэсэг 5.4.6 (хуудас 119) нь төсвийн шинж бүхий зарцуулалтын талаар тайлбар өгсөн ч олборлох үйлдвэрлэлийн салбар дахь төрийн өмчит 21 компаниас 13 нь л нэгтгэлд хамрагджээ (Хэсэг 5.4.2 (хуудас 110-111)). Нэгтгэл тайланд хамрагдаагүй 8 төрийн өмчит компанийн 5 нь барилгын материалын үйлдвэрлэл, 3 нь уран, нүүрс, гянт болд зэрэг ашигт малтмалын үйлдвэрлэл эрхэлдэг байна. Нэгтгэлд хамрагдсан 13 компанийн нэгээс (Шивээ Овоо) бусад нь нэг бол өөрийн тайлангаа гаргахдаа төсвийн шинж бүхий зардлаа тайлагнаагүй эсвэл ямар нэгэн байдлаар төсвийн шинжтэй зардал гаргаагүй хэмээн тайлагнасан болж байна. ОУИТБС-ын 2014 оны тайлан нь аль компани нь ямар нэгэн мэдээлэл гарган өгөөгүй болохыг заагаагүй эсвэл энэ талаар ямар нэгэн тайлбар өгөөгүй байна. ОТОБ нь мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө татаас олгож буй асуудлыг судлан үзээгүй эсвэл төрийн өмчийн компаниуд бүтээгдэхүүн нийлүүлээд төлбөр хийгдэхгүй тохиолдолд авах ёстой ч хүлээгдсэн торгууль, орон нутгийн захиргаанаас шаардан гаргуулдаг нийгмийн төлбөр зэрэг улсын төсвийн зардлын шинж бүхий төлбөр байж болно (боломжит) гэдгийг судлан үзээгүй мэт харагдаж байна. Зарим төрийн өмчит уурхай зах зээлийн үнээс доогуур үнээр цахилгаан станцуудад нүүрс нийлүүлэн эргэн татаас авдаг талаар тайланд дурдаагүй байна. Хэий Хэсэг 5.4.4 (хуудас 118) дээрх хүснэгт төрийн өмчит компаниудын зүгээс орон нутагт хийсэн төлбөрүүдийг жагсаасан ч эдгээр төлбөрийг төсвийн шинжтэй эвсэл заавал хийгдэх дэд бүтцийн зарцуулалт эвсэл сайн дурын зарцуулалт (дэд бүтцэд) эсвэл нийгмийн төлөөх сайн дурын зарцуулалт хэмээн ангилсан байх эсэх нь тодорхойгүй байна.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагын төлөөллийн зүгээс жил тутмын улсын төсөв нь Хөгжлийн банкны хэрэгжүүлж буй тогтворжуулах хөтөлбөрт зориулан хөрөнгө хуваарилж буй тухай ярьсан бөгөөд энэхүү хөрөнгөнд цахилгаан станцуудад хямд үнээр нийлүүлж буй нүүрсний өртөг шингэж буй юм. Гэвч иргэний нийгмийн үзэж буйгаар төрийн өмчит Багануур ХК нь эрчим хүчний нүүрсийг тонныг нь 2500 төгрөгөөр цахилгаан станцуудад борлуулж буй ч үүнд хэдий хэмжээний мөнгийг төсвөөс өгөх татаас болгон зарцуулж буй талаар ямар нэгэн мэдээлэлгүй байсан.

¹⁵⁷ АХБ (2015), Монгол улс: Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр, <http://www.adb.org/printpdf/projects/49210-001/main> мөн ОУВС (2015), Монгол улсын зөвлөлдөх үйл ажиллагаа 4: Өрийн тогтвортой байдлын шинжилгээ, <https://www.imf.org/external/pubs/ft/dsa/pdf/2015/dsacr15109.pdf>

¹⁵⁸ Жишээ болгон АХБ (2013/9), “Монгол улс: Эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх нь” (хуудас 15) үзнэ үү, <http://www.adb.org/sites/default/files/project-document/81826/43079-012-tacr-01f.pdf>

Уулзан ярилцсан Хараат бус нэгтгэгч (өмнө ажиллаж байсан) болон ОТОБ-ийн гишүүн хэлэхдээ Монгол улсад төрийн өмчит компаниудын гаргаж буй төсвийн чанартай зарцуулалтын талаар 2014 оны тайлангийн мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө ямар нэгэн хэлэлцүүлэг ОТОБ дээр хийгдээгүй байна. Төрийн байгууллагын хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ ийм төрлийн төсвийн шинжтэй зарцуулалтын ил тод болгоход эрх зүйн ямар нэгэн саад тогтор байхгүйг мэдэгдэж байв. Төрийн байгууллагын хоёр төлөөлөл төрийн өмчит уурхайнуудад олгох татаасыг жил тутмын улсын төсөвт тусгадаг ба төрийн өмчит компаниудад нийлүүлсэн хэмжээнд нь тооцон тодорхой хувиар татаас олгодог тухай хэлж байв. Засгийн газраас нүүрсний дотоодын үнийг тогтвортой барьж байдаг ба олгосон татаас нь зөвхөн нэг хэсэг нь байдаг ба нүүрсний уурхайнууд үнийн зохицуулалтаас хамааран багахан ашгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болдгийг дурдаж байсан.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны анхдагч үнэлгээгээр Монгол улс нь энэ шаардлагыг биелүүлэх талаар хангалтгүй ахиц дэвшил гаргажээ. ОУИТБС-ын 2014 оны тайлан нь зөвхөн нэг компанийн төсвийн шинжтэй зарцуулалтыг тайлагнасан ч энэ нь уул уурхайн салбар дэх ийм төрлийн зарцуулалтын иж бүрэн тойм мэдээлэл болж чадахгүй байна. Мөн төсвийн шинжтэй зарцуулалт болон төрийн өмчит компаниудын нийгмийн зардлууд бол тэдний орон нутагт хийдэг шууд төлбөр зэргийн хоорондын ялгаа заагийг гаргахад хүндрэлтэй, эргэлзээтэй байжээ. Мөн мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө ОТОБ дээр энэ сэдвээр ямар нэгэн хэлэлцүүлэг хийгдээгүй байна. Мөн зарим компанийн орон нутагт төлсөн төлбөрийг буруу ангилсан байж болох юм. Энэ нь дээр дурдсан цахилгаан станцуудад борлуулж буй нүүрсний (бусад ашигт малтмалтай ч холбоотой байж болно) татаастай онцгой хамааралтай байж болох ба учир нь төв банкнаас 2013 оноос хойш их хэмжээний төсвийн бус зээл гаргасан мэдээ байгаа билээ. ОТОБ нь энэхүү асуудлыг судлан үзэж, уул уурхайн салбар дахь төсвийн шинжтэй зарцуулалтын талаар дэлгэрэнгүй тайлбар гаргах шаардлагатай байна. Энэхүү мэдээлэл нь ЗГ-ын зүгээс эрчим хүчний салбарт шинэтгэл хийх төлөвлөгөөтэй холбоотойгоор чухал ач холбогдолтой байж болно.

Олборлох салбараас орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр (#6.3)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

2014 оны ОУИТБС-ын тайлан нь олборлох салбараас орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг иж бүрнээр тайлбарласан бөгөөд үүнд доор дурдсан мэдээллийг багтаажээ:

- Олборлох салбарын хэмжээг абсолют утгаар болон ДНБ-д эзлэх хувиар Хэсэг 5.1.1.1 (хуудас 47) дээр,
- Ашигт малтмалын үйлдвэрлэл төвлөрсөн гол газруудыг Хэсэг 5.1.4.3 (хуудас 71), газрын тосны үйлдвэрлэлийг Хэсэг 5.1.5.3 (хуудас 86) дээр,
- Эдийн засагт тухайн үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмрийг абсолют утгаар Засгийн газрын нийт орлогод эзлэх хувь хэмжээгээр нь Хэсэг 5.1.1.2 (хуудас 48) дээр,
- Олборлох салбарын экспортын дүнг абсолют утгаар, нийт экспортод эзлэх хувиар Хэсэг 5.1.1.3 (хуудас 49) дээр,
- Олборлох салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн абсолют утгыг, нийт ажил эрхлэлтэд эзлэх хувиар Хэсэг 5.1.1.4 (хуудас 50) дээр. Хавсралт 13 (хуудас 205-206) нь 79 компанийн ажил эрхлэлтийн мэдээллийг, ажиллагсадын хамаарах улс, хөдөлмөр эрхлэлтийн төрөл, сум, аймгийн тоогоор,

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

- Албан бус салбарын хэмжээг бичил уурхай эрхлэгчдийн тухай мэдээллийн хамтаар Хэсэг 5.1.4.5 (хуудас 79-83) дээр. Хавсралт 17 (хуудас 296-297) нь бичил уурхайн үйлдвэрлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг аймаг бүрээр, гэхдээ зөвхөн гурван аймгаар харуулсан байна.

Оролцогч талуудын санал бодол

Баталгаажуулалтын уулзалтад оролцсон иргэний нийгэм болон компанийн төлөөллийн зүгээс 2014 оны тайланд дурдагдсан олборлох салбараас орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийн талаарх мэдээллийг иж бүрэн, оновчтой хэмээн үзэж, мөн 2016 оны 6 дугаар сард нийтлэгдсэн НҮБХХ-ийн гаргасан Уул уурхайн салбар дахь авлигын нөхцөл байдлын судалгаа зэрэг олборлох салбарын тухай бусад баримт бичгүүдэд дурдагдсаны ижил тоо баримтыг гаргасан байна гэж үзсэн. Ялангуяа иргэний нийгмийн байгууллагууд нь бичил уурхай болон гар аргаар ашигт малтмал олборлохтой холбоотой нэмэлт мэдээллийг ОУИТБС-ын сүүлийн тайланд оруулсаныг сайшааж, сүм бүрээр мэдээллийг задлан харуулсан нь орон нутгийн дэд зөвлөлийн мэдээллийн хэрэгцээнд нийцсэн ажил болсон хэмээн үзэж байна. Зарим иргэний нийгмийн байгууллагууд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг байршлаар нь задлан харуулсаныг ихээхэн чухал хэмээн үзсэн ба орон нутгийн дэд зөвлөлийн мэдээллийн эрэлтийг хангахад мөн л чухал хэрэгцээтэй гэж үнэлжээ. Уулзан ярилцсан аль ч оролцогч тал нь газрын тосны үйлдвэрлэл, экспортын байршлыг ил тод болгосонтой холбоотой санал бодлоо илэрхийлээгүй.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү шаардлагыг ханган биелүүлэхэд хангалттай хэмжээний ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэж байна. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар дурдсан өмнөх тайлангуудаас илүү өргөн хүрээнд бэлтгэгджээ. Энэхүү тайлан нь абсолют болон харьцангуй утгаар олборлох салбарын хэмжээ, Засгийн газрын орлого, экспорт болон хөдөлмөр эрхлэлтэд салбарын эзлэх хувь зэргийг оруулжээ. Албан бус салбарын тухай тайлбар, үйлдвэрлэл явагдаж буй гол бүс нутгуудын тухай мэдээллийг мөн багтаажээ. Энэхүү мэдээллийг ОУИТБС-ын цахим мэдээллийн порталаар мөн дэлгэн харуулж байна. ОТОБ нь уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг ажилчдын хамаарах улс болон уурхай бүрээр (газрын тосны салбарыг оруулаагүй ч) гарган харуулсан нь ОУИТБС-ын шаардлагаас давсан хэмжээний мэдээлэл юм. Энэ нь үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт ашиглах хэрэгцээтэй, бодитой мэдээллийг ил тод болгоход ОУИТБС-ын тайланг хэрхэн ашиглаж болохыг харуулсан жишээ юм.

Хүснэгт 6 – Үнэлгээний тойм хүснэгт: Нийгэм, эдийн засгийн зарцуулалт

ОУИТБС-ын заалтууд	Гол үр дүнгийн тойм	Ажлын албаны зүгээс өгөх анхдагч үнэлгээ
Нийгмийн чиглэлтэй зардлууд (#6.1)	ОТОБ нь хэдийгээр нийгмийн чиглэл бүхий зардлуудыг дэлгэрэнгүй судлан үзэж, 2013 болон 2014 оны ОУИТБС-ын тайланд тусгасан ч заавал болон сайн дурын нийгмийн зардлуудын ялгааг тайлан гаргасан аж ахуйн нэгжүүд өөрийн ойлголтоор тайлбарлан оруулсан мэт харагдаж байна. Заавал шаардаглах	Тодорхой хэмжээнд ахиц гаргасан.

	нийгмийн зарцуулалтын мэдээллийн иж бүрэн байдал нь тодорхой бус харагдаж байна. Мөнгөн бус зардлуудыг тайлагнах байдал болон үндэслэлийг тайлбарлаагүй. Төрд үл хамаарах хүлээн авагчийн талаар мэдээлэл байхгүй байна.	
Төрийн өмчит компаниудын төсвийн шинжтэй зарцуулалт (#6.2)	ОУИТБС-ын 2014 оны тайлан нь зөвхөн төрийн өмчит нэг компанийн гаргасан төсвийн шинжтэй зардлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл багтаасан ба төсвийн шинжтэй зарцуулалтын үнэлгээг иж бүрэн хийсэн эсэх нь тодорхойгүй байна. Мөн хэд хэдэн төрийн өмчит компани дээр “орон нутгийн төсөвт төлсөн төлбөр”-ийн ангилал дээр эргэлзээтэйгээр ангилсан мэт харагдаж байна. Цахилгаан станцуудад төрийн өмчит компаниуд хямд нүүрс нийлүүлэн нөхөн олговор авдагаас өөр ийм төрлийн зардал байдаг эсэхийг ОТОБ нь судлан үзээгүй гэж ойлгогдож байна.	Ахиц дэвшил хангалтгүй.
Олборлох салбараас эдийн засагт үзүүлэх хувь нэмэр (#6.3)	2014 оны ОУИТБС-ын тайлан нь өмнөх тайлангууд дээрх эдийн засагт үзүүлэх хувь нэмрийн талаарх тайлбараас илүү өргөн хэмжээнд энэ мэдээллийг багтаажээ. Үүнд абсолют болон харьцангуй утгаар олборлох салбарын хэмжээ, Засгийн газрын орлого, экспорт, хөдөлмөр эрхлэлт дэхь хувь хэмжээг тусгасан байна.	Хангалттай хэмжээний ахиц дэвшил гарсан
<p>Зөвлөмжүүд:</p> <p>1. ОТОБ нь уул уурхайн салбарт татаас олгох болон төрийн өмчит компаниудын зүгээс төсвийн шинжтэй төлбөр хийх явдал байдаг болохыг судлан үзэх шаардлагатай байна. Эрчим хүчний салбарт хамаарах төрийн хүчин чармайлт, төсвийн удирдлагын шинэтгэлийн хүрээнд ОТОБ нь ОУИТБС-ын тайланг төрийн зүгээс шууд болон шууд бусаар олгож буй татаасыг тодорхой болгоход ашиглаж болно.</p> <p>2. ОТОБ нь заавал шаардагдах болон сайн дурын төлбөрүүдийг хэрхэн ялган ангилах талаар харилцан зөвшилцөх шаардлагатай байна.</p>		

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Хэсэг III – Үр дүн болон нөлөөлөл

7. Үр дүн болон нөлөөлөл

Энэхүү бүлэгт ОУИТБС-ын зүгээс санаачилгын үйл явцын үр дүн болон нөлөөлөлтэй холбоотой шаардлагын хэрэгжилт, биелэлтийн талаар дурдсан.

7.1 Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Мэдээлэл, харилцаа холбоо: 2016 оны 1-5 дугаар саруудад ОУИТБС-ын санхүүжилтад саад учирсан нь Ажлын албаны зүгээс хийх мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагаанд ихээхэн саад учруулсан ч зарим тодорхой ажлууд санхүүжилтгүй ч үргэлжлэн хэрэгжжээ. 2015 оны 12 дугаар сард олон нийтэд мэдээлэл түгээх гурван удаагийн арга хэмжээ зохион байгуулагдсан ба эдгээр нь ОУИТБС-ын тайланд үндсэндээ төвлөрсөн байв. Эдгээрийн тоонд 12 дугаар сарын 21-ний өдөр хийгдсэн сэтгүүлчдэд зориулсан арга хэмжээ (15 сэтгүүлч оролцсон), 23-ны өдөр хийгдсэн иргэний нийгмийнхэнд зориулсан арга хэмжээ (23 иргэний нийгмийн төлөөлөл оролцсон) болон 25-ны өдөр буюу Уурхайчдын баярын өдөр хийгдсэн компаниудад зориулагдсан арга хэмжээнээс (АМГ болон УУЯ зохион байгуулсан) бүрдэж байна. 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр ОУИТБС-ын тайлан гарсантай холбогдуулан Төрийн ордонд хэвлэлийн бага хурал зохион байгуулж, үүнд ойролцоогоор 15 орчим хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл хүрэлцэн иржээ. ОУИТБС-ын Ажлын алба нь 2014 оны хураангуй тайлан бэлтгэн, олон нийтэд хүргэжээ. Германы олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны газрын дэмжлэгтэйгээр ОУИТБС нь 2014 оны тайланд үндэслэн 4 аймгийн (Баянхонгор, Өвөрхангай, Увс, Сэлэнгэ) хураангуй тайланг 2016 оны 2 дугаар улиралд бэлтгэн гаргасан ч эдгээрийг 2016 оны 7 дугаар сарын байдлаар ОУИТБС-ын вебсайт дээр оруулаагүй байв.

ОУИТБС-ын Ажлын алба нь 2014¹⁵⁹ оны тайлан, ikon.mn вебсайтын үйлчилгээг ашиглан инфографик боловсруулж, ОУИТБС-ын вебсайт дээрх зураглалыг илүү сайжруулсан байна¹⁶⁰. Мэдээлэл түгээх, олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь ОУИТБС-ын цахим тайлангийн систем болон мэдээллийн порталд төвлөрчээ. Ажлын алба нь 2015 оны 11 сар болон 2016 оны 4 дүгээр сард сэтгүүлчдэд зориулсан сургалтыг мөн зохион байгуулжээ. Үүний зэрэгцээ ОУИТБС-ын ажиллуулдаг нийгмийн сүлжээнд мэдээлэл оруулах үйл ажиллагаа 2015, 2016 онуудад идэвхжиж санаачилгын зүгээс хэрэгжүүлж буй нээлттэй мэдээллийн хүртээмж болон Олон улсын 7 дугаар их хурал зэрэг олон улсын чанартай мэдээллийг ойр давтамжтайгаар байршуулах болжээ. Мөн 7 дугаар их хурлын үеэр Монголын талаас 2014 оны хураангуй тайлан, инфографик мэдээлэл болон календарь зэрэг сурталчилгааны материалуудыг тарааж ажилласан. ЕСБХБ нь өөрийн шинэчлэн баталсан Монгол улс дахь хөтөлбөрийн дагуу ОУИТБС-ын мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж буй бөгөөд тодорхой хэлбэл үндэсний болон орон нутгийн түвшинд бодлого боловсруулахад ОУИТБС-ын мэдээллийг ашиглах чиглэлд төвлөрч байна.

Өөрийн мэдээлэл, харилцаа холбооны стратегийн дагуу Ажлын алба нь ОУИТБС-ын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх хэвлэл мэдээллийн кампанит ажил хэрэгжүүлэхээр Монгол Масс Медиа групптэй 2013 оны сүүлээр гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу телевизийн 12 цуврал, таван

¹⁵⁹ <http://eitimongolia.mn/en/infographics>

¹⁶⁰ <http://e-reporting.eitimongolia.mn/>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

удаагийн ярилцлага болон www.news.mn вебсайт дээр таван удаагийн ярилцлага гаргах зэрэг үйл ажиллагааг тусгасан ба гурван удаагийн арга хэмжээг телевизээр шууд дамжуулжээ. Мөн телевизийн гол сувгууд болох Блумберг Монгол, TV9, TV8, Eagle TV болон Эко TV зэрэг сувгаар нэвтрүүлсэн байна. Мөн ажлын алба нь www.eitimongolia.mn вебсайтыг дахин ажиллуулж, үүнийг хэрэглэгчдэд илүү эвтэйхэн болгосноор ОУИТБС-ын тайлангуудын хэрэглээг нэмэгдүүлсэний дээр 2016 оны 2 дугаар сард Перу улсын Лима хотод болсон Олон улсын 7 дугаар их хурлаас өмнө шинээр вебсайт нээн ажиллуулжээ. Үүний хүрээнд 2012 оны тайлангийн мэдээллийг ашиглан инфографик боловсруулан, Монголын ОУИТБС-ын вебсайт болон www.ikon.mn сайтууд дээр байршуулжээ.

2015 онд Ажлын алба нь Үндэсний шуудан сонинтой гэрээ байгуулан 2013 оны ОУИТБС-ын тайлангаар гарсан үр дүнгийн талаар 5 нийтлэл хэвлүүлжээ (1- 6 дугаар саруудад сар бүр нэг). 2013 оны тайланд дурдагдсан бенефициар өмчлөлийн талаарх мэдээллээр 2015 оны эхээр инфографик бэлтгэн гаргажээ. Мөн Ажлын албанд холбоо барих мэдээлэл нь буй 400 гаруй байгууллагуудад 2014 оны 9 дүгээр сараас хойш сар тутмын мэдээллийн хуудсыг бэлтгэн хүргүүлж байна.

Монголын ОУИТБС нь мөн өөрийн нийгмийн сүлжээний харилцаа холбооны стратегийг хэрэгжүүлж байна. Ажлын албатай хийсэн уулзалт дээр Твиттер болон Фейсбук хуудсанд хамгийн багадаа сар тутам шинэчлэгдсэн мэдээлэл оруулдаг бол YouTube болон Фликер хуудсанд тухайн үед явагдаж буй арга хэмжээнээс хамааран мэдээлэл оруулдаг болохыг хэлж байв. 2016 оны 7 дугаар сарын 5-ны байдлаар 2014 оны 10 дугаар сараас хойш Фейсбук хуудсанд¹⁶¹ 398 дагагч, 2014 оны 6 дугаар сараас хойш Твиттер хуудсанд¹⁶² 210 дагагч буй бол YouTube¹⁶³ хуудсанд 15 видео, Фликер¹⁶⁴ хуудсанд 20 фото альбум байна. Фликерын хуудас нь ердөө гурван дагагчтай ч Ажлын албаны зүгээс энэхүү хуудсыг зөвхөн зураг оруулан, талуудад цахим шуудангаар мэдэгддэг тул зөвхөн дагагчдын тоо нь үүний хүртээмжийг бүрэн гаргах боломжгүй байж болно. ОУИТБС-ын Ажлын алба нь дотоодын хэвлэл мэдээллийн зөвлөх компани Максима Медиатай гэрээ байгуулан санаачилгын хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагааны хүртээмжийг судлахаар төлөвлөж байна.

Үндэсний зөвлөл, ОТОБ-ын хүсэлтээр мэдээлэл харилцаа холбооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хийгдэж, 2013 оны 12 дугаар сарын 13-ны ОТОБ-ын 34 хуралдаан дээр хэлэлцсэн судалгааны дүнгээр ОУИТБС-ын мэдээлэл түгээх үйл ажиллагаанд түлхүү анхаарал хандуулах шаардлагатай хэмээн дурдсан байна. Орон нутагт мэдээлэл түгээх болон хэрэгжүүлэх стратеги нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутагт түлхүү хэрэгжсэн байна. (Орон нутаг дахь хэрэгжилтийн талаар доор үзнэ үү). 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Монголын ОУИТБС-ын Ажлын алба болон Монголиан Майнинг Жоурналтай хамтран орон нутгийн 52 сэтгүүлчдэд сургалт хийж ОУИТБС-ын мэдээллийг хэрхэн хөрвүүлэх талаар сургажжээ.

Мэдээлэл түгээх: Ажлын алба нь сүүлийн жилүүдэд сургалт, мэдээлэл түгээх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж иржээ. 2016 оны эхний хагаст санхүүжилттэй холбоотой асуудал үүссэн ч мэдээлэл түгээх үйл ажиллагаа нь онлайн мэдээллийн портал дээр төвлөрөн үргэлжилж байсан. Уул уурхайн яамнаас Ажлын алба, Адам Смит Интернейшнл болон ЕСБХБ-тай хамтран 2016 оны 4 дүгээр сард шинээр боловсруулсан ОУИТБС-ын мэдээллийн порталын талаар 30 орчим сэтгүүлчид сургалт явуулжээ. Ажлын алба нь мөн академик болон дүн шинжилгээний судалгаанд зориулан мэдээлэл

¹⁶¹ <https://www.facebook.com/EITIMongolia/>

¹⁶² <https://twitter.com/eitimongolia>

¹⁶³ <https://www.youtube.com/user/eitimongoliamn/videos>

¹⁶⁴ <https://www.flickr.com/photos/123397335@N02/albums>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ханган өгөх үйл ажиллагааг үргэлжлүүлж, хамгийн сүүлд гэхэд 2016 оны 5 дугаар сард НҮБХХ болон Уул уурхайн яамны хамтран хийсэн Уул уурхайн салбарын авлигын эрсдлийн судалгаанд зориулан мэдээллээр ханган өгчээ.

2013 онд Ажлын алба болон ОТОБ хамтран Адам Смит Интернейшнл болон ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр Улаанбаатар хот болон дөрвөн аймагт (Дархан-Уул, Ховд, Говь-Алтай, Хэнтий) арга хэмжээ зохион байгуулан, 21 аймгаас ирсэн ойролцоогоор 700 гаруй хүнд хүрч ажиллажээ. Ажлын албаны тооцож буйгаар тус алба нь нийт 25 сургагч багш, 20 сэтгүүлчийг эдгээр арга хэмжээний үр дүнд бэлтгэжээ. Монгол улс нь нэг хэлтэй, хэл нь олон төрөл салбаргүй тул ямарваа нэгэн мэдээллийн үйл ажиллагаанд ихээхэн давуу талтай болохыг дурдах хэрэгтэй. Энэ нь мэдээлэл түгээх болон үндэсний хэмжээний олон нийтийн хэлэлцүүлгийг олборлох үйлдвэрлэлийн сэдвээр хийх боломжийг хангахад үр дүнтэй ч Монгол улсын хүн амын дийлэнх нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг ба хөдөө орон нутагт ажиллах нь дэд бүтцийн асуудлаас үүдэн хүндрэлтэй байдаг.

2014 онд ОТОБ болон Ажлын алба нь 9 суманд мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагааг явуулж нийт 619 хүнд хүрч ажиллажээ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд аймаг, сумын түвшний орон нутгийн хураангуй тайланг анх удаа бэлтгэн гаргажээ. 2014 болон 2015 онуудад нийтдээ 4 аймгийн хураангуй тайлан, 12 сум/дүүргийн тайланг гарган, нийт 4800 хувийг¹⁶⁵ тараажээ. 2016 онд Ажлын алба нь 4 аймаг, 6 сумын хураангуй тайланг гаргахад төлөвлөж байна. Германы хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага мөн 3 аймаг, сумын хураангуй тайланг гаргасан ба эдгээр нь 2013 оны тайланд суурилсан. Эдгээр тайланг Монголиан Майнинг Жоурнал гэрээний үндсэн дээр гүйцэтгэжээ. Улмаар тус байгууллагын зүгээс 2016 онд 4 аймгийн (Баянхонгор, Өвөрхангай, Увс болон Сэлэнгэ) 2014 оны тайлангийн хураангуйг хийж, 2016 оны 7-8 дугаар сард олон нийтэд хүргэх үйл ажиллагааг төлөвлөж байна.

ОУИТБС-ын Ажлын алба нь 2014 онд 5 аймгийн 9 суманд судалгаа хийж (120 хүний дүнд) 2015 онд мөн судалгааг гурван суманд (102 оролцогч) хийж, олборлох салбарын талаарх ямар мэдээлэл тэдэнд хүрч байгаа, ямар мэдээлэл хамгийн сонирхолтой байх талаар асууж, судалжээ. Судалгаанд хамрагдсан хүмүүс нь доорх сэдвүүдийг түлхүү нэрлэсэн ба үүнд байгаль орчны нөхөн сэргээлт (20%), хандив тусламж (25%), ажлын байр (15%), орон нутгийн хөгжлийн гэрээ (15%), татвар (10%), нөөц (10%), тусгай зөвшөөрөл (5%) болон бенефициар өмчлөлийг нэрлэжээ. 2015 онд Ажлын алба нь орон нутагт 4 удаагийн Нээлттэй өдрийн арга хэмжээ (3 дүүрэг, 1 аймаг), Баруун, Хойд болон Өмнөд бүсүүдэд 3 удаагийн бага хурлыг зохион байгуулсан ба 2016 онд Зүүн бүсэд мөн ийм арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү бага хурал нь харилцан суралцах, мэдээлэл хуваалцах боломжийг хангах зорилготой бол Нээлттэй өдрийн арга хэмжээ нь тухайн орон нутаг дахь уул уурхайн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх зорилготой байна.

2015 оны аймаг, сумдад зохион байгуулагдсан хэлэлцүүлэг нь доорх гурван гол сэдвийг хамран, олон дахин зохион байгуулах эрэлттэй арга хэмжээ болсоныг Ажлын алба дурдаж байв.

- Уул уурхайн тодорхой үйл ажиллагааны цаг хугацаа болон хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөлөл
- Тусгай зөвшөөрөл олгох үйл явц
- Уул уурхайгаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл (үсны хэрэглээ болон хөдөө аж ахуйд

¹⁶⁵ Ажлын албаны Мэдээлэл харилцааны ажилтан Дэлгэрмаатай хийсэн ярилцлага, болон Үндэсний форумын баримт бичиг, 2015/11/3.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

үзүүлэх нөлөөлөл) болон байгаль орчны доройтлын эсрэг төрийн авч буй арга хэмжээ.

Ажлын алба 2014, 20445 онуудад хэд хэдэн удаагийн олон улсын болон дотоодын арга хэмжээнд оролцон сурталчилгааны материал тараасан ба үүнд Коул Транс форум, Дисковер Монголиа хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, Уул уурхайн яамны Нээлттэй өдрүүд зэрэг арга хэмжээ байна. Ажлын алба нь мөн 2015 онд оролцогч талын бүлэг бүрт сургалт хийжээ. 4 дүгээр сард иргэний нийгмийн талуудад (ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөл) сургалт хийн 2013 оны ОУИТБС-ын тайлангаас хэрхэн мэдээлэл ашиглах, Эксел програм ашиглах зэрэг сэдвээр ярилцжээ. 2 болон 3 дугаар саруудад засгийн газар болон компаниудад зориулсан сургалтыг хийж 2013 оны тайлангийн тухай мэдээлэл өгч, ил тод болгох үйл ажиллагааны чанарыг хэрхэн сайжруулах талаар хэлэлцсэн байна.

Засгийн газрын #222 дугаар тогтоолоор ОУИТБС-ын тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд жил тутам гарган өгч байхаар заасан ч хэрэг дээрээ энэхүү заалт хэрэгжээгүй байна. Ажлын албанаас хэлж буйгаар УИХ-д чухам хэн нь (Төрийн нарийн бичгийн дарга, Уул уурхайн сайд) өргөн мэдүүлэх нь тодорхойгүй буйгаас үүдэлтэй гэж буй ч зарим иргэний нийгмийн байгууллагын зүгээс Үндэсний зөвлөлийн дарга болохын хувьд энэхүү үүргийг Ерөнхий сайд хүлээх нь тодорхой гэж үзэж байна. Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн зүгээс 2014 оны 12 сар, 2015 оны 3 дугаар саруудад УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад сургалт явуулж, олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаар ярилцсан ба үүнд ОУИТБС-ын тухай модуль мөн багтжээ.

Орон нутаг дахь хэрэгжилт: 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын #222 тоот тогтоолд бүх аймаг, суманд ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлийг байгуулах тухай заасан байдаг. Монгол улсын бүх 21 аймагт уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй бөгөөд нийт 329 сумын 103 дээр нь уул уурхайн үйл ажиллагаа хэрэгжиж байна. Аймагуудын төвд очиж ажиллахад дэд бүтцийн асуудал гардагаас үүдэн орон нутгийн дэд зөвлөлүүдийг байгуулах нь олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэхэд чухал ач холбогдолтой юм. 2015 оны дунд үе гэхэд 20 аймаг, 14 сум өөрийн дэд зөвлөлийг байгуулсан гэж ТАН эвсэл мэдэгдэж буй ч Ажлын алба эдгээр дэд зөвлөлийг байгуулсан тухай албан ёсны тогтоолыг бүгдийг нь хараахан аваагүй байна (Бүх 20 аймгаас авсан ч дөнгөж 7 сум тогтоолоо ирүүлжээ). Засгийн газрын тогтоол нь дэд зөвлөл байгуулах орон нутгийн захиргааны үүрэг, ролийг тодорхой заасан ба үүний 11.2 дугаар заалт нь дэд зөвлөлд бүх гурван талын төлөөлөл тэгш тоотой байх ёстойг тусгажээ. Аймаг, сумын түвшин дэх дэд зөвлөлийн үүрэг нь ОУИТБС-ын тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн захиргаа, олон нийт болон компаниудын хоорондын хэлэлцүүлгийг өрнүүлэх, ОУИТБС-ыг орон нутагт урагшлуулах, орон нутгийн хөгжлийн асуудлуудыг шийдэхэд хувь нэмэр оруулах явдал юм. Тогтоолоор дэд зөвлөлийн чиг үүрэг, дэд зөвлөл хоорондын болон Үндэсний зөвлөл, ОТОБ хоорондын харилцаа, санхүүжилтын эх үүсвэр зэргийг шууд заагаагүй. Гэхдээ тогтоол нь тайлангийн маягуудад дурдсанаас гадуурх өөр төрлийн мэдээллийг ил тод болгох, байгаль орчны нөхөн сэргээлтийн сан, үүний зарцуулалтыг хянах зэрэг үйл ажиллагааг явуулах боломжтой. Дэд зөвлөлийн хуралдаан хийж буй байдал аймаг, сумаараа ялгаатай буй бөгөөд зарим дэд зөвлөл сар тутам, зарим нь арай хол хугацаанд хуралдаж байна. Бидний уулзан ярилцсан 20 дэд зөвлөлийн гишүүдийн хэлсэнээр сум жижигхэн тул хурал зохион байгуулахад хялбар байдаг ажээ.

Зохион байгуулалтын асуудалтай буй ч орон нутгийн захиргаа болон иргэний нийгмийг төлөөлсөн 20 төлөөлөлтэй бид уулзан ярилцсан ба төрийн байгууллагууд болон компаниудын хандлагад гарч буй өөрчлөлтийн талаар хэлж байв. Тэдгээр орон нутгийн төлөөлөл өмнө нь уул уурхайгаас орон нутагт үзүүлж буй нөлөөллийг анхаардаггүй байсан ч одоо орон нутгийн иргэдийн сонирхол, эрх

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ашигт түлхүү анхаарал хандуулдаг болсон хэмээн хэлж байв. Орон нутгийн иргэд одоо тухайн орон нутагт олгосон тусгай зөвшөөрлийн тооны талаар мэдээлэлтэй болсон бол өмнө нь энэ талаар зөвхөн Засаг даргад л мэдээлэл байдаг байжээ. Тэдний хэлсэнээр орон нутгийн дэд зөвлөлийн хэлэлцүүлгийн гол сэдэв нь ажлын Албаны үзэж буйтай ижилхэн, доорх сэдвүүд байна:

- Тусгай зөвшөөрөл олгох үйл явц
- Компани болон нутгийн захиргаадын хооронд хийсэн орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ

2016 оны ажлын төлөвлөгөөндөө Ажлын алба нь 4 аймаг, 6 сумын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг тусган, ОУИТБС-ын аймаг болон сумдын дэд зөвлөлийн чиг үүрэг хоорондын эрх зүйн ялгаатай байдлыг тодорхой болгох зорилт дэвшүүлжээ. ЕСБХБ нь ОУИТБС-ын чиглэлээр туршилтын төсөл хэрэгжүүлэх сумдыг сонгон авч ажиллахаар төлөвлөж байна. 2016 оны ажлын төлөвлөгөөнд орон нутаг дахь мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагааг иргэний нийгэм тэргүүлэн ажиллахаар тусган, ТАН эвсэлийн зүгээс орон нутагт хийж гүйцэтгэх үйл ажиллагаан дээр талууд зөвшилцөлд хүрсэн байна.

Оролцогч талуудын санал бодол

ОУИТБС-ын үйл ажиллагаанд ойр оролцдог төрийн өндөр тушаалтан хэлэхдээ ОУИТБС-ын тайлангуудыг УИХ-ын бүх гишүүдэд системтэйгээр тараасан ч УИХ-д албан ёсоор өргөн мэдүүлээгүй байна. Тиймээс УИХ-ын гишүүд тайлангуудыг бараг уншаагүй байх магадлалтай буй учир нь цаг давчуу, тайлангууд нь маш том зэргээс хамаарч байж болно. Мөн ОУИТБС-ын тайлангууд нь хэлэлцүүлэг өрнүүлээгүй хэмээн зарим талууд үзэж байв. Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь бодлогын судалгааны тинк танк байгууллагатай гэрээ хийн мэдээлэл эмхлэн ашиглах зөвлөмж гарч байсан ч санхүүгийн асуудлаас үүдэн боломжгүй болжээ. Компанийг төлөөлсөн 2 хүн Ажлын хэсэг эвсэл ОТОБ нь тайланд дурдагдсан мэдээллийг эрэмбэлэн, инфографик түлхүү ашиглах замаар олон нийтэд мэдээллийг түлхүү хүртээмжтэй болгох санал гаргасан. Иргэний нийгмийн төлөөллийн зүгээс 2016 оны ажлын төлөвлөгөөнд мэдээллийг ашиглахад түлхүү анхаарал хандуулсаныг тэмдэглэн хэлсэн. Иргэний нийгмийн нэг байгууллагын хэлсэнээр мэдээлэл түгээхэд оролцох замаар Засгийн газар санаачилгыг хэрэгжүүлэх хүсэлтэй буйгаа илтгэн харуулах шаардлагатай бөгөөд үүнийг төрийн өмчит Олон нийтийн радио, телевизийг ашиглан хийх боломжтой хэмээн үзэж байна. Тухайн хүний хэлсэнчлэн олон нийтэд мэдээлэл хүргэн тусдаа арга хэмжээнээс илүүтэйгээр зар сурталчилгаа хэлбэрээр хийвэл мэдээлэл илүү үр дүнтэй хүрнэ гэж үзэж байна.

Салбарын төлөөллийн зүгээс Монголын уул уурхайн үндэсний ассоциаци нь өөрөө ОУИТБС-ын тайланг ашигладаггүй, чадавхи муутай бөгөөд нийт ажилтны тоо нь 2012 онд эдийн засгийн нөхцөл хүндэрсэнээс үүдэн 4 хүртэл багассан болохыг дурдсан. Салбарын төлөөллийн зүгээс компаниуд ОУИТБС-аар дамжуулан мэдээллээ ил тод болгож буй тул үр дүн харагдаж байх ёстой, олон нийтийн харилцаа хариуцсан ажилтнуудтай энэ талаар зөвлөлдөж байх шаардлагатай хэмээн үзжээ.

Компаниудыг төлөөлсөн хэд хэдэн хүний үзэж буйгаар хэрэв мэдээлэл түгээх үйл ажиллагаанд компаниуд оролцвол олон нийт уул уурхайн компаниудад итгэл муутай тул ОУИТБС-ын мэдээлэлд итгэл алдрах эрсдэлтэй гэж үзэж байна. Оюу Толгой ХХК 2014 онд ОУИТБС-ын мэдээллийг агуулсан, мөн өөрийн онооны карт бүхий сонин гаргасан байна. Уулзан зөвлөлдсөн газрын тос, байгалийн хийн компаниуд нь өөрсдөө орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулдаг ч ОУИТБС-ын мэдээллийг ашигладаггүй, харин өөрийн мэдээлэлдээ илүү найддаг ажээ. ОУИТБС-ын хувьд тайлан гаргах болон тоон дээр түлхүү төвлөрдөг ба харин мэдээлэлд дүн шинжилгээг хамаагүй бага

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

түвшинд хийдэг хэмээн үзэж байна. Том хүснэгт бүхий их хэмжээний мэдээлэл харсан олон нийт тухайн компаниуд ил тод бус хэвээр байгаа гэсэн бодолтой үлдэнэ гэж тэд үзжээ. Тиймээс ОУИТБС-ын мэдээлэлд илүү ихээр дүн шинжилгээ хийж, хураангуй тайлан, товхимол зэргийг ашиглах нь зүйтэй.

Уулзаж ярилцсан иргэний нийгмийн байгууллагууд үзэхдээ иргэний нийгмийн байгууллагууд л тайлангуудыг ашигладаг ба сэтгүүлчид зэрэг бусад талуудаас иргэний нийгэм илүү ашиглаж буй бөгөөд орон нутагт мэдээлэл түгээхдээ хураангуй тайлан ашиглах нь илүү үр дүнтэй гэдэгт санал нэгдэж байна. Иргэний нийгмийн нэг төлөөлөл хэлэхдээ нэг том тайлан хэвлэн нийтлэх нь үр дүн муутай тул ОУИТБС нь зөвхөн орон нутгийн тайланг аймаг, сумаар нь бэлтгэн гаргах нь илүү эрэлтэд нийцнэ хэмээн үзэж байна.

Уулзан ярилцсан дэд зөвлөлийн гишүүд хэлэхдээ ОУИТБС-ын мэдээлэл авдаг ганц боломж нь орон нутагт болдог Нээлттэй өдрүүд гэж хэлсэн. Уулзан ярилцсан хэвлэл мэдээллийн төлөөлөл хэлэхдээ хэрэв судалж үз л гэж зааварчилгаа өгөөгүй бол ихэнх хэвлэл мэдээлэл ОУИТБС-ын вебсайт руу орохгүй гэжээ. ОУИТБС-ын мэдээллийг түгээх хураангуй тайлан, вебсайт, мэдээллийн портал болон нийгмийн сүлжээий сувгаас гадна хэд хэдэн суваг байгаа гэж үзэж байна. ОУИТБС-ын тайлан нь жилд нэг удаа гарч, хэвлэгддэг ч үүнийг эргэн ашиглах нь маш доогуур байна. Монгол улс нь нэг хүнд ноогдох хэвлэл мэдээллийн тоогоор ихээхэн өндөр бөгөөд ялангуяа нийгмийн сүлжээ өргөн тархсан юм. ОУИТБС-ын мэдээллийг түгээхэд одоо гаргаж буй сар тутмын мэдээллийн хуудаснаас илүүтэйгээр нийгмийн сүлжээг ашиглаж, олон нийтийг хэлэлцүүлэгт татан оруулах боломжтой гэж зарим хүмүүс үзэж байна. Мөн талуудын хэлсэнээр олон салбараар сэтгүүлчдийн сүлжээ үйл ажиллагаа явуулж буй бөгөөд үүгээр дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэж болно гэж үзэж байна. Үүний нэгэн адил сүлжээг ОУИТБС болон ТАН эвсэл мөн үүсгэж болно. Иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн хэлсэнээр улс төрийн хамаарал бүхий хүмүүс жил тутмын 2 сард гаргадаг хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой иргэдийн “гайхширал” болон ОУИТБС-ын тайлангийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг явагдахгүй буй хоёрыг ижилсүүлэн ярьж байна (нийт 10000 мэдүүлгээс 200-г нь ил болгосон).

Иргэний нийгмийн зарим төлөөлөл зарим сумд дахь дэд зөвлөл дэхь иргэний нийгмийн оролцоо бага буйг дурдсан. Гэхдээ дэд зөвлөлийн төлөөллийн хэлсэнээр зарим тохиолдолд дэд зөвлөлд орох хүсэлтэй иргэний нийгмийн байгууллага байхгүй ажээ. Ийм тохиолдолд өөр иргэний нийгмийн байгууллагыг (ТАН болон Байгаль орчны иргэний зөвлөлд хамрагддаггүй) урьдаг ба эдгээр нь үндсэндээ ахмадын, залуучуудын болон эмэгтэйчүүдийн байгууллагууд байдаг ажээ. Орон нутгийн дэд зөвлөл дэхь иргэний нийгмийн зарим төлөөллийн үзэж буйгаар тэдний сумын дэд зөвлөлд компанийн төлөөлөл байхгүй, ОУИТБС-ын тайланг түгээхэд л компанийн төлөөлөлтэй уулздаг байна. Хэвлэл мэдээллийн зарим төлөөлөл хэлэхдээ орон нутгийн түвшинд ихээхэн хэмжээний хэлэлцүүлэг хийгдэж буй бөгөөд орон нутгийн ИТХ дээр илүү анхааран ажиллах хэрэгтэй гэсэн зөвлөмж өгч байна. Ашигт малтмалын хуулийн дагуу шинээр тусгай зөвшөөрөл авахад орон нутгийн ИТХ-тай зөвшилцсөн байхыг шаарддаг ч ИТХ нь тэр бүр хуралддаггүй байна. Энэ нь уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагаан дээр компаниудтай зөвлөлдөхөд орон нутаг нь ОУИТБС-ыг ашиглах боломжтойг харуулж байна. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын зүгээс дэд зөвлөлийн гол ажил нь орон нутагт ажлын байр бий болгох, байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, тусгай зөвшөөрөл болон хайгуулын тусгай зөвшөөрлийн эзэмшил зэрэг асуудал байна хэмээж байна.

Анхдагч үнэлгээ

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Олон улсын Ажлын албаны зүгээс энэхүү шаардлагыг ханган биелүүлэхэд Монгол улс нь хангалттай ахиц дэвшил гаргасан гэж дүгнэж байна. ОТОБ нь гарч буй тайлангууд иж бүрэн байхад анхаарал хандуулж, тайланг идэвхтэй сурталчлан, олон нийтэд түгээж байна. Орон нутагт мэдээлэл түгээх үйл ажиллагаа зохион байгуулж, орон нутгийн дэд зөвлөлийг байгуулсанаар Монголын ОУИТБС нь олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах, ялангуяа аймаг, сумын түвшинд хувь нэмэр оруулж байна. Олон нийтийн хэлэлцүүлэг нь ОУИТБС-ын тайлангаас авсан тусгай зөвшөөрөл, нийгмийн шинжтэй зарцуулалт, байгаль орчин зэрэг мэдээллийг ашиглахын зэрэгцээ ОУИТБС нь уул уурхайн салбарыг хэрхэн удирдах тухай хэлэлцүүлгийн платформ болоод байна. ОТОБ нь орон нутгийн дэд зөвлөлүүд үндэсний хэмжээний үүлзалтад оролцох, өөрсдийн саналыг хүргэх, тэдний санал тусгагдах боломжийг хангасан албан ёсны механизмыг бий болгох талаар судлан үзэх шаардлагатай байна.

7.2 Мэдээллийн хүртээмж (#7.2)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь хэдэн жилийн туршид ОУИТБС-ын мэдээллийг хүснэгт хэлбэрээр өөрийн вебсайт дээр байршуулж байна. Өмнө хийгдсэн бүх тайлангийн тойм мэдээлэл нь засгийн газрын¹⁶⁶ болон компанийн¹⁶⁷ тайлан бүрээр гаргасан буй юм. Хураангуй тайлангууд нь 2013 болон 2014 оны ОУИТБС-ын тайлан дээр суурилсан ба 4 аймаг, 12 сумыг хамарч байна (дээр үзнэ үү).

ННФ нь мөн Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнтэй хамтран гэрээний портал сайтыг үүсгэхээр ажиллаж буй бөгөөд энэхүү портал нь ННФ-ын вебсайт дээр байх ч Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн эх кодыг www.resourcecontracts.org ашиглан газрын тосны Бүтээгдэхүүн хуваах 20 гэрээг ОТОБ дээр гэрээний ил тод байдлын тухай хэлэлцсэний үр дүнд юуны өмнө ил тод болгох юм. Гэрээний порталыг 2016 оны 8 дугаар сард нээх бөгөөд Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн портал www.resourcecontracts.org дээр буй гэрээг мөн оруулах юм. ТАН эвсэл нь 2015 оны 11 дүгээр сард¹⁶⁸ ОУИТБС-ын мэдээллийг ашиглах талаар сэтгүүлчдэд сургалт явуулжээ.

Монголын ОУИТБС-д мөн ЕСБХБ-ны зүгээс цахим тайлангийн¹⁶⁹ платформ боловсруулах чиглэлээр дэмжлэг үзүүлж буй бөгөөд энэ нь мэдээлэл ил тод болгох үйл ажиллагааг автоматжуулах, олон нийтэд мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилготой билээ. Улмаар энэхүү систем нь хэрэглэгчид илүү мэдээлэлтэй болж, уул уурхайн компаниуд болон төртэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд нь түлхэц болж өгөх юм. Тус төслийн эхний шатыг Адам Смит Интернейшнл дотоодын програм хангамжийн компани болон Интерактив ХХК-тай хамтран хэрэгжүүлж, 2015 оны 1 дүгээр сард нээсэн. Төслийн зорилго нь тайлан гаргах үйл явцыг үр дүнтэй болгох, ялангуяа Засгийн газар болон компанийн тайланг нэгтгэх болон гаргахад дэмжлэг үзүүлэх явдал юм. Тус систем нь мэдээллийг кодлон, цахим хэлбэрээр хадгалах ба аюулгүй байршилд хадгална. Цахим тайлангийн систем нь доорх зүйлсийг хангаж байна:

- Компани болон төрийн байгууллагууд ОУИТБС-ын тайланг онлайн хүргүүлэх
- Гүүглын хиймэл дагуулын зурагт суурилсан лицензийн кадастрын зураг

¹⁶⁶ <http://www.eitimongolia.mn/en/government-reports>

¹⁶⁷ <http://www.eitimongolia.mn/en/companies-reports>

¹⁶⁸ <http://www.publishwhatyoupay.org/pwyp-news/big-data-ready-set-go/>

¹⁶⁹ <http://e-reporting.eitimongolia.mn>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

- Олборлох салбарын компаниудад зориулсан онлайн мэдээлэл илгээх модуль
- Төрийн байгууллагуудад зориулсан онлайн мэдээлэл илгээр модуль
- Хараат бус нэгтгэгчид зориулсан нэгтгэн тулгалтын модуль болон мэдээлэл засах модуль
- ОУИТБС-ын мэдээлэлд дүн шинжилгээ хийн нийтэд харуулах мэдээллийн портал

Цахим тайлангийн системийг 2014 оны ОУИТБС-ын тайланд зориулан анх удаа хэрэглэсэн ба үүнд 987 компани болон төрийн 35 байгууллагын мэдээллийг хамруулан, тайлангуудыг нь онлайн байдлаар авч байна. Систем дээр бүх харилцагч 2015 оны 3 дугаар сарын 31 гэхэд мэдээллээ ирүүлсэн байх хугацаа заажээ. Төрийн байгууллагууд нийт 1570 компаниар мэдээлэл гарган өгчээ. Мэдээлэл гарган өгсөн л бол бүгд олон нийтэд нээлттэй болж, хэрэглэгч нар компанийн нэр, ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрлийн дугаар зэргээр хайлт хийн үзэх боломжтой болно. Энэ нь мэдээллийн цаг хугацаандаа байхыг баталгаажуулж, олон нийтийн хүртээмжийг нэмэгдүүлж буй юм.

Цахим тайлагналын төслийн 2 дугаар шат нь 8 дугаар сарын 25-нд эхэлсэн бөгөөд хуваарь ёсоор 2016 оны 12 дугаар сард дууссан байх ёстой. Хоёрдугаар шатны гол зорилтууд нь:

- Туршилтын шатны цахим тайлагналын тухай хэвлэн нийтлэх боломжтой, өндөр чанарын кейс судалгаа хийх – энэ нь тухайн системийг ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй бусад орнуудад дэлгэрүүлэх анхны алхам болно.
- Тайлангийн маягтууд, талбай болон тодорхойлолтуудыг (туслах цэс гэх мэт) дахин боловсруулан, шинэ дизайнд оруулах, сонголтот хэлбэрээр мэдээлэл явуулах боломжийг хангах Redesigned reporting forms, field/definitions (online help files), and alternative submission proposals.
- 2015 оны тайлагналын хугацаанд эрэлтэд суурилсан байнгын дэмжлэг үзүүлэх.
- Сонгосон түүлийг (багаж) харуулахын тулд хуучин мэдээллүүдийг ачаалан оруулах.
- Мэдээлэл оруулах/уялдуулан нэгтгэх болон мэдээллийн санг автоматаар шинэчлэх боломжийг хангах. Татварын ерөнхий газрын мэдээллийн сантай Үндэсний дата төвөөр дамжин холбогдох тухай хэдийн зөвшилцөлд хүрсэн. Харин АМГ дээр байгаа 4 тусдаа, харилцан үл ажилладаг мэдээллийн сангуудтай холбогдох нь урт хугацаа шаардах ба гэхдээ Дэлхийн Банкны зүгээс АМГ-ын 4 санг Үндэсний дата төв дээр нэгтгэх талаарх үнэлгээг 2015 оны 11 дүгээр сард хийж байсан.
- Нэгтгэл хийх үйл явцад өөрчлөлт оруулан шилжүүлэг нэг бүр дээр гүнзгийрүүлэн судлах сонголтыг оруулан, Хараат бус нэгтгэгчийн сонгосон тайланг автоматаар гаргах боломжийг хангах.
- Байгаль орчны мэдээлэл зэрэг нэмэлт өгөгдлийн багцийг оруулах.
- Бүх мэдээллийг (эсвэл сонгосон мэдээллийг) XML/XSD програмд экспортлон харуулах.
- Демонстратор багажийг сонгох, авах болон хэрэглэх, мэдээлийг хүснэгт, график, кадастрын мэдээллээр өөрчлөх, үүсгэх боломжийг хангах.
- Үйл явцыг тайлбарлахын тулд Эксел дээрх загвар өгөгдлийг задлан харуулах документийг төлөвлөн гаргах, XML/XSD болон демонстратор програм ашиглан импортлох.
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, материалууд болон саналын хуудас зэргийг бэлтгэх.
- Админ модулийн тайлагнах хэсгийг сайжруулах, хүснэгт, график болон газрын зургийг

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан
автоматаар үүсгэдэг болгох (хэрэглэгчийн байршлыг харуулан).

2016 оны 4 дүгээр сарын 20 орчимд Ажлын албанаас ЕСБХБ болон Адам Смит Интернейшнл, Уул уурхайн яамтай хамтран, 30 орчим сэтгүүлчдэд шинээр гаргасан цахим тайлагналын тухай семинар хийснээр төсөл нь оргил үедээ хүрсэн байна. 2006- 2014 онуудын хуучин мэдээллийг нөхөн оруулсанаар төсөл нь Татварын ерөнхий газрын мэдээллийн сантай холбогдоход бэлэн болох ба энэ нь автоматаар мэдээлэл солилцох боломжийг хангана. АМГ нь мэдээлэл солилцохоос татгалзаж байсан ч кадастрын мэдээллийг цаасан хэлбэрээр сар тутам авч байхаар тохиролцсон. 2016 онд буй төслийн үлдэх 8 сарын хугацаанд хэрэглэгчийн аппликейшн болон дүрсжүүлэх/дүн шинжилгээ хийх функц дээр төвлөрөх болно.

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагуудын хэд хэдэн төлөөлөл ОУИТБС-ын мэдээллийг ажилдаа ашигладаггүй гэсэн болон Орлогын хэлтэс болон УСГ-ын төлөөлөл ОУИТБС-ын мэдээллийг орлогын мэдээлэл нэгтгэх болон ДНБ-ийг тооцоход ашиглаж байна. 2014 онд Шилэн дансны тухай хууль гарсанаар 2015 оны эхээр хийгдсэн хууль бус төлбөрүүд ил болж, мөрдөн шалгалт явагдсан ч ОУИТБС-ын мэдээллээс үүдэн ийм мөрдлөгө хийгдсэн тохиолдол байхгүй. Төрийн байгууллагын нэг ажилтан хэлэхдээ тэрээр өөрийн ажилдаа ОУИТБС-ын мэдээллийг ашигладаг бөгөөд өөрийнх нь газрын боловсруулсан статистик мэдээг шалгахад ашигладаг байна. Үндэсний аудитын газрын нэг ажилтан хэлэхдээ тэрээр ОУИТБС-ын мэдээллийг төрийн өмчит компанитай ажиллахдаа ашигладаг ч аудиторуудад албан ёсны тоо хэрэгтэй тул ОУИТБС-ын мэдээллийг албан ёсны гэж үздэггүй, мөн найдвартай байдалд нь эргэлздэг болохоо хэлж байсан. Иргэний нийгмийн байгууллагууд ч мөн Сангийн яам зэрэг байгууллагууд ОУИТБС-ын мэдээллийг ашигладаг гэдэгт эргэлзэж байсан ч ТАН эвсэлийн 2013 оны хэрэгжүүлсэн “өгөгдлийн уурхай” төсөл нь ОУИТБС-ын мэдээллийг ашигласан тухай дурдаж байв. Уулзан ярилцсан салбарын төлөөлөл хэлэхдээ тэд ОУИТБС-ын мэдээллийг ашигладаггүй бөгөөд учир нь тухайн мэдээлэл цаг хугацааны хувьд хоцрогдсон байдаг ажээ. Эдгээр төлөөллийн үзэж буйгаар орон нутгийн хураангуй тайлан гаргасан нь сайшаалтай ч энэхүүд мэдээллийг аймаг, сумдад буй иргэдэд хүргэхэд хангалттай хүчин чармайлт гаргахгүй буй ажээ. Орон нутгийн хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс хайгуулын тусгай зөвшөөрлийн хууль ёсны эзэмшигчийн талаар ОУИТБС-ын гарган өгч буй мэдээлэл нь нутгийн иргэд болон захиргаанд ихээхэн тустай мэдээлэл бөгөөд тэдгээр талууд нутагт нь хичнээн компани үйл ажиллагаа явуулж буйг ч мэддэггүй ажээ.

Хэвлэл мэдээллийн зарим төлөөлөл мөн ОУИТБС-ын тайлан нь иргэдийн хувьд ихээхэн хэрэгцээтэй мэдээлэл агуулдаг ч олон тооны хүснэгт дундаас авч хэрэглэхэд маш хүндрэлтэй байдаг ажээ. Монголын ОУИТБС-ын зүгээс орон нутгийн хураангуй тайлан бэлтгэн гаргахаар үйл ажиллагаа явуулж буй нь мэдээллийг тэдгээр хүмүүст хүртээмжтэй болгоход тустай үйл ажиллагаа болсон ажээ. Тус тайланг гаргахдаа мэдээллийг энгийн байдлаар оруулан, инфографик ашиглаж, хаана амьдарч буйгаас нь хамааруулан иргэдийн хэрэгцээнд зориулсан байна.

Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн мэдээллийн систем болон ОУИТБС-ын мэдээллийн портал хоорондын уялдаа холбоо гол асуудал болж буйг хэлж байлаа. Эх үүсвэрээсээ хамааран эдгээр системийн мэдээлэл нийцэхгүй байх зэрэг асуудал гарч буй бөгөөд 2014 оны ОУИТБС-ын тайланд хамаарах төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн линкийг оруулсан ч тэдгээрийг харилцан холбох үйл ажиллагааг 2016 онд хийхээр төлөвлөж байна. уулзан чрилцсан бүх оролцогч талууд ОУИТБС-ын мэдээллийн портал нь өмнө зөвхөн АМГ-ын вебсайтаас авч болдог байсан мэдээллийг илүү хүртээмжтэй болгон, олон талуудад хүргэж буй хэмээн магтаж байна.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Ялангуяа иргэний нийгмийн байгууллагууд хэлэхдээ энэхүү мэдээллийн портал нь иргэний нийгмийн санааг зовоож буй гол асуудал болох ОУИТБС-ын мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүгээс ОТОБ нь ОУИТБС-ын тайланг хүртээмжтэй болгохын тулд ихээхэн өндөр хэмжээний ахиц дэвшил гаргасан гэж үзсэн. ОУИТБС-ын мэдээллийн портал нь энэхүү мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгож, байршилд суурилсан хайлт хийх боломжийг хангаснаар үр дүнтэй болжээ.

7.3 Сургамжууд, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь (#7.3)

Ахиц дэвшлийг баримтжуулсан нь

Үндэсний зөвлөл болон ОТОБ нь 2014 оны ОУИТБС-ын тайлан, хэлий ерөнхий ч гэсэн 11 дүгээр сард хийгдсэн туршилтын үнэлгээний тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэлэлцжээ. ОТОБ нь 2015 оны 12 сарын 11-ний хурлаараа ОУИТБС-ын 2014 оны тайлангийн төсөлд дурдсан зарим зөвлөмжүүдийг мөн хэлэлцсэн байна.¹⁷⁰ Энэхүү хэлэлцүүлэг нь Хараат бус нэгтгэгчийн ажлыг эрт эхлүүлэх, ингэснээр цахим тайлангийн системийн мэдээллийг аль болох эрт авах болон мэдээллийн бодит байдлыг хангахын тулд цахим тайлангийн системд иж бүрэн үнэлгээ хийх зэрэг дээр төвлөрсөн байна. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс туршилтын баталгаажуулалтын тайлан нь ерөнхий зөвлөмжүүдийг өгсөн тухай дурдаж байсан ч хэлэлцүүлэг дээр эдгээрээс алийг нь ч багтаагаагүй байна.

Үндэсний зөвлөл нь 2014 оны ОУИТБС-ын тайланд өгсөн зөвлөмжүүдийг судлан үзэж, 2015, оны 12 сарын 18-ны хурлаараа хэлэлцсэн¹⁷¹ ба энэ хурал дээр нэгтгэгч мөн танилцуулга хийсэн байна. Иргэний нийгмийн хэд хэдэн төлөөлөл нэгтгэгчийг эртнээс ажиллуулж эхлэх зөвлөмжийг дэмжиж байна. Үндэсний зөвлөл нь 2014 оны тайланд дурдсан бүхий 12 зөвлөмжийг хэрэгжүүлэх болсон ч Ажлын алба нь нийт 12 зөвлөмжийн 11-ийг нь хэрэгжүүлэх үүрэг ноогдсон байна. Үндэсний зөвлөл нь туршилтын баталгаажуулалт 2015 оны 11 сард хийгдсэнийг анхаарч үзсэн тул энэхүү тайланд дурдсан зөвлөмжүүдийн талаар ямар нэгэн хэлэлцүүлэг хийгдээгүй байна.

ОУИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөө нь¹⁷² 2014 оны тайлан, туршилтын баталгаажуулалтын тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг багтаасан ч үндсэндээ ерөнхий байдлаар дурдсан байна. Ажлын төлөвлөгөөний 10 дугаар үйл ажиллагаа нь Баталгаажуулалтад бэлтгэх, зохион байгуулах, үр дүнгээ Үндэсний зөвлөлд гарган өгөх, хэлэлцүүлэг хийх болон нэмэлт үйл ажиллагааг зэрэг тодорхой бус ажлыг туршилтын баталгаажуулалтын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зориулан оруулсан байна. Шаардлага 1.5.c.iv дээр 2016 оны 12 дугаар сараас үйл ажиллагаа эхлэхээс өмнө ОТОБ нь ОУИТБС-ын тайлан болон Баталгаажуулалтын тайланд буй гол зөвлөмжүүдийг 2017 оны ажлын төлөвлөгөөндөө тусгах шаардлагатай.

¹⁷⁰ http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/AH_39_20151211_en.pdf

¹⁷¹ http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_15_20151218_en.pdf

¹⁷² <http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/wokplanandreport/Mongolia%20EITI%202016%20Workplan%20in%20English.pdf>

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

2015 ажлын тайлан¹⁷³ нь 2014 оны тайланд дурдсан 12 зөвлөмж, гүйцэтгэх хураангуйн хуулбар болон туршилтын баталгаажуулалтаас өгсөн гол зөвлөмжүүдийг жагсаан оруулжээ. 2015 оны ажлын тайлан нь туршилтын баталгаажуулалтаас өгсөн ихэнх зөвлөмжийг тусгасан, 2016 оны ажлын төлөвөгөөнд багтаасан ч дээр дурдсанчлан ихээхэн ерөнхий байдлаар байна. Гэхдээ 2015 оны ажлын тайлан нь Үндэсний зөвлөлийн 2014 оны 12 сарын 18-н хурлаар зөвлөмжүүдийг (тайлан болон баталгаажуулалтын) хэлэлцсэн болохыг баталгаажуулжээ. Гэхдээ тухайн үед (2016 оны 4 сар) ОУИТБС нь санхүүжилтгүй байсан тул 2016 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саад тулгарсан.

ОТОб болон Хараат бус нэгтгэгч нь 2013 оны тайлангийн санхүүгийн нэгтгэлийн хэсэг дээр зөрүүнүүдийг системтэйгээр судлан үзжээ. ОТОб нь хэд хэдэн уулзалт дээр¹⁷⁴ ОУИТБС-ын гол зорилтуудын нэг нь зөрүүг арилгах явдал гэдгийг давтан хэлж байсан тул зөрүүнд ихээхэн анхаарал хандуулсан байна. 2013 оны тайлангийн төслийг 2014 оны 10 сарын 10-ны хурлаар хэлэлцэх явцад ОТОб нь тухайн зөрүүг нарийвчлан хэлэлцжээ. Петро Чайна Дачин Тамсаг компанийн 2013 оны мэдээлэл дээр 55 тэрбум төгрөгийн зөрүү илэрсэнийг нягтлахад тус компани нь газрын тос борлуулсан орлогыг Монгол дахь бус харин Хятад дахь салбараар дамжуулсан болох нь тодорсон ба үндсэндээ 2014 оны газрын тосны хуулиар энэхүү борлуулалтыг Монгол дахь салбараар дамжуулах үүргийг хүлээж буй юм.¹⁷⁵ Бусад зөрүү нь гаалийн үйлчилгээний төлбөрийг гаалийн татвараас салгаагүй, импортолсон бараа бүтээгдэхүүнд ноогдох НӨАТ болон гаалийн үйлчилгээний төлбөр, мөн гурван компани тайлан гаргаагүй зэрэг асуудлаас үүджээ (2013 оны ОУИТБС-ын тайлангийн хуудас 80).

Өмнө гарч байсан зөвлөмжүүд дээр арга хэмжээ авах нь 2013 оноос хойш Үндэсний зөвлөл болон ОТОб-ын хэлэлцүүлгийн гол сэдэв байсаар иржээ. Хүний эрх, хөгжил төв болон Зориг Сан 2014 онд ОУИТБС-ын нэгтгэл тайланд өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд мониторинг хийж, тайлан гаргасан байна. 2006-2011 онуудад өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт дээр үнэлгээ хийсэн энэхүү тайланд нийт 6 тайлангаар 89 зөвлөмж өгөгдсөн бөгөөд эдгээрээс 40 нь бие даасан давтагдаагүй зөвлөмж байжээ. Эдгээрийн дунд олон удаа давтагдсан зөвлөмж хэд хэд байсан ба жишээ нь 28 зөвлөмж 2-4 тайланд, 12 нь зөвхөн нэг тайланд тусгагдсан байна. Зөвлөмжүүд нь бүгд тайлан гаргах үйл явцад хандсан бөгөөд судалгаагаар үндсэн 5 сэдэв болгон авч үзжээ:

- Тайлангийн маягтын тухай зөвлөмжүүд
- Тайлангийн хамрах хүрээний тухай зөвлөмжүүд
- Тайлан гаргагч талуудын тухай зөвлөмжүүд
- Тайлан гаргах үйл явцыг зохион байгуулахтай холбоотой зөвлөмжүүд
- ОУИТБС-ын ач холбогдол, үр дүнг сайжруулах тухай зөвлөмжүүд

ОУИТБС-ын тайлангуудаар өгсөн зөвлөмжүүд нь 2006- 2014 онд болсон Үндэсний зөвлөлийн 11 уулзалтын 8 дээр нь яригдсан байна. Судалгаанд дурдсанаар Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь 40 зөвлөмжөөс 27 нь хэрэгжсэн гэж үзсэн ч судалгаагаар цөөн зөвлөмж л хэрэгжсэн гэх дүн гарсан байна. Ийнхүү 32 зөвлөмж хэрэгжихгүй буй гол шалтгаан нь үйл ажиллагаа болгохуйц зөвлөмж

¹⁷³<http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/wokplanandreport/Mongol%20EITI%20AAR%202015%20report%20in%20English.pdf>

¹⁷⁴ Хамгийн сүүлд 2014 оны 10 сарын 10 уулзалт дээр.

¹⁷⁵ ОТОб-ын хурлын тэмдэглэл, 2014/10/10, х.4.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

байхгүй, хэн хариуцан хэрэгжүүлэх нь тодорхойгүй зэргээс үүдэлтэй ажээ. Улмаар энэхүү судалгаа нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол сорилтуудыг тодорхойлжээ:

- Зөвлөмжүүд хэт ерөнхий, заримдаа ойлгомжгүй, бүр эрх зүйн зөрчилтэй
- Зөвлөмжүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөөц эх үүсвэр дутмаг
- Урт үйл явц шаардах болон хэрэгжүүлэх эзэн байхгүй
- Хэрэгжүүлэх талуудын хооронд хамтын ажиллагаа сул

Оролцогч талуудын санал бодол

Төрийн байгууллагын хэд хэдэн төлөөлөл болон Ажлын алба мөн 2014 оны тайлан, туршилтын баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжүүдийг 2016 оны ажлын төлөвлөгөөнд үйл ажиллагаа 10.1- 10.5 дээр тусгасан талаар дурдсан. Иргэний нийгмийн зүгээс хэлэхдээ хоёр багц зөвлөмжийг ОТОБ болон ҮЗ дээр 2015 оны 12 сард хэлэлцсэн ч хэрэгжилт нь 2016 онд үүдсэн төсвийн хомсдлоос хамааран хэрэгжээгүй талаар ярьж байв. Гэхдээ иргэний нийгмийн нэг төлөөллийн хэлсэнээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд тусгайлсан санхүүжилт шаардлагагүй ба жишээ нь мэдээллийн хомсдлын асуудлыг ОТОБ эсвэл төрийн төлөөлөлтэй хэлэлцэн шийдэх боломжтой талаар дурдаж байв.

Төрийн нэг төлөөллийн хэлсэнээр тэдний хэрэгжилтэд нь тодорхой байдлаар хамаарах нэг гол зөвлөмж нь төрийн байгууллагуудын тайлангийн мэдээлэлд чанарын баталгаажуулалт хийх явдал гэж хэлсэн ч энэ талаар ямар нэгэн ажил хийгдээгүй байна. 2015 оны хавар Үндэсний аудитын газар албан захидал илгээн төрийн байгууллагуудын гаргаж буй тайланд аудит хийж байх хүсэлтийг илгээжээ. Тус байгууллагаас ирүүлсэн хариунд ийнхүү аудит хийх боломжтой ч үүнийг цаашдын төлөвлөгөөнд оруулан, УИХ-аар батлуулсан тохиолдолд хэрэгжүүлж болно хэмээн мэдэгджээ. Энэ талаар шаардлагатай төсвийг 2016 оны улсын төсөвт тусгаагүй ажээ. Төрийн аудит нь зөвхөн бүрэн хэмжээний буюу төрийн байгууллагуудын анхдагч тайлан болон ОУИТБС-ын нэгтгэл тайланд хоёуланд нь цуг хийсэн тохиолдолд бүрэн хэмжээний баталгаа гаргаж болно хэмээн мэдэгджээ. Төрийн байгууллагыг төлөөлөх хэд хэдэн хүн энэхүү мэдээллийн чанарын асуудлыг мэдэж байсан ба энэ нь томоохон сорилт болж буйг бүрэн ойлгож байв.

Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын бүтэц эь ОУИТБС-ын зөвлөмжүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг болохгүй гэдгийг ярилцлагад хамрагдсан ҮАГ-ын төлөөлөл үзэж байв. Монгол улсад ийм төрлийн олон талын оролцоот зөвлөлүүд олон байдаг ба жишээ нь ХДХВ-ээс сэргийлэх, хөдөлмөрийн эрх олон чиглэлээр байдаг ч тэднийг төрийн байгууллага хэмээн тооцдоггүй тул тэдний гаргасан зөвлөмжийг төрийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн адил анхааралтай хүлээн авдаггүй байна. Тэдний хэлсэнээр ОУИТБС-ын тайланг УИХ-д эсвэл Засгийн газрын аль нэг бүтцэд шууд өргөн мэдүүлэх тохиолдолд зөвлөмжүүдийг түлхүү хэрэгжүүлнэ хэмээн зөвлөсөн. Төрийн байгууллагуудын хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой ихэнх ажил нь төрийн ажлууд байсныг хэлж байв.

Төрийн байгууллагын хоёр төлөөлөл хэлэхдээ ОУИТБС-ын зөвлөмжүүд хэрэгцээтэй зөвлөмж байсан тул хамаарах сайдын эрхлэх ажлын төлөвлөгөөнд уялдуулах зарим арга хэмжээг авсан байна. Хамгийн гол асуудал нь тухайн зөвлөмжүүдийн хэрэгжүүлэх үүрэг бүхий хүмүүсийг дурдаагүй нь гол асуудлыг үүсэж байжээ. ОТОБ-ийн зүгээс 2015 оны 1 дүгээр сард байгуулсан 5 ажлын хэсэг нь илүү тодорхой болгон, үйл ажиллагааг гаргаж ирэх байх хэмээн хүлээж байна. ОУИТБС-ын үйл ажиллагаатай ойр байдаг өндөр албан тушаалтан хэлэхдээ хэрэв өндөр түвшинд дэмжлэг байгаа бол зөвлөмжүүд илүү сайн хэрэгжинэ хэмээн үзэж байна. Гэхдээ Ерөнхий сайдад ОУИТБС-ын үйл

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

ажиллагаанд гарч буй ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгч буй ажээ. Салбарын хоёр төлөөллийн хэлсэнээр ОУИТБС-ын зөвлөмжүүд нь төрийн хувьд тэргүүлэх ач холбогдол бүхий ажлын жагсаалтад орохгүй гэж үзжээ. Салбарын нэг төлөөллийн хэлсэнээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ бага буй талаар 2013 оноос хойш дэлгэрэнгүй ярьсаар буй ч ямар ч үр дүн гараагүй хэмээн байна. Тэд мөн зохицуулалт тодорхой бус байгаа асуудлаар төрд хандан лобби хийхэд ОУИТБС-ын тайланг ашиглах талаар огт бодож үзээгүй байна. Иргэний нийгмийн үзэж буйгаар ОУИТБС-ын тайлангийн үзүүлэх нөлөөлөл баг байгаа нь өмнөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс үүдсэн байна. Үндэсний зөвлөлд өндөр албан тушаалтнууд байдаг ч улс төрийн хүсэл байхгүй бол зөвлөмжүүд нь хэрэгжихгүй хэмээн үзжээ.

Иргэний нийгмийн нэг төлөөлөл, АТГ-ын нэг ажилтны хэлсэнчлэн ОУИТБС-ын тайлангаар илэрсэн зөрүүг албан ёсоор мөрдөн шалгахгүй буйг нэг асуудал гэсэн бол нөгөө нь ОУИТБС-ын тайлан гарсан жилүүдэд хуримтлагдсан дүнгээр нийт 5,1 тэрбум төгрөгийн зөрүү илэрсэнд санаа зовниж байв.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албаны зүнээс Монгол улс нь энэхүү шаардлагыг биелүүлэхэд хангалттай ахиц дэвшил гаргасан гэж үзэж байна. ОУИТБС-ын тайланд өгсөн зөвлөмжүүдийг зохих ёсоор хэрэгжүүлэхгүй буй ч ОТОБ нь энэ талаар сүүлийн 3 жилийн туршид хэлэлцүүлэг хийж байна. ОТБ нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж байна.

7.4 Хэрэгжилтийн үр дүн болон нөлөөлөл (#7.4)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

ОУИТБС-ын ОТОБ болон Үндэсний зөвлөл аль аль нь Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтээс гарч буй үр дүн болон нөлөөлөлд үнэлгээ хийх шаардлагын талаар хэлэлцсээр ирсэн бөгөөд хамгийн сүүлд 2015 оны 11 дүгээр сард болсон Үндэсний форумын үеэр хэлэлцсэн ч форумын тэмдэглэл, хурлын протоколыг судлан үзэхэд өргөн хүрээнд нөлөөллийн үнэлгээ хийх ямар нэгэн хүчин чармайлт гаргаагүй байна.

2015 оны 12 сарын 30-ны өдөр нийтлэгдсэн 2015 оны ажлын тайлан нь хоёр баримт бичгээс бүрдэж буй бөгөөд нэг нь тайлан, нөгөө нь 2015 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжилттэй нь харуулсан хүснэгтэн матриц юм. Тус ажлын тайлан нь 2015 онд хийсэн ажлын тоймыг дурдсан ч ОУИТБС-ын шаардлага нэг бүрийг хангасан эсэх дээр дэлгэрэнгүй үнэлгээ хийгээгүй ажээ. Хоёрдахь хэсэг нь “ОУИТБС-ын шаардлагуудын биелэлтийн статус” хэмээх гарчигтай ч туршилтын баталгаажуулалтын тайлангийн гүйцэтгэх хураангуйг л хуулбарласан байна.

Хэсэг 2.2 дээр “Монголын ОУИТБС-ын 2014 оны эсвэл 9 дүгээр тайлан нь стандартаар шаардсан бүх мэдээллийг багтаасан” хэмээн дурдсан нь олон талуудын зүгээс 2014 оны тайланд мэдээлэл дутмаг байсан гэж хэлж байсантай нэгтгэн үзэхэд хэцүү дүгнэлт юм. Ажлын тайлан нь ОТОБ-ын зүгээс зөвлөмжүүдийн дагуу авсан арга хэмжээг дурдсан ч ерөнхий байдлаар, зөвхөн 2014 оны тайланд дурдсан зүйлсийг л багтаасан байна. Жишээ нь Үндэсний зөвлөл нь 2014 оны ОУИТБС-ын тайланд дурдсан бүх зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн гэсэн буй ч эдгээрийг эрэмбэлсэн эвсэл ач холбогдлоор нь жагсаан гаргаагүй байна. 2015 оны ажлын тайлан нь өмнө гарсан ОУИТБС-ын тайлангуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар юу хийснийг огт дурдаагүй, харин 2013 оны ОУИТБС-ын тайлангийн хэд хэдэн зөвлөмж дээр ахиц гарсан гэж тэмдэглэжээ. Жилийн ажлын тайлан нь шаардлагуудыг давуулан биелүүлэхийн тулд хийсэн ажлын тухай оруулаагүй байна (цахим тайлангийн систем болон орон нутаг дахь хэрэгжилт гэх мэт).

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

2015 оны ажлын тайлан төлөвлөсөн 50 ажлаас 47 нь биелсэн (90%) гэж үзсэн ч ажлын төлөвлөгөөний зорилтууд биелсэн эсэхийг тайлагнаагүй, ер нь ОУИТБС-ын хэрэгжилтийн зорилтуудад огт хандаагүй байна. Жилийн ажлын тайлан нь оролцогч талуудын оролцоо байнгын бүс гэж үзсэн ч өмнө нь оролцоог нэмэгдүүлэхийн тулд хийсэн ажил, цаашид хэрхэн нэмэгдүүлэх санаа зэргийг багтаасангүй.

Олон улсын Ажлын алба нь 2014 болон 2015 оны жилийн ажлын тайланг боловсруулахад өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсэн тухай ямар нэгэн нотолгоо олоогүй ба ОТОБ болон ҮЗ нь багахан хэмжээнд хэлэлцээд л эдгээрийг баталсан байна. Илүү ерөнхий авч үзвэл ОУИТБС-ын үйл явц, нөлөөллийн талаар ОТОБ-ээс гадуур санал өгөх, хэлэлцүүлэг хийгдэж буй талаар нотолгоо бага байна.

Иргэний нийгмийн төлөөлөл нь Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж иржээ. 2014 онд Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн Монгол улс дахь ОУИТБС-ын үйл ажиллагаанд орхигдлын үнэлгээ хийжээ. Энэхүү шинжилгээ нь 2012 оны ОУИТБС-ын тайлан дээр суурилсан ба тайлан гаргах явдал болон шинэ стандартын хоорондын зөрүүг тогтоон, 2013 оны ОУИТБС-ын тайланд зориулан зөвлөмж өгсөн байна. Тус хүрээлэн нь судалгааны талаар уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн төлөөлөлд 2014 оны 6 сард танилцуулга хийх, мөн хувийг ОУИТБС-ын Ажлын албанд илгээсэн ч энэхүү шинжилгээг ОУИТБС нь өргөн хүрээнд түгээн хэлэлцсэн гэдэгт итгэхгүй байна. Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн нь мөн 2014 онд Хараат бүс нэгтгэгчтэй уулзалт хийн, шинжилгээний үр дүнгийн талаар танилцуулан, тодорхой асуудалд хэрхэн хандах талаар зөвлөгөө өгсөн байна. Хараат бүс судалгааны хүрээлэн (IRIM) мөн ОУИТБС-ын нөлөөллийн үнэлгээний загварыг боловсруулжээ. Тус загварыг 2 шаттай хийсэн ч өнөө хүртэл албан ёсоор батлагдаагүй, хэрэгжээгүй байна (2015 оны 11 сарын байдлаар). Тухайн загвар нь ОУИТБС-ын зарчмууд нь хэрхэн өөрчлөлтийн онолыг дэмжиж, Монгол улс яагаад ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа вэ гэсэн асуултад төвлөрч, хэрэгжилтээс үзүүлж буй нөлөөлөл болон орцод бүс харин гарцад суурилах хэрэгцээг тодруулжээ.

Оролцогч талуудын санал бодол

Уулзан ярилцсан бүх хүмүүс иргэний нийгэм нь үйл ажиллагааны тайлангийн төсөлд бодитой санал өгсөн цорын ганц тал байсан гэдэгтэй санал нийлж байна. Ихэнх тал нь жилийн ажлын тайланг “Олон улсын ажлын албанд зориулан гаргасан баримт бичиг” гэж үзэж буй ба иргэний нийгмийн нэг байгууллага энэ талаар ОВТОБ-ийн хурлаар ярьж, энэхүү баримт бичиг нь ОУИТБС-ын ололт амжилт, сорилт, зөвлөмжүүдийг Монгол улсын нийт иргэдэд хүргэх баримт байх ёстой хэмээн маргаж байжээ.

Төрийн байгууллагын төлөөлөл, өмнө болон одоогийн Хараат бүс нэгтгэгч нарын хэлсэнээр ОУИТБС нь орон нутаг дахь олон хүнд, нутгийн захиргаадад уул уурхайн салбарыг ойлгох, эдийн засагт үзүүлэх хувь нэмрийн талаар мэдэхэд нь тодорхой нөлөөлөл үзүүлж буй гэж үзэж байна. Уул уурхайн салбарын нэр хүнд тааруугаас салбарыг эсэргүүцэх үйл явц явагдаж буй ч ойлголтын түвшин нэмэгдэж байна. Үүнийг хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага баталгаажуулсан ч олон нийттэй үүссэн зөрчилдөөн зарим хэмжээнд бүүрч байна. Мөн ОУИТБС-ын мэдээлэл түгээх нь уул уурхай, газрын тосны компаниудад үлгэр жишээ болж тэд ч олон нийттэй уулзалтуудыг хийх болжээ. Төрийн төлөөллийн үзэж буйгаар орлогын ил тод байдал нь хөрөнгө оруулалтыг дэмжих орчныг бий болгож, нутгийн иргэдийн итгэлийн олж авах суурь болж, нийгмийн лицензийг нь баталгаажуулж байна. Гэхдээ төрийн төлөөллийн зүгээс ОУИТБС нь дангаараа хангалттай бүс гээд бусад төрлийн

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

жишээ нь төрийн худалдан авалт, төсвийн зарцуулалт, ашиг сонирхлын зөрчилдөөн зэрэг олон санаачилгатай уялдах ёстойг хэлж байв.

Ул уурхайн салбарын төлөөллийн үзэж буйгаар ОУИТБС нь салбарт илүү ил тод байдлыг авчирсан ч өөрийн үзүүлж буй нөлөөллийг судлан үзэхгүй байна. Тогтвортой нөлөөллийг үзүүлэхийн тулд ОУИТБС-ын зөвлөмжүүдийг зохистой хэрэгжүүлэх хэрэгтэй гэж тэд үзэж байна. Газрын тос , уул уурхайн компаниуд ОУИТБС-ын хүрээнд илүү их ил тод болсон, салбарын талаарх олон нийтийн сэжиг таамаг буурсан гэж үзэж байна. Өмнөх Хараат бус нэгтгэгчийн нэг хэлэхдээ сүүлийн жилүүдэд томоохон компаниуд татварын хууль тогтоомжийг сайн дагаж мөрдөх болсон нь ОУИТБС-ын хэрэгжилтээс үүдэлтэйг хэлж байна. Иргэний нийгмийн зарим байгууллага 2007 онд ОУИТБС эхэлсэнээс хойш уул уурхайн кадастр сайжирсан гэсэн ба өөр хүчин зүйлс мөн нөлөөлсөнийг дурдаж байв.

Төрийн байгууллагын нэг төлөөлөл хэлэхдээ ОУИТБС ихээхэн нөлөөлтэй тодорхой хүрээ буй бөгөөд жишээ нь мэдээллийн найдвартай байдлыг дурдсан. Үүний жишээнд Таван Толгойн төслийн оруулсан ба төлөвлөсөн төсөл нь асар том тул иргэдэд энэ талаар бараг төсөөлөл байгаагүй ажээ. Таван Толгойд үйл ажиллагаа явуулдаг компаниуд өндөр үнэтэй аудитор ажиллуулж байсан ч Таван Толгойн тухай ихэнх мэдээлэл ОУИТБС-ын хүрээнд ил тод болжээ. Төрийн хэд хэдэн төлөөлөл мөн бенефициар өмчлөлийн мэдээллийг цаашид ил тод болгох нь олборлох салбарт томоохон нөлөө үзүүлнэ гэж бодож байна.

Анхдагч үнэлгээ

Олон улсын Ажлын албанаас Монгол улс нь энэхүү шаардлагыг ханган биелүүлэхэд тодорхой хэмжээнд ахиц гаргасан гэж үнэлж байна. ОТОБ нь ОУИТБС-ын Монгол улсад үзүүлж буй үр дүн, нөлөөллийн талаар байнга хэлэлцдэг ч энэ түр зуурын, албан бус хэлбэртэй болсон байна. Иргэний нийгмийн байгууллагууд нь 2014 оны ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилт дээр судалгаа хийсэн бөгөөд энэ хүрээнд ОУИТБС-ын үйл явц болон бодлогод үнэлгээ хийжээ. ОТОБ нь мөн бүлэг бүр дээр нөлөөллийн үнэлгээ хийх талаар 2016 оны ажлын төлөвлөгөө гаргахдаа судалж байсан ч ямар нэгэн зүйл хийгдээгүй байна. 2015 оны ажлын тайлан нь хэрэгжилтийн нөлөөллийг үнэлэхэд ашиглагдахгүй байна.

Хүснэгт 7 – Тойм үнэлгээний хүснэгт: Үр дүн ба нөлөөлөл

ОУИТБС-ын заалтууд	Гол үр дүнгийн тойм	Олон улсын Ажлын албаны зүгээс гарсан ахиц дэвшилд өгсөн үнэлгээ
Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)	ОТОБ нь гаргаж буй ОУИТБС-ын тайлангаа иж бүрэн, хүртээмжтэй байлгаж, аймаг болон сумдын түвшний тайлангаа онцгойлон идэвхтэйгээр сурталчилж байх олон арга замыг эрэлхийлсэн байна. ОУИТБС-ын мэдээлэл нь өргөн хүрээний , ялангуяа орон нутагт олон нийтийн хэлэлцүүлгийг бий болгожээ.	Хангалттай ахиц дэвшил гарсан
Мэдээллийн хүртээмж (#7.2)	ОУИТБС-ын мэдээлэл нь хүртээмжтэй, олон улсын ангилалд нийцсэн, компютерт унших боломжтой болсоны дээр цахим тайлагналын вебсайтаар мөн дамжин түгэж байна.	
Сургамжууд болон	ОУИТБС-ын тайлангуудаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн	Хангалттай ахиц дэвшил

зөвлөмжүүдийн хэрэгжилт (7.3)	дүүрэн зохистой хэрэгжүүлээгүй ч зөвхөн ОТОБ л эргэн харж арга хэмжээ авч иржээ.	гарсан
Хэрэгжилтийн үр дүн болон нөлөөлөл (#7.4)	ОТОБ нь хэрэгжилтийн ахиц дэвшил, үр дүнг баримтжуулсан тайланг бэлтгэн гаргаж байсан ч үзүүлж буй нөлөөллийн судлан үзээгүй байна. 2015 оны жилийн үйл ажиллагааны тайланд гурван талын нэг нь л санал өгсөн мэт байна. Нөлөөллийг үнэлэх чиглэлээр цаашид ажил хийх шаардлагатай ажлын тайлан гаргахад оролцогч талуудын оролцоог бэхжүүлэх шаардлагатай.	Тодорхой хэмжээний ахиц дэвшил гарсан
<p>Зөвлөмжүүд:</p> <ol style="list-style-type: none"> ОТОБ нь орон нутгийн дэд зөвлөлүүд үндэсний хэмжээний ОУИТБС-ын хэлэлцүүлэгт илүү хувь нэмэр оруулж байх, орон нутагт хийгдсэн хэлэлцүүлгийн үр дүнг үндэсний хэмжээнд тусгаж байхыг баталгаажуулсан илүү албан ёсны механизмыг бий болгохоор судлан үзэх болох юм. ОТОБ нь олборлох салбарын шинэтгэлтэй холбоотой үндэсний тэргүүлэх ач холбогдол бүхий золрилтыг хангахад ямар үүрэг рольтой байх талаар дээр жил тутмын ажлын төлөвлөгөөг гаргахдаа ярилцан, хэлэлцэж байх шаардлагатай байна. ОТОБ нь ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж буй түр ажлын хэсгүүд өөрийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулж байх тодорхой механизмыг бий болгож, тэдэнд ажлаа дуусгах тодорхой хугацаа заан өгч байх талаар судлан үзэх шаардлагатай байна. ОТОБ нь хэрэгжилтийн үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор нөлөөллийн үнэлгээ хийлгэх талаар судлан үзэх болох юм. ОУИТБС-ын тайлангаар гарсан үр дүнг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд Засгийн газрын 2012 оны #222 дугаар тогтоолын дагуу гарган өгч байхаар судлан үзэх шаардлагатай байна. Орон нутгийн ИТХ-ууд нь өөрийн дэд зөвлөлийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу, шинээр лиценз олгохыг зөвшөөрөх эсэх дээр компани болон иргэний нийгэмтэй зөвлөлдөхөд ашиглах талаар судлан үзэх хэрэгтэй байна. ОТОБ нь ОУИТБС-ын зөвлөмж нэг бүр дээр хэрэгжилтийг хариуцах талуудыг тодорхойлон, тайлан болон баталгаажуулалтын зөвлөмжүүдийг илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжийг хангах талаар судлан үзэх нь зөв. 		

7.5 Нөлөөллийн дүн шинжилгээ (ОУИТБС-ын заалтуудын хэрэгжилтийг үнэлэхэд харгалзан үзэхгүй)

Ахиц дэвшлийг баримтжуулах нь

Нөлөөлөл: Монгол улс дахь ОУИТБС-ын үйл явц нь зарим нөлөөлөл үзүүлж буй ч энэхүү нөлөөлөл нь мэдлэг нэмэгдүүлэх болон тайлагнах үйл явц дээр л төвлөрсөнийг зарим оролцогч тал зөвшөөрч болох юм. ОУИТБС-ын зүгээс 10 жил хэрэгжихдээ Монгол улсад үзүүлж буй нөлөөлийг үнэлэх Олон улсын Ажлын албаны үнэлгээний хүрээнд бүх оролцогч талаас ямар шалтгааны улмаас Монгол улс нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй гэж боддогыг асуусан билээ. Үүний хариу болгон төрийн байгууллагын нэг төлөөлөл хэлэхдээ олборлох салбар бүрхэг байсан 2005 онд Монгол улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдсэн нь ЗГ гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээ авч байсан үетэй таарсан. Тиймээс ОУИТБС-ыг хөрөнгө оруулалт татах аргачлал хэмээн үзэж байсан гэж хариулсан.

Монгол улсын баталгаажуулалт: ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны анхдагч мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан

Иргэний нийгмийн өөр нэгэн хүний хэлсэнээр ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эцсийн зорилго нь Монгол улсад ядуурлыг бууруулах явдал гэж үзсэн.

Иргэний нийгмийн хэд хэдэн төлөөлөл хэлэхдээ ОУИТБС хэрэгжиж эхлэхээс өмнө олон нийт хэдийн хэмжээхий мөнгийг Засгийн газар тус салбараас олдог болохыг мэддэггүй байсан, харин одоо хүмүүс энэ талаар мэдээлэлтэй болж, магадгүй 2009 оны өсөлтөөс хамаарсан байж болох ч төв болон орон нутгийн түвшинд олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаарх хэлэлцүүлэг нэмэгдсэн хэмээн үзэж байна. Тэр үетэй харьцуулбал орон нутгийн иргэд мэдээлэлтэй болж, орон нутгийн захиргаа компаниудаас хэдий хэрийн орлого олж буй талаар мэддэг болсон тул илүү өөр олон зүйлийг жишээ нь тусгай зөвшөөрөл, байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон зүйлсийг мэдэх хүсэлтэй болжээ. Зарим иргэний нийгмийн байгууллага мөн ил тод байдал нэмэгдэж энэ нь УИХ-ын гишүүд, оюутнууд, төрийн албан хаагчдын байнгын сэдэв болсон хэмээ үзжээ. Иргэний нийгмийн зарим төлөөлөл үзэхдээ Засгийн газар анхлан ОУИТБС-ыг нэр хүндийн хэрэг гэж үзэж байсан ба хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, стандартаар шаардсан зүйлсийг ил тод болгоход туслах боломжгүй гэдгээ мэдэж байсан ч нэр хүндийн хувьд давуу тал өгсөн байна. Иргэний нийгэм мөн тодорхой асуудлаар жишээ нь 2015 оны эхээр хийгдсэн Эрдэнэс Таван Толгойн асуудлаар авсан арга хэмжээгээ эргэн дурсаж, ОУИТБС-ын үр дүнд иргэний нийгмийн байгууллагууд одоо ОУИТБС-ын статусыг ашиглан лобби хийж, олборлох салбар дахь иргэний хяналтыг бий болгож чадаж байна хэмээн тайлбарлажээ. Харин төрийн төлөөллийн зүгээс ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орон гэсэн статус нь засгийн газрын зүгээс ил тод байдлыг хангах, олон нийт уул уурхайн салбарыг хүлээн зөвшөөрөх зэрэг дээр тусгагдсаныг хэлсэн ч хэрэгжилтээс гарсан тодорхой нөлөөллийн талаар ямар нэгэн тайлбар хэлээгүй.

